



**АННЕ ФРАНК**

**ЗАЛУУ ОХИНЫ  
ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ**

**Анне Франк**

# **Залуу охины өдрийн тэмдэглэл**

## Оршил

Асар богинохон хугацаанд ч утга төгөлдөр амьдарч болохыг харуулж чадсан охин бол 15 насандаа нацист Германы хорих лагерьт нас барсан Анне Франк хэмээх еврей охин юм.

Түүний бичиж үлдээсэн өдрийн тэмдэглэл нь фашизмын гамшиг, дэлхийн хоёрдугаар дайны үеэр еврейчүүдийн туулсан зовлон, амьдрах хүсэл тэмүүллийн гайхамшигт гэрч болон үлдсэн юм. Аннегийн өдрийн тэмдэглэлийг Америкийн ахлах сургуулийн сурагчдын заавал унших номын жагсаалтанд оруулж биелээгүй хүсэл мөрөөдөл, амьдралыг таних, өөрийгөө олохыг хүссэн охины чин хүслийн үгийг сая сая хүүхдүүд уншсаар байна.

Аннелис Мариэ буюу Анне Франк 1929 оны 6-р сарын 12-нд Германы Франкфурт хотод Отто Франк, Эдит Франк нарын бага охин болон төржээ. Тэдний ууган охин Маргот нь Аннегаас гурван насаар эгчмэд байв. Франкийнх жүүдүүдийг ялгаварлан гадуурхдаггүй бүсэд амьдарч байсан тул Аннегийн бага нас нь католик, лютеран, иудей шүтлэгт үеийнхнийхээ дунд аз жаргалтай сайхан өнгөрч байсан юм. Франкийнх ч иудейн уламжлалт ёс заншлыг төдийлөн хатуу баримталдаггүй айл байжээ.

Аннегийн эцэг Отто Франк дэлхийн нэгдүгээр дайнд оролон Германы офицерүүдийн гавьяаны одонгоор шагнуулж явсан сайн боловсролтой, гайхамшигт баялаг номын сантай, гэр бүлээ эрхэмлэн дээдэлдэг хүн байв. Харин хатагтай Франк нөхрөөсөө илүү шашинд чин сүсэгтэй эмэгтэй байжээ.

1933 онд Франкфуртийн орон нутгийн сонгуулиар А.Гитлерийн нам ялж, арьсны үзэл даамжрах шинжтэй болсонд Франкийнх Холланд руу нүүхээр шийдсэн юм. Тэднийх Германаас Холланд руу дүрвэсэн 300.000 жүүдүүдийн нэг байлаа. 1934 онд тэднийх Амстердамд төвхнөжээ. Тэдний ууган охин Маргот математикт толгой цохиж байхад Анне нь аливааг уншиж ойлгох болон бичих авьяастайгаа харуулж эхэлсэн байна. Аннегийн багын найз нарын нэг Ханне Гослар дурсахдаа "Анне дандаа л юу ч юм бичиж байдаг. Түүнийгээ хамгаалахын төлөө хөвгүүдтэй гар зөрүүлэхэд ч бэлэн. Бичдэг юмныхаа тухай ам нээхгүй нууцлан нандигнадаг байж билээ. Эгч дүү Маргот, Анне хоёр тэс өөр охид байсан. Маргот үлгэр жишээ охины жишгээр биеэ авч явдаг, дуу цөөтэй бүрэгдүү, нээлттэй зантайгаас гадна хоол хийх мэтийн гэрийн ажил хамгийн уйтгартай зүйл хэмээн ярьдаг, ямагт өвөрмөц сэтгэдэг охин байлаа" хэмээсэн байдаг.

1940 онд Герман Холланд руу довтолж эзэлснээр жүүдүүдийг ялгаварлан гадуурхаж, мөрдөн мөшгиж эхэлжээ. 1941 онд Отто Франк еврей эзэнтэй компанийг хориглож эхлэхэд "Пектагон" хэмээх компаниа И.Клейман гэдэг хамтрагчдаа шилжүүлсэн юм.

1942 онд эцэг эх нь Аннед 13 насных нь төрсөн өдрөөр нь гоёмсог тэмдэглэлийн дэвтэр бэлэглэсэн нь охиныг гайхамшигт тэмдэглэлээ бичихэд хүргэжээ. Анне тэмдэглэлээ хамгаас дотнын найз охинд тооцон Китти гэж нэрлэсэн юм. Энэ үеэр Аннегийн эгч Марготыг бөөнөөр хорих лагерьт явуулах зарлан дуудах ирүүлсэн байна. Энэ өдрөөс эхлэн Франкийн гэр бүл германчуудын мөрдөлтөөс зугтан компанийхаа байрны дээврийн хөндийд хамт ажиллаж байсан нэгэн хүний гэр бүлтэй хамт хоргодох болсон юм. Анне германуудаас

нуугдан бүгж байхдаа тэмдэглэлээ бичсээр хоргодох байрны амьдрал, зовлон бэрхшээл, хамт бүгж байсан 17 настай Петер хэмээх хөвгүүнд өгсөн анхны хайр, бодол санаа мэдрэмжээ бүгдийг сонирхолтойгоор бичиж үлдээсэн юм. Франкийнхны бүгж нуугдсан түгшүүр дүүрэн ч элэг бүтэн амьдралыг эцэс болгосон тэр гунигт өдөр бол 8-р сарын 4 байлаа. Тэр өдөр германы SS-ийн нэг офицер, Холландын 3 цагдаа тэдний байранд гэнэт дайран орж ирсэн юм. Хоргодох байранд нуугдаж байсан хөөрхийлөлтэй 8 хүнийг тэдэнд тусалж байсан хоёр ажилтны нэг нь германчуудад илчилсэн гэж үздэг. Тэдний баривчлагдсаны дараа хоргодох байрны шалан дээр хөсөр хэвтсэн Аннегийн дэвтрийг урьд хоол хүнс зөөн тусалж байсан Мийп бүсгүй олжээ. "Бид дээврийн хөндий рүү гарч шалан дээр Аннегийн дэвтэр унасныг хараад Беп үүнийг бушуухан ав гэхэд тэр салганасан гараараа дэвтрийг аваад бид бууцгаасан. Бид үнэхээр айсан. Тэр гунигт хоргодох байрнаас гарангуутаа би цөхөрсөн дуугаар "Үүнийг яах вэ ? Бэп" гэж асуусан сан. Тэр харин надад дэвтрийг өгч "Чи илүү эгчмэд хашраараа үүнийг хадгалж яв" гэсэн" хэмээн дурссан байдаг.

Анне Маргот хоёр Берген-Бельзений хорих лагер руу, Даан, Дуссель, эхнэр нөхөр Франк нар Освенцим руу ачигджээ.

1945 оны нэгдүгээр сард Аннегийн ээж Эдит Освенцимд нас баржээ. Анне, Маргот хоёр чөлөөлөгдөхөөс хэдхэн долоо хоногийн өмнө Берген-Бельзэнд хоорондоо ганцхан хоногийн зөрөөтэй гэдэсний хижгээр насан эцэслэсэн юм. Харин эцэг Франк л Освенцимыг чөлөөлөгдөх хүртэл амьд байж эрх чөлөөтэй золгосон байна. Аннегийн хайртай хөвгүүн Петер германчууд хорих лагерийг нүүлгэх үед хөл дээрээ явах чадалтай хоригдлуудыг ачихад төв хорих руу жагсан одохыг бие нь муу байснаас хоцорсон Отто Франк сүүлчийн удаа харснаа дурссан байдаг. Ирээдүйд агуу зохиолж болохыг хүсэн мөрөөдөж явсан Анне охин үргэлжийн 15 насандаа мөнхрөн үлдэж, бичиж үлдээсэн өдрийн тэмдэглэлийг нь сая сая хүүхдүүд уншиж, түүний тухай бүрэн хэмжээний хоёр кино бүтээж, мянга мянган шүтэн бишрэгчид нь энэ охины тухай эссе, сэтгэгдлээ бичсээр байна.

Ингээд "Анне Франкийн өдрийн тэмдэглэл"-ийг таалан уншина уу.

**Орчуулсан Б.Амина**

## 1942 оны зургадугаар сарын 14. Ням гариг

*Би баасан гаригийн өглөө зургаан цагт сэрэв. Төрсөн өдөр маань байсан болохоор эрт сэрэлгүй яахав. Харин сэрмэгцээ босож болохгүй юм чинь зургаан цаг дөчин таван минут хүртэл орондоо хэвтэх хэрэг гарав. Гэвч төдөлгүй тэсч ядаад Моорхон гэдэг муужгай байгаа галын өрөө рүү гүйн орвол тэр минь эрхлэн угтав. Долоо болгоод аав ээж дээр орж, төрсөн өдрийнхөө бэлгийг хамтдаа үзэж, задлахаар зочдын өрөөнд оров. Тэгэхэд л би тэмдэглэлийн дэвтэр чамайгаа эхлэн харсан шүү дээ. Миний төрсөн өдрийн хамгийн сайхан бэлэг л чи минь байлаа. Чамтай минь хамт сарнай цэцгийн баглаа, халуун орны кактус, цээнэ цэцгийн мөчир тэргүүтэн байв. Тэдгээр нь амьд цэцгийн баглааны эхнийх нь байсан. Дараа нь харин надад хичнээн ч олон баглаа цэцэг ирэв, бүү мэд. Аав ээж хоёр ч надад зөндөө их юм бэлэглэв. Анд найз нар маань ч их л бэлэг өгсөн. Нэг л мэдэхэд "Camera Obsura" гэсэн Холландын нэртэй ном, олуулаа тоглох наадам, төрөл бүрийн амттан, тэвчээр сорих тоглоом, хатгуур зүүн гоёл, Иозеф Кохенишийн "Холланд домог туульс", "Дейсис ууланд аялсан нь" гэдэг номнууд, бас мөнгө төгрөгтэй ч болов. Тэр мөнгөөр нь дараахан нь Рим, грегийн баатарлаг туульс худалдаж авсан. Мөн ч гоё оо!*

*Намайг аваачихаар Лизийг ирмэгч сургуульдаа явав. Тэгээд л багш нар, ангийнхнаа чихрээр дайлаад хичээл эхлэх нь тэр.*

*За болих уу даа. Би тэмдэглэлийн дэвтэр чамтай болсондоо хязгааргүй баяртай байна!*

*Анне*

## 1942 оны зургадугаар сарын 15. Даваа гариг

*Төрсөн өдрийнхөө үдэшлэгийг бямба гаригийн их үдэд хийв. "Гэрэлт цамхгийн манаач" гэдэг кино үзүүлэв. Найзуудад минь кино овоо таалагдав. Бид хэд бахаа ханатал төрхгүйтэцгээж, ёстой гоё цэнгэв. Миний төрсөн өдөрт олон ч охид, хөвгүүд ирсэн юм чинь. Ээж маань тэр хөвгүүдийн хэнтэй нь намайг суух бол гэдгийг мэдэх санаатай тагнуулдана. Хэрэв тэр ирээдүйн "хүргэн" нь Петер Весель гэдгийг мэдвэл ээж хичнээн их гайхах бол. Яагаад гэвэл ээжийг надтай нөхөр мөхөр гэсэн яриа үүсгээд эхлэхээр нь би тоохгүй дүр үзүүлдэг юм. Охидоос Лиз Коозен, Занне Хоутман нар миний хамгийн дотны, олон жил үерхсэн найзууд маань юм. Харин сүүлийн үед сурвалжит еврейчүүдийн сургуулийн Жопи Вааль гэдэг охинтой танилцаж олон орой хамта байж, хамгийн дотно үерхдэг болсон. Жопи ч миний төрсөн өдөрт бас ирсэн. Лиз ер нь надаас өөр олон охинтой үерхдэг, Занне ч өөр сургуульд явдаг болохоор тэндээ мэдээж олон найз охинтой.*

*Анне*

## 1942 оны зургадугаар сарын 20. Бямба гариг

*Би хэдэн өдөр тэмдэглэлийн дэвтэртээ ганц ч мөр бичсэнгүй. Учир нь өдрийн тэмдэглэлийнхээ санаа, зориулалтыг юуны өмнө сайн бодох гэсэн юм л даа. Өдрийн тэмдэглэл хөтлөх гэдэг бол тийм ч амар юм биш. Өмнө нь яагаад "хөтөлсөнгүй"- вэ гэдгээс ч биш. Хэзээ нэгэн цагт арван гуравтай ердийн нэгэн сурагч охины сэтгэл зүрхний үг нь хэн нэгэнд юмуу эсвэл өөрт нь ч сонин байж болно гэдэг нь мэдээж. Гэхдээ хамгийн гол нь энэ биш. Ердөө л бичихийн хүслэнд автаж юуны өмнө сэтгэлээ, өөрийгөө сатааруулан амраах, бодол санаагаа уудлахын тулд бичих болсон юм.*

*"Цаас ямар ч хүнээс илүү тэвчээртэй" гэж би, хөнгөн уйтгарт өдрүүдэд шанаагаа тулан, заримдаа юу хийхээ мэдэхгүй болохдоо үе үе боддог юм. Гэртээ баймаар байсан ч тэвчилгүй гармаар санагддаг ч ихэнхдээ суудалдаа суугаад, элдвийг бодлогоширдог юм. Тиймээ, цаас л тэвчээртэй шүү!*

*Энэхүү өдрийн тэмдэглэл гэсэн том нэртэй үдмэл дэвтрийг хэн нэгэнд хэзээ нэгэн цагт үзүүлэх бодол мэдээж надад алга. Харин үүнийг, сэтгэл зүрхнийхээ хамаг нууцыг дэлгээж болох хамгаас итгэлт анд найзаа болгох гэсэн юм. Үүнээс өөр бодол ч алга даа. Үнэхээр өдрийн тэмдэглэл чам шиг хамаг бүхнээ итгэн ярих тийм итгэлтэй найз охин надад алгаа.*

*Над шиг арван гуравтай жирийн нэгэн охины ийм ганцаардмал байдлыг хэн ч ойлгохгүй болохоор л өөрийгөө чадлынхаа хэрээр тайлбарлах гэсэн юм. Энэ ч бас л гайхмаар байгаа биз. Надад хайраа зориулсан халамжит аав, ээж, арван зургаа хүрэх гэж байгаа хайртай ганц эгч таньдаг, найзалдаг бусад хүмүүс гээд ойр дотнын 30 гаруй хүн байна. Мөн бүхний нь өөрсдийнх нь нүднээс уншин, заримдаа өөрсдийн нь тольхноор ажиглаж инээмсэглэн тал өгдөг үеийн найз хөвгүүд байна. Бас намайг хайрладаг авга, нагац нар гээд хамаатан садан, тансан тохитой сайхан гэр гээд дутуу юм үгүй. Гэтэл ганцхан сэтгэл зүрхээ хуваалцах хүн хамгаас итгэлт сайн найз охин л үгүйлэгдэх юм!*

*Би ойр дотныхоо хэнтэй нь ч өдөр тутмын ердийн л юм ярихаас биш сэтгэлээсээ илэн далангүй ярьж чаддаггүй. Гэтэл хүн сэтгэл санаагаа уудлан ярихыг ямар их хүсдэг билээ дээ. Тэгээд л худлаа дүр үзүүлж сэтгэлдээ нууцаа хадгалан явах болдог. Бодвол энэ нь намайг хэн ч итгэдэггүйд байх шиг байна. Тэгээд ч энэ байдлаа яагаад ч өөрчилж болохгүй нь харамсалтай юм.*

*Ингээд л би өдрийн тэмдэглэл хөтлөхөөр шийдлээ. Хэн бүхний нэгэн адил өөртөө тохиолдсон өдөр тутмын явдлыг тоочин бичих гэж бус харин сэтгэл зүрхнийхээ нандин бүхнийг хуваалцах найз охин гэж өөртөө төсөөлөөд өдрийн тэмдэглэлдээ Китти гэж нэр өгсөн юм!*

*Киттитэйгээ илэн далангүй хүүрнэхийг минь надаас өөр хэн ч ойлгохгүй байж болох юм.*

*За ингээд би өөрийнхөө намтрыг эхэлж ярихыг хүснэм. Дотроо дургүй байгаа ч гэсэн өөрийгөө танилцуулахаар шийдлээ. Аав ээж хоёрыг гэрлэхэд аав гучинтавтай, ээж хоринтавтай байжээ. Миний эгч Маргот 1926 онд Майн голын хөвөөн дэх Франкфурт хотноо төрсөн бол би 1929 оны зургадугаар сарын арван есөнд төрсөн. Еврейчүүдийг германаас гадуурхагдан цагаачлахад манайхан 1933 онд Холландад нүүж ирсэн юм. Энд аав*

*маань худалдааны трестэд даамлын албанд оров. Тэр трест нь нэгэн барилгад байрладаг Колений худалдааны нэгдэлтэй ажил төрлийн нягт холбоотой.*

*Нүүн дүрвээж чадаагүй германд хоцорсон төрөл төрөгсөд маань Гитлерийн хатуу чанга мөрдөлтөнд байгаагаас манайхан тав тух муухан амь зууж байв. 1938 оны Гитлертийн зохицуулалт гэгчийн дараахан хоёр нагац ах маань Америкт дүрвээж, эмээ бидэн дээр ирэв. Эмээ маань тэр үед далан гуравтай байсан. 1940 он гарахад энд ч муу юм хаяалж эхлэв. Эхлээд дайн, дараа нь буулт, сүүлд нь Германчууд Холландад ороод ирэв. Тэгээд л гамшиг зовлон эхлэх нь тэр. Дарангуйлах хууль ёс дараалан гарсаар ялангуяа еврейчүүд бидний хувьд бүр ч аймшигтай боллоо. Еврей хүн заавал зургаан хошуу тэмдэг зүүн, унадаг дугуйгаа ч хураалган, цахилгаан галт тэргээр ч зорчиж болохгүй. Машины тухайд бол бүүр ч ярилтгүй. Бид гурваас таван цагийн хооронд зөвхөн бидэнд үйлчилдэг мухлаг гэгчид худалдаа хийдэг болж оройн найман цагаас хойш гудамж цэцэрлэгт явах хөл хориотой, бүр тагтан дээрээ ч гарч болохгүй болов. Еврейчүүлийн хувьд кино театр болон цэнгээн зугааны бусад газраар орох, усанд сэлэх, одон бөмбөг, хоккей мэт биеийн тамирын аливаа тоглоомоор тоглох зэрэг нь бүгд цээртэй. Еврейчүүд христос шашинтан танилындаа айлчлан очиж болохгүй. Еврей хүүхдүүд зөвхөн л еврейчүүдийн сургуульд явна гэх мэт зүйл зүйлийн тушаал захирамжууд хөвөрч эхлэв. Ийм л дарамт талхинд бүх л амьдрал маань орчихлоо. Жопи маань "Үргэлж л айж амьдрах болсноос юу ч хийх, сонирхох итгэл маань алдрах боллоо. Тэртэй тэргүй бидэнд юу ч хийх хориотой юм чинь!" гэж ярих боллоо.*

*Энэ оны нэгдүгээр сард эмээ маань нас барав. Эмээтэйгээ миний ямар холбоотой байсныг, түүнийг хэрхэн үгүйлж байгааг хэн ч мэдэхгүй. Уг нь би, аль эрт 1934 онд Монтессорийн сургуулийн дэргэдэх хүүхэд саатуулах газар орж, дараа нь тэндээ сургуульд сурч билээ. Захирал К. авгай сүүлдээ манай ангийн багш болсон юм.*

*Жил өнгөрөөгөөд багш бид хоёр асгартал уйлан салж билээ. Маргот эгч бид хоёр, түүнээс хойш 1941 оноос эхлэн еврейчүүлийн тусгай сургууль Лицейд нэг нь дөрөвдүгээр ангид, нөгөө нь нэгдүгээр ангид сурч эхэлсэн. Бид дөрвийн явдал ийн өнөөтэй золгосон шиг өлзийтэй байгаасай.*

*Анне*



## 1942 оны зургадугаар сарын 21. Ням гариг

*Бид ангиараа л нэг айсан улс байна. Багш нарын хурал босгон дээр ирэв. Ангийн маань тэн хагас нь хэн анги дэвших, хэн улирах вэ хэмээн мөрийцөж байна. Жоныгийн Мийн бид хоёр, мөнгөө бүгдийг нь хэн улирах, хэн анги дэвшихийг таах бооцоонд тавьсан ширээнийхнийгээ хараад элгээ хөштөл инээлдэв. Тэд "Чи анги дэвшинэ, улирна. Үгүй, тийм..." гээд л өглөөнөөс үдэш болтол шуугилдав. Уг нь Мийтийн аргадангуй харц, миний ухааруулах гэсэн шаргуу оролдлогын аль нь ч тэднийг сэхээрүүлж чадсангүй. Минийхээр бол, залхуугаас хойш, ангийнхны маань тэн хагасы нь ч улираасан яахав санагдана. Багш нар гэдэг олноос онцгой олон зантай улс, гэхдээ одоо сайхан зантай байгаа байж ч мэдэх юм.*

*Миний хувьд бол бүх л эрэгтэй эмэгтэй багш нар цөм надад сайн. Есөн багшийн долоо нь эрэгтэй, хоёр нь эмэгтэй. Тооны багш ноён Кеплер намайг хичээл дээр их ярьдаг гэж нэг хэсэг муухан байсан юм. Тэр надад шийтгэл болгож нэмэлт даалгавар өгнө шүү хэмээн байн байн анхааруулдаг байлаа. Тэгээд нэг удаа "Чалчаа охин" гэсэн сэдвээр зохион бичлэг хийж ир гэв. Очиж, очиж чалчаа охин шүү! Энэ тухай юу бичих юм бэ? гэж санаа ер зовсонгүй, даалгаврынхаа дэвтрийг цүнх рүүгээ чулуудчихаад дуугүй байх гэж оролдов. Орой нь бусад бүх даалгавраа хийгээд дууссаны дараа тооны багшийн өгсөн нөгөө зохион бичлэгийн сэдвийг гэнэт саналаа. Би үзгээ хэмлэн хэсэг зуур бодлогоширон суулаа. Ер нь хэн хүнгүй, ямар нэг юмны тухай санаандаа орсныг жаахан эрээчээд зохион бичлэг хийчихэж болно л доо. Гэтэл чалчих нь зайлшгүй зүйл юм гэдгийг гарцаагүй батална гэдэг нь нэг ёсны урлаг шүү дээ. Би бодоод л бодоод л байлаа. Гэнэт нэг юм санаанд орж, би яах ийхийн зуургүй гурван нүүр биччихлээ. Бичсэн зүйл маань ч өөртөө таалагдаж байнаа.*

*Чалчина гэдэг нь эмэгтэйчүүдийн гэм биш зан юм. Хэмжээ хязгаартай чалчихыг би хичээнэ. Ээж маань ч над шиг л их яриа хүн. Тэгэхлээр удамшиж заяасан араншин төрхийг аргалахад бэрх гэсэн баталгаа нотолгоо гаргав. Миний ингээж тайлбарласныг үзээд Кеплер багш хөхөрч гарлаа. Дараагийн цаг дээр нь би мөн л тэссэнгүй ярьж эхэлтэл бас л "Засаршгүй чалчаа охин" гэсэн сэдвээр зохион бичлэг хийх даалгавар надад өгөх нь тэр. Түүнийг нь бас л бичиж өгчихөөд хоёр цаг хэртэй гэм зэмгүй суулаа. Тэгтэл гурав дахь цаг дээр багш маань уурлан чалчсаны шийтгэл болгож "Жир жир жир жиргэдэг үглээ бялзуухай" гэсэн нэртэй зохион бичлэг бич гэв. Ангийнхан маань нирхийтэл хөхрөлдөв. Чалчихын талаар зохион бичлэг бичих хамаг чадвар маань дууссан ч би тэднийг даган хөхрөв. Арай л шинэ арай л юм бодож олоод бичих хэрэгтэй санагдав. Ангидаа бол нэлээн гайгүй шүлэгч Занне маань тэгтэл, чадахаараа тусламз, шүлэг бич гэж зөвлөв. Би ч бүр хөөрчихөв. Тооны багш маань ч намайг өөрийнхөөрөө байлгах гэв. Би ч мөчөөгөө өгөхгүй ноён Кеплерийг хоёр гурав дахин чадах сан гэж тэсгэлгүй хүсч байлаа.*

*"Жир жир жир жиргэдэг үглээ бялзуухай" гэдэг шүлгээ ч бичив. Их амжилт шүү. Тэр маань гурван хөөрхөн дэгдээхэйгээ ганганаж гунганадаг гээд тоншоод алчихсан. эр хун, эм нугасны тухай байв. Азаар, Кеплер багш тэр егөөдлийг маань ойлгож, шүлгийг минь манай болон бусад ангиудад тайлбартайгаар уншив. Түүнээс хойш би ч багшид шийтгүүлэхээс айлгүй чалчиж, тэр бүрд Кеплер багш шог үг хэлээд л өнгөрдөг болов.*



## 1942 оны зургадугаар сарын 24. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Гадаа, бөгчим халуун гэж жигтэйхэн. Бүгд л хөлөрч, амьсгаадна. Тийм халуунд хөл дүүжилдэг л юм бүхнээр дөхмөөх байв. Цахилгаан галт тэрэг, юуны өмнө задгай тэрэг хичнээн тохитой унаа юм бэ гэдгийг анх удаагаа мэдлээ. Гэвч тэр нь еврейчүүд бидэнд олдошгүй эд болж дээ. Бид адаглаад, "Ах дүү Беенекенийхан" шиг ч байдаг бол аятай юу. Өчигдөр би бага үдэд Ян Лукеништраас дахь шүдний эмчид очив. Эмчийнх маань, хотын цэцэрлэгийн дэргэдэх манай сургуулиас хол гэдэг нь учиргүй. Үдээс хойшихи хичээл дээр ядраад бараг л унтчихсангүй. Аяга уух юм өгдөг сайхан сэтгэлт хүмүүс байдагт л тэссэн шүү. Шүдний эмчийн сувилагч бидний зовлонг ойлгож байна билээ.*

*Биднийг зөвхөн завиар явахыг л зөвшөөрчээ. Иозеф дэх израйльчуулын дүүрэгт бяцхан завь аргамжаатай байв. Завьчин ашгүй биднийг асуумагц нөгөө эрэгт хүргэхээр хөдлөв. Еврейчүүд бидний байдал муу байгаа нь Холландчуудаас болсон хэрэг биш нь мэдээж.*

*Би ч сургуульдаа явж чадахгүй болох нь ээ. Улаан өндөгний баяраар дугуйг минь хулгайлав. Аав ээжийн дугуйг танилындаа хадгалуулав. Аз болоход харин амралт долоо хоноод эхэлнэ. Юу ч гэсэн даваа ч ойртов.*

*Өчигдрийн бага үдэд сонин юм болов. Дугуйгаа тавьдаг байсан газрынхаа дэргэдүүр өнгөртөл хэн нэгэн хүн дуудав. Эргэж харвал өнгөрсөн орой нь танил Эвагийнд тааралдсан зүс таних хөөрхөн хөвгүүн зогсож байлаа. Бүрэгдүү байхын тэр банди өөрийгөө Харри Гольдберг гэж танилцуулав. Түүний яах гээд байгаа г ч мэдэхгүй гайхаж орхив. Тэгтэл төдөлгүй юмны учир тайлагдаж тэр намайг сургууль руу маань дөхүүлэх гэсэн нь мэдэгдэв. Тэгэхэд нь "Зам чинь хазайхгүй бол яахав дээ" гээд хамт явлаа. Харри аль хэдийнээ арван зургаа хүрсэн тул аливаа юмны тухай аятайхан ярьж байв. Тэр өнөө өглөө намайг дахиад л хүлээгээд зогсож байсан гээч. Энэ явдал нэлээд удаан үргэлжлэх бизээ.*

*Анне*

## 1942 оны зургадугаар сарын 30. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Үнэндээ үзэг харандаа барих ч завгүй өнөөдрийг хүргэлээ. Өнгөрөгч Пүрэв гаригийн их үдийг танилындаа өнгөрөөв. Баасан гаригт зочинтой байв. Тэгж ингэснээр л зөндөө олон хоног өнгөрчихөж. Өнгөрөгч долоо хоногт Харри бид хоёр нэлээн сайн танилцлаа. Тэр өөрийнхөө тухай их л юм яриу. Холландад суугаа хөгшичүүл дээрээ ганцаараа ирсэн гэнэ. Уг нь аав ээж хоёр нь Бельгид суудаг гэнэ.*

*Харри өнөөг хүртэл Фанни гэдэг охинтой үерхжээ. Миний танил тэр охин нь ноомой томоотой амьтдын үлгэр жишээ болсон охин л доо.*

*Харри надтай танилцсанаасаа хойш л Фаннигийн дэргэд уйдаад бараг хөшиж үхэх шахдагаа мэджээ. Товчоор хэлбэл би түүнийг хөгжсөөн цэнгээгч гэнэ. Хүн ер нь өөрийнхөө юунд арай сайн гэдгээ хэзээ ч мэддэггүй ажээ.*

*Жопи бямба гаригт над дээр ирж хонов. Бүтэн сайн өдрийн их үдийг тэр Лизийнд өнгөрөөжээ. Миний уйдсан гэж жигтэйхэн.*

*Харри уг нь манайд орой ирэх байсан юм. Тэгтэл орой нь зургаан цагт утасдаад -Харри Гольдберг ярьж байна. Аннетай ярьж болох болов уу? гэхэд нь би,*

*-Би Анне байн гэв. Түүнийг:*

*-Сайн уу, Анне? гэхэд нь би,*

*-Баярлалаа гэв. Түүнийг,*

*-Харамсалтай нь би өнөө орой удаан саатаж чадахгүй нь. Харин яримаар юм байна. Арваад минутад гараад ирж чадах уу гэхэд нь би:*

*-За за. Одооохон гэв.*

*Тэгээд яаран хувцсаа сольж үсээ самнасан болоод цонхон дээрээ тэсэж ядан зогсож байтал тэр ч ирэв. Тэгсэн мөртөө шатаар яаран уруудан гүйлгүй, түүнийг харин хонх дартал тайван хүлээсэн маань нэн гайхмаар юм шүү.*

*Намайг бууж үүдээ онгойлгомогц тэр гэрт орж ирэв.*

*-Аан гэж бай! Эмээ маань, чамайг надаас хэтэрхий дүү жаахан охин юм гээд байна. Намайг тэгээд Лүйс рүү очих хэрэгтэй гэж байна. Фаннитай үерхэхээ байсныг минь бас мэджээ гэхэд нь би,*

*-За, та нар чинь хэрэлдэж маргаа юу? гэв.*

*-Үгүй. Бүүр ондоо юм болсон гээч. Харри би Фаннид, бид хоёр таарахгүй юм байна, нэгэнт*

*тийм болохоор үерхээд ч яахав. Харин чи манайд ирж байж болно би ч танайд очиж байж болох юм гэдгээ хэлсэн. Түүнээс гадна Фанни өөр залуустай үерхээд байх шиг байгаа юм, гэхдээ энэ үгүй бололтой. Авга ах маань намайг Фаннид очиж уучлалт гуй гэсэн. Би харин тэгж гуйж чадахгүй. Хөгшчүүл заримдаа дээр үеийнхээрээ байлгах гээд байхын. Бид яаж тэдний зааснаар амьдрах юм бэ? Би ч эмээгээ сэнхрүүлж өгсөн шүү. Тэгсэн чинь овоо нааштай болж байх шиг байна лээ. Лхагва гаригт би завтай. Хөгшчүүл маань намайг дархны дугуйланд яваа гэж боддог. Тэгэхэд нь би Сионистуудын нийгэмлэгт очдог юм. Бид жинхэнэ сионистууд биш л дээ. Харин тэр тухай төсөөлөлтэй болох гэж л сонирхдог. Түүнийг сүүлдээ сонирхохоо ч больсон. Очихоо ч больж байгаа.*

*Тэгэхээр гурав дахь өдөр, хагас сайн өдрийн үдээс хойш, мөн тэр оройдоо, бас бүтэн сайн өдрийн үдээс хойш чамтай уулзаж байж болох юм. Түүнээс ч олон уулзсан болно.*

*-Харри хөгшчүүл чинь зөвшөөрөхгүй байхад нүднээс нь далдуур ингэж надтай үерхээд байж болохгүй шүү дээ!*

*"Сэтгэл гэдэг чинь хөндлөнгийн заавраар шийддэг зүйл бишээ" гэж тэр хэлэв.*

*Бид хоёр энэ тэрийг ярилцаар нэг мэдэхэд номын дэлгүүр өнгөрч булан тойров. Тэгтэл тэнд Петер Вессель хоёр өөр хөвгүүний хамт зогсож байв. Өөр хөвгүүнтэй хамт явж байгаад түүнтэй анх дайралдаж байгаа минь энэ билээ. Эмээх баярлах зэрэгцэв. Харри бид хоёр дэмий л Карри руу очоод, маргааш орой, долоон цагт таван минут дутуу байхад, тэдний үүдэнд уулзахаар болоод саллаа.*

*Анне*

### 1942 оны долдугаар сарын 3. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр Харри аав ээжтэй маань танилцах гэж манайд ирсэн. Би түүнийг цай, жигнэмэг бялуу, бусад амттанаар дайлав. Гэрт зүгээр суугаад баймааргүй санагдахаар нь салхинд гарцгаав. Наймаас арван минут өнгөрөхөд Харри намайг гэрт хүргэж өгөв. Ингэж оройтсонд аав их уурлав. Учир нь оройн наймаас хойш гадуур явах нь еврейчүүлд хориотой билээ. Уг нь наймаас яг арван минутын өмнө гэртээ ирнэ гэж ам өгсөн юм.*

*Өглөө нь би Харригийнд уригдан очив. Жопи найз маань түүнтэй намайг үргэлжид холбон шоолох болов. Мэдээж миний хувьд Харрид сүртэй ч хайр сэтгэлтэй болчихоогүй л дээ. Миний насны охин хэн нэгэн хөвгүүнтэй үерхэж болох шүү дээ. Үерхдэг хүүхдийг маань хэн ч, ээжийн хэлдгээр хайрт хархүүтэй болжээ гэж үзэж болохгүй нь мэдээж.*

*Эва нэг өдөр Харрийг тэднийхээр ороход:*

*-Фанни, Анне хоёрбын хэн нь чамд илүү таалагддаг юм бэ? гэхэд тэр:*

*-Хэн нь илүү таалагддаг нь чамд ямар хамаа байна гэсэн гэнэ. Тэд тэгээд л тэр тухай дахин юу ч ярилцсангүй. Гэтэл Харри явахдаа:*

*-Мэдээж. Анне л байж таарна шүү дээ. Харин чи энэ тухай ам ангайв аа гээд гарчээ.*

*Би Харригийн надад сайн болсныг мэдэж байв. Тэр нь хичнээн таатай санагддаг гээч. Маргот эгч ч гэсэн түүнийг лав сайн хөвгүүн гэх байх. Тийм л юм шиг санагддаг юм. Ээж ч бас түүнийг хүмүүжилтэй, хөөрхнөөс хөөрхөн хөвгүүн байна билээ гэж магтсан. Манайхан Харриг тийм таатай хүлээж авсанд баярлах юм. Түүнд ч бас л аятайхан байгаа байх. Найз охин маань, түүнийг хүүхдэрхүү гэдэг. Хүүхэд л юм чинь хүүхдэрхүү байх юу нь буруу юм бэ?*

**Анне**

*Хайрт Китти минь!*

*Хүсээж мөрөөдөн байсан анги дэвших баяр маань баасан гаригт болов. Миний гэрчилгээ ч гайгүй л дүнтэй байна. Алгебр дээр л тав бусад хичээлүүдийн хоёрт нь зургаа, ихэнхд нь долоо, хоёр хичээлд наймын дүнтэй байв. Гэрийнхэн маань ч дүнг минь ихэд таалав. Аав ээж маань ч ийм юманд бусад хүүхдүүдийн аав ээж нараас өөр ханддаг улс. Тэд гэрчилгээний сайн муу гэсэн дүнг голчилдоггүй, харин "дүн нуруу нь зөв, эрүүл, цовоо байх нь л гол хэрэг" гэдэг хүмүүс. Тэр хоёр хэрэг явдал бүтэх л чигтэй бол бусад нь өөрөөс нь болно гэж үздэг юм. Би, ээж аавыгаа тэгэх тусам нь үнэхээр сайн сурахсан гэж хичээдэг юм. Намайг, Монтессори дахь сургуулийн ахлах ангид суугаагүй гэж энэхүү Лицей сургуульд ороход хэл амтай авсан юм. Харин еврей хүүхдүүдийг зөвхөн еврейчүүдийн сургуульд сургах болсноос, манай захирал Лиз бид хоёрыг их хэл яриа, ам өчигтэй оруулсан юм. Би ч захирлыг нэг их эвгүй байдалд оруулчихгүй юмсан гэж мэрийсэн.*

*Маргот эгч ч гэрчилгээгээ авчээ. Бас ч гайхамшигтай сайн сурчээ. Гойд сайн дүнтэй бол анги дэвших нь илэрхий бус уу. Ухаантай толгой!*

*Ажлаа хийж болохгүй болсноос хойш аав гэртээ суух болов. Өөрий нь гэнэт, хэнд ч хэрэггүй амьтан шиг болгосон нь аавд тун зовиуртай байгаа аж. Коофуйс гуай "трест"-ийг удирдах болжээ. Уг нь Кралер гуай аав шиг, Колений худалдааны нэгдэлд хувь нийлүүлсэн юмсанжээ.*

*Хэд хоногийн өмнө салхинд гарахад аав маань фашистуудаас нуугдан "бүгэх" тухай надад ярив. Хүний ертөнцөөс таслагдан нэг газар хоргодож амьдрах нь бидэнд хэцүү дээ гэв.*

*-Яагаад тэр тухай ярина вэ гэхэд аав,*

*-Ноднингоос эхлэн хувцас хунар, гэрийн тавилга, хүнс тэжээлийг айл руу зөөж байгааг минь чи мэднэ. Бид жаахан юмаа германчуудын идэш болгон алдахыг хүсэхгүй байна. Идэш болголоо гэхэд аль болох жаахныг нь алдах хэрэгтэй. Бид одоо амиа бодож нуугдах болно. Хэзээ биднийг ирээд ачихыг нь хүлээж суух аргагүй гэлээ.*

*Аавыг тэгж ярихад нь би цочиж балмагдан,*

*-Тийм үү, хэдийд вэ, аав аа? гэвэл тэр "Охин минь, бүү ай. Чамд үүнийг эртхэн сонсгох гэсэн юм. Эрх дураахаа амьдралын сайхныг чадахын хэрээр амтал" гэв. Ааваас би ийм үг дуулав. Ээ та минь, тэр нуугдан бүгэх өдөр холхон л байгаасай!*

**Анне**

## 1942 оны долдугаар сарын 9. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Тийнхүү хар усан борооноор аав, ээж бид хэд ниг дүүрэн цүнх, ууттай юм барьцаан гэрээсээ оргон явав. Ажилдаа эртлэн гардаг ажилчид, биднийг өрөвдөн ажиглана. Еврейчүүд бид ингээж автобусанд ч сууж ч болохгүй, машин ч унаж болохгүй, ачаа бараагаа барин явган нүцгэн гүйлдэх болсныг тэр хүмүүс өрөвдөж байгаа нь хараажсаар мэдэгдэнэ. Бидний энгэртээ зүүцгээсэн зургаан хошуу шар тэмдэг хэн болохыг маань илтгэнэ. Аав ээж хоёр замынхаа тури хэрхэн нуугдаж бүгэхээ ширхэгчлэн тайлбарлав. Манайх бараг сарын өмнөөс хувцас хунар, гэр ахуйн зарим зүйлээ тэнд аваачин бэлэн, айхгүйгээр болгожээ. Уг нь тэртэй тэргүй долдугаар сарын арванзургаан нуугдаж бүгэх гэж байжээ. Гэтэл өнөөдрийн дуудлагаас болж ингээд арав хоногийн өмнө нуугдахад хүрчээ. Бүгэх өрөө тасалгаагаа тохижуулж амжаагүй байсан боловч засваргүйгээр болгохоос өөр аргагүйд хүрэв. Бидний нуугдах газар маань аавын нүүсийн байр байлаа. Гаднаасаа бол итгэхийн аргагүй юм байв. Тийм болохоор нүүсэндээ цөөн хүн авч ажиллуулсан ажээ. Өгүүлбэл: Кралер гуай, Коофуйс гуай, Мийн эгч, Элли Воссен гэдэг хорин гурван настай бичээч эмэгтэй энэ хэд юм. Тэд бидний ирнэ гэдгийг бүгд мэдэж байжээ. Зөвхөн Эллигийн эцэг, дэлгүүрийн худалдагч ноён Воссен, хоёр цэвэрлэгч л мэдээгүй аж.*

*Пүүс нь доод давхартаа том гэгчийн агуулахтай тэндээс нь бараа тээвэрлэдэг бөгөөд түүн рүү орох үүдний хажууд нүүс рүү гаднаас орох хаалга оршино. Түүгээр ормогцоо богино шатаар дээшээ өгсвөл цайвар шилэн дээр бичээстэй "КОНТОР" гэсэн том хар хаягтай хаалга тулгарна. Сайхь контор нь цэлгэр, маш гэрэл гэгээтэй ажээ. Өдөр нь тэнд Мийн, Элли, Коофуйс гуай нар ажиллана. Тэндээс, өлгүүрүүд том шүүгээ, мөнгөний том авдар байх өрөөг дамжин цаашилбал урьд нь Даан гуайтай сууж ажиллаж байсан Кралер гуайн зэгсэн харанхуй том өрөө байна. Энэ өрөө нь гаднаасаа онгойдоггүй зөвхөн дотроосоо онгойх, гудмаас шууд орох шилэн хаалгатай бөлгөө. Кралер гуайн контороос дөрвөн гишгүүртэй шатаар өгсвөл энэ нүүсний ганц дөнгүүр өрөө нь гэгдэх эзний хувийн тансаг албан тасалгаанд орно.*

*Зөөлөвч хулдаас бүхий шалан дээр өвч хивс дэвсэж, хүрэн сум модон тавилга, сондор цацагтай гоёмсог дэнлүү, радио тавьж тохижуулсан үнэхээр тансаг өрөө ажээ. Тэрхүү өрөөний зэргэлдээ халуун усны том ган, шатдаг хийн хоёр ч тулга бүхий асар том гал зуух цаашилбал 00-ийн өрөө гээд бүгд байна. Хоёрдугаар давхар нь гэвэл ийм. Тэндээсээ модон шатаар өгсөж гудам бүхий бяцхан чөлөөнд гарвал баруун зүүнтээ нь хаалганууд харагдана. Үүнтэйгээр нь орвол доод, дээд давхрын агуулах руу шууд дамждаг гол агуулах, дээврийн агуулах руу очно.*

*Мөн нүүсний барилга нь нөгөө талдаа гудамжнаасаа шууд орох нэлээд урт, налуу жинхэнэ Холланд хийцний эгч шаттай ажээ.*

*Баруун талын нь хаалгаар орвол "арын нуувч" руу очно. Хэнд ч тоогдомгүй саарал будагтай энэ хаалганы цаана, хэн хүнд анзаарагдамгүй маш олон өрөө байна. Ганцхан гишгүүртэй тэр хаалгаар ормогц л шат харагдана. Шатнаасаа зүүн тийшээ эргэвэл Франкийнхны буюу*



*аав ээжийн унтлага, зочдын жижиг өрөө, мөн цаахан нь тэдний хоёр охин буюу Маргот бид хоёрын ажил, унтлагын өрөө, шатны баруун талд нь цонхгүй угаалгийн тэвш бүхий бие засах газар байна. Хажуу хаалгаар нь Маргот бид хоёрын унтлагын өрөө рүү орж болно.*

*Шатаар өгсөж хаалга татвал тэрхүү арын нуувчинд баймгүй гайхмаар уудам, саруул тохитой тасалгаа байна. Өмнө нь пүүсний лаборатори байсан энэ өрөөнд шатдаг хийн зуух, сав суулга угаах тэвш тэргүүтэн харагдана. Энэ нь одоо Даан гуайнхны унтлагын болон гал тогоо, зоогийн өрөө юм. Дэргэдэх дамждаг бяцхан өрөөнд Дааны Петер гэдэг хөвгүүн ганцаар суух болсноор манайханд хамгийн эрх дураараа байх хүн болжээ. Нуувчинд жинхэнэ пүүс шигээ агуулах, дээврийн агуулахтай гээч. За ойлгов уу чи минь. Нуувчаа чамд бүхэлд нь танилцуулчихлаа шүү дээ би.*

*Анне*

## 1942 оны долдугаар сарын 10. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Сууцныхаа тухай их нуришиж чамайгаа баахан залхаачихвуудаа. Ямар ч гэсэн минийхээ хаана ирж хоргодоод байгааг дотны чи минь мэдэх хэрэгтэй биз дээ! За, яриагаа бас л үргэлжлүүлэх нь байна. Биднийг аавын нүүс орших, хотын Принзенграхт дүүрэгт ирмэгц Мийн эгч ум хумгүй дээш дагуулан нуувч руу оруулав. Түүнийг хаалга цоожлоод явахад ингээд л арайхийж нэг германчуудаас нуугдлаа гэдгээ мэдэрч билээ. Маргот дугуйгаар явсан болохоор аль эрт ирчихээд хүлээж байв. Бидний сууц, энэ тэр өрөөнүүд нь эхлээд надад яг л новины агуулах шиг харагдсан гээч. Бичмээр юм биш! Хэдэн сарын өмнөөс нүүс рүү зөөсөн бүх л хайрцаг, чемодантай юмс шалаар нэг ундуй сундуй хэвтэнэ. Нэгэн жижиг өрөөг таазанд нь тултал ор, ор дэрний хэрэглэлээр дүүргэсэн байв. Орой нь жинхэнэ сайхан зассан орон дээр унтах гэвэл энэ юмнаас зөөж янзлах хэрэгтэй.*

*Ээж, Маргот хоёр гар хуруугаа ч хөдөлгөж чадахааргүй болтол ядарчээ. Тэд гудас дэвсээд л хэвтээд өглөө. Өрх гэрээ "эмхэлж цэгцэлдгээрээ" аав бид хоёр л хамаг юмаа янзалж эхлэв. Бид хоёр задлахыг нь задалж, зайчилж, гөвж, шүүрдсээр үдэш болоход зассан орон дээрээ үхлүүт юм шиг л унав. Манайхан тэр өдөр халуун хоол огт хэлэн дээрээ тавьсангүй. Юун идэх уух манатай. Ээж, Маргот хоёр юм идэх сэн гэж уурлана. Яана гэх вэ, аав бид хоёр ямар завтай байсан биш. Хурааж засах ажил бас л мягмар гаригийн өглөө үргэлжлэв, Элли, Мийн бидний хүнсний картаар идэх уух юм авчирлаа. Аав, гэрэл гэгээ тусах онгорхой цоорхойг бөглөн, гал тогоооны өрөөний гэгээвчинд банз хадав. Бүгд л өглөөнөөс үдшийн бүрий болтол гар хумхисангүй. Амьдралд маань тохиолдсон энэ өөрчлөлтийн тухай бодох зав надад үнэндээ лхагва гариг хүртэл олдсонгүй. Юу болсныг, цаашид юу болохыг чамдаа хүүрнэх, өөрөө тунгаан бодох зав зай нуувчинд ирснээс хойш дөнгөж одоо л олдож байна даа*

*Анне*

## 1942 оны долдугаар сарын 11. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Арвантаван минут тутамд хангинах Вестертурмийн хонхны дуунд аав, ээж, Маргот гурав ч хараахан дасаж чадахгүй л байна. Миний хувьд харин ч таатай л байна. Ялангуяа шөнө бол бүүр ч аятайхан гээч. Нуувч маань надад хэр санагдаж буйг чи минь мэдэхсэн гэж байгаа болов уу гэж бодох юм. Үнэнээ хэлэхэд, би өөрөө ч юу гэхээ мэдэхгүй байна. Ямар ч гэсэн гэртээ байгаа юм шиг тохилог санагдахгүй байна. Гэхдээ тарчилж шаналж, сэтгэл зовиуртай байна гэвэл худлаа. Энэ нь надад заримдаа ер бусын асрамж тэтгэмжийн газар очсон юм шиг санагдана. Энэ маань ёстой л жинхэнэ нуувч, өөрөө хэлбэл хоргодох байр л даа. Үл ялмг мурий, ташуу, чийгтэй болохоос биш, үнэндээ Амстердамд олдохгүй тохитой, дэгсдүүлж ярьдаг хүнд бол Холландад ч ховор байр сууц гэсэн ч болно.*

*Манай өрөө одоохондоо хана туургандаа хадсан наасан юмгүй нүцгэн цулгүй л байна. Аз болоход аав маань кино жүжигчид, гадаад орнуудын зургууд бүхий ил захидлын цуглуулгыг маань орхичихсонгүй аваад гарсан байлаа. Би захидлуудаа баахан нааж чимэглэж санаа амрав. Өрөө маань одоо нэлээд аятайхан, арай л хөгжсөөнтэй байж болмоор болсон. Даан гуайнхныг ирэхээр хураалттай байгаа модоор хананы шүүгээ, энэ тэр хэрэгтэй юм хийцгээнэ дээ.*

*Ээж, Маргот хоёрын бие нэлээд засрав. Ээж маань өчигдөр л анх удаагаа хоол хийв. Вандуйны шөл шүү. Ээж л болсон хойно гал дээр шөл тавьснаа мартаж дэмий ярьсаар байгаад өнөөхөө түлчихжээ. Вандуйнууд нь тогооноосоо салахгүй хар нүүрс болсон байв. Харамсалтай нь би, энэ явдлыг Кеплер багшдаа ярьж чадахгүй нь ... Яагаав намайг хичээл дээр их ярилаа гээд "Чалчаа охин", "Засаршгүй чалчаа охин" гээд баахан зохион бичлэг хийлгэдэг багшийг санаж байна уу?*

*Ёстой чалчаа зан ээжээс охинд удамишина гэж энэ биз дээ.*

*Өчигдөр орой бид дөрөв английн нэвтрүүлэг сонсохоор эзний гэгдэгч аавын хуучин албан өрөөнд оров. Айл хөршийнхнөөс хэн нэг нь сэжиг авчих бий гэж үнхэлцгээ хагартал айхдаа аавыг дэмий л нуувч руугаа очъё гэж гуйв. Ээж маань миний айж байгааг мэдээд хамт явав. Бид санаандгүй анир чимээ гаргаж, элдэв хүн амьтанд үзэгдэж харагдчих бий гэж болгоомжлох гэж жигтэйхэн. Ирсэн өдрөө л хөшиг оёв. Тэр нь хөшиг ч гэж дээ, аав бид хоёрын эвлүүлж зүйсэн янз бүрийн хэлбэртэй олон өнгийн даавууны өөдөс байв. Тэр инээдтэй эрээн мяраан хөшгөө үргэлжид дүүжлээстэй байхаар цонхны дээд хүрээнд нь товруутай хадаасаар сайн хадаж бэхлэв.*

*Бидний энэ бүгэн буй бяцхан нүүсний баруунтай нь асар том худалдааны контор, зүүнтэй нь мебелийн том үйлдвэр байдаг. Ажил тармагц л тэр газрууд эзгүйрч хүн амьтангүй болдог ч хаа нэгтээ чимээ авахыг байг гэх газаргүй. Тиймээс ч, салхинд цохиулсан Марготыг бид шөнө ханиаж хахаж цацахыг нь хүртэл хориглов... Хөөрхий амьтан ханиахгүйн тулд зогсоо зайгүй л кодейн хүлхэх болов.*

*Даан гуайнхныг мягмар гаригт нүүж ирэхийг сонсоод бид их баярлав. Тэгэх юм бол нуувч*

*маань улам тохижиж хөл хөдөлгөөнтэй болох байх. Би л болсон хойно, уйтгартай нам гүмд уурсан бухимдах болов. Тэр тусмаа шөнө орой бүүр ч дэндүү дээ дэндүү. Манийг өмгөөлж хамгаалагчдын хэн нэг нь ч атугай энд бидэнтэй хамт хонодог болоосой гэж хүсэх боллоо. Ганц ч удаа болсон гадаа гарч болохгүйгээс болоод уйдаж үхэх нээ. Бас тэгээд германчуудад санамсаргүй харагдаад буудуулчих бий гэж үргэлж айхыг яана. Нэг бодоход биднийг аймшигтай хүнд юм няц дарчих гээд байгаа юм шиг санагдана. Өдөр ч тэр, чимээ аниргүй байх болов. Доорхи агуулахад орж гарах хүмүүс бидний чимээг сонсчих бий гэж үргэлж л гэтэж шивнэцгээнэ. За намайг дуудах шиг болов, болихоос.*

*Анне*

## 1942 оны наймдугаар сарын 14. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би бүтэн сар чамайгаа хайхарсангүй. Учир нь өдөр бүр сонин гойд юм тохиолдоно гэж үгүй шүү дээ. Долдугаар сарын арвангурванд Даан гуайнхан нуугдахаар ирсэн. Хэлэлцэж тохиролцсоноор бол тэд арвандөрвөнд ирэх байжээ. Германчууд еврейчүүдийг дуудах нь улам ихсэж үймсэн өдрүүдэд тэд нар хожимдсоноос өрсөн нь дээр гэж хаширлаад наашаа хүрээд иржээ. Өглөө нь ес хагаст манайхныг цайгаа ууж суухад, Даан гуайн Петер гэгч, миний сэтгэлд даанч нийцдэггүй хэтэрхий бүрэг ноомой зантай арванзургаан насны хөвгүүн орж ирэв. Хагас цагийн дараа Даан гуай, бүрх малгайны цаасан хайрцганд хөтөвчөө хийж, инээдтэй нь аргагүй яваа гэргийнхээ хамт орж ирэв. Даан гуайн авгай:*

*-Би хөтөвчгүй бол хол явахгүй хүн гээд түүнийгээ орон доогуур хийв. Даан гуай харин авгай шигээ хөтөвч бус цайны эвхдэг явган ширээ сугавчилсан байв. Эхний өдөр ч таатай л байв. Гурав хоносноос хойш манайх чинь ийм олуулаа билүү гэж санагдах болов. Мэдээж, Даан гуайнхан сүүлийн долоо хоног хүмүүсийн дунд байсан болохоор, ихийг үзсэн, ярих юм ихтэй байв. Бид ч орон гэрээ, бас манайд өрөө хөлслөгч Гүүдсмит ясныг сонирхов.*

*Даан гуайн ярих нь:*

*-Даваа гаригийн өглөө есөн цагт Гүүдсмит, намайг хурдхан шиг ирнэ үү гэж утасддаг юм байна. Очвол тэр (муужгайг айлд тавьчихаарай гэсэн) та нарын зурвасыг үзүүлэв. Гүүдсмит гэр орныг тань германууд нэгжинэ гэж их айсан бололтой байв. Гэтэл Мааширихт гэсэн хаягтай нэг Франкийн бичгийн ширээн дээрх хуанли дээр байгааг олов. Салан задгайгаасаа болсон юм шиг зориудаар орхисныг мэдмэгцээ би ихэд айж цочсон байдалтайгаар тэрхүү золгүй тэмдэглэлийг түргэхэн шиг шатаагаач гэж Гүүдсмитийг гуйв. Та нарыг оргож дүрвээд хаачих ч билээ дээ гэж гайхаж цөхсөн шинжтэй ажиггүй сууж байснаа гэнэт нэгийг санасан мэт, Гүүдсмит гуай, одоо л би өнөөх хаягийн чинь учрыг олов. Бараг зургаан сарын өмнө нэг өдөр энэ Франкийн тань багын түни, том тушаалын нэгэн герман офицер нүүсэнд нь ирсэн юм. Тэр нь энд хэцүү хүнд болбол тусална гэсэн гэдэг. Мааширихтэд суудаг тэр офицер нь хэлсэндээ хүрч, Франк гуайнхан эхлээд Бельги рүү, тэндээсээ Швейцар руу дүрвэж дээ. Франк гуайн сайн нөхөд танаас асуувал та тэр тухай дурсаж болох байх. Харин гуйхад Мааширихт гэдгийг битгий дурсаж үзээрэй гээд гарсан даа. Ихэнх хүмүүс танайхыг нуугдсаныг гадарлаж байгаа байх. Гэвч янз янзаар ярих юм.*

*Нэг айл биднийг өглөө эрт бүгд дугуйтай хөдлөхийг харсан байхад бас нэг авгай шөнө дөлөөр цэргийн машин ирээд биднийг ачаад явахыг нүдээрээ харсан гэнэ. Хүмүүсийн тийн элдвийг зохион цуурхах нь хөгжилтэй санагдсан тул бид элгээ хөштөл инээлдэцгээв.*

*Анне*

## 1942 оны наймдугаар сарын 21. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Бидний бүгж байгаа энэ байр маань ёстой жинхэнэ нуувч болжээ. Кралер гуай унадаг дугуйн нэгжлэг ихсэж байгаагаас нуувч руу ордог хаалгыг арай л өөр харагдахаар болгомоор байна гэв. Боддог л бодол. Нуувч руу ордог хаалгыг эргэдэг тавиур болгож өөрчлөхийг Воссен санаачилсан юм. Мэдээж, тэрээр нууцыг хадгалж, туслахад бэлнээ илтгэх гэжээ. Бид доош буух бүрдээ одоо байнга бөхийж, дараа нь гишгүүргүйгээс харайх болов. Түүнээс хойш гурав хоноход намхан хаалганы тотгыг анзааралгүй мөргөцгөөж бүгд л булдруутсан духтай болов. Ашгүй хаалганы тотгонд мяндаслаг зөөлөвч хадав. Хэрэг болох эсэхийг үзэж дээ!*

*Би нэг их ном уншихаа болиод байна. Мэдээжийн юмсыг ч мартаж эхлэв. Сонин юм, манай энэ нуувчинд ямар нэг их болоод байх биш. Даан гуай бид хоёр л заримдаа ам мурийх болов. Түүний хувьд маргот эгч надаас хөөрхөн ааштай санагддаг нь мэдээж. Ядаж байхад ээж намайг заримдаа яг нялх хүүхэд шиг бодох юм. Түүнийг нь би тэвчиж чадахгүй нь. Петер ч мөн ааш зан муутай болов. Тэр хөвгүүн бүх л өдөржингөө ор дэрэн дээрээ хөрвөөн хааяа нэг мод чулуугаар оролдсоноо, төдөлгүй тонголзон нойрмоглоно. Ёстой л нэг нойрны тулам юм аа! Юун халуун бүгчим байх юм бэ. Бид дэмий л дэлгэмэл сандал дээр хөрвөөлдөнө.*

*Анне*

## 1942 оны есдүгээр сарын 2. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Даан гуай авгайтайгаа аймар хэрэлдэв. Би урьд нь айлын авгай, нөхөр хоёрын тиймэрхүү хэрүүлтэй нэг ч дайралдаж яваагүй. Манай аав, ээж хоёр хэзээ ч тэгэж хашгичиж орь дуу болж хэрэлдэж чадхааргүй улс. Уг нь тийм ч үг зөрж хэрүүл шуугиан тарихаар юм болоогүй юм л даа. Харин өөрсдийнх нь ааш араншин л ийм юм байлгүй дээ. Хэнийх нь ч талд орж болохгүй. Петерт л хэцүү байдаг байх, гэтэл төрөлхийн нунж дорой зантай мань эр яагаад байгаа нь ч мэдэгдэхгүй л өнгөрлөө. Гагцхүү өчигдөр хэлээ хөхөрснийг мэдмэгцээ л маш их сандрав. Тэр нь харин удалгүй зүгээр болов. Хүзүү хоолойгоо зузаан алчуураар ороосон Петерийн зүрх, уушиг, бөөр гээд өвдөхгүй эрхтэн үгүй гэнэ. Ёстой нэг янгууч амьтан юм гээч.*

*Даан гуайн авгай, ээж хоёр бас хоорондоо тийм ч эвтэй биш байх болов. Муудалцах шалтаг ч мундахгүй юм. Жишээлэхэд л нийтийн ариун цэврийн шүүгээнд нүүр гарын гурван алчуур өлгөчихөөд биеэ арчих болоход манайхны алчуурыг хэрэглээд монжисж гарна. Тэгэхээр нь хариугаа авах гээд өөрсдийнхийг нь аваад арчих юм бол дургүйцээд бөөн юм болох нь тэр. Мөн Даан гуайн авгай, өөрсдийнхөө аяга тавганд ууж идэхгүй манайхыг л хэрэглэх юм гэж ээжид бухимдана. Манай аяга таваг юм юмны цаанаас авхын аргагүй далд орчихсон гэдгийг мэдэлгүй, өдий болтол өөрийнхөө аяга тавгийг гаргаж хэрэглэсэнгүй гэж хатагтай Даан уурладаг бололтой.*

*Манай аяга таваг энэ нуувчаас гарахаас нааш хэзээ ч авч болохооргүйгээр, агуулахад байгаа бүх л зарлал, чимэглэлийн цаана санаандгүй орчихсон ажээ. Би ч бүтэлгүйтэж дуусахгүй ээ. Өчигдөр санамсаргүй шөлний тавгийг нь унагачихав. Тэгтэл Даан хатагтай “Хөөш, гар хөл чинь яачихсан юм бэ? Цорын ганц юмыг минь” хэмээн уурсан хашгирав. Даан гуай харин надтай өнгөн дээрээ сайн байх гэж хичээгээд байдаг юм.*

*Өнөө өглөө дахиад л ээжийн ааш хөдөлчихжээ. Би гэдэг хүн аашлуулахгүй явж ч чадахгүй юм. Ер нь хүн хүний бодол өөр өөр шүү дээ. Аав бол таван минут уурлалаа ч гэсэн намайг ойлгоод байдаг.*

*Өнгөрсөн долоо хоногт бас нэг эвгүй юм болов. Эмэгтэйчүүдийн тухай ном... Петерээс болоод тэр л дээ. Номын сангаас ноён Коофуйсын авчирдаг бүх номыг Маргот, Петер хоёрт уншихыг зөвшөөрснийг чи ямар мэдэхгүй биш. Харин энэ номыг томчууд тэр хоёрт ч өгсөнгүй.*

*Тэгэх тусам нь Петер түүнийг нь унших гэж хорхойтон, юу бичсэнийг нь сонирхох гэж ээжийгээ доор байхад нь нууцаар аваад дээвэрт гарчээ. Тэгээд номоо тэврээд тэндээ хоёр ч хоночихжээ. Ээж нь энэ тухай мэдсэнээ биднээс тас нуужээ. Харин Даан гуай үүнийг мэдчихээд ихэд уурлан Петерээс тэр номыг нь хурааж аваад болчихлоо гэж боджээ. Даан гуай хүүгийнхээ шохоорхлыг ер юман чинээ санасангүй. Харин уншиж дуусаагүй номыг нь аав нь хурааж авсан нь Петерт дэндүү шударга бус санагдсан нь мэдээж.*

*Дараа нь Даан хатагтай ээжид:*

*-Бусад номыг ч хориод яахав. Харин тэр номыг Марготод ч уншуулаад хэрэггүй шүү гэхэд ээж,*

*-Даан хатагтай танай манай хоёр хүүхэд шал өөр өөр шүү дээ. Нэгдүгээрт охидууд хөвгүүдээс арай түргэн бойжилттой байдаг, хоёрдугаарт Маргот нэлээн ухаан суусан хэрсүү чамбай, их юм уншсан охин, гуравдугаарт охин маань хэр барагтай юмыг шүүж тунгаах чадвартай, гимнази бараг дүүргэсэн хүн гэжээ. Даан авгай тэгэхэд наанаа үгийг нь хүлээж аваад байгаа мөртлөө, харин насанд хүрэгчдийн номыг хөвгүүд, охидод уншуулахын хэрэггүй хэмээн зүтгэсээр байв.*

*Петер өнөөх л номоо хэдийд аваад уншихья даа гэж тохиромжтой цагийг хүлээж байжээ. Тэгээд л биднийг орой бүгдээрээ радио сонсохоор аавын хуучин албан тасалгаанд ороход тэр нөгөө нууц судар шиг номоо аваад дээвэрт гарчээ. Ес хагас гэхэд доош бууж ирэх ёстой хүн чинь номынхоо амтанд ороод аавыгаа радио сонсоод яг өрөөндөө ирэхэд нь бууж ирж яваад дайралджээ. Тэгээд юу болсон гээч. Чи ч бараг төсөөлөхгүй бизээ... Тасхийтэл алгадах чимээ гарч аав нь түүнийг хүчтэй түлхэхэд өнөөх ном нь ширээн дээр үсэрч, Петер өрөөний булан руу үсрээд өгчээ. Даан гуай оройн хоолонд авгайтайгаа хоёулхнаа орж ирэв. Петер дээр үлджээ. Хэн ч түүнийг хүүе хаая гэсэнгүй болохоор Петер хоол унд ч үгүй унтахад хүрчээ. Бид ч өдрийнхөө тогтсон хуваарийн дагуу оройн хоолоо идэж суув. Тэгтэл гэнэт... чих дөжиртөл шүгэлдэх нь сонсдов. Цаас шиг цайсан бид өөд өөдөөсөө харцгаан барьж суусан хутга сэрээгээ алдав. Гэтэл Петерийн “Та нар намайг оройн хоол иднэ гэж бүү сана!” гэсэн дуу чихэнд хадахад, Даан гуайн царай час улаан, “За, алийн болгон тэсэх вэ!” гээд үсрэн босов.*

*Аав тэгэхэд муу юм болж мэднэ гэж түүний гараас бариад хамтдаа дээш гарав. Жаал дуу шуугиан болсны дараа Петерийг өрөөнд нь оруулж, үүдий нь түгжжээ. Хөөрхий эх нь хүүдээ хиамтай талх өгөх гэтэл эцэг нь “Петерийг хэрэв одоохон уучлалт гуйхгүй юм бол, байшингийн дээвэрт хонуулах минь!” гэж тас хорив.*

*Бид тэгэхэд, хоолгүй хонуулдгаараа л хонуулъя, салхинд цохиулаад хатгалгаа авчихвал эмч домч авчирч чадахгүй шүү дээ гэж ам амандаа өгүүлэлдэв.*

*Петер уучлалт ч гуйсангүй. Эцгийнхээ хэлснээр байшингийн дээвэрт гарав. Даан гуай авч хэлэлцсэн ч үгүй. Петер өрөөндөө орж унтчихаад өглөө нь долоон цагт дээвэрт гарсныг аав нь мэдсэн бөгөөд баахан загнуулсны эцэст бууж ирэв.*

*Петер гурав хоног хэртэй дүнсгэр явснаа эргээд хэвэндээ орлоо.*

*Анне*



## 1942 оны есдүгээр сарын 21. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр би чамдаа өнгөрсөн өдрүүдийн аар саархан явдлаас сонирхуулъя. Даан гуайн авгай үнэхээр тэсэхэд бэрх хүн юмсанж.*

*Би ч урт хэлнээсээ болж загнуулж ханахгүй юм. Гэтэл Даан хатагтай болж өгвөл бидэнтэй ам муруйж, муудалцаад авах юмсан гэсэн шиг л байх юм. Одоо бүр сав суулгаа ч угаахаа больсон. За эсвэл сав суулгаа угаасан ч тогоонд жаахан хоолны үлдэгдэл байх юм бол, жишээ нь, бидэн шиг таваг саванд юүлээд тавьчихгүй тэнд нь гашилгах буюу хатаачихна.*

*Тэгээд л Марготын маань угаах арчих хоёр дахин нэмэгдэнэ. Хурдлахгүй бол болохгүй шүү Маргот минь гэсэн үг дуулдана. Аав бид хоёр ч мундахгүй нарийн ажилтай болсон. Бид аавынхаа удам судрыг нарийвчлан тогтоож, төрөл төрөгсөд, хамаатан садныхаа тухай нэгд нэгэнгүй ярилцана. Тэгэх бүрд би, асар том нэгэн овогтой холбоотойгоо мэдэх боллоо.*

*Коофуйс гуай номын сангаас хоёр долоо хоног тутамд охидын унших ном авчирна. Жоор-тер-Неул-ийн цувралууд үнэн гайхалтай. Ер нь Марксвеллийн Циссугийн бичсэн бүхэн цөм сайхан юм. "Зуны баяр" гэдэг номыг нь дөрөв дахин уншив. Инээдэмт явдлууд нь элэг хөшөөчихдөг юм. Бид дахиад л хичээллэж эхлэв. Өдөр бүр өвөрмөц таван үйл үг ялгална. Франц хэлээ уйгагүй оролдоно. Петер ч англи хэлнийхээ даалгаврыг хийх гэж шуухитнан сууна. Бид шинэ ном сурахуудтай болсон. Харандаа, дэвтэр, баллуур тэргүүтнийг дүрвэхдээ авчирсан тул энэ талаар санаа зоволтгүй. Би "Орентя" нэвтрүүлгийг үе үе сонсдог. Саявтархан Холландын хан хүү Бернхард үг хэлэв. Хатан нь дахиад л нэгдүгээр сард төрөх гэнэ. Хэн хүнгүй л намайг ийнхүү Холландын хааны удмынхны тухай мэдээг сонсох дуртайг гайхдаг юм.*

*Хэд хоногийн өмнө бид их юм сурах хэрэгтэйн тухай жаал шуугив. Тэгээд ч тэр үү би өмнөхөөсөө хоёр дахин их суух болов. Хожим дахиад л эхнээс нь эхлэхийг хүсэхгүй байна. Сүүлийн үед намайг хэрэггүй юм их уншиж байна гэсэн яриа гарав. Ээж намайг "Хаад, барон, албат"-ыг хэтэрхий их уншиж байна гээд ухаантай авьяастай эгч шигээ байхын тулд илүү юм унших хэрэггүй гэв.*

*Бас сониноос, манайхан миний ерөөс төсөөлдөггүй гүн ухаан, сэтгэл зүй, физиологийн тухай ярилцлаа. (Анх удаа би ийм нэр томъёог сонсов). Ирэх жил гэхэд тэндээс нь ямар ч байсан жаахан юм мэдсэн байх вий! Хүүгээ хувцасны тухайд онцгүй байна аа. Би энд ханцуйтай ганц палааж, ханцүйгүй гурван хантаазтай бүхэл бүтэн өвлийг барна гэхээс айдас хүрээд байнаа. Аав харин дан хонины ноосоор ханцуйтай ганц цамц нэхэхийг зөвшөөрсөн. Дан хонины ноос гоё ч биш л дээ. Харин дулаан л байвал болох нь тэр. Манайх хувцах хунараа бүгдийг нь айлуудад тавьчихсан. Хэрэв юм үлдвэл дайны дараа л байх даа. Санаснаас хатагтай Даан өөрсдийг нь муулаад бичиж байхад ороод ирлээ. Би ч шалавхан дэвтрээ хаагаад авсан. Түүнийг,*

*-За, Анне, уншиж болох уу? гэхэд нь:*

*-Болохгүй, Даан эзэгтэй! гэв.*

*-Хамгийн сүүлчийнх нь мөрийг ч гэсэн үзэж болохгүй юу?*

*-Үгүй, болохгүй.*

*Миний айсан сандарсан гэдэг тоймгүй. Яг тэр хуудсан дээр Даан эзэгтэй унших юм бол яагаад ч уучлахгүй юм байлаа.*

*Анне*

## 1942 оны есдүгээр сарын 25. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр би жаал ярьж хөөрдөг юм билүү гэж Даан гуайн хэсэгт “айлчлав”. Их л элгэсэг байцгаалаа. Намайг хэт навталиндсан хувцасны шүүгээн дээрх савтай “Цагаан эрвээхэй” жигнэмэг, хийжүүлсэн ундаагаар дайлав.*

*Бид Петерийн тухай ярилцлаа. Би ч Петер намайг үе үе өдөж хоргоодог тухай, бас иймэрхий хэтэрхий даварчихсан хөвгүүдэд ер нь дургүйгээ ярив. Тэгэнгүүт нөгөө хоёр чинь харин ихэнх эцэг эхчүүлийн адил “Хүү минь чамд сайн юм байна, охин минь чи манай хүүтэй үерхэх үү” гэх зэргээр гэж шалгааж гардаг юм байна. Би хэдийгээр “үерхсэн ч яадаг юм бэ” гэж бодсон ч “Өө, үгүй, үгүй” л гэлээ. Петер уг нь охидын аяыг олдоггүй бүрэг, донгио маягийн хөвгүүн л дээ. Манай “Хоргодох байрныхан” их идэвх санаачлагатай хүмүүс. Тэдний юм бодож олсныг сонс л доо! Манай сайн танил, бас ч багагүй юм хумыг маань хадгалж байгаа, “Трест”-ийн маань гол төлөөлөгч ноён Диакад бидний амьд байгааг мэдэгдэх гэж шийджээ. Тэд Цойвиш Влаан дер дахь нэгэн эмийн санчид эртний худалдан авагчийнх нь хувьд хариу хүссэн захиаг дотор нь буцах дугтуйтай хамт илгээжээ. Тэгээд буцах дугтуйн дээрх нүүсний хаягийг аав зориуд гараар бичжээ. Хэрэв хариу захиа ирвэл эмийн санчийн захиаг аваад аавын бичсэн захиаг хийж ноён Диакад аавын амьд мэнд яваа гэсэн мэдээг хүргэх ажээ.*

*Тэд Бельгийн хил дээр байдаг, бас захианы хариуг хяналтгүйгээр авах боломжтой гэдгээр нь Целандыг зориуд сонгон авчээ.*

*Анне*

## 1942 оны есдүгээр сарын 27. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Сүүлийн үед би ээжийн уурыг мөн их хүргэж байна! Бид хоёр ер нь бие биенээ ойлголцох биш дээ. Тэрнээс гадна эгч Марготоосоо ч би бас хөндийрч байх шиг. Манай гэрийнхэн Даан гуайнхан шиг тэгж хэрүүл шуугиан гаргадаггүй л дээ. Гэхдээ л бидний харилцаа нэг л санаанд хүрэхгүй онцгүй байна. Би чинь ээж, Маргот хоёроос шал өөр хүн. Заримдаа надад найз охид маань хүртэл манай ээжээс хамаагүй дээр санагдах юм. Мөн ч харамсалтайяа!*

*Хажуугаар нь энэ Даан хатагтай ч гэж арай дэндүү аймаар хүн юм. Хоёр айлын дундаа хэрэглэдэг аяга шанага энэ тэрийг юм л бол түгжчихнэ. Би ээжийг тэрэнтэй яг л адилхан хариуг нь бариасай л гэж боддог!*

*Зарим эх эцэг зөвхөн өөрийнхөө хүүхдэд үглэж яншаад зогсохгүй бүр танилынхаа үр хүүхдийг ч зааж сургах санаатай байх юм. Даан гуайнхан яг л тийм улс гээч. Маргот ч яахав тэр чигээрээ сайн сайхан, хайр талархал, ой ухаан бүрдсэн төгс амьтан юм чинь, өөлөх юм олддоггүй юм байгаа биз. Ядаж байхад би Маргот шиг үлгэр жишээ охин биш юм чинь. Хоол идэх хооронд л амар заяа үзүүлэхгүй тэг, ингэ гээд зааварлаад эхлэхээр нь би л болсон хойно, үг гээнэ гэж байх ч үгүй, сүүлдээ бүүр өөдөөс нь хэдэрлэж гарна. Харин муу аав ээж хоёр маань овоо намайг гэх юм даа. Тэр хоёр маань байхгүй бол ч өнгөрсөөн. Битгий их чалч, өөртөө хамаатай хамаагүй юманд битгий оролцоод бай, ахмад хүмүүстэй эелдэг бай гэх мэтээр хичнээн ч үглэж яншсан би бахь байдгаараа. Аав маань ийм тэсвэртэй хүн биш байсан сан бол элдвийг танин мэдэх гэсэн сонууч зангаа би аль хэдийн алдах байсан биз. Ямар ч байсан аав ээжийнхээ л хүслийг биелүүлэх хэрэгтэй.*

*Ногоонд дургүй учраас намайг ногооноос багахан шиг, төмснөөс ахиухан шиг авчихвал Даан гуайнхан миний ааштай, болдоггүйг гайхан, учиргүй их уурлаж:*

*-Ав, ав гэж ногоогоор шахна.*

*-Үгүй, баярлалаа. Би зөвхөн төмс л идмээр байна гэхэд*

*-Ээж чинь ногоо сайн гэдэг шүү дээ ид! хэмээн аавыг хөндлөнгөөс дуугарахад л Даан гуайн авгай арайхийж болин:*

*-Та нар манайд байгаа бол ингэхгүй дээ. Энэ бол хүүхдийнхээ занг эвдэж байгаа хэрэг! Танай Анне эвдэрсэн хүүхэд юм. Миний охин байсан ч болоосой! гэж дуу алдана. Аз болоход би тэдний охин болж төрсөнгүй!*

*Сурган хүмүүжүүлэх тухай ярианд эргэж оръё. Өчигдөр Даан гуайн авгайг үглэж, номлож номлож арайхийж чимээгүй болоход аав:*

*-Би, Аннег сайн хүмүүжилтэй охин гэж боддог шүү. Юу ч гэсэн таны наад яниших, үглэхийг таг чиг өнгөрөөвөл боллоо гэдгийг л ойлгосон байна. Ногооны тухайд бол vice versa гэв.*

*Тийнхүү Даан гуайн авгай намайг дахиж ногоогоор хэзээ ч шахахааргүй болгов. “Vise versa” гэдэг нь латинаар “хүний толгой дээрх өвсийг харав” гэсэн үг бөгөөд энэ нь намайг болохоор ногоо ид ид гээд байсан мөртөө өөрийнхөө таваг дээр болохоор тэрнээсээ шувууны баас шиг жаахныг авчихсан суугааг нь хэлсэн бололтой. Тэгсэн чинь нөгөөх чинь унтахын өмнө ногоо их идэхээр шингэдэггүй юм гэж шалтаглав. Ашгүй намайг одоо нгэ ногоогоор шахахгүй амар байх боллоо! Даан эзэгтэйн царай хоромхон зуур чавга шиг улайх нь зугаатай санагдсаныг яана, хэ хэ. Тэр намайг ингэж ямар ч гэм зэмгүй өнгөрсөнд боож үхэх гэж байгаа бололтой дог оо.*

*Анне*

# 1942 оны аравдугаа сарын 1. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр миний айсан гэдэг жигтэйхэн, би бараг төсөөлөх ч үгүй байхаа, найман цагийн үед гэнэт л нэг юм тас няххийгээд явчихлаа. Миний цочсоныг ээ. Гадаа яваа дүрсгүй хүүхдүүд юм чулуудсан байна гэхэд л сая нэг тайвширсан шүү.*

*Өдөр хоног нам гүм өнгөрсөөр л байна. Бас эмийн санч Левин гэдэг хүн нүүсний бараанд химийн сорил хийх гэж гал зууханд ажиллав. Пүүсийг биднээс илүү мэдэх тэр хүн хуучин лаборторидоо оръё гэвэл яана гэж бид сэтгэл түгшицгээсээр байв. Хамгийн гол нь дуу чимээ гаргачихгүйг хичээх хэрэгтэй байсан. Хөдөлгөөнтэй, сэргэлэн цовоо гэгдсэн намайг энд хоргодох газар ингэж хөдлөх ч үгүй, ярих ч үгүй хэлгүй юм шиг ийм удаан сууж чадах юм гэж хэн санах билээ? Аа бас өнгөрсөн 29-д Даан гуайн авгайн төрсөн өдөр болов. Бид нэг их баяр хөөр болсонгүй. Түүнд цэцэг, бяцхан бэлэг сэлт өгөөд, ердийн өдрийнхөөс арай илүү их хоол идсэн дээ. Даан гуай гэр бүлийнхээ уламжлал ёсоор эхнэртээ гал улаан лиш цэцэг бэлэглэв.*

*Хүүш ээ, Даан гуайн авгай тухай чамдаа бас жаахан хов яримаар, хэлмээр байна. Манай аавд тэрний сээтэгнэхээр нь миний уур хүрээд болдог юм биш. Даан авгай юм л бол аавын үс, нүүрийг шүргэчих санаатай далим хайгаад л, Пимийн анхаарлыг татах гэж өөрөө дажгүй сайхан гэж боддог хөл гуяа гялалзуулан, хошигнох гэж оролдох юм. Харин тэр бүхэн нь Пимд энхрий хөөрхөн харагдах нь бүү хэл, ярих дургүйг нь хүргэх нь илт. Хэдийгээр би тийм их хартай амьтан биш ч гэсэн энэ бүхнийг тэсвэрлэж чадашгүй нь. Тэгээд ч би л болсон хойно, манай ээж Даан гуайн өмнө тан шиг ингэж маягладаггүй шүү гэж, Даан гуайн авгайд улаан нүүрэн дээр нь хэлчихсэн.*

*Нээрээ, Петер заримдаа бүр инээд хүргэчих юм. Бид хоёр уйдсандаа эсрэг хүйснийхээ хувцасыг өмсөж тоглох болов. Тэр саявтар ээжийнхээ бариу даашинзыг өмсөж, хатагтай нарын бүрх малгай духдуулсхийн, би түүний хүрэм өмдийг өмсч, саравчтай малгайгий нь хэлтгий тавьсаар ороход томчууд элгээ хөштөл инээж, бид ч чамлалтгүй зугаацаж авсан шүү.*

*Элли эгч Маргот бид хоёрт муу мөртлөө айхтай үнэтэй хоёр бошинз дэлгүүрээс авчээ. Сониноос Элли бас Маргот, Петер бид гуравт таталган бичгийн ном авчрав. Хойтон гэхэд бид гурав шилдэг татлан бичээчид болно. Тийнхүү “нууц”-аар бичиж чаддаг болбол ямар гоё вэ, тийм ээ?*

*Анне*

## 1942 оны аравдугаа сарын 3. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр дахиад л аймар хэрүүл болов. Ээж миний бүх гэм зэмийг аавд хэтрүүлээд ховлочихжээ. Ээж ч уйлав. Би ч уйлав. Миний толгой өвдсөн гэж жигтэйхэн. Би ч аавдаа илүү хайртайгаа хэлээд тавьчихсан. Пим ч бүх л юм миний боддогоос өөр болж байх шиг байна гэв. Би ээжтэй эвтэй байхыг тулд биеэ барих хэрэгтэй болж байна. Ээжийгээ санаа сэтгэлээр тааруухан байгаа үед асран халамжилж бай гэж аав хэлсэн боловч би тэгж чадахгүй юм. За бас франц хэл сурах гэж шамдаж байна. Одоо “La belle Nivernaises”-г уншиж сууна.*

*Анне*

## 1942 оны аравдугаар сарын 9. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би өнөөдөр эмгэнэлтэй, сэтгэл шаналгасан мэдээ аваад байна. Бидний нөхөд болон танил еврейчүүдийг Мюнхен рүү зөөжээ. Гестапогийнхан тэдэнд тун ширүүн догшин байна гэнэ. Тэднийг үхэр мал ачдаг тэрэгнүүдэд чихээж, Вестерборк дахь еврейчүүлийн хорих лагерь руу аваачсан гэнэ. Вестерборк бол аймшигтай ширүүн газар гэсэн. Хэдэн мянган хүнд хүрэлцэхгүй жорлон байхгүй, хир буртагнаасаа салах халуун усны газаргүй хорих лагерь ямар байх нь мэдээж шүү дээ. Наартай дан байшингуудад эр, эм, хүүхэд шуухадгүй хоригддог гэлцэнэ. Оргож зугатах ч аргагүй. Хоригдлуудын ихэнхийх нь үсийг хайчилсан ба еврей гадаад төрх байдлаараа хүний нүдэнд амархан өртдөг ажээ.*

*Холландад ийм аймшигтай байгаа юм чинь, баригдаад хорих лагерьт ачигдсан хүмүүст хичнээн аймшигтай байгаа бол? Хорин лагериудын хорт хийгээр утдаг өрөөний тухай Английн радиогоор ярьж байна лээ. Мийн нэг аймаар явдлын тухай ярихдаа өөрөө ч түүнээсээ айж байх шиг санагдсан. Саявтархан нэг татанхай эмгэн Мийгийн үүдэн дээр харанхуй шөнө сууж байжээ. Хөөрхий эмгэн еврейчүүдийг баривчилж цуглуулах гестапогийн машиныг өөрөө хүлээж суугаа нь тэр гэнэ. Эмээ айсандаа дагжин чичирч байжээ. Харанхуйд английн нисэх онгоцнуудын дуу хүнгэнэн, хүчтэй гэрэлтүүлэг гялбалзан, агаараас эсэргүүцэх их буунууд нижигнэж байжээ. Хэдийгээр Мийн тэр эмгэнийг өрөвдсөн ч гэртээ оруулж зүрхлээгүй гэнэ. Учир нь тийм тохиолдолд германчууд аймаар хатуу цээрлүүлдэг юм.*

*Элли бас дуу шуугүй болж, битүү уйтгарлах болов. Үерхдэг залуугий нь герман руу ажилд дайчлан явуулжээ. Тэгээд хайртыгаа бөмбөгөнд өртчих вий гэж их айдаг гэнэ. Английн нисэгчид сая сая кило бөмбөг хаяж байна. Эллигийн сэтгэлт залуу Дирк ганцаараа ажилд дайчлагдсангүй. Үнэхээр үгүй шүү. Дайчлагдсан залуусаар дүүрэн гэлт тэрэг өдөр бүр Герман руу явсаар байна. Замаасаа ганц нэг нь л азаар оргож зугатан, нуугдаж бүгж амжсан гэнэ.*

*Миний уйтгартай гоншигноон дуусах болоогүй шүү. Чи барьцааны тухай сонссон уу? Германчууд бас л зальтай арга олжээ. Энэ нь урьд өмнийхээс шал өөр, дэндүү аймшигтай явдал ажээ. Гэм буруугүй хүмүүсийг толгой дараалан баривчлаад нэгий нь ч сулладаггүй гэнэ. Тэгээд хаа нэг газар Германчуудыг эсэргүүцсэн явдал гараад гэмтнүүдийг нь олохгүй бол нөгөө барьцааны хүмүүсээс бөөн бөөнөөр нь буудаж алдаг болоод байна. Тэр тухай бүрд нь сонинууд бидийг заналхийлэх мэт мэдээлнэ. Герман гэдэг чинь ийм улс болоод байна. Гэтэл би урьд нь бас тэр улсын иргэн байсан сан. Гитлер гарч ирээд л жүүдүүд биднийг уг удмаараа цагаачид гэж зарласан. Тэгээд ч энэ герман жүүд хоёрых шиг ийм дайсагнал энэ дэлхийд хаа ч алга даа.*

*Анне*



## 1942 оны аравдугаар сарын 16. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би чинь толгой өндийхгүй их ажилтай сууна. Өнөөх “La beile Nivernaise”-аасаа нэг бүлгийг орчуулж хэдэн үг түүлээ. Дараа нь нэлээд хүнд бодлого бодоод, франц хэлнийхээ сурах бичгээс гурван хуудас уншиж дасгал хийв. Би тоо бодох тийм ч дуртай биш, дандаа л тоогоо хойш тавьдаг юм. Аав ч гэсэн тоог хэцүү гэдэг, харин заримдаа би түүнээс илүү боддог гээч. Хоёулаа дийлэхгүй юман дээр Марготоос тусламж авдаг даа. Таталган бичгээ үзсээр байна. Таталган бичгээр Петер, Маргот хоёроосоо арай жаахан дөртэй нь би болоод байна. Өчигдөр “Довтлогчид” гэдэг номоо уншиж дуусгав. Сайхан ном юм. Гэхдээ Хойлын “Жооп”-той зүйрлэхээргүй л дээ. Дахиад л чамд гэж хэлэхэд Марксвелийн Цисси гайхамшигтай бичдэг юм шүү. Түүний номыг хожим миний хүүхдүүд ч уншина гэдэгт итгэлтэй байна. Аав бас Корнерийн “Бремений зээ нар”, “Хотын дарга”, “Ногоон Домина” зэрэг жүжгүүдийг өгөв. Сайн л зохиолч байна.*

*Ээж, Маргот бид гурав ээж, эгч дүүсийн ёсоор овоо дотно болоод байна. Энэ нь ч дээр дээ. Өчигдөр орой Маргот эгч ирж, миний орон дээр надтай хамт хэвтэв. Нарийхан орон дээр бид хоёр багтахгүй, шахцалдаад байсан ч хөгжсөөнтэй байлаа. Маргот өдрийн тэмдэглэлийг чинь уншиж болох уу гэж асуув. Би тэгэхэд нь заримы нь болно гээд чинийхийг бас уншиж болох уу гэвэл тэр бас дуртайяа зөвшөөрөв. Дараа нь ирээдүйн тухай ярьцаав. Чи ямар мэргэжилтэй болох вэ гэж Марготоос асуувал тэр нууц гээд хэлсэнгүй. Багийн тухай ярихыг нь зөндөө сонссон болохоор багш л болох байлгүй гэж таагаад ам хэлий нь сугалчих шахам сониучирхахаа болив.*

*Өнөө өглөө би Петерийг хөөж босгоод орон дээр нь хэвтэв. Мань эр дургүйцсэн ч би тоосонгүй. Урьд орой нь хүн алим бэлэглээд байхад надад арай эелдэг байж болдоггүй юм байх даа. Би чамд царай муутай харагддаг уу гэж Марготоос асуухад тэр хөгжсөөнтэй л харагддаг шүү. Харин нүд чинь хөөрхөн шүү гэсэн. Нээх хүсмээр ч хариулт биш байгаа биз? Баяртай!*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Айснаасаа ч болсон юмуу гар минь чичирсээр байна. Уг нь аль хоёр цагийн өмнө тэр явдал болоод өнгөрсөн байдаг. Пүүсэнд авсаархан таван ч галын хор байдаг юм байна. Гэтэл тэр хорнуудыг цэнэглэх хүн ирнэ гэж хэн ч хэлээгүй байв. Манай хоргодох байрны өмнөх бяцхан чөлөөнд нэг хүн юм балбах шиг болохыг би эхлээд сонсох хүртэл манайхны хэн нь ч анзаарсангүй. Гэтэл мужаан санаанд орж бидэнтэй цуг хооллож байсан Эллийг доошоо бууж болохгүй шүү гэж анхааруулав. Аав бид хоёр тэр хүнийг хэзээ явахыг нь мэдэх санаатай хаалганы ард зогсон чагнав. Тэгтэл нөгөө хүн хэсэг юм оролдон багаж хэрэгслээ шүүгээн дээр тавих шиг болсноо манай нууц байрны хаалгыг цохив. Бид айсандаа хувхай цагаан юм болчихов. Тэр хүн сэжиг аваад энд юу байна гэж сониучирхсан юм уу? гэж санагдав. Учир нь хаалга зогсоо зайгүй цохиж, татаж, түлхэж гарлаа. За ингээд амь хоргодох байрыг минь хүн илрүүлчихэв үү гэсэн бодол орж ирэн зүрх түгштэл харин “Тайлаарай таминь, би байна!” гэх ноён Коофуйсын хашигирах сонсогдоход л сая энд хичнээн удаан зогссоноо мэдэв. Хаалгаа яаран тайлаад түүнээс учрыг мэдлээ. Гаднаас өөрийн хүмүүс онгойлгож болох дотор талын түгжээ гацсанаас хор цэнэглэх хүн ирнэ гэдгийг цаг тухайд нь бидэнд мэдэгдэж чадаагүй гэнэ. Тэр хүн ч ашгүй тэгээд яваад өгчээ. Тэгээд ноён Коофуйс Эллийг аваачих санаатай ирэхдээ нөгөө хүнийг эргэдэг хаалганаас холдож явахыг харсан гэнэ. Ашгүй сэтгэл амсхийгээд явчихлаа. Гэвч хаалга түлхсэн тэр хүн надад аймшигийн аварга хүн шиг санагдсаар л байлаа. Бид ч бүх юм сайнаар төгссөн нь аз гэлцээд өнгөрөв.*

*Даваа гариг ёстой зугаатай өнгөрлөө. Мийн, Хенк хоёр манайд хонов. Энэ шөнө Маргот бид хоёр аав ээжийн өрөө рүү “нүүж”, залуу хос бидний орон дээр унтав. Хоол унд ч овоо хүрэлцээтэй болов. Гэхдээ аар саар юм мундах биш. Аавын ширээний чийдэн гэнэт унтарч бид нэг хэсэг харанхуй суув. Гал хамгаалагчтай цахилгааны тоолуур агуулахын ард байдаг юм. Харанхуйд түүнийг олно гэдэг тийм ч амаргүй. Харин аз болоход арван минутын дараа гэмтлийг олж заслаа. Бид ч лаагаа унтраав. Өглөө нь тавд бослоо. Хенк найм хагаст явах тул тавтай цайлах гэж эрт босоцгоосон юм. Бороо цутгаж эхлэв. Мийн тэгэхэд хар борооноор ажилдаа гүйхгүй болсондоо баярлав. Би аавтай хамт гэр орноо янзлаад, хичээлээ үзэж гарлаа. Франц үйл үгс жаал цээжиллээ. Дараа нь “Мөнхийн дууч ой” гэдэг ном уншив. Гоё ном байна. Уншаад бараг ч дуусах нь. Ирэх долоо хоногт Элли манайд хононо!*

**Анне**

## 1942 оны аравдугаар сарын 29. Пүрэв гариг

*Сэтгэл минь нэг л их тавгүй байна! Аав өвдчихсөн. Их халуурч, яг л улаан бурхантсан юм шиг бие нь туурав. Ээж түүнийг сахин, халууны нь буулгах гэж жин тавина. Өнөө өглөө Мийн германчууд Даан гуайн байрыг тонож хоосолсныг дуулгалаа. Бид тэр тухай Даан гуайн авгайд хэлсэнгүй. Сүүлийн үед тэр ямагт уурлан бухимдах болоод байгаа. Тиймээс ч хайран сайхан чамин аяга шаазан, үнэт тавилгаа авч чадалгүй гэртээ орхичихсон юм сан хэмээн янишихы нь бид огт ойшоодоггүй байв. Амь л аврагдаж байвал хичнээн гоё ч эд хогшил ямай болоод байхад. Нээрээ, намайг томчуудад зориулсан ном уншихыг зөвшөөрсөн шүү. Одоо би Зүхтелийн “Евагийн залуу нас” гэдгийг уншиж байна. Охидын номноос юугаараа тийм ялгаатай нь мэдэгдсэнгүй. Хүүхнүүд их мөнгөөр эрчүүдэд биеэ үнэлж байгаа тухай л гарч байна. Тийм завхай эрчүүдийн өмнөөс ичмээр юм. Бас Ева гэдэг хүүхний бие мууддаг юм.*

*Аав, Гёте, Шиллерийн жүжгүүдийг авчирчээ. Орой бүр л ном уншмаар санагдах юм. Бид, “Дон Карлос”-ыг нь уншиж эхлэв. Аавын энэ номнуудыг авчирсанд нь ээж дургүйцэхдээ надад мөргөлийн ном өгөв. Би л болсон хойно түүний нь бас сонирхон уншив. Уншихад зүгээр юм шиг мөртлөө, тэр мөргөлийн ном нь надад ямар ч өгөөжгүй санагдав. Ээж маань намайг яагаад бурханд сүсэг биширэлтэй болгох гээд байдаг юм бол?*

*Өглөө пийшингээ эхэлж галлана. Оройдоо хөөлөөгүй юм чинь, биднийг лав тарвага шиг утах байх даа.*

*Анне*

## 1942 оны арван нэгдүгээр сарын 7. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Ээж уурлаад бөөн ядаргаа. Энэ нь дарамттай юмаа. Маргот болохоор аав ээжтэй хэл ам татлана гэж үгүй, харин би л үргэлж уурлуулж, уцаарлуулж байдаг нь тохиолдол юм гэжүү? Жишээ нь өчигдөр орой Маргот маш гоё зурагтай юм уншиж суулаа. Тэгээд дээш гарахдаа номоо цааш нь унших санаатай тавьчихаад яваад өгөв. Хийх юмгүй байсан би тэгэхэд зурганд нь болоод тэр номыг нь үзэж гарсан юм. Гэтэл Маргот бууж ирээд, “өөрийнхөө” номыг надад байхыг хармагцаа хөмсөг зангидан “алив өгөөтөх” гэв. Би л болсон хойно цааш нь жоохон үзэх гээд зөрж байгаад Марготыг уурлуулчихлаа. Тэгсэн чинь ээж хөндлөнгөөс:*

*-Наадхий чинь Маргот уншиж байгаа юм. Бушуу өг чи! гэдэг байна. Тэгтэл аав орж ирэв. Аав хүртэл юу болсныг мэдээгүй байж, Марготыг л гомдоочих вий гэж ирээд л намайг:*

*-Маргот номыг чинь авчихвал чамайг яахыг харахсан гэдэг байна ш дээ.*

*Би ч дуугүй болж тэр гайтай номыг нь тавиад гомдсондоо өрөөнөөс гараад явчихсан. Энэ явдал үнэндээ намайг гомдоогоо ч үгүй, уурлуулаа ч үгүй, зөвхөн л уйтгарлуулсан. Юу болсныг мэдээгүй байж учиргүй*

*Марготын талд орсон нь аавын буруу байсан юм. Би уг нь аав ээж хөндлөнгөөс оролцож, Марготыг өмөөрч сүйд болоогүй бол тэр номыг нь дор нь л өгчих байсан л даа. Мэдээж ээж Марготыг гэх нь ойлгомжтой хэрэг. Тэр хоёр бол байнга хэл амаа ололцдог улс. Тэгээд ч би ээжийн үглэж загнах, эгчийн дүрсхийн уурлахыг ер анзаардаггүй болчихсон юм. Нэгэнт л миний төрсөн ээж, эгч хоёр юм чинь тэгж л байна биз. Харин аавтай бол өөр хэрэг. Аав хэрэв Марготыг илүү үзэж магтаж, эрхлүүлээд явчихаар би шаналдаг юм. Яагаад гэвэл манай гэр бүлд намайг гэх ганц хүн аав байгаа юм. Аав бол миний хамгийн дотны хүн. Би энэ дэлхийд түүнээс өөр хэнд ч тийм их хайртай байж чадахгүй. Гэтэл аав заримдаа намайг гэхээсээ илүү эгчийг гэдэг. Маргот маань үнэхээр ухаантай, үзэсгэлэн гоо, эелдэг зантай төгс төрсөн охин л доо. Гэхдээ намайг ч бас тоохгүй байж болохгүй ш дээ. Би бол гэрийнхэндээ үргэлж л алиа салбадай, бүтэлгүй амьтан гэгдэн, толгой тархигүй загнуулдгаараа, тэглээ гээд засардаггүйгээрээ заримдаа удаа дараалан шийтгүүлэхэд хүрнэ. Надад дүр үзүүлэх, худлаа нялуурах, сүржигнэн шуугиан тарих явдал таалагддаггүй. Би ааваасаа намайг ганцааранг нь хайрлахыг л хүсдэг. Маргот эгчдээ би атаархдаггүй. Түүн шиг мундаг, ухаалаг, үзэсгэлэн гоо болохыг ч хүсдэггүй. Надад ердөө л эцэг хүний чинь үнэн элбэрэлт хайр, зүгээр нэг хүүхдийнх нь хувьд биш харин Анне гэдэг бие хүнийхээ хувьд хэрэгтэй.*

*Гэр бүлээ гэх сэтгэлийг минь дулаацуулж явдаг цорын ганц хүн аав минь учраас л ингэж ярьж байгаа юм. Би өөртэй нь ээжийн тухай яримаар байдгийг минь аав ойлгодоггүй. Ээжийн өчнөөн дутагдлыг ярихыг аав ерөөсөө сонсдоггүй, хэрэв энэ тухай яриа гарах юм бол сэргэлэг гэгч нь дүйвүүлээд өнгөрөөнө. Гэвч надад ээжийн зан ааш ердөө ч таалагддаггүй. Ээжийн салан задгай, хайш яйш байдал, егөөдөл, хатуу догшин зан авир нь*

намайг заримдаа үнэхээр биеэ барьж чадахгүйд хүргэдэг. Тэгэхээр бүх буруу минийх биш нь мэдээж бус уу.

Ээж бид хоёрын зан төрх тэнгэр газар шиг зөрөөтэй байдаг болохоор юм л бол гал ус шиг харшилдана. Тэгэхдээ би ээжийг тийм ийм гэдэггүй. Тэгэж болох ч үгүй, чадах ч үгүй. Ямар ч атугай тэр миний төрсөн эх шүү дээ! Ээж тэгэхдээ надад эх шиг байсангүй. Ингээд л өөрөө өөртөө эх болж явахаас аргагүйд хүрдэг юм. Тэгээд ч өөрийгөө түүнээс бүрмөсөн тусгаарлаж, өөрөө өөрийхөө замыг сонгосон. Би одоо жинхэнэ эх, эмэгтэй хүний өв тэгш дүрийг харах сэтгэлийн нүдтэй болжээ. Тэр нүдээрээ ээжийг харахаар үнэндээ түүнд, тэр эх гэдэг хүндэт нэр тохирохгүй юм шиг санагдана.

Би ээжийн муу бүхнийг анхааралгүй харин дан сайн сайхныг нь олж харах, түүнд байхгүй чанаруудыг өөртөө бий болгохыг ямагт хичээдэг.

Хамгийн уур хүрмээр нь миний энэ хичээж байгааг ээж, аавын аль нь анзаардаггүй болохоор тэвчээр алдаад нэг л мэдэхэд тэдний дургүйг хүргэчихдэг юм. Ер нь эцэг эхчүүд хүүхдүүдээ ойлгож, зөв харьцаж чаддаг юм болов уу даа?

Заримдаа бурхан намайг шалгаасай гэж бодох юм. Ямар ч атугай өөрөө л хэний ч үлгэр дууриал, тусламжгүйгээр биеэ даах хэрэгтэй.

Надаас өөр хэн энэ тэмдэглэлийг хожмын өдөр унших бол? Хэн надад туслах гэж гар сунгах бол? Хайр халамж, түшиг тулгуургүй бол би амьдарч чадахгүй нь. Заримдаа хүчин мөхөсдөж хүссэн шигээ охин байж чадахгүйд хүрэх юм.

Намайг ер нь хэн ч ойлгохгүй юм. Өнөөдөр томчуудын яриаг сонсож бүгдийг мэдэж болох байтал маргааш нь намайг юу ч мэдэхгүй жулдрай хүүхэд, номоос их зүйл сурлаа ч гэсэн үнэндээ зөвийг нь биш л дээ гээд тоохгүй. Би үгээр хэлж чадахгүй л байгаа болохоос өөрийн гэсэн үзэл бодол, хүсэл мөрөөдөлтэй, зорилготой хүн. Энд хоргодох байранд нуугдсанаас хойш уулзаж чадахаа больсон найзууд минь ч намайг бүрэн ойлгож байгаагүй. Ингээд л явж явж өдрийн тэмдэглэл дээрээ буух нь тэр. Өдрийн тэмдэглэл минь чи миний санаа бодлын эхлэл төгсгөл юм. Китти минь чи үнэхээр тэсвэртэй юм. Чамдаа Анне чинь бүхнийг тэвчихээ, зовлон даахаа, өөрийнхөө замыг өөрөө засаж чадна гэдгээ андгайлъя. Харин тэгэхдээ, үүнийхээ үр дүнг харж өөрийгөө хайрлах хэн нэгний хайраар урам зориг орох сон.

Өөрийгөө би үнэхээр буруутгаж чадахгүй нь. Тэгэх нь надад дэндүү ахдана гэдгийг ойлгож үзээрэй!

Анне

## 1942 оны арван нэгдүгээр сарын 9. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Петерийн төрсөн өдөр өчигдөр болсон. Тэрээр хөөрхөн тоглоом, сахлын машин, цахилгаан асаагуур зэрэг гоё гоё бэлэг авлаа. Хэт нь тамхи татаж эхэлж байгаа түүнд гоё санагдав бололтой.*

*Тунис, Касабланка, Алжир, Ираныг Англичууд эзлэх гэнэ гэдгийг Даан гуайгаас сонсоод бид ихэд гайхацгаав. Бүгд л энэ бол үхлээ хурдасгах гэсэн үг гэлцэв. Ийм яриаг бас өчнөөн сонссон Английн ерөнхий сайд Черчилль харин “Ингээж дайран орох нь үйл явдлын маш чухал үе шат юм. Хэн ч үүнийг үхлээ хурдасгаж байна гэж үзэж болохгүй. Харин би юу юунаас ч түүрүүнд, энэ бол гай таригчийн үхлийг хурдасгахын эхлэл нь гэж тэмдэглэх байна.” гэжээ.*

*Энэ ч нээрээ л ялгаатай юм шүү. Ямар ч гэсэн өөдрөг л үг байна. Германчууд Оросын том хот Сталинградыг гурван сарын өмнөөс бүслээд эзэлж чадаагүй байна шүү дээ.*

*За, өдөр тутмынхаа сэдэв рүү оръё. Хоргодох байрныхаа тухай ярих гэвэл хоол хүнс хэрхэн залгаж байгаагаг бас тайлбарлах хэрэгтэй еэ. Коофуйс гуайн нэгэн танил сайхан сэтгэлт талхчин талхыг маань залгуулдаг юм. Мэдээж бид гэртээ байдаг шигээ тийм ихээр худалдан авдаггүй ч болоод л байдаг юм. Хүнсний карт ч яахав дамаас л олж байна. Картны үнэ хадаж байна гэж жигтэйхэн. Эхлээд картанд 27 гульден төлж байсан бол одоо 33ыг төлөх болов. Хумсын чинээхэн цаасанд шүү!*

*Шил савтай даршилсан хүнсний хамт хадгалж болох юм гэж 135 кило шош шуудайлан нөөцөлж, эргэдэг хаалганы дотор талд зүүв. Тэгтэл шуудайны ёроолын утас нь даахгүй задарсан тул Петерийн өвөл идэх нөөцөө агуулах руу зөө гэжээ. Тэр таван шуудайгий нь зөөчихөөд, зургаа дахийг нь оруулах гэж байтал, ёроол нь зад үсрэн, яг л мөндөр шиг шаагин, шалан дээр асгарах нь тэр. Доор байсан манайхны зарим нь хуучин муу байшингаа нурчихав уу гэж сандарсан гэж байгаа. Аз болоход гадны хүн нүүсэнд байсангүй. Петер анхандаа үнхэлцгээ хагартал айснаа, шатны дор намайг шагайгаа хүртэл шошин дунд зогсоог хараад тас тас хөхрөв. Тэр дороо л асгарсан шошоо түүж эхэлсэн ч хатаж гөлчгөр болсон шош гарт баригдахгүй шалны ан цав, нүх сүвээр өнхрөн орсоор байв. Түүнээс хойш шатаар өгссөн хүн бүхэн асгарсан шош түүн, Даан эзэгтэйд өгдөг болов. Хүүе хамгийн чухал юмаа хэлэхээ мартаж шахлаа. Аав эдгэрсэн шүү.*

**Анне**

*Жич өгүүлэхэд: Дөнгөж сая Алжир эзлэгдлээ гэж радиогоор мэдээлэв. Марокко, Касабланка, Иран зэрэг орнууд англичуудын гарт оржээ. Удахгүй Англичууд Тунисд цөмрөн орно доо.*

## 1942 оны арван нэгдүгээр сарын 10. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Нэг хэсэгтээ мартахааргүй сонинтой! Хоргодох байранд маань найм дахь бүгээгч ирэх гэнэ. Арга ядсан хэн нэгэнтэй хуваалцахад хоол унд, байр сууцны зай хүрэлцэнэ гэж бидэнд санагддаг байв. Хамгийн гол нь бидэнд тусалж байгаа ноён Кралер, Коофуйс хоёрт л нэмж тээр болохгүй юмсан. Еврейчүүлийг мөрдөн мөшгөх нь улам ширүүсэхэд аав тэр хоёрт энэ тухайгаа хэлэхэд Кралер, Коофуйс гуай хоёр хариуд нь энд байгаа хүмүүс долоо ч бай, найм ч бай аюул нь адил шүү дээ гэжээ.*

*Тэгээд л танилууд дотроосоо ганц бие ямар хүн манай хоргодох байранд нуугдаж болох вэ гэж бодоцгоож эхэллээ. Еврейчүүд хаа сайгүй баригдаж байхад тийм хүнийг олж ядахааргүй байв. Аав хамаатан саднаасаа нэг хүн авчиръя гэсэн Даан гуайхны саналыг татгалзаж татгалзаж, эцэстээ эхнэр нь гадаадад байгаа шүдний эмч Альберт Дусселиг суулгахаар сонголоо. Гэтэл Дааныхан болон манайхны хэнд нь ч гэмгүй явдаг тэр төлөв даруу эр Германчуудаас дуудлагаа авчихсан байжээ. Мийн түүнийг сайн таних тул хэл дуулгаад бүхнийг зохицуулж чадах байв. Түүнийг ирэхэд, Маргот аав ээжийн өрөө рүү нүүж, орон дээр нь тэр ах орох гэнэ.*

*Анне*

## 1942 оны арван нэгдүгээр сарын 12. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Мийгийг очоод Германчуудаас нуугдах газар байгааг хэлэхэд Дуссель эмч маш их баярлажээ. Мийн түүнд нөгөөдрөөс хэтрэхгүй хоргодох байранд очихыг зөвлөжээ. Гэтэл цаадхи нь картуудаа эмхлэн, хоёр өвчтөнөө гүйцээн эмчилж, тооцоогоо дуусгана гэжээ. Энэ тухай өнөөдөр Мийн бидэнд хэлэв. Бидэнд бол юун өвчтөн, карт эмхлэх, Дуссел эмч наашаа ирэхээ нэг ч мөч хойшлуулж болохгүй юм шиг санагдав. Тиймээд Мийд Дусселийг зургаа дахь өдөр ирүүлэхээр дахин зөвлөхөө тогтов. Тэгээд энэ тухай хэлсэн нь Дуссел “Үгүй, нэг дэх өдөр л очъё” гэжээ. Амь насаа бодохгүй ингэж зөрүүдэлж байгаа нь инээдэмтэй ч юм шиг. түүнийг Германчууд ачаад явах юм бол юун карт эмхэлж, өвчтөнөө эмчлэхтэй манатай юм бишүү. Аав Дуссель эмчийг энд авчрах гээд байгаа нь буруу юм шиг санагдах юм. Өөр ч юмгүй дээ.*

*Анне*



## 1942 оны арван нэгдүгээр сарын 17. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Дуссел гуай ирсэн. Бүх юм санасанчлан бүтлээ. Мийн түүнийг төв шуудан руу очоорой гэжээ. Дуссел ч цагтаа очжээ. Түүнийг мэдэх Коофуйс гуай шууд очиж, тантай уулзах хүн жоохон хожуу ирэх нь байна. Энэ завсар нүүсэнд очиж хүлээвэл дээр гэжээ. Тэгээд Дуссел нүүсэн дээр ирж зургаан хошуут тэмдгээ хүн харчих вий гэж пальтогоо тайлаад цэвэрлэгч авгайг явтал Коофуйс гуайн албан өрөөнд хүлээсэн байна. Мийн түүнийг эзний өрөөнд орж ярих гэж буй бололтой зангаад байхаар нь дээш гарах нь уу гэтэл гайхсан эрийн өмнө тавиуртай хана эргэн нээгдэж манай бүгэвч рүү орж иржээ. Шинэ зочноо бид коньяк, кофетой хүлээн авах гэж дээр Даан гуайн хэсэгт цугласан байв. Эхлээд Мийн түүнийг бидний өрөөнд оруулж ирлээ. Гэрийн тавилгы маань таньсан атлаа биднийг тийн эрээд байхааргүй ойр сууж байна гэж тэр харин даанч санаагүй гэнэ. Мийнийг учрыг тайлбарлахад ч тэр эхэндээ сайн ойлгоогүй гэнэ. Мийн түүнд бодох зав ч олгосонгүй шууд дээш нь авчрав. Дуссел гайхсандаа мэндлэх ч сөхөөгүй сандалд суугаад нүдэндээ итгээж ядан биднийг нэг нэгээр нь гөлөрсөөр байлаа. Дараа нь тэр “Ингэхэд...үгүй...харин” хэмээн ээрснээ:*

*-Та нар чинь Бельги рүү дүрвэчихээгүй юу? Өнөөх герман дарга тань ирээгүй юу? Машин тэрэг тань яасан бэ? Дүрвэж амжсангүй юу? гэв. Тэгэхэд нь бид, хүмүүсийг тэр тусмаа германчуудыг бидний мөрийг мөшигх бий гэсэндээ чулуу хөөлгөх гэж машин тэрэг, герман офицер гээд л баахан үлгэр зохиосноо тайлбарлав. Дуссел гуай тийн хүний санаанд оромгүй юм болсонд дуу алдан, биднийг ийм аятайхан газар суурьшиж авсанд гайхсаар байлаа. Манайхантай хамт хооллосныхоо дараа тэр жаахан амраад дахин цай уумагцаа өмнө нь Мийтийн авчирсан юмсыг эмхлэв. Дуссел Даан гуайн боловсруулсан бүгэгсдийн дүрмийг авч судлааж овоо дасч идээшлээ.*

*Хоргодох байрныхны танилцуулга, журам*

*Энэ нь жүүдүүд буюу еврейчүүд ба тэдэнтэй зовлон нэгтнийг орогнуулах зорилготой. Бүхэл жилийн турш нээлттэй байна.*

*Энэхүү хоргодох байр нь трамвайн 13,17р шугам, машин, дугуйн аль нэгээр, нийтийн унаанд суух эрхээ хасуулагсад бол явгаар очих Аместердамын төв дэх эл хуль, ой мод, хөл хөдөлгөөнгүй сайхан газар оршино.*

*Сууцны түрээс: Үнэгүй*

*Өөх тосгүй цагаан хоолтой. Олон өрөөнүүдийн аль нэг газарт гоожуурын усанд орж болно. Уудам агуулахад бүх юмсаа нэг дор хадгална.*

*Өөрийн гэсэн радио цэгээр Лондон, Нью-Йорк, Тель-Авив болон бусад хотуудын алины ч нэвтрүүлгийг оройн зургаан цагаас хойш сонсож болно.*

*Унтах цаг: Оройн арваас өглөөний долоо хагас. Бүтэн сайн өдөр өглөөний арав хүртэл.*

*Тухайн байдлаас хоргодох байрны зөвлөлийн шийдвэрээр тогтооно. Энэхүү захирамжийг бүгээгсдийн аюулгүй байдлын тулд хатуу сахих ёстой.*

*Амралт: цагийн байдлаар хойшлогдсоор байна.*

*Яриа: соёл урлагийн тухай. Харин нам дуугаар шүү!!!*

*Биеийн тамир: өдөр бүр.*

*Хичээл сургууль: татлан бичгийг долоо хоногт нэг удаа. Бүх өдрүүдэд тоо, түүх, англи хэл, франц хэл үзнэ.*

*Хооллох цаг: өглөөний цай ням гариг болон баярын өдрөөс бусад өдрүүдэд тогтмол 9 цагт. Үдийн хоол 1:15-1:45 хүртэл. Оройн хоол: халуун хүйтэн ялгаагүй, радио нэвтрүүлгийн цагаас болж тогтмол биш.*

*Ханган нийлүүлэх албаныхны өмнө хүлээх үүрэг: аль ч үед пүүсийхний ажилд туслахад бэлэн байна.*

*Усанд орох: оршин суугч бүтэн сайн өдрийн 9 цагаас өөрсдийн хүссэнээрээ бие засах газар, гал тогоо, пүүсний конторуудад орж болно.*

*Архийг эмчийн зөвшөөрлөөр хэрэглэнэ.*

***Анне***

## 1942 оны арван нэгдүгээр сарын 19. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Бид бүхний хүсэн хүлээж байснаар Дуссел гуай сайхан зантай хүн байв. Хар элгийн хүнтэй нэг өрөөнд суух нь үнэндээ эвгүй санагдах авч буянт сайн хүн байвал ч гадуурхах юу байхав. Аав маань “Нэг ч болов хүнийг Германчуудаас аврах минь. Бусад нь ч яамай” гэж байв. Энэ бол ёстой зөв үг шүү.*

*Ирсэн өдөрт нь л би Дуссел гуайд цэвэрлэгч авгай хэд хүртэл нүүсэнд байдаг, хэзээ бие засаж болох, хаана усанд орвол зүгээр зэргийг хэлж өглөө. Китти минь чи л лав инээнэ биздээ. Харин бүгэвчинд бол энэ бүхэн маш чухал шүү. Мөн гадны хүн нүүсэнд хөлхөлдөж байх үед чимээгүй байхын чухлыг, ер нь тэгээд ямар үед амьдарч буйгаа санах хэрэгтэй гэхэд Дуссел гуай гайхсандаа ч юмуу, дахин дахин асууж лавлан хүлээн авч чадахгүй байсан. Бид ямар энгийн үед гэртээ байгаа биш нуугдаж байгаа хүмүүс гэдгийг тэгээд аяндаа ойлгоно биздээ.*

*Бусад юм ч яахав хэвэндээ л байна.*

*Бидний энд бүгсэн цагаас хойш наранд болсон явдлын талаар Дуссел гуай бидэнд ярьж өгөв. Түүний ярьсан бүх түүх дандаа эмгэнэлтэй төгсөж байв. Тоо томшгүй олон нөхөд, танилууд маань аймшигт Герман луу ачигдан оджээ. Үдэш бүр ногоон, хар өнгөтэй цэргийн машинууд гудамжаар нижигнэн давхисаар байдаг гэнэ. SS-н ногоон, Холландын нацист цагдаа нарын хар машинууд еврейчүүдийн анд гардаг гэнэ. Хаа нэгтэйгээс жүүд хүн барьвал өрх гэрээр нь хуу хамж байгаа гэнэ. Тэд хаалга бүхнийг алгасахгүй балбан, байшингаас байшин дамжин, жүүдүүдийг эрж хайн нэгжиж байгаа гэнэ. Заримдаа нэрийн хуудас барьцаан, зохион байгуулалттай гэгч нь баривчилгаа явуулж байгаа юм байхаа. Бидэн шиг баривчилгаанаас өрсөн дүрвэж, бүгж чадаагүй хүмүүсээс нэг нь ч энэ гунигт тавилангаас мултарч чадаагүй ажээ. Заримдаа мөнгөөр барьцаа тавин амиа аварч үлддэг гэнэ. Тэд еврейчүүдийн амь насныхаа төлөө тавьж буй мөнгөөр хэтэвчээ дүүргэж бүр амташжээ.*

*Улирч баларсан эрт дээр үеийн боолын ангуучлал л тийм байсан бизээ. Нүдэнд минь буу агссан аймар догшин царайтай Германууд хүүхэд шуухдыг орилуулж, чарлуулсаар гэм зэмгүй хэдэн мянган хүнийг бүдчүүлэн, эгнээ эгнээгээр нь тууж, жагсаалаас хоцорсныг нь зодож тарчилгаж байгаа үзэгдэн, эрүү өвдөг нийлсэн хөгшичүүд, эхийхээ өврөөс гараагүй нялхас, тэнгэр шиг гэдэстэй бүсгүйчүүд, хоногоо хүлээсэн өвчтөн...бүгд л ингэж эрлэгт очих ёслолоо үйлдэн буй нь төсөөлөгдөнө.*

*Энэ бүхэнтэй зэрэгцүүлэхэд бид энд юутай тайван, амгалан байгаа билээ. Бид өөрсөд шигээ еврей түмний амсч буй энэ гашуун зовлонг үзэлгүй, амар амгалан байна шүү дээ.*

*Гэхдээ үндэс нэгт еврей анд нөхдөө ийнхүү тамын зовлон дунд тарчилж байхад, бид энд халуун орондоо тухтай нь аргагүй хэвтэж байгаадаа санаа зовох юм. Энэн шиг шаналгаатай юм үгүй. Бид еврей хүн болж төрсөн учраас л энэ шүү дээ!*



## 1942 оны арван нэгдүгээр сарын 20. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Бид цөм нэг л тавгүй байна. Еврейчүүдийн тухай мэдээ улам бүр л сонсогдох нь багассаар байна. Үнэндээ ч элдэв муу мэдээ сонсохгүй байх нь сэтгэлд амар байх юм. Мийн ирээд хэн нэг танилд нь тохиолдсон эмгэнэлт явдлыг дуулгахад Даан гуайн авгай, ээж хоёр уйлж гардаг юм. Тиймээс Мийн юу ч дурсахгүйг хичээх болжээ. Дуссел гуай харин түүнийг чөлөө завгүй шалгааж гарахад жаахан юм ярьсан нь аймшигтай мэдээ байсан шүү. Хэдий энд нуугдаж байгаа ч тэр зовлонгоос мултраагүй юм шиг санагдана. Энэ бүхнийг түр ч гэсэн мартагнаж чадвал бид инээж чадах болов уу? Гэхдээ бид хэрэв энэ нуувчиндаа сэтгэлээр унаад уйтгарын далай болгочихвол гадуур айж, түгшиж яваа хүмүүсээс долоон дор болно биз. Гэвч ямар ч байлаа гэсэн Германуудад баригдан одсон хүмүүсээ дурсах л хэрэгтэй. Заримдаа санаандгүй инээж хөхрөхдөө хүртэл ийм хэцүү үед бид ингэж хөгжилдөж болох билүү гэж шаналах боллоо. Үгүй ингэхэд бүхэл өдөржингөө уйтгарлаад байх хэрэгтэй юу? Мэдээж дандаа тэгээж гуньж гутраад байж хэрхэвч болохгүй. Энэ гутранги байдал төгсөнө гэж найдъя даа.*

*Энэ уйтгар гунигаас өөр таагүй юм хэчнээн их байна. Тэр нь хүний зан төрхөөс болж байна. Чамдаа гэж хэлэхэд би чинь сүүлийн үед хэнд ч анзаарагддаггүй ганцаардмал амьтан болсноо мэдрэх боллоо! Өөрийнхөө сэтгэл дотроо нэг л хоосон болсныг анзаараад байна. Урьд нь би ийм болно гэж даанч бодсонгүй явжээ. Ухаан бодлыг минь баяр хөөр, эв найрамдал амилуулж байжээ. Тэгтэл одоо ухаан бодлыг минь муу муухай юм болгон хөндөж эмзэглүүлээд л байх юм. Одоо надад хамгий хайртай аав минь хүртэл орхин одсон тэр аз жаргалтай ертөнцхөнийг минь эргүүлэн сэргээж чадахгүй юм шиг санагднам.*

*Китти минь чи минийхээ яагаад уйтгарлах болсныг мэдэв үү? Заримдаа миний нүгэл хилэнц ийм их болж, хувийн гаслан зовлон минь дааж давахын аргагүй юм шиг санагдан, энэ аймшигаас гарч чадалгүй тэнхэл тасран сөхөрчих вий гэж байх боллоо.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Бид гэрлээ дэндүү их асааснаас цахилгааны хөлсийг хэтрүүлчихжээ. Үүний гайгаар цахилгааныг онцгой хэмнэх хэрэгтэй боллоо. Тэгэхгүй бол тог тасалж хоёр ч долоо хоногоор харанхуй сууж магад гэнэ. Дөрөв буюу дөрөв хагасаас ном уншдаг хөг өнгөрөв. Бид харанхуйд оньсого таалцах, гимнастик хийх, уншсан номынхоо тухай англи, францаар ярьж цаг нөхцөөх болов. Би дурангаар айл хөршийнхнөө дурандах шинэ ажилтай болсон. Хөшгийг өдөр хумсын чинээ ч онгойлгож болох биш. Орой бол харин өөр хэрэг шүү дээ. Айл хөршийнхнөө тийм сонин байдгийг урьд нь мэдээгүй явжээ. Голдуу л хоол ундаа идэж уухыг нь, нэг айлын кино гаргахы нь, эсрэг талд байдаг шүдний эмч нэг аймхай настай авгайг эмчлэхийг л харна.*

*Өө нээрээ шүдний эмч гэснээс! Хүүхдийг сайн ойлгодог, хүүхдэд учиргүй хайртай гээд байсан Дуссел эмч харин яхир зантай өвгөн шиг юм л бол тэг, ингэ гэж зааж зааварлаж, үглэж дуулдаг яришигтай хүн юмаа. Ийм ядаргаатай хүнтэй хамт нэг өрөөнд байна гэдэг жинхэнэ шийтгэл юм уу даа.*

*Энд байгаа гурван хүүхдээс хамгийн хүмүүжил муутайд тооцогдох би гэдэг хүнд үглэж яниших дутсан биш дээ. Томчуудын аашилж загнахаас ангижрахыг аминдаа байдгаараа хичээж, юу ч болж байсан таг дуугүй байхыг бодох боллоо. Гэхдээ Дуссел эмчийн үглэхээс залхчихаад сууж байтал, ээж орж ирж дайран дээр давс нэмэх юмуу, Даан гуайн авгай бас таван минут болов уу үгүй юу үглээд эхэлбэл би ч тэсвэр тэвчээрээ барна л даа.*

*За, Китти минь нэр хугархаар яс хугар гэж юутай үнэн үг вэ? Би гэж хүн дуулгаваргүй охин гэдэг муу нэрнээсээ болоод л ингэж үйлээ үзэж байна шүү дээ. Үгүй тэгээд би өөрийгөө өөрчлөлтэй биш дээ.*

*За, за толгойг чинь эргүүлчихэв бололтой. Бүү уурлаарай! Гэхдээ би харыг цагаанаар хэзээ ч будаж чадахгүй ээ. Цаас ховордсон өнөө үед хуудас цаасыг ч дэмий үрмээргүй байна. Тэр бол ёстой нүгэл! Чамдаа гэж зөвлөхөд үүнийг дуустал нь унших гэж шамдасны хэрэггүй шүү.*

*Анне*

## 1942 оны арван хоёрдугаар сарын 7. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Ханука(еврейчүүдийн үндэсний баяр), Николаус(Холландчуудын өвлийн баяр) хоёр энэ жил бараг зэрэг болов. Ханукагаар лаа асаацгаав. Тэгэхдээ ховордож үнэ нь тэнгэрт хадсанаас арваад минутаас илүү асаасангүй. Хэрэв дуулж болдог бол мөн хөгжилтэй еэ. Даан гуай дэнлүүний маш гое модон суурь урлажээ.*

*Николаусын үдэш хагас сайн таарсан нь харин улам ч дажгүй байлаа. Элли, Мийн хоёр бидний сониуч занг бүүр дэврээчихлээ. Тэднийг дээр аавтай шивнэлдээд байхаар нь нэг юм болох нь гэж хүлээцгээв.*

*Найман цаг болоход цөм шатаар буун харанхуй хонгилоор явахдаа бага зэрэг айдас хүрч байсан ч ямар нэгэн гэнэтийн бэлэг хүлээж байгаа даа гэхээс сониуч зандаа хөтлөгдөн явсаар конторуудын дундах хэсэг зайнд хүрэв. Тэр өрөө нь цонхгүй учир гэрэл асааж, аавыг ханын шүүгээ нээхэд бүгд л гайхаж шагшандаа “Өө юутай гоё юм бэ?” гэлцэн дуу алдав. Шүүгээн дотор эрээн мяраан цаасаар хээлж, хуарлан, хар Петерийн багаар бэлэгдэн чимсэн том сагс байж байлаа. Бид тэр сагсаа дээш авчирангуут ерөөлийн бадаг шүлэг бичиж хийсэн өөр өөрсдийнхөө бэлгийг авцгаасан. Чи тиймэрхүү ерөөлийн бадаг шүлэг олныг сонссон болохоор тэр бүхнийг нуришаа болих уу даа. Би томоос том гурилан боовон хүүхэлдэй, аав номын тулгуур, ээж хуанли, Даан гуайн авгай тоосны алчуурын сав, Даан гуай тамхины үнсний сав бэлгэнд авцгаалаа. Цөмд нь овоо бэлэг өгсөн нь Николаусын баярыг нэг л гоё санагдуулчихав. Яахав хоргодох байрандаа бид ингэж аятайхан л хөгжилдлөө.*

*Бидэнд санаа тавьж байгаа нүүсийхэндээ жаргалтай сайхан цагаас үлдсэн ганц нэг юмнаас бэлэглэв. Ноён Воссенд Даан гуайн үнсний савыг, аавын номын тулгууртай бэлэглэв.*

*Анне*

## 1942 оны арван хоёрдугаар сарын 10. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Даан гуай уг нь мах, хиам, цуу боловсруулдаг мэргэжлийн хүн юм. Тиймээс энэ чиглэлийнхээ нэг фермд ажиллаж байжээ. Даан гуай одоо хиамны тэр мэргэжлийнхээ хүчээр бидний ходоодыг заримдаа баярлуулаг аа. Бид мах хомсдох үедээ хэрэглэхээр нэлээд их мах даршлах санаатай авлаа. Мэдээ дамын үнээр авсан. Махыг хоёроос гурван удаа машиндах нь сонин юм. Тэгснээ амталж, эцэст нь өлөн гэдсэнд чихэв. Ингээд л шарсан хиам, байцааны давсалсан шанцайтай үдийн хоол болох нь тэр. Нөөцлөх хиамыг хатаах хэрэгтэй тул хананд татсан хэцэнд тохов. Орсон гарсан бүгд л тэр хиамнуудын агаарт савлахыг хараад, инээхгүй өнгөрнө гэж үгүй. Тийнхүү харах зугаатай юмтай боллоо. Чамд сонирхуулах юм нэлээд ихтэй. Авгайнхаа хормогчийг зүүсэн Даан гуай том биеэрээ бөгс эргэх зайгүй болтол хөндөлсөөд хиамны мах татаж, амталж, түүнийгээ өлөнд чихэх гээд л зав чөлөөгүй ажиллана.*

*Даан гуай халууцсандаа мал нядлагч шиг л харагдана. Юм юманд оролцомтгой Даан эзэгтэй ч гэсэн нэг гартаа Холланд хэлний ном барьж, нөгөө гараараа шүүс хутган, татсан махыг харангаа хавирга гэмтсэн гэж гонгиноно. Энэ нь турах гэсэн хөгшин нэрэлхүү авгайчуулын хийдэг элдэв балай дасгалаас л болсон хэрэг л дээ. Нүд нь өрөвсөж улайсан Дуссел эмч пийшин бараадаж дугтуй хийнэ. Аав цонхон дээр нарны зурвасхан гэрэл бараадан сууна. Харваас үе мөчний нь хууч хөдөлсөн бололтой. Тэр сандал дээрээ бөгцийн сууж ажилдаа шимтсэн Даан гуайг ажиглана. Петер Муши гэдэг мууртайгаа тоглоно. Маргот, ээж бид гурав төмс цэвэрлэнэ. Ер нь Даан гуайн хиам хийхийг харах гэж бүгдээрээ л гар хурууны үзүүрээр аар саар юм оролдсон болж байсан.*

*За тэгээд Дуссел гуай шүдний эмчийхээ ажлыг эхлэв. Хоргодох байранд хийсэн шүдний анхны эмчилгээний тухай сонсох нь чамд лав зугаатай даа. Даан гуайн авгай эхлээд эмчлүүлэх юм болов. Ээж тэр үед нь юм индүүдэж байсан юм. Дуссел гуай өрөөний голд сандал тавин Даан гуайн авгайг суулгаад багаж хэрэгслээ гаргадаг юм байна. Тэр ариутгах үнэртэй ус, вазелин авмагцаа Даан гуайн авгайн амыг ангайлган харж, шүдийг нь тогшсоноо өвчтэй араагий нь ухаж гарлаа. Даан гуайн авгай тэр бүрд нь үргэлж хавчигнаж, хөндүүрлэхдээ дуу алдана. Үнэндээ бол хоёрхон минутаас хэтрээгүй, өвчтөндөө бол зөндөө удах шиг болсон энэ үзлэгийнхээ дараа эмч хорхой идсэн шүдий нь эмчлэх юм болов. Харин тэгэхэд юу болсон гэж санана. Шүднийх нь цоорхойг цэвэрлэх үед Даан эзэгтэй гар хөлөө сарвалзуулан тийчигнэхэд араанд нь үлдээсэн дэгээгээ авах гэж Дуссел гуай зүтгэн бөөнэ юм болдог байна шүү. Ёстой л нэг бөхчүүд шиг ноцолдож гарах нь тэр. Арай гэж дэгээгээ салгаж аваад шүдийг нь өрөмдөх юм болов. Даан гуайн авгай тэгэхэд бас л гар хөлөө сарвалзуулаад, өрмөө сугалж авахын завдалгүй хэт өрөмдүүлчихээд байв. Дуссел эмч тайвнаар гарыг нь зайлуулан тэр явдлыг хараг гэсэн байртай эмчилгээгээ үргэлжлүүлэв. Харин энэ эмчилгээг үзэж суусан бидний зарим нь баахан хөхрөлдөв.*

*Даан гуайн авгайг орилуулж, чарлуулсаар арайхийж багажаа амнаас нь авсан Дуссел гуай юу ч болоогүй юм шиг эмчилгээгээ хийсээр байлаа. Ер нь өвчтөнийхөө тэсэж байгаа дээр нь дуусгая гэсэн янзтай эмчилгээгээ улам ч түргэлэв. Ер нь тэгээд урьд өмнө нь хэзээ ч*



*байгаагүй олон туслагчтай эмчиллээ. Учир нь Даан гуай бид хоёр сувилагчийн оронд түүнд тусалсан юм. Харамсалтай нь өвчтөний маань тэвчээр сүүлдээ бүүр алдрав. Эмчилгээ дуусангуут тэр хоол ундны нарийн дэглэм барина гэж ярьж гарав. Мэдээж дахин ийм аймшигтай эмчилгээ хийлгэхээс айж байгаа биз.*

*Анне*

## 1942 оны арван хоёрдугаар сарын 13. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Би пүүсний том конторт цонхны дэргэд суучихаад зузаан хүнд хөшигний завсраар гадаа болж байгаа явдлыг харж сууна. Үдшийн бүрий болж байгаа ч гэсэн чамдаа үүнийг бичиж байгаа болохоор гэрэлтэй байна. Гадаа гудамжаар явж байгаа хүмүүсийг харах сонин юм. Зарим нь яарч сандран алхах нь хөлөөрөө явах биш гулгаад байх шиг. Эрэгтэй, эмэгтэй нь мэдэгдэхгүй дугуйтай хүмүүс жирэлзэн өнгөрцгөөнө.*

*Манай эндэх чинь ёстой л борчуудын дүүрэг юм байна. Хүмүүс нь ядуу, хүүхдүүд нь гар хүрэхийн аргагүй хар халтар, хир буртагтай явдаг юм байна. Тэр нусгай халтар жаалууд нэг дуу шиг юм дуулалдаад байх шиг. Даанч тэр нь ойлгогдохгүй юм. Өчигдөр Маргот бид хоёр усанд орж байхдаа "Хүүе тэр халтар жаалуудаас ганц хоёрыг нь ч гэсэн авчраад усанд оруулж, цэвэрхэн хувцас өмсгөөд гаргах юмсан. Тэгвэл ч..." гэж намайг хэлэхэд Маргот харин:*

*-Тэд чинь яаж ч угаасан маргааш нь ахиад л бохир, уранхай хувцастайгаа гүйлдэнэ за юу гэдэг байгаа.*

*Бас л машин тэрэг, усан онгоц, бороо орж буй нь үзэгдэнэ. Цахилгаан тэрэгний шуугихыг сонсохуйяа элдвийн мөрөөдөлд автчихлаа. Бодол санаа минь яг л бидэн шигээ хашигдаж хоригдон ядуураад, еврейчүүдийн тухайгаас идэх уухын тухай, идэх уухаас улс төрийн тухай, улс төрөөс дахиад л еврейчүүдийн тухай гэх мэт нэгэн бяцхан хүрээнд эргэлдэнэ. Өчигдөр бид хөшигний цаанаас гудамжинд яваа еврей хүн харав. Тэгэхэд хөөрхий тэднийг золиосонд хаяад, зовж яваагийг нь харах гэж энд суугаа юм шиг санаа зовж байлаа.*

*Манай эсрэгхэн эрэгт завь онгоцонд нэг загасчных суудаг юм. Тэр завь онгоцны хитэг дээр хуцахы нь ч таних болсон нэг хав гүйж яваа үзэгдэнэ. Бороо дахин цутгаж бараг хүн бүр шүхэр барьжээ. Цув, юүдэнтэй хүмүүс л харагдана. Өөр ч хараад байх юм алга. Харин өргөн ташаатай улаан ногоон өнгийн пальто өмсөж, элэгдэж хуучирсан цүнх барьсан, төмс чихсээр байгаад таргалж аахилсан авгайцуулыг би ялгаж мэддэг болов. Тэд нар эр нөхрийнхөө зан араншингаас болж зарим нь уйтгартай, зарим нь сэтгэл хангалуун янз бүрийн л царай зүстэй явах юм даа.*

**Анне**

## 1942 оны арван хоёрдугаар сарын 22. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Манай нуугдагчид христосын мэндэлсэн өдрөөр хүн бүр 125 грамм цөцгийн тос илүү авах болсныг сонсоод бөөн баяр болцгоолоо. Албан ёсныхоороо бол хүн бүрд 250 грамм цөцгийн тос олгох юм байх. Тэр нь харин наранд амьдрагч азтай хүмүүст л хамаатай л даа. Гэхдээ нуугдаж бүгсэн бидний найман хүнд дөрвөн хүний л карт дамын үнээр олдож байгаа нь аз гээд баярлаж суусан нь дээр. Тэр цөцгийн тосоор нэлээд юм жигнэж болно. Хоёроос доошгүй бялуу хийнэ гэж манайхан тогтов. Ээж намайг гэр орны ажил хийж дуусахаас нааш юу ч уншиж үзэж болохгүй гэв.*

*Хавирга сүврэгний бэртэнгэ хөдлөөд гэр орондоо орсон Даан хатагтай үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол асруулж сувилуулаад байгаа мөртөө цаг үргэлж гомдоллон сэтгэл дундуур хэвтэнэ. Түүнийг босч гэр орныхоо ажлыг хийвэл баярлах л байна. Үнэнийг хэлэхэд Даан гуайн авгай бие нь зүгээр, ааш нь сайн байхдаа бас ч зугаатай, ажилд махруу юмсан.*

*Инээдтэй юм. Миний дуу шуу ихтэйгээс болоод Дуссел эмч өдөржингөө “Чи, чи” гэж сануулсаар байгаад шөнө хүртэл унтаагаараа “Чи, чи” гээд байдаг боллоо. Түүнийхээр бол би гэдэг хүн шөнө ч орондоо хөрвөөж болохгүй юм гэнэ. Би л сүүлдээ өөрийг нь бас “Чи” гэж байдаг боллоо. Тэгээд бас өөрөө бүтэн сайны өглөө бүр гимнастик хийж байгаа нь энэ гэж хар үүрээр гэрэл асааж лай болж уур хүргэхийг нь яана. Цаг хэртэй үргэлжилдэг тэр тэнэг гимнастикаа хийж байгаад нэг удаа орны минь хөл дэх хивсэн сандал хөдөлгөн намайг сэрээх нь тэр. Унтахгүй ч гэсэн би ядаж тайван байх эрхтэй л баймаар юм. За тэгээд биеэ чийрэгжүүлэн, гоо сайхан галбиртай болгодог гэх тэр дасгалаа дуусангуут л нөгөөх чинь угааж арчиж эхэлнэ. Өлгүүрт дотуур өмдөө өлгөж орхиод хэсэг алга болсноо буцаад ирнэ. Ширээн дээр зангиагаа мартчихаад авах гэж нааш цааш гүйн сандал унагаж босгохы нь яана. Бүтэн сайн өдөр жаахан хэвтэх гэсэн маань тэгээд л өнгөрдөг юм.*

*Ийм инээдтэй том хүнд уурлаад ч яах билээ. Заримдаа дүрсгүйтмээр санагдхаараа би хаалгаа түгжиж, чийдэнгээ унтраагаад хувцсыг нь нуучихна. Хэрүүл маргаангүй найрсаг байхын учир тэгээгүй нь мэдээж билээ.*

*За гайгүй, ямар байхыг нь нэг үзүүлье. Амаа татаж, хэлсэн ярьсныг нь даган, нөхөрсөг, тусч, дуулгавартай ямар Анне байх ёстой тийм л байя. Өөр ямар байх ёстойг мэдэхгүй байна. Хааяа ч гэсэн сэтгэлээ сэргээж байхгүй бол дайн дуусахад хүүхдээрээ бүүр хөгширчихсөн байх ч юм билүү?*

*Анне*

## 1943 оны нэгдүгээр сарын 13. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Би өнөөдөр нэг л сэтгэл хямраад амарч ч ажиллаж ч чадахгүй байна. Гадуур бүр ч аймшигтай юм болж байгаа гэнэ. Хүмүүсийг өдөр шөнөгүй баривчлан дараа нь тэртэй тэргүй хураагаад авчихдаг юм байж үүргэвч, цөөн мөнгөнөөс өөр юу ч авхуулахгүй хорих лагерь луу тууж байгаа гэнэ. Нэг гэр бүлээс хэнийг ч хамаагүй бариад явчихдагаас заримдаа хүүхдүүд хичээлээсээ ирэхэд аав ээж нь баригдаад явчихсан, эсвэл ээж нь хүнсэнд яваад ирэхэд гэрийхнийг нь аваад явчихсан хаалгыг нь лацадсан байдаг болсон гэх юм.*

*Еврей биш христос шашинтныхан ч залуус хөвгүүдийг нь герман руу илгээх болсноос мөн л бөөн буужигнаан. Зовлонгүй хүн гэж үгүй болжээ.*

*Хэдэн зуун нисэх онгоц германы хотыг бөмбөгдөхөөр шөнө бүр Холландын дээгүүр нисэн өнгөрч, орос, африкт хэдэн мянган хүн цусанд живж байна. Дэлхий ертөнц бүхэлдээ дайнд нэрвэгдэн, газар сайгүй алаан хядаан болж байна. Эвслийнхний байдал гайгүй ч дайн яаж төгсөхийг таахын аргагүй.*

*Ийнхүү зовж буй сая сая хүнтэй харьцуулбал бид сайхан л байна. Тухтай нь аргагүй бүгж, дайны дараа юу хийхээ төлөвлөн, хувцас шинэ номоор сэтгэлээ баярлуулахын хамт бас хэн нэг хүнд туслан, амийг нь аврахын тулд идэх уух юмаа хэмнэж л сууна. Эндхийн хүүхдүүд цөм л нимгэн хүрэм холхиндог угласан модон шаахай төдийхөнтэй, пальто, малгай, бээлий ч үгүй гүйлдэх юм. Өлсөж турсан энэ хүүхдүүд ялзарсан лууван төдийхөн идэж, гал хөсгүй сууцнуудаас ус шавхай, салхи шуурга болсон гудамжинд гарцгааж, мөн л хүйтэн нойтон чийг даасан анги танхимдаа очих бөлгөө. Тиймээ, Холланд гэгч улс хүүхдүүд нь дэргэдүүрээ өнгөрсөн хүнээс зүсэн талх гуйхдаа тултал амьдрал нь доройтжээ. Хэдэн цагаар ч яриад дуусаагүй энэ их зовлон дайны л уршиг шүү дээ. Бид тэр бүх зовлонг дэмий л харж сэтгэл эмтрэхээс цаашгүй юм даа. Ер нь дайны хүнд хэцүү үеийг тэвчээртэй давж туулахаас өөр зам алга.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Би гэдэг хүн биеэ барьж чадахааргүй уурлах болоод байна. Гэхдээ энэ уураа хэнд ч мэдэгдэхгүйг хичээх юм. Заримдаа багтартлаа хашигчин, дэвсэлж ээжийг хүртэл сэгсрээд авмаар болох юм. Ээж, Маргот, Дуссел, Дааныхан болон аавын өөдөөс ч гэсэн “Намайг тайван байлгаач. Шөнөжингөө дэрээ нортол уйлж цурамхийлгүй үдишийг өнгөрөөх намайг ганцааранг минь орхиод өгөөч. Та нараас, энэ орчлон ертөнцөөс тонилоод өгөх сөн. Та нар намайг хичнээн шаналж цөхөрч байгааг минь мэдэхгүй байна. Та нар миний сэтгэлийг хичнээн шархлуулж байгаагаа ойлгохгүй байна.” гэж хашигирмаар болох юм.*

*Тэдний намайг өрөвдөх, егөөдөхийг ч ганц ч мөч тэсвэрлэшигүй нь. Тэр нь намайг зөвхөн л уйлж унжихад хүргэж байна. Бүгд л намайг үг хэлбэл инээдэмтэй юм, дуугүй суувал минь увайгүй, хэлсэнд нь хариулбал өөллөө, санасан бодсоноо хэлэхээр залхуурлаа, ядарснаа хэлбэл амиа бодлоо, санамсаргүй хоолноос илүү халбагадчихвал ховдоглолоо гэх мэтээр өөлж гоочилно. Өдөржингөө л өөрийгөө тэсэхүйеэ бэрх хачин амьтан гэж хэлэхийг сонсох юм. Тэр бүхний нь тухайд инээн, яагаа ч үгүй юм шиг дүр үзүүлэхээс залхлаа. Заримдаа намайг ингэж хүмүүст гадуурхагддаггүй хүн болгож өгөөч гэж бурханд ч залбирмаар болох юм. Тэр нь мэдээж бүтэшгүй л дээ. Миний бодгаль бол байгалиас заяагдсан юм. Өөрийнхөө гүн гүнзгий дотоод шаналгаагаа нуухын тулд тэднийг даган инээж байна. Би нэг өдөр нь хөөрхий хөөрхий болон хэтэрхий нялуурч, маргааш нь гахай нохойдоо хүрэн уралцаж хэзээ ч чадахгүй хүн. Нэг их гэгээрсэн биш мөртлөө төвийг сахиж бодол санаагаа тас нуугаад яг л тэдний надад ханддаг шиг үл тоомсорлосон дүртэй байх нь зөв юм байна даа. Хэрэв чаддаг л юм бол.*

*Анне*

## 1943 оны хоёрдугаар сарын 5. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Хэрүүл маргааны тухай чамд бичилгүй удчихжээ. Гэхдээ нэг их өөрчлөгдсөн юмгүй л байна. Дуссел гуай энд дасч өгөхгүй эхлээд бас л зовж байлаа. Одоо харин хоргодох байрандаа овоо дасаж, тийм ийм гэхээ болив.*

*Маргот, Петер хоёр их л төлөвшиж буурьтай суурьтай хүмүүс болжээ. Мэдээж тэднээс болоод “Маргот, Петер хоёр шиг байгаач. Тэдний юу хийж, юуг хийхгүй байгааг хараач.” гэж залхтал үглэцгээхийг нь сонссоор л байна. Ой гутмаар юм. Би хэзээ ч Маргот шиг болохыг хүсэхгүй гэдгээ чамд дуулгая. Тэр дэндүү уйтгартай, үхээнц, өөрийн гэсэн бодолгүй, хүн хүний аяыг олох гээд ядчихсан юм шиг санагддаг. Хүн ер нь хэзээд өөрийн гэсэн бодолтой байх ёстой. Гэхдээ энэ онолыг би өөртөө л бодож явъя. Тэгэхгүй бол бас л үглэж, янишцаах болно биз.*

*Бид хоолны ширээнд суух бүрд л хэрүүл болно. Гэтэл өнөөдрийн хөнгөн цайн дээр нүүснийхэн ирсэн байсны ачаар ямар ч хэрүүлгүй нам гүм өнгөрөв. Өнөөдөр Даан гуай үдийн хоолон дээр Марготыг юу ч идэхгүй юм гэснээ “Бас л өнөө таргалхаас айгаад ингэж хоолоо сойгоод байгаа юмуу” гэсэн хорон үгээр яриагаа дуусгалаа. Марготын төлөө яахаас ч буцдаггүй ээж тэгэхэд нь чангаар “Та нарын энэ тэнэг яриаг сонсохгүй юмсан” гэхэд Даан гуайн авгайн царай минчийн улайв. Авгайгаа улайгаад явчихаар Даан гуай дэмий л урагшаа харан гөлөлзөв.*

*Гэхдээ бид заримдаа хэрэлддэг ч гэсэн бас зөндөө инээж хөхрөлддөг юм шүү. Даан гуайн авгай саяхан өөрийнхөө гэнэхэн, гэмгүйхэн сээтэгнэлийн түүхийг аль хөгжсөөнтэйгөөс нь ялангуяа тэр бүрдээ аавыгаа яаж молигддог байснаа ярив. Петерийн донгио номой зангаар бид бас өчнөө тоглоом хийдэг юм. Тэр заримдаа гадаад үгийн утгыг мэдэхгүйгээс бөөн онигоонд орчихно. Нэг удаа Петер аавын хуучин өрөөнд ороод байж байтал жорлонд орж чимээ гаргаж болохгүй болчихжээ. Гэтэл бие засахгүй бол тэсэхийн аргагүй болоод байдаг. Жорлонд ороод чимээ гаргахаас айсандаа усаа таталгүй орхиод гарчээ. Тэгээд жорлонгийн ус татаагүйгээ бидэнд мэдэгдэх гэхдээ “S’il vous plait, Gas!” гэж францаар бичээд жорлонгийн хаалган дээр наажээ. Уг нь “Болгоомжлоорой, эвгүй үнэртэй.” гэж бичих гэсэн хүн чинь харин “Эвгүй үнэр болгооно уу.” гээд биччихсэн гэж байгаа. Гэтэл мань хүн одоо хүртэл энэ нь францаар “болгооно уу” гэсэн үг гэдгийг мэддэггүй байсан байгаа юм.*

*Анне*

## 1943 оны хоёрдугаар сарын 27. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өдөр бүр ялалтын тухай чих тавьж байх боллоо. Черчилль хатгаа тусч гэнэ. Гэхдээ бие нь сайжирч байгаа юм байх. Энэтхэгийн эрх чөлөөний нэрт тэмцэгч Ганди дахин дахин өлсгөлөн зарлажээ. Даан гуайн авгай хувь тавилан л мэднэ гэх боллоо. Буудуулахаас бидний хэн нь хамгийн их бол?*

*Хенк бүх сүм дуганыханд илгээсэн хамба ламын шувуут захидлыг авчирчээ. Хүмүүсийн зүрх сэтгэлийг уриалан дуудаж чадсан тэр захидалд “Холландчууд аа, бид тэвчих цаг дууслаа. Хэн ч байсан эх орон, ард түмэн, шашин шүтлэгээ хамгаалахын төлөө зэвсэг барин тэмцэгтүн! Цаг алдалгүй эх орондоо туслацгаая!” гэжээ. Гэвч энэ уриалга тус болох юм гэж үү?*

*Юу болсныг чи нэг боддоо. Пүүсний байшинг түрээслэгч эзэн нь ноён Коофуйс, Кралер нарт юу ч мэдэгдэлгүйгээр бидний хоргодож буй байрыг худалдахаар болсон гэнэ. Шинэ эзэн нь нэг өглөө юу юуны тухандгүй пүүсний байшинг үзэхээр уран барилгачинтай ороод иржээ.*

*Бурхан өршөө, ашгүй Коофуйс ноён байж тааралдаад арын бүгэвчийг хүртэл тэдэнд үзүүлэв. Тэгээд бидний хоргодож байгаа бүгэвчний хаалганы түлхүүрийг нь гэртээ орхичихож гээд тэр ноёдод үзүүлэлгүй өнгөрчээ. Азаар тэд түүнээс өөр юм асуулгүй өнгөрч. Дахиад байшин хаашаа үзэх гэж битгий л ирээсэй. Түүн шиг аймшиг алга.*

*Аав бидэнд номын картын тавиур өгөв. Маргот бид хоёр одоо Доверсийн гэх номын жагсаалттай карттай болж уншсан бүх номынхоо картыг зохиогч төдийгөөр биш харин агуулга, өөрсдийнхөө сэтгэгдлийн хамт тэмдэглэн тэмдэглэл хөтлөх болсон шүү. Би бас гадаад үгнүүд, өвөрмөц хэллэгийг нь дэвтэрт бичиж тэмдэглэнэ.*

*Сүүлийн үед ээж бид хоёр нэлээн сайн ойлголцох боллоо. Тэгэхдээ жинхэнэ итгэлцэл нэлээд удна бизээ. Маргот хэн бүхнээс илүү золбоожиж, аав нэг л юмаар оролдон, түүндээ улайрна. Гэхдээ аав минь надад хэнээс ч илүү дотно хэвээрээ байна!*

*Хиймэл болон жинхэнэ цөцгийн тос хуваарилах юм болов. Хүн бүхний тавганд өөр өөрийнх нь хувийг тавьжээ. Хэрэв Даан гуайнхан хуваасан бол ч бөөн бульхайтай юм болох байсан биз. Аав ээж хоёр байнгын хэрүүлийн үг залхталаа сонссон ч хариу хэлэхгүй юм даа. харамсалтайяа! Минийхээр бол иймэрхүү хүмүүст бас таарсан хариуг нь барьж баймаар юм.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр орой тог тасарснаас гадна агаараас хамгаалах их буунууд тасралтгүй нижигнэн тав муутай байсан. Бөмбөгдөгч онгоцны болон буун дуунд бас л дасаагүйдээ ч юмуу, айхдаа би аавынхаа өвөр рүү орой бүр гүйдгээрээ гүйлээ. Би ч шал нялхаараа амьтан байгаа биз. Гэхдээ чи нэг ч удаа гэсэн над шиг аашлаад үзээрэй! Чи лав их бууны нүргээнд өөрийнхөө хэлснийг ч сонсохгүй биз. Хувь тавиланч Даан гуайн авгай яадаг гэж санана. Буун дуу нэжигнээд эхэлмэгц уйлагнан, амандаа “Ээ таминь, юун ч их буудалцдаг юм бэ!” гэж дуулдахтэй үгүйтэй үглэнэ. Тэр нь бодвол “Яасан ч их аймар юм бэ дээ!” гэсэн үг байх л даа. Өдөр бол арай ч шөнө шиг биш л дээ. Би халуунтай юм шиг хаширан, лаагаа асаагаач гэж энэ шөнө аавыг гуйв. Аав харин юу ч сонсоогүй юм шиг хэвтээд л гэрэл асаасангүй. Тэгтэл их бууны дуунаас долоон дор өнөөх пулёмётууд нь гэнэт тачигналдаад эхэллээ. Ээж маань аавд уурлан тэсэлгүй орноос босож лаа асаахдаа:*

*-Анне чам шиг буун дуунд дөжирчихсөн хөгшин цэрэг биш гэлээ. Ингээд л болох нь тэр!*

*Би чамдаа Даан гуайн авгайн занг ярьж байсан байхаа? Чи ер нь манай хоргодох байранд юу болж байдгийг бүгдийг нь мэдэх хэрэгтэй. Нэг өдөр Даан хатагтай агуулах руу явж байгаа хулгайчийн хөлийн чимээг сонсоод айхдаа нөхрөө сэрээжээ. Даан гуайд харин нөгөө хулгайчийн хүнд хөлийн чимээ биш ердөө л хувь тавиланг зөгнөгч эхнэрийнх нь зүрх түг түг цохихоос өөр юу ч сонсогдсонгүй гэнэ. Даан авгай тэгтэл:*

*-Хүүш Пүти гэж нөхрөө дуудаад:*

*-Тэд лав хиам, вандуйг маань хулгайлж байгаагаас зайлахгүй. Петер маань хаана байна вэ? Цаадах чинь байна уу гэхэд Даан гуай:*

*-Тэд Петерийг яалаа гэж хулгайлах бэ? Битгий айгаад бай! Намайг тайван унтуулж үз гэжээ. Даан эзэгтэй болохоор айсандаа унтаж чадсангүй гэнэ.*

*Түүнээс хойш хэд хоног өнгөрсний дараа нэгэн шөнө Даан гуайнхан бас л нэг ер бусын чимээнээр сэржээ. Петерийг гар чийдэнгээ авч агуулахад орвол сүрэг харх гүйлджээ. Хулгайч хэн байсныг мэдээд бид Муши муужгайг тэнд хонуулдаг болов. Тэр цагаас хойш харх хэмээх урилгагүй зочин шөнө ч үзэгдэхээ больсон. Харин хэдхэн хоногийн өмнө Петер оройн долоо хагаст гэрэлтэйд хэдэн ширхэг хуучин сонин авчрах гэж дээврийн агуулахад гарчээ. Буухдаа дээш гардаг нүхний амсраас барих байв. Тэгээд санамсаргүй нүхний модон хашилаган дээр нь гараа тавьтал часхийгээд явчихаж. Өвдсөн айсандаа золтой л уначихсангүй гэнэ. Бууж үзвэл харх хазсан байжээ. Өмссөн хувцас нь нил цусанд будагдаж, царай нь цагаан даавуу шиг цайж, өвдөг нь чичирч байв. Хэн ч гараа санамсаргүй харханд хазуулна гэдэг дэндүү аймар хэрэг шүү.*



*Хайрт Китти минь!*

*Нэгэн сонин дуулгахыг зөвшөөрнө үү. Миний ээж буюу хатагтай Франк гэнэт залуусын эрхийг хамгаалагч болчихлоо! Охид хөвгүүд бидэнд цөцгийн тос нэмж өгөх, бидэнд холбоотой асуудлыг шийдэхийн төлөө шаргуу тэмцэх болсон гээч! Ээж маань үргэлж Маргот бид хоёр болон Петерийн талд зогсоно. Тэгээд бидний төлөө нэлээд маргалдаж байж санасандаа хүрнэ.*

*Бас даршилсан нэг шил хэл мууджээ. Муудсан хэл Муши, Мофи хоёр мууранд л дээд зэргийн зоог болох нь тэр. Өө нээрээ, чи минь Мофи муурыг мэдэхгүй байх аа. Мофи бол биднийг энд ирж нуугдахаас өмнө нүүсний байранд байсан мий. Түүнийг нүүсийнхэн зоорины муур болгосноос хойш агуулахын хархнууд бүр дийлдэхээ болилоо. Учир нь энэ нүүс урьд нь агуулахын, зоорины гэсэн хоёр мууртай байжээ. Харамсалтай нь, хоёр муур хаа л тааралдана үргэлж уралцаж, муудалцдаг байж. Агуулахын муур нь өддөг, зоориных нь ямагт дийлж төгсдөг байжээ. Түүнээс болж агуулахын Мофиг Герман, зоорины муурыг Томми гэж нэрлэжээ. Хожим Томми нь алга болж, Мофи нь үлдэж бидэнд байгаа нь энэ юм.*

*Хүүш ээ, манайхан сүүлийн үед харахаас дургүй хүрч, огиултлаа цагаан вандуй идэж байна. Оройдоо талхны бараа харахгүй болсоор удаж байна. Аав минь талх олуулах гэж хөөцөлдүүлж л байгаа гэнэ. Хөөрхий, муу аавын минь нүд нь улам л уйтгартай болоод байх юм.*

*Ина Боудер Бэккэрийн “De Rlor op de deur” гэдэг номыг уншаад бараг л галзуурах шахдаг юм байна. Нэгэн гэр бүлийн тухай роман юм. Өгүүлэмж нь гайхмаар юм. Дайн, хүүхнүүдийн явдал гээд энэ номонд гарч байгаа бүхэн бүгд дургүй хүргэчихлээ. Сүүлийн үед сонин юм юу ч алга. Герман орон аймшигт бөмбөгдөлтөд нэрвэгдэж байна. Янжуур тасарснаас Даан гуай татах тамхигүй баларч байнаа. Даршилсан ногоогоо идэх үү, байх уу гэдэг нь охид, хөвгүүдэд ашигтайгаа шийдэгдэв. Би түрийтэй гутлаас өөр өмсөх юмгүй болчихлоо. Гэрт түрийтэй гутал ямар эвгүй гээч. Сүрлэн шаахай бол дөнгөж долоо хоног өмсөв үү үгүй юу салаад уначих юм. Мийн эгч л дамаас нэг гутал залгуулах байх. Аавын үсийг заслаа. Намайг үс сайн заслаа гэж аав дараа нь надаас өөр хэнээр ч үсээ засуулахгүй гэдэг байгаа. Би ч уг нь үсий нь засахчаа аядахдаа чихэнд нь хайчаа хэд хэд шүргээд авсан байхад шүү.*

*Анне*

**1943 оны гуравдугаар сарын 18. Пүрэв гариг**

*Хайрт Китти минь!*

*Турк улс дайнд ороцлоо. Бөөн шуугиан, тийм мэдээ радиогоор сонсоно гэж даанч санасангүй.*

*Анне*

## 1943 оны гуравдугаар сарын 19. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Гайхмаар нэг юм сонсогдсон нь дэвхцэн баярлахад хүргэснийг яана! Турк дайнд ороогүй юм байна! Туркийн гадаад явдлын яамны сайд нь төвийг сахина гэж мэдэгджээ. Худал мэдээ тарсны учир нь Вангийн ордны өмнөх “Дам” талбай дээр нэг сонин худалдагч “Туркууд английн талд!” гэж хашгирсан юм гэнэ. Тэр нь ам дамжин дамжсаар бидэнд хүрэхдээ Турк дайнд оржээ болтлоо цуурсан байгаа юм даа.*

*Таван зуут, мянгатын гульдений дэвсгэртүүдийг хүчингүй болгожээ. Түүн шиг том гай дамчид болон бидэн шиг нуугдсан хүмүүст байхгүй. Хэрэв мянгатыг задлуулах гэвэл хаанаас хэнээс авснаа заавал хэлэх ёстой болсон гэнэ.*

*Дуссел гуай шүдний гар өрөмтэй болсон. Удахгүй миний шүдийг ломбодохдоо тэр өрөмөө хэрэглэх байх.*

*“Бүх германуудын фюрер” Гитлер шархадсан цэргүүдийнхээ өмнө үг хэлж, дараа нь тэдэнтэй ярилцжээ. Сонсохоос ой гутах юм. Жишээ нь:*

*-Намайн Хенрих Шеппель гэдэг.*

*-Хаа шархадсан бэ?*

*-Сталинградад!*

*-Яаж шархадсан бэ?*

*-Хоёр хөл хөлдөж, зүүн гар хугарсан.*

*Радиоогоор энэ яриаг хүүхэлдэйн жүжиг шиг улиг болтол давтах юм. Бодвол тэр цэрэг нь шархадсанаараа бахархаад байгаа бололтой. Уг нь германууд шархдаж л байвал сайн биз! Нэг гар нь шархадсан герман цэрэг фюрертэйгээ гэр барих завшаан тохиолдсон чинь зүүн гартайгаа үлдсэндээ хэлэх үгээ олж ядан баярлаж буйгаа хэлсэн ч гэх шиг.*

*Анне*

## 1943 оны гуравдугаар сарын 25. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр аав, ээж, Маргот бид дөрвийг нээх сайхан халуун бүлээрээ сууж байтал Петер орж ирээд аавтай шивнэлдэж гарлаа. Сонсвол дэлгүүрт нэг торхтой юм унаж, хэн нэг хүн хаалганы тэнд юм оролдоод байх шиг байна гэв. Түүнийг Маргот ч бас сонсов бололтой. Миний царай айснаас болоод цаас шиг цайхад тэр намайг тайвшруулах гэв. Аав Петер хоёр тэгээд гараад явчихав. Бид гурав хүлээгээд үлдлээ. Дараа нь хоёр минут болов уу үгүй юу аавын хуучин контороос Даан эзэгтэй орж ирээд радиогоо таслаад дээшээ чимээгүйхэн шиг гар гэнээ гэв. Хүн ер нь болгоомжлох гэж хичээх тусам улам алддаг юм билээ. Даан эзэгтэй алхах бүрдээ хуучин шатны гишгүүрийг улам чанга хяхтнуулна. Аав, Петер хоёр яваад дөнгөж таван минут л болж байлаа.*

*Айснаас хамрын нь үзүүр хүртэл цайчихсан тэр хоёр буцаж ирээд юу сонссоноо ярьцаалаа. Тэд доош бууж зорины шатны тэнд очиж чимээ чагнажээ. Эхлээд юу ч сонсогдсонгүй гэнэ. Тэгтэл хүчтэй нь аргагүй түниших сонсогдон хаалга саван онгойх шиг болжээ. Тэгэхэд аав ганцхан үсрээд дээш гарч, Петер нааш ирэх гэж юмаа цуглуулан байсан Дусселийг авчирчээ. Бид цөм л оймстойгоо Даан гуайнхруу гэтэв. Даан гуай салхи цохиулчихаад хариугүй хэвтэрт байв. Тэнд цөм цуглацгаан тэгсэн байх, ингэсэн байх гэж баахан таамаглал дэвшүүллээ. Даан гуайг өөрийн эрхгүй чангаар ханиахад сандарсан эзэгтэй бид хоёр зэрэг ухасхийлээ. Ашгүй түүний ханиах ч намдав.*

*Бид хүлээж, хүлээж чимээ тасраад удсан хойно эзгүй гэж бодсон энэ байшинд гэнэт хөлийн чимээ сонсоод хулгайч арилаад өгсөн болов уу гэгцээж саяхан тэнд байснаа мэдэгдэх гэсэн юм шиг сандал ширээгээ ч хураалгүй, хүлээн авагчаа английн нэвтрүүлгийн долгион дээр орхисноо санацгаав. Тэгээд гадаа хаалга хэрэв эвдэрсэн бол агаарын хамгаалалтын эргүүлүүд ажиглаж, цагдаа магдаа болон бүүр ч хөөгөө тарихыг байг гэх газаргүй гэлцэв. Даан гуай ч юун хэвтэхтэй манатай босож хувцаслан, пальтогоо өмсөж, малгайгаа духдуулаад аавын араас дээврийн шатаар аяархан гэгч уруудав. Петер бас тэдний араас алх барин буулаа. Эмэгтэйчүүд бид тэднийг сэтгэл шаналан хүлээн суутал ашгүй нөгөө гурав маань таван минут хэртэй болоод буцаж ирцгээв. Онц гойдын юм юу ч болоогүй байна гэв. Тэгээд ч бид ус ер гоожуулахгүй, жорлонгийн усыг хүртэл татахаа байя гэж тохирлоо. Айсандаа бүгдийн ходоод гэдэс өвдчихжээ. Тийм газар олон хүн орсны дараа үнэр танар нь ямар байдгийг чи лав төсөөлөх биз ээ.*

*Иймэрхүү юм болсны дараа юу болдог билээ тийм л юм болох нь тэр. Юуны түрүүнд л Вестертурмийн хонхны чимээг тэр болгон сонсохоо болив. Уг нь тэр хонхны дуу миний сэтгэлийг тайвшруулдаг цорын ганц эгшиглэнт авиа байсан юм. Бид өчигдөр орой ноён Воссены эртхэн явсныг сайн мэдэж байв. Харин Элли түлхүүрээ авсан эсэх, хаалга үүдээ цоожилсон эсэхийг мэдсэнгүй. Наймаас арав хагас болтол юу ч сонсогдсонгүй. Цөм л айж цочсон хэвээрээ байв. Тэгж тэгж жаахан тайвшираад гадаа гудамжинд түм түчигнэж, бум бужигнаж, бүрий тасраагүй байхад гаднах хаалга үүд яавч эвдмээргүй юм, залгаа пүүсний агуулахын манаач ажилтай байсныг хэн байг гэх вэ гэсэн бодол төрөв. Хана нимгэн учраас гаднах чимээний цуурайг эндүүрсэн байж болох юм. Тэгээд айснаас бүүр ч сүртэй дуулдсан*

*байх гэж нэг нь хэлэв. Ингээд элдвийг бодоцгоон орондоо орсон боловч хэн ч тайван унтсангүй. Аав, ээж, Дуссел гуай нар сав л хийвэл өндийн, жаахан хэтрүүлж хэлэхэд би бараг нүд аньсангүй...*

*Өглөө нь эрчүүд гадаах хаалга үүд хаалттай, цоожтой эсэхийг үзэхээр хөдлөв. Тэгтэл юу ч болсон шинжгүй бүрэн бүтэн, цоож түгжээтэйгээ байлаа. Зүрх хагалчих шахсан тэр явдал нь нэмэр хачиртайгаар нүүсийнхэнд сонсогдсон нь мэдээж. Их бага ч гэсэн айж сандарч байхдаа хэн ч инээхтэй манатай байдаг. Харин өнгөрсөн хойно нь л элгээ хөштөл инээдэг юм байна. Бидний энэ явдлыг ганц Элли л тийм ч инээдтэй ч юм биш дээ гэв.*

***Анне***

*Хайрт Китти минь!*

*Татлан бичгийн курс маань дуусаж байна. Одоо удахгүй татлан бичих дасгалдаа орж, цөөн тохиолдох үеүдийг нүдлэх болно. Цаашидаа би энэ цаг нөхцөөсөн ажилдаа улам их хичээх болно. Ер нь бид энд нуугдаж буй цагаа ашигтай өнгөрөөх л гэж элдвийн юмаар оролдоод байгаа юм шүү дээ. Би бас санаандгүй домог судлалыг сонирхоод үзтэл грек римийн бурхдын домгоос салж чадахаа больдог байгаа. Хүмүүс энэ тухай сонсвол над шиг нусгай охин бурхдын тухай сонирхож эхэлсэнд үнэмшихгүй бөөн юм болох биз. За яахав би л тэгвэл анхных нь болог.*

*Даан гуай салхинд цохиулчихжээ. Үнэнийг хэлбэл хоолой нь л жаахан эрвэгнэсэн аж. Тэгтэл хоолой зайлах эм тан, царван, хоолойд түрхэх тос, хэл амны хөндий хамрын тос гээд л бөөн хөл болов... Бас тэгээд ааи зан нь улам муудсан гэдэг нь хэлэх юм биш.*

*Эндэх германчуудын хамгийн том дарга нарын нэг ноён Рауте герман улсын нутгийг зургаадугаар сарын нэгэн гэхэд еврейгүй болгож цэвэрлэнэ гэж мэдэгдсэн байна. Дөрөвдүгээр сарын нэгнээс тавдугаар сарын нэгнийг хүртэл Утрехт мужийг, тавдугаар сарын нэгнээс зургаадугаар сарын нэгнийг хүртэл умарт, өмнөд Холландыг яг л гал тогооны өрөөгөө цэвэрлэдэг шиг ариутгах юм байхаа. Өвчин хуучид баригдаж, насанд дарагдан, сүргээ гүйцэхээ больсон мал шиг хөгширч туйлдсан тэр олон хөөрхийлөлтэй хүмүүсийг мөрдөн баривчлах юм гэнэ. Бид харин ингэсхийгээд л амьд мэнд үлдээсэй билээ.*

*Гэхдээ хааяа сайн мэдээ бас дуулах л юм. Холландчуудыг ажилд хөөдөг германы хөдөлмөрийн товчоонд гал гарч шатсанаас хойш удалгүй иргэдийн товчоо гэдэг нь бас шатаж гэнэ. Герман цагдаагийн хувцастай эрчүүл харуул манааг нь барьж хүлж хаяад бүртгэл дансыг нь устгаснаар гэмгүй хүмүүсийг германууд дуудаж мөрдөөд байхааргүй болжээ.*

*Анне*

## 1943 оны дөрөвдүгээр сарын 1. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Хуанли дээрх инээдмийн өдрийн тухай ярих юм юу ч алга. Бид мөн л бахь байдгаараа даа. Бидэнд таарах нэг цэцэн үг байдаг шүү дээ. Нэг бүдэрхэд долоо бүдэрдэг гэдэг байхаа. Яагаад гэвэл нэгд, биднийг зоригжуулагч Коофуйс гуай ходоодондоо цус алдсанаас гурван долоо хоног хэртэй хэвтэрт байх болжээ. Хоёрт, Эллид хамрын шуухинаа тусчээ. Гуравт, Воссен гуай ирэх долоо хоногоос эмнэлэгт хэвтэх болов. Ходоодны хавдартай болсон юм байх. Лав мэс засал хийлгэх биз ээ. Бас энд маш чухал хэлэлцээр болох юм байх. Ноён Кралер хэлэлцээрийн явцыг дор дор нь мэдээлж чадахааргүй байв. Хэлэлцээрийг юу болж дуусдаг бол гэхээс айдас хүрч байгаа нь мэдээж. Тэгээд ч тэр үү байж ядахдаа аав “Хэлэлцээрт оролцъё гэвэл шалан дээр хэвтэх хэрэгтэй. Шалан дээр шүү. Тэд яг энд, миний ажлын хуучин өрөөнд хэлэлцээр хийнэ. Шалан дээр хэвтэж байгаад бүгдийг сонсож болно байх.” гэв.*

*Арав хагаст аав Маргот хоёр хажуу өрөөг сонсохоор шалан дээр хэвтэв. Нэг хүнээс хоёр хүн арай илүү юм сонсоно л доо. Хэлэлцээр үд гэхэд дууссангүй. Харин аав үдээс хойш тэгээж удаанаар хэвтэж чадахгүй болсон байв. Муу аав минь аргагүй л ядарчээ. Түүний оронд хэвтвэл, хоёр цаг хагасын хэртэйд, доор хүмүүсийн ярилцах сонсогдов. Маргот бас надтай хамт хэвтэж байв. Хүмүүсийн яриа сунжирч залхуу хүрэв. Нэг мэдэхэд би шалны хүйтэн хулдаас дэрлээд унтчихсан байсан. Хэ хэ. Маргот чимээ гаргачих вий гээд намайг сэрээсэнгүй. Шалан дээр хагас цаг хэртэй унтаад сэртэл, сонссон чухал юмаа таг мартсан байв. Аз болоход Маргот бүгдийг сайн тогтоожээ.*

**Анне**

## 1943 оны дөрөвдүгээр сарын 2. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би дахиад л нүглийнхээ хүүдийд нэг аймар юм хийчихэв. Өчигдөр орой аавыг оройн мөргөл хамт хийж сайхан нойрсоорой гэж хэлэхээр ирнэ байх гэж хүлээж байтал, ээж орж ирэв. Тэгээд орон дээр минь суугаад чухал царай гарган:*

*-Анне, аав чинь ирэхгүй. Хоёулаа оройн мөргөлөө хийх үү? гэхэд нь би:*

*-Үгүй ээжээ гэчихэв.*

*Ээж тэгтэл гомдсондоо огло үсрэн босож хэсэг зогссоноо хаалга руу хэд алхав. Тэгснээ гэнэт эргэж, нүүрээ барайлгаснаа:*

*-Анне, чи тийм ч муу ээжтэй биш байх шүү. Хайр тэр болгон гаднаа байдаггүй юм даа гээд нулимс цийлэлзүүлсээр гарч одов. Би хөдлөхгүй хэсэг хэвтээд, “Би чинь ямар нүгэлтэй юм хийчихэв дээ. Ээжийгээ ингэж гомдоох гэж. Одоо би өөр юу ч хэлэх билээ” гэсэн бодолд автав. Ээжтэй мөргөл үйлдэхгүй гэдгээ би нууж чадсангүй. Ердөө чадсангүй. Ээж өөрөө намайг ойлгодоггүй, миний зан аашинд дургүйг мэдсэн тэр цагаас хойш бидний хооронд ийм хөндий хачин харилцаа би болсон юм. Хайр тэр болгон гаднаа байдаггүй юмдаа гэж хэлээд ээжийг гарч одоход царай нь үнэхээр гомдсон байсан. Үнэнээ хэлэх хатуу юм. Гэхдээ ээж л өөрөөсөө намайг хөндийрүүлсэн нь үнэн шүү дээ. Чих дөжиртөл үглэж, бас сэтгэлий минь эмзэглүүлсэн тоглоом тохуурхлаараа өөрийнхөө хайр халамжийг хүлээж авахааргүй болгосон нь түүний буруу бус уу. Өөрөө юм болгонд намайг мэрдэг тийм хатуу атлаа, бие биеэ гэх хайраа бөхөөж байгааг мэдмэгцээ сэтгэл нь ихэд хямарчээ. Ээж бараг шөнө хагаслатал уйлж, унтаагүй ажээ. Аав ч надруу ирсэнгүй. Хэрэв ирсэн бол “Яахаараа чи ингэж өөдгүй муухай загнана вэ? Эхийгээ ийн гомдоож болох уу даа” гэж намайг зэмлэх нь тодорхой байв.*

*Тэд намайг уучлалт гуйхыг хүлээж байв. Би харин хэрхэвч уучлалт гуйхгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт бид хоёрын харилцаа ийм хөндий болсныг ээж мэдэх нь үнэн юм чинь, юу гэхэв дээ. Энэ удаад ээжийн нулимс, аавын ширүүн харцны алиныг ч анзаарах гэсэнгүй. Би ийм л хүн дээ. Тэд анх удаагаа л миний байнга эдэлж байдаг хайраа дутахын тэр зовлонг мэдрэв. Би ээжийг зөвхөн өрөвдөж чадах л даа. Харин өрөвдүүлэх эсэхээ ээж өөрөө шийднэ шүү дээ. Би цаашдаа дуугүй, хүйтэн хөндий хэвээр байх болно. Үнэнээс ухрахгүй. Энэ нь хэлэх гэснээ худлаа булзааруулснаас дээр л дээ.*

*Анне*



## 1943 оны дөрөвдүгээр сарын 27. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Манайхан гэдэг бөөн хэрүүлтэй байна. Ээж бид хоёр, бас Дааныхан аав хоёр, мөн ээж Даан эзэгтэй хоёр, бүгд биендээ муухай аашилна. Эвтэй найртай орчин хэзээ бий болдог бол? Воссен гуай аль хэдийн эмнэлэгт хэвтсэн. Коофуйс гуай харин хөл дээрээ босов. Энэ удаа ходоодны нь цус алдалт хурдан илааршжээ. Иргэдийг бүртгэх товчоонд дахин гал гарсан нь уг товчоог бүр ч сүйдэлсэн гэнэ гэж тэр ярив. Гал командыхан унтраах гэж байгаа нь энэ гээд байшингий нь бүхэлд нь усанд авахуулсан гэнээ. Гарз хохирол ч тэнгэрт хадсан юм байх аа.*

*Карлтон зочид буудал үнсэн товрог болжээ. Галт бөмбөг ачсан английн хоёр онгоц офицеруудын сууцыг бөмбөгдөж Виечилиштраат-Зингелийн тойргийг түймэрджээ.*

*Шөнө ч гадаа тайван байхгүй болов. Бага унтах болсноос доод зовхи минь хөхрөөд байна. Бидний хоол унд ч гэж өрөвдмөөр байх боллоо. Өглөөний цайнд коферхуу юм ууж хатсан талх иднэ. Хагас сарын өмнөөс эхлэн үдийн хоолонд ногоон бууцай юм уу байцаа, улайж амт орсон хэрчим төмстэй идэх болсон. Турж жингээ хасах сонирхолтой хүүхнүүд л манай энд хоргодмоор юм.*

*Таван өдрийн дайн гэгчид тулалдсан буюу дайчлагдсан бүх эрс фюрерийн төлөө ажиллах олзныхон болов. Дахиад л дайрах, халдан довтлоход хүчээ сэлбэх гэсэн арга бач.*

*Анне*

# 1943 оны тавдугаар сарын 1. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Энд амь зууж байгаагаа бодоход бид чинь бүгж дүрвэж чадаагүй еврейчүүдийн хажууд ёстой л диваажинд жаргаж байна гэсэн үг. Гэхдээ мэдээж энд яаж нуугдаж, гадаа гарах нь бүү хэл чангахан ханиаж ч болохгүй хичнээн өрөвдмөөр байдалд дассанаа дайны дараа эргэн санаад гайхах биз. Жишээ нь энд ирсэн өдрөөс эхлээд ширээ бүтээсэн хулдаас маань бүүр элэгдэж тамтаг болоод байна. Бүтээлэг гэхэд өрөвдмөөр түмэн нөхөөс болсон нэг муу хуучин юмаар жаахан өнгө засах гэж бодож л байна. Тэр нь ч бас нэмрээр бага л даа.*

*Угаалгын нунтаг ховордсоноос Дааныхан гудасныхаа өнгийг бүхэл өвөлжингөө угаасангүй. Аав цоорч урагдсан өмд, элэгдэж сэмэрсэн зангиатай байх болов. Ээжийн бэлхэвч хуучирч муудан, Марготын хөхний даруулга нь хоёр размерээр жижгэрч, цээжий нь барина. Маргот, ээж хоёр өвөлжингөө дундаа гурван цамц ээлжлэн өмсч, минийх багадаж тоодойгоод байна. Хувцас ч яахав болж л байна. Харин гутлын минь ул ханзарч, аавын сахлын багсны үс унаж дуусахаар тэрийг яаж засна даа гэхээс айдас хүрнэ. Өнөө шөнө хэчнээн аймаар буудалцаж хонов оо. Би ч хамгийн хэрэгтэй гэсэн юмнуудаа цуглуулаад үүргэвчиндээ хийчихсэн гэж байгаа. Тэгсэн чинь ээж “Чи чинь хаашаа зугтах нь вэ?” гэж асуулаа. Энд тэндгүй бослого, мөргөлдөөн гарч байгаа болохоор*

*Холланд бүхэлдээ баривчилгаа, залхаан цээрлүүлэлтэд автаад байна. Тэгээд Холланд бүслэлтэд орсон гээд нэг хүнд оногдох цөцгийн тосны ногдлыг хасчихсан.*

*Өнөө орой би ээжийн толгойг угааж өгөв. Толгой угаана гэдэг манай нуувчинд бас амаргүй ажил гээд л бод. Эхлээд шингэн савангаа түрхэн угаана. Дараа нь арваадхан шүдтэй, бидний ганцхан самаар ээжийн ширүүн үсийг самнах амар биш шүү.*

*Анне*

# 1943 оны зургаадугаар сарын 1. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Миний төрсөн өдрөө бичиж өгсөн аавын шүлэг үнэхээр гоё болжээ.*

*Отгон охин минь чи боловч*

*Огт балчирхан амьтан биш билээ*

*Омгolon дураараа байх гэдэг өөрийн бодолтой зан чинь*

*Огтхон ч амар зам биш шүү, охин минь*

*Хажуугаар чинь зааж сургах гэсэн хүмүүс чамд*

*Харваас хэчнээн хэцүү байдгийг би мэднээ.*

*Хорвоод чамаас илүү олон оймс элээсэн бид*

*Хосгүй ухаантай биш ч амьдралыг чамаас илүү мэднэ гээд л*

*Хэлтэй амтай бүхэн зааж сургах гэгцээнэ*

*Алдсан ч оносон ч өөрийнхөөрөө байх гэж*

*Амьдрал, тавилангаа өөрөө залахын амтыг мэдэрсэн чинь сайн хэрэг*

*Сохрын газар сохор, догolonгийн газар догolon байх*

*Сонирхолгүй, дургүй хүрмээр үг сонссон ч тэвчих үе байдаг юм*

*Алтан наран, мөнгөн саран ээлжлэн мандсаар*

*Амьдрах хоногийн тоо нэг л өдөр дуусдаг юм*

*Хорвоод амьдрах хором мөч бүхнээ ашиглан*

*Хоног өдрийг сурч мэдэх, хийж бүтээхэд зориулаарай*

*Өмсөх хувцас, гангарах гоёлгүй боллоо гэж*

*Өхөөрдөм охин минь чи шаналж байгааг мэднэ*

*Өдөр цаг тутамд өсч томорсоор байгаа охин чамд*

*Үнэндээ гутал, даашинз, цамц чинь бүгд багаджээ*

*Хонгор охин чамайг юунд шаналж, зовж байгааг*

*Хэн хүнгүй л мэдэрч ойлгохыг хичээнэм.*

*Хоол зоогийн тухай харин Маргот шүлэглэжээ. Гоё чамин бэлгэнд дуртай надад миний дуртай Ром, Хелласын домгийн зузаан ном хамгийн их таалагдав. Амттан чихэр жимж ховор байхад гоморхох юм алга. Манайхан хадгалсан, дарсан амттаныгаа хамаг л нөөцийг гаргацгаав. Би ч энэ хоргодох байрны эрх танхил гүнж юм аа.*

*Анне*

## 1943 оны зургаадугаар сарын 15. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Өнгөрсөн хоёр өдөрт зөндөө л юм боллоо. Гэхдээ баахан нуришиж чамайг залхаахаас айхдаа товчхон бичихээр шийдлээ.*

*Ноён Воссений ходоодны хавдарт мэс засал хийхээ больжээ. Учир нь эмч нар нээж үзээд хавдар нь хэтэрхий томорсныг хараад мэс засал хийх шаардлагагүй гээд буцаан оёсон гэнэ. Тэгээд гурван долоо хоногийн дараа шарх нь анингуут гэрт нь гаргасан байна. Хүнд өвчинд нэрвэгдсэн түүнийг өрөвдөх юм. Ядаж бид гадагшаа гарч болохгүй болохоор түүний сэтгэлийг засаж, эргэж тойрч чадахгүй нээ. Сайхан сэтгэлт ноён Воссенийг бид хичнээн үгүйлнэ вэ.*

*Дараагийн сард хүлээн авагчаа хураалгах гэнэ. Энэ том “Philip’s” хүлээн авагчийн оронд нууцаар авчран хэрэглэх жижиг хүлээн авагч азаар ноён Коофуйст бий гэнэ. Хүчтэй, их гарын хүлээн авагчгүй болно гэдэг харамсмаар аа. Үнэндээ бүгж байгаа хүмүүс аз сорьж болохгүй л дээ. Ер нь бүгсэн бүгээгүй бүгд л бүртгэлтэй хүлээн авагчаа хураалгаж, оронд нь хуучин жижиг радио авч байна. Хүлээн авагч л хөөрхий биднийг гадаад ертөнцтэй холбож, мэдээгээр хангах ганц гарц юм даа. Сэтгэлд бөөн гуниг болоод байх үед нэвтрүүлэгчийн цээл хоолой хангинан “Толгойгоо бүү гудайлгацгаа. Сайн сайхан цаг ирэх л болно” хэмээн урам өгөх шиг болдог юм.*

*Анне*

## 1943 оны долдугаар сарын 11. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Чамдаа гэж хэлэхэд чихний чийр болсон хүмүүжлийн тухай яриагаа сөхөн, эелдэг, тусч, хөөрхөн сайхан ааштай болох гэж хичээсний хүчинд, зэмлүүлж, загнуулахаас овоо салж байна шүү. Гэхдээ санаа нийлдэггүй хүмүүсийн аясаар байх шиг хараал идсэн шийтгэл алга аа. Цаашид бусадтай хэл амаа ололцохыг хэчнээн оролдсон ч хэлье гэсэн үгээ улаан нүүрэн дундуур нь хэлэхдээ л хэлэх болно гэж бодох юм.*

*Сонирхуулахад цагаа хэмнэх, бас нүдээ хайрлах үүднээс нөгөө таталган бичгээ больсон. Миний холын хараа сүүлийн үед муудаад байгаа юм. Нүдний шил зүүх юм бол би гэдэг хүн яг шар шувуу шиг юм болно доо. За тэгээд бүгж амь хоргодож байгаа хүн юун харааны шил тааруулахтай манатай гэдгийг чи мэднэ шүү дээ.*

*Өчигдөр энд бөөн яриа боллоо. Ээж намайг хатагтай Коофуйстай хамт шүдний эмчид очуулна гээд. Юу гэсэн үг вэ. Гадуур гудамжаар ил явна гэхээр толгой эргэмээр санагдлаа. Эхлээд зүрхээ дэлбэртэл айснаа би гэнэт баярладаг байна шүү. Баригдах аюул, заналын доор тийм амь дүйсэн алхам хийнэ гэдэг мэдээж амар юм биш. Эцэст нь Мийптэй хамт явахаар болж шүүгээнээс саарал пальтогоо гаргаад өмсөх гэтэл багадчихсан байдаг байгаа. За ингээд л гудамж руу гардаг байгаа гэтэл ашгүй эмч рүү явах хойшилчихлоо.*

*Англичууд Сицилийг чөлөөлжээ. Аавын ярьж байгаагаар дайн тун удахгүй дуусах гэнэ. Элли Маргот бид хоёрт баахан хийх юм өглөө. Бид хоёр ч дуртай байлаа. Захиалгыг нь ялгаж дансанд бүртгэлээ. Энэ нь бид хоёрт амархан ажил байсан шүү. Хөөрхий Элли бидний төлөө яг л ачааны илжиг шиг зүтгэх юм. Өдөр бүр хаа нэгтэйгээс томоос том хүүдий саваар дүүрэн дүүрэн ногоо энэ тэрийг дугуйгаар зөөнө. Бас хагас сайн өдөр бүр номын сангаас бидэнд шинэ ном таваас доошгүйг авчирна. Бид, тэр хагас сайн өдрийг бяцхан хүүхдүүд өвлийг өвгөнөөс бэлэг горьддог шиг л хүлээж ядна. Наранд эрх дураараа яваа хүмүүс хоргодох байранд байгаа бидэнд ном хэчнээн хэрэгтэйг мэдэхгүй л дээ. Бидний хувьд цагийг зугаатай өнгөрүүлдэг хэдхэн л зүйл нь радио чагнах, ном унших, хичээл давтах л байлаа.*

*Анне*

## 1943 оны долдугаар сарын 13. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр би аавын зөвшөөрснөөр өөрийнхөө өрөөнд байдаг ширээг долоо хоногт хоёр удаа дөрвөн цагаас тав хагас хүртэл хэрэглэж болох эсэхийг Дуссел эмчээс асуув. Би мөн ч хүмүүжилтэй байгаа биз. Дуссел гуайн унтдаг хоёр цаг хагасаас дөрвөн цаг хүртэлх хугацаанд бол асуусан асуугаагүй би ширээндээ сууж юмаа хийдэг л дээ. Харин түүнээс хойш л өрөө, ширээгээ хэрэглэх эрхгүй болчихдог байв. Бусад өрөөнд үдээс хойш юм хийхийн аргагүй бөөн чимээ шуугиантай болохоос гадна аав хүртэл ширээндээ суух дуртай байв. Уг нь одоо л хүнтэй хамт байгаа болохоос миний өрөө юм чинь Дусселээс асуух нь эелдэг харилцааны л илрэл юм даа. Гэтэл нөгөө эрдэм номтой эрхэмсэг хүн гэгддэг Дуссел эмч юу гэсэн гээч? Үгүй, шууд л үгүй гэдэг байна шүү. Гайхахдаа өнөөх ёсорхуу зан минь ч хаа байхав, яагаад болдоггүй юм бэ гээд л шалгаав. Дуссел тэгтэл, “Юу гэнээ чи? Надад ч хийх юм их байна. Үдээс хойш суухгүй л бол над ерөөсөө юм хийх цаг олдохгүй байна. Хийхээр бодсон юм зөндөө байна. Миний хийх юм чинийх шиг тийм дэмий юм биш шүү. Чиний хийж байгаа чинь хэнд хэрэгтэй юм бэ? Домог үлгэр ч гэх шиг. Ном унших, юм нэхэх чинь ажилсаад байх юм биш. Ширээ мэрээ гэж битгий дэмийр!” гэв. Тэгэхэд нь би:*

*-Юу гэсэн үг вэ? Миний хийх юм ч бас чухал. Үнэндээ энд үдээс хойш юм хийх газар олдохгүй юм. Та бас ойлго л доо гэж хэлж үзлээ.*

*Хөөрхий муу Анне чинь ийм шүү үг дуулаад, өө зайлуул, доктор маань иймэрхүү л шог амьтан байсан юм уу. Өнөөх эелдэг, өрөвч, нигүүлсэнгүй эрхэмсэг хүн гэдэг нь хаа байна вэ гэж багтартлаа уурлав. Орой нь Пимтэй уулзмагцаа эмч миний ширээг надад хэрэглүүлэхээс татгалзсаныг хэлээд яах тухайгаа зөвлөв. Тэгээд ямар ч байсан санасандаа хүрнэ гэж шийдэв. Аав яаж түүнийг аргалахыг зөвлөөд намайг уураа гартал харин нэг хоног хүлээ гэв. Гэвч би аавын зөвлөснийг юман чинээ бодолгүй, аяга шанагаа угаачихаад л өрөөндөө орж Дуссел гуайг хүлээв. Аав зэргэлдээ өрөөнд сууж байсан юм. Аавыг ойр байхад би нэг л тайван, зориг орчихдог юм. Тэгээд түүнийг ороод ирмэгц л:*

*-Дуссел гуай, та миний асуусныг бодох гэж хичээсэнгүй еэ? Би танаас гуйж байна! гэв. Тэр ихэд дотноор инээмсэглэн “Хэцүү юм нь шийдэгдсэн. Ярилцаж бололгүй яахав” гэв. Би тэгэхэд нь яриагаа таслах чөлөө өгөлгүй “Доктор гуай таныг ирэхэд, үнэндээ энэ өрөөг тань бид хоёрынх гэж хуваарилсан шүү дээ. Тэгэхэд та үдээс өмнө, би үдээс хойш юмаа хийж байхаар тогтсон биш билүү. Түүгээрээ байя гэж харин шаардаагүй шүү дээ. Ердөө л долоо хоногийн хоёр өдрийн үдээс хойшихи цагийг л зөвшөөрчих гэж байна. Тэгэхэд л учраа ололцох нь тэр!” гэтэл Дуссел гуай могойд хатгуулсан юм шиг үсрэн босож:*

*-Чамайг тэгээж давраахгүй. Би чухам хаана байх болж байна? Даан гуайгаас өөртөө тохирох нохойн оромж олж өгөөч гэж гуйх болж байна уу? Тэгээж л толгой хоргодох юмтай болохоос доо. Надад ч юмаа хийх газар алга. Чамаас болж дандаа л уурлаж байх боллоо. Хүн шиг байдаг Маргот эгчий чинь хэрэв гуйсан бол би дуртай зөвшөөрнө. Харин чамтай бол.. гэдэг байна. Тэгээд л өнөөг домог момог, нэхэх, унших гэдгээ донгосч эхлэв.*

Муу Anne чинь ингээж л доошоо орж байна даа. Тэглээ гээд хэнд ч хэлэх юм билээ. Дуссел гуай ч:

-Чамтай ярихгүй. Чи бол хувиа бодогч, санасандаа хүрч л байвал бусад нь ямар ч хамаагүй гэдэг хүн. Чам шиг ийм охин үзээгүй! Сайнаар төгсгөх гэвэл чиний л дураар болох хэрэг үү? Аягүй бол Дуссел ширээгий нь өгөөгүйгээс Anne Франк шалгалтандаа унаж балрах юм биш биз дээ гэдэг байгаа.

Миний уур хүрч тэсч ядахдаа “Хөгшин луйварчныг хана мөргүүлчихэж чадна шүү гайгүй!” хэмээн дотор арзагнаснаа “Тайван бай. Өөрөө тэгтлээ уурлаад, юу ч өөрчлөгдөх биш” гэж өөрийгөө тайвшрууллаа. Байж ядсан Дуссел гуайг өрөөнөөс гарахад царайд нь уурласан, санасандаа хүрэх гэсэн шазруун шинж илт байлаа.

Тэр Мийгийг олж өгснөөс хойш юм л бол идэх юмаа нууж чихдэг болсон тэр л цүнхээ барьсан байв. Миний хүсэлт юу болсныг мэдээгүй болохоор аавд дуулгах санаатай би ч өрөөнөөс гарав. Аав тэр орой Дуссел гуайтай уулзахаар болов. Тэгээд ч уулзацгаав. Тэд бараг хагас цаг ярьцгаав. Аав энд яаж эвтэй найртай байхаар тохиролцсоноо сануулан, хөгшид залуучууд тэр бүр таардаггүй гэхчлэн ярихыг оронд ингээд хоорондоо тохирохгүй юм гарна гэдгийг урьдчилан хараагүй нь бидний буруу биш... гэх мэт баахан юм нурихсан бололтой. Тэгтэл Дуссел гуай “Би ч баригдах гээд аргаа барж яваад орж ирсэн болохоор аар саар юман дээр буруудах маань ч яамай” хэмээн үг сөржээ. Аав бидний юу ярьсныг сонссон болохоор ишийдмэг ярьж, нэг ч үг алдаж буруу ойлгуулж болохгүйг мэдэж байв. Намайг “Дэмий юм оролдож байх юм”, “Хувиа бодогч” гэснийг аав засаж залруулж, өөдөөс нь Дуссел гуай уцаарлан муухай аашилж зөндөө л маргав. Тэгж тэгж Дуссел гуай арай гэж нэг юм мугуйдлахаа больж, би долоо хоногт хоёр удаа оройн таван цаг болтол ширээндээ сууж юмаа хийх болов.

Даанч Дуссел гуай хэлсэн үгэндээ хүрсэнгүй. Хоёр өдрийн турш тэгэхээс тэгэх гэсэн юм шиг оройн тав хагас хүртэл зөрүүд тэнэг хөвгүүд шиг элдэв дэмий юм оролдон ширээнээс босож өгсөнгүй. Энэ хүн тавин дөрөв хүртлээ ийм л аар саархан юмаар хөөцөлдөн, над шиг жаахан охинтой мөчөөрхөж яваа нь өөрийгөө хэн бэ гэдгийг л харуулж байгаа нь энэ байх даа.

**Anne**



## 1943 оны долдугаар сарын 16. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Энд бас л бөөн үймээн. Дахиад л бас хулгайч орлоо гэж сандарцгаав. Харин энэ удаад ёстой хулгайч орсон доо! Петерийг өглөө бүр агуулах руугаа ордгоороо орвол агуулах, гудмын хаалгууд цөм дэлгээстэй байжээ. Тэгэхээр нь шууд л хуучин албан өрөөндөө германы нэвтрүүлэг сонсохоор үүдээ түгжээд сууж байсан аав руу очжээ. Аав тэр хоёрыг дээш гарахад бид угаах арчихаа дуусган, бүх юмаа амжуулчихаад жорлонд орж болохоо больдог өглөөний найман цаг болсон байжээ. Гэтэл бидний найман хүн шөнө юу ч сонсолгүй нам унтсан байдаг.*

*Арваннэгэн цаг болоход Коофуйс гуай орж ирэв. Түүний ярих нь хулгайч нар гадаа хаалгыг төмрөөр гөжиж онгойлгоод агуулах руу орсон байжээ. Тэгээд агуулахад аваад байх юмгүй болохоор дээш гарч азаа үзсэн байна. Тэндээс дөчхөн гульдентэй мөнгөний хайрцгийг хоосон чекний дэвтэртэй аваад арилжээ. Харамсалтай нь зуун тавин кило элсэн чихрийн карт хулгайд алдсан байв. “Сар хагасын өмнө хаалга эвдэх гэсэн тэр хулгайчид мөн байх. Тэр үед дотогшоо орж чадаагүй болохоор дахиж ирсэн байна. тэр үед та нарыг бодоод цагдаа энэ тэрд мэдэгдэж шуугиан тариагүй юм” гэж Коофуйс гуай ярьсан. Бид ч бичгийн машин, кассаа эндээ авч байдагтаа л баярласан шүү.*

*Анне*

**1943 оны долдугаар сарын 19. Даваа гариг**

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр, бүтэнд сайн өдөр Амстердамын хойд дүүргийг нэлд нь бөмбөгдөв. Бүтэн барилга бараг үлдсэнгүй бололтой. Гудамж талбайнууд тэр аяараа барилгын нурангиар дүүрч, хэдэн арван хоног цэвэрлэж зөөгөөд барахааргүй юм болжээ. Одоогоор амь үрэгдсэн хүн хоёр зуу, шархадсан хүн тоолоод барахгүйгээр болсон юм байх. Эмнэлгүүд дүүрч, төөрсөн хүүхдүүд энд тэндгүй эх эцэгээ эрж эвдэрч сүйдсэн байшин барилгаар л нэг гүйлдэх болж. Аймшиг зөгнөсөн дэлбэрэлтийн энэ битүү доргионыг сонсох бүрд нуруу хүйт даан, бие арзайх юм.*

*Анне*

## 1943 оны долдугаар сарын 23. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Элли нябо бүртгэл тооцооны мэргэжлийг одоо гэрээр сурч эхэлж буй Маргот эгчид хэрэгтэй дансны бүртгэлийг байгаа газраас нь олох гэж бөөн юм болж байна. Жирийн дэвтэр ч гэсэн талонгүйгээр олдохоо байсан цаг. Арванхоёр хуудастай саарал хавтастай жирийн нэг сурагч дэвтэр ч олдохоо болиод байна шүү дээ.*

*Одоо би ганц ч удаа бол чамайг хөгжсөөхийн тулд эндээс гарч, эрх чөлөөтэй болж, нарыг харах анхныхаа өдөр бид юу хийх вэ гэдгээ хэлэх үү?*

*Маргот, Даан гуай хоёр юуны өмнө халуун ус дүүргэсэн ваннад орж, цаг хагасаас нааш гарахгүй хэвтэх гэнэ. Харин Даан эзэгтэй хаашаа ч юм бэ нэг нарийн боовны газарт очиж янз бүрийн бялуу, нарийн боовыг цадталаа идэх гэнэ. Дуссел гуай өөрийнхөө лянхуа цэцэг мэт хайрт эхнэртэйгээ л уулзах юм байх. Ээж ёстой л хан гэсэн ганц аяга кофе уух гэнэ. Аав бол хамгийн түрүүнд дотны найз Воссен гуайнд л айлчлах юм байх. Петер шууд л хот орж кино үзэх гэнэ. Харин би гэдэг хүн яах, юу хийх юм бол оо? Гэтэл би л эндээс гарангуут яг юу хийх, яахаа төсөөлөх ч үгүй явна. Би ер нь юу дуртайгаа хийж, хэн ч надад саад болохооргүй бие дааж амьдрахын тулд өөрийн гэсэн байртай л болмоор байна. За тэгээд л тэглээ ингэлээ гэж үглүүлээд байлгүй, харин нөхөрсөг зөвлөгөө тусламж аван, жинхэнэ сургуульдаа явахсан гэж бодож байна.*

*Элли дамаас л тэнгэрт хадсан үнээр жимс авчирч байна. Үнэ нь ч дүүрсэн хэрэг. Усан үзэм 5 гульден, тошлой 40 цент, ширхэг интоор 50 цент. Ганц кило хулуу 1 гульден 50 центийн үнэтэй. Өдөр бүрийн сонинд л юмны үнэ өсч байна гэсэн гарчиг үзэгдсээр байна даа.*

*Анне*

## 1943 оны долдугаар сарын 26. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр ганц ч агишин тайван байсангүй. Бүгд л сэтгэл түгшиж өнжив. Ингэхэд айж сандрахгүй өдөр гэж та нарт ер нь байна уу гэж чи гайхаж байна уу?*

*Дөнгөж цайгаа уух гээд сууцгаатал түгшүүрийн урьдчилсан дохио хангинаад явчихлаа. Энэ нь дайсны онгоц тэнгисийн эрэгт ойртож явааг дохиолох тул бид нэг их сандарсангүй. Миний толгой өвдөөд байхаар нь өглөөний цайны дараа хэсэг дугхийгээд доошоо буув. Хоёр цаг болж байлаа. Хоёр хагаст Маргот бүртгэл дансны ажлаа дуусгасан ч түгшүүрийн дохио, тэгэхдээ бүүр сүртэй түгшүүрийн дохио өгсөн болохоор юмаа ч эмхэлж амжаагүй гэнэ. Биднийг дээш гараад таван минут болов уу үгүй юу хүмүүс гадаа сандран бужигналдаж гарлаа. Бид ч бөмбөгдөлтөөс зугатан хонгил руу орж хоргодлоо. Байшин доргиж, дэргэд бөмбөг тэсрэх сонсогдов. Би ч зугатах хэрэг гарч магад гээд ойр зуурын юмаа чихчихсэн цүнхээ тэврэн суув. Гэвч бид зугатаад ч хаачих юм билээ. Гадаа гудамжинд гарах нь бөмбөгдөлтөөс долоон дор аюултай юм чинь.*

*Бөмбөгдөлт өнгөрөөд хагас цаг болсны дараа, нүүснийхэн ажлаа эхлэв. Петер дээврийн агуулах дахь ажиглалтын байрнаасаа бууж, Дуссел гуай хэнхэглэн сууж, Даан эзэгтэй аавын хуучин конторт амь хоргодон, Даан гуай гадаа юу болсныг харахаар Петертэй зөрөн дээшээ гарав. Биднийг дээш гарахад “ИЕ” хэмээгч Амстердамын боомт зогсоолоос бөөн утаа олгойдон, уугиж харагдсанаа төдөлгүй түймрийн утааны үнэрээр солигдон, хот нэлдээ гүн хар утаанд умбав. Тийм их түймэр гэдэг сонирхоод баймаар юм биш аж. Бидэнд хал балгүй өнгөрсөн нь л яамай гэж баярлан дор дороо ажилдаа оров. Оройн хоолны үеэр бас л агаарын түгшүүр. Хоол үнэхээр сайхан байсан ч түгшүүрийн дохионы ёнгинооноос болоод юу ч хоолой давдаггүй. Дөчин таван минут хэртэй чимээгүй байснаа дахиад л агаараас эсэргүүцэх буунууд нижигнэн, сав суулга угааж дуусав уу үгүй юу, дахиад л түгшүүрийн дохио хангинаж, дээгүүр маань онгоцууд дүнгэнэж гарав. Бид тэгэхэд бурхан минь битгий л галзууруулчихаж үзээсэй гэж залбирч суулаа. Мэдээж залбирал өчүүхэн ч тус болсонгүй. Бөмбөг бороо шиг асган, Англичууд түрүүнд нь мэдээлж байснаар Амстердамын “Шипол” нисэх онгоцны буудал руу мөндөр мэт цутгав. Нисэгчид онгоцтойгоо нэг шумбан, нэг хөөрөн, нэг хэсэг шүршин буудалцах нь тэр чигээрээ тэнгэр буцлах мэт. Эгшин бүрд л тэдний нэг нь дээрээс уначих вий гэж айхдаа зүрх дэлссэнийг хэлээд яана. Оройн есөн цагт хажуулахад бараг хоёр хөл дээрээ тогтож чадахааргүй ядарчихсан байснаа чамд хэлье. Шөнө дөлөөр бас л сэрж, 12 цагийн үед бас л онгоц гэгцгээв. Дуссел гуай бүр хувцаслачихсан сууж байлаа. Би ч бас хувцаслав. Эхний бөмбөгдөлтөөр л орноосоо огло үсэрсэн дээ. Хоёр цаг хэртэй онгоц дүнгэнэв. Би юуны өмнө аав дээрээ л очив. Тэгтэл буудалцаан ч зогсож, өрөө рүүгээ буцах болов. Хоёр хагас хэртэйд унтах санаатай хажуулав.*

*Өглөөний долоон цаг болж байв. Бас л чимээ гарахаар нь айж сандран аав дээрээ очвол Даан гуай ирчихсэн сууна. “За бүгдийг нь сонсдог хэрэг, лав хулгайч даа, бас л баахан юм аваад арилаа биз” гэж бодтол харин эсрэгээр Даан гуай өчнөөн сарын турш сонсоогүй чихэнд чимэгтэй мэдээ хэлэх гэж явсан юмсанж.*

*Муссолини огцорч, италийн ван дахин засгийн эрхийг авч гэнэ. Бид хөөрөн баярлацгаав. Өчигдрөөс эхлэн үнхэлцгээ хагартал айж сандарсны дараа ингэж сайхан мэдээ сонсож, амьдрах итгэл олж авах гэж. Муу юм цаашилж, сайн юм нааилах зөн шүү. Ноён Кралер ч ирэв. Түүний ярих нь боомт, зогсоолууд их сүйдэж гэнэ. Дараа шөнө бас л тугшүүрийн дохио, дахиад л онгоцны дүнгэнээн. Тугшүүрийн дохионоос сэтгэл хямран, унтаж ч ажиллаж ч чадахгүй боллоо. Харин муу юм төгсөнө гэсэн итгэл л биднийг зоригжуулна гэж горьдож байна даа.*

*Анне*

## 1943 оны долдугаар сарын 29. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Даан гуайн авгай, Дуссел эмч бид гурав сав суулга угааж байв. Тэд намайг өөлж муулахгүй байгаа нь өдрийн од шиг ховорхон явдал шүү. Элдвийн юманд хошуу дүрэхээс нь сэргийлэх санаатай хал балгүй сэдэв хөндөхөөр шийдэж “Henri van der Overkant” гэгч номын тухай яриагаа эхлэв. Гэхдээ би Даан гуайн авгай биш юм гэхэд Дуссел эмч ямар нэг зэвүүн үг хэлэхэд үгүй гэх газаргүй гэдгийг ч бодолцов. Учир нь Дуссел тэр номыг дажгүй ном гэж бидэнд зөвлөөд байсан юм. Би ямар Маргот биш ганц хоёр уншаад тэр номых нь гоц гойдыг нь мэдсэн ч үгүй. Хөвгүүдийг гайхмаар дүрсэлсэн байв. Харин бусдын нь тухайд бол... үнэндээ дуугай өнгөрсөн нь дээр дээ. Гэвч би санаснаа нуулгүй ярив. Тэгтэл ч өнөөх аятай байдал тэгсгээд алдагдав. Дуссел гуай “Чи эр хүний сэтгэхүйн талаар юу мэдэх вэ дээ. Хүүхдийн тухай ярьж байгаа бол өөр хэрэг. Тэр ном чамд ахадна. Хорьтой хүмүүс ч тэр болгоныг сайн ойлгохгүй” гэдэг байгаа. Тийм юм бол яагаад Маргот бид хоёрыг унш гээд байсан юм бол? Тэгтэл өнөөх хоёр чинь дахиад л ам амандаа:*

*-Чи өөрөө үзээгүй, өөртөө тохиолдоогүй юмыг юун сайн мэддэг юм бэ. Маш буруу хүмүүжиж байгаа нь энэ дээ.*

*Ингээд байвал яагаа ч үгүй байж амьдралаас уйдна гэсэн үг. Тэгээд юм болоход “Аа тийм энийг чинь хорин таван жилийн тэртээ номноос уншиж билээ гэлтэй нь биш. Эртхэн шиг нэг залууд үнэнээсээ дурлахыг бод. Чамд ер нь хэр барагтай залуу таалагдахгүй дээ. Номд нэвтэрлээ ч амьдрал чинь шал өөр байдаг” юм гэгцээлээ.*

*Инээдэм хүрмээр мэдэмхий, худлаа номчирхсон энэ хүмүүсийн улаан нүүр рүү нь буудчихмаар дургүй хүрэх юм.*

*Ер нь би ингэтлээ уурлаж үзээгүй санагдана. Эднээс хэдийд нэг ангижирдаг бол гэж хоног тоолон суухаас өөр аргагүй нь. Даан гуайн авгай бол ёстой хүний шаар. Үнэнхүү тийм шаарын жишээнд тохирно. Хүн ямаршуу байж болохгүй вэ? гэдэг жинхэнэ муугийн жишээ гэвэл түүнийг заахад болно. Энэ эмэгтэй бол тулга тойрсон өчүүхэн бодолтой мөртөө зальтай, бэртэгчин, атаа жөтөөч, хэрүүлч, онгироо сагсуугаараа зартай хүн дээ. Түүний мууг тоочвол бүхэл бүтэн ном ч бичиж болох юм. Заримдаа Даан гуайн авгай худал инээж, сайхан загнана. За эрэгтэйчүүдтэй бол бүр ч адтай гээч. Ээж түүний тухай ярьж үг зарахын хэрэггүй тэнэг гэдэг юм. Маргот бол тоодог ч үгүй. Аав ердөө л түүнийг мөс муутай хүн гэдэг юм. Удаан ажигласны эцэст тэд хичнээн онож хэлснийг гайхах болов. Тэр эзэгтэй, миний л тоочиж чадах бүх муу зан чанар бүхнийг шингээсэн хүн юм.*

**Анне**

*Жич өгүүлэхэд: Хайрт Китти минь энэ хэсгийг би үнэхээр ууртай байхдаа бичсэнийг ойлгоорой гэж хүснэм.*

### 1943 оны наймдугаар сарын 3. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Улс төрийн амьдралд сайн мэдээ их байгаа нь аз. Жишээ нь Италид фашист намыг хоригложээ. Газар сайгүй хүмүүс фашистуудыг эсэргүүцэж, цэрэг арми ч хүртэл тэр тэмцэлд нэгдэж байна. Тийм улс яаж англитай дайтаж чадах билээ? Энд гурав дахь удаагаа хүчтэй бөмбөгдөв. Миний хувьд гэхэд шүдээ тас зуун зоригтой байж чадлаа. Харин Даан гуайн авгай л “Эцэс төгсгөлгүй ингэж сууснаас эдлэх зовлонгоо амсах минь яалаа” гэж үргэлж үглэн, хамгийн тэвчээргүй зориггүйгээ харуулав. Эзэгтэй өнөө өглөө яг л улиасны навч шиг чичрэн, нулимс асгаруулж гарлаа. Долоо хоног хэртэй муур нохой шиг муудалцаж байснаа харин одоо л эвлэрч буй нөхөр нь түүнийг аргадаж тайтгаруулав. Цаашидаа л иймэрхүү эвтэй найртай, нялуун зөөлөн байцгаагаасай.*

*Муурын тухай ярих юм их ээ. Муур дан ганц ашигтай амьтад биш гэдгийг Муши муужгай нотолсон доо. Мушигаас болж энд нохой бөөс, муурын ширх ихдэж бөөн зовлон тарив. Коофуйс гуай муурын тэр элдэв халдварт шавьжийг устгах санаатай газар сайгүй л нунтаг шар юм цацах боловч тус болж байгаа юм алга. Бид бүгдээрээ бөөн уур уцаар болцгоолоо. Гар, хөл, биеийн хаа нэгтэй ирвэгнэх шиг болон, тэр муухай нохой бөөсийг чимхээд авах санаатай өвөр түрүүгээ ухааж төнхөнө.*

*Биеийн галбираа хадгалах гэж хөдөлгөөний дасгал хийцгээх нь цөөрсөөр бие бүр хөшиж гүйцлээ.*

*Анне*

## 1943 оны наймдугаар сарын 4. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Энд бүгснээс хойш жил болоход бид яаж шүү амь зууж байгааг чи юу эс андах вэ. Гэхдээ бүхнийг чамд тоочно гэж юу байх вэ. Эрх дураараа наранд байгаа биш болохоор бүх юм амаргүй л байна. Чамдаа сайн ойлгуулахыг тулд би манайхны нэг өдөр яаж эхэлж яаж төгсдөгийг тоочдог юм бил үү? За тэгээд энэ үдэш болох шөнөөс эхлэе.*

*Оройн есөн цаг болж унтацгаах гэж бөөн ажил эхлэх нь тэр. Унтах гэж орой бүр сандлуудыг хурааж, хөнжил гудсаа авчран, ор тавьж, хөнжил гудас дэлгэн бужигналддаг. Товчоор хэлэхэд өдөр байсан юм бүхнийг зайчилж хураан шөнө унтахад тохируулан ор дэр засна. Би нэг метр тавьхан сантиметрийн урттай ванданг уртасгаж сандал тавиад унтдаг юм. Хөнжил, гудас, дэр, дэвсдэг даавуу энэ тэрээ өдөр нь Дуссел гуайн орон доогуур хийдэг гэж байгаа. Зэргэлдээх өрөөнд Маргот эвхдэг ороо хяхтнуулан татах нь сонсогдон, хөнжил гудсаа янзалж байгаа бололтой.*

*Даан хатагтай ороо цонхруугаа ойртуулах гэж пижигнүүлэн чирэх нь хэтрүүлдэг хүнд бол тэнгэр дуугарав уу гэж андуурмаар. Учир нь Даан авгай өөрийнхөө хэлдгээр хөөрхөн шөнтгөр хамраараа аль болох ойроос цэвэр агаар амьсгалан, улаан торгон цамц өмссөн “сайхан биеэрээ” таашаал хүртэх гэж тэгдэг юм. Хэ хэ.*

*Петерийг арай гэж есөн цаг орчимд нүүр, шүдээ угаах ажлаад дуусахад би бас ганц сайн угаал үйлдэх минь гэж угаалгын өрөөнд оров. Заримдаа ч нохой бөөсний үр төлийг усаар эд бад болгох хэрэгтэй болдог юм. Заваан санагдаж байгаа бол уучлаарай. Мөн шүдээ сойздож, үсээ ороон, гоо сайхны ач холбогдолтой жижиг сажиг засал хийнэ. Тэр бүхнээ гүйцээхэд бараг л хагас цаг орно.*

*Тэгээд л есөн цаг хагас гэхэд усанд орохдоо өмсдөг халатаа углаж, нэг гартаа саван, нөгөө гартаа үсний зүү, ороодог хөвөн, дотуур хувцасаа мөрөн дээрээ тохон, угаалгын өрөөнөөс гарч ирнэ. Угаалгын ширээнд түр сууж сайхан хар үсээ янзалдаг юм билүү гэтэл дараачийн хүн нь хүлээж ядан дуудна.*

*Арван цаг гэхэд өдөр нь харанхуйлж татсан хөшгөө нээнэ. Сайхан нойрсоорой гээд хэвтэхэд нэг мөч хэртэй хүмүүсийн эргэж хөрвөхөд ор нь нужигнан хуучирч муудсан пүриш нь хяхтнах нь сонстоно. Хэрэв дээд давхрынхан гэр бүлийн уншлагаа эхэлчихгүй бол бүгд тэгээд л анир чимээгүй болно доо.*

*Шөнийн арван нэгэн цаг хагасын хэрд угаалгын өрөөний хаалга онгойн, гэрэл туссанаа, хөлийн чимээ гарав. Харвал Дуссел гуай томдсон халатаа нөмөрсөөр орж ирэв. Тэрээр ноён Кралерийн конторт сууж байгаад ирж байгаа нь тэр. Арваад минут хэртэй, Дуссел юм эрж байгаа мэт сууснаа, бодвол нуусан юмаа ганцаараа идэж байгаа бололтой хэсэг цаас шажигнуулаад ороо засав. Тэгснээ хэсэгхэн зуур өнөөх чинь хааччихав гэлтэй алга болсноо тэнд юугаа хийгээд байгаа юм бэ гэмээр жорлонд сүр сархийв.*

*Шөнийн гурван цагт жаахан юм янзлахаар босов. Янзлах ч гэж дээ, бяцхан төмөр*



хайрцагны доогуур хийсэн хаймар бохио авч зажиллаа. Шүлс гоожиж эхлэхэд амьсгаагаа барьж ядна. Бүтээлгэн доор байгаа юмсыг минь үдэш Маргот харчихаад үгүй, энэ үзэлд ормоор унтлагын цамцыг дээ гэсэн. Тэр үзэлд ормоор цамцаа өмсөөд би төдөлгүй хөнжилдөө орно.

Тэгээд л нойр хүрэхгүй хулгайч доор байна уу, үгүй юу гэж баахан чимээ чагнан хэвтэнэ. Манайхны ихэнх нь дуг нойрондоо дугжирч ганц нэг нь ч л сэрүүн байгаа бололтой. Сэрүүн байгаачуулын нэг нь Дуссел гуай байвал бүүр ч онцгүй. Уснаас гарсан загас л амьсгалахдаа арвантаа ингэж амьсгааддаг болов уу гэмээр шуухитнан, уруулаа дуугаргаж ирээд л шилэмдэнэ. Тэгээд байн байн эргэж, хөрвөн, дэрээ хойш урагш нь болгоно. Эрхэм доктор гуай тэгж тэгж л нэг юм дуг нойрондоо автана даа.

Шөнийн нэг цагаас дөрөв хүртэл гадаа буудалцдагаараа л буудалцах сонсогдоно. Би юу болж байгааг ч ойлгохгүй, нэг л мэдэхэд босчихсон орныхоо дэргэд нойрмоглон сууж байна. Тэгж байхдаа зүгээр сууж байхаар гээд ховор үйл үгүүдийг үе үе амандаа уншин, заримдаа дээд давхрын айлын хэрүүл санаанд ороод ирнэ. Бодлогоширсондоо болоод буудалцааныг мартчихсанаа анзаараад үсрэн босч гэрийн халат, шаахайгаа углахчаа болоод төрсөн өдөрт минь зориулсан Марготын шүлэгт

Айдаст шөнийн шуугианд сэрсэн ч

Амар амгаланг эрэн мөрөөднө

Аврал хайсан жаалхан охин

Аавынхаа нөмрийг эрэн гүйнэ

гэж гардагчлан аавын нөмөрт хоргодохоор өрөө рүү нь гүйнэ. Аавын дэргэд л байвал буудалцаан энэ тэр нэг их аймаар юм биш мэт санагддаг юм.

За тэгээд өглөөний зургаа дөчин тав дээр сэрүүлэг тачигнаж гарна даа. Сэрүүлгийг Даан хатагтай тэгж тааруулдаг. Нөхөр нь босож байгаа бололтой чимээ гарснаа, ус шоржигнон угаалга хийж эхэлнэ. Тэгээд арван таван минут хэртэй болмогч Дуссел гуай босож усанд орох нь сонсогдоно. Хамгийн сүүлд нь би хөшигнүүдийг татаж харанхуйлан, манай хөөрхий нуувчны нэгэн шинэ өдөр эхэлдэг юм даа.

Анне

## 1943 оны наймдугаар сарын 5. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр чамдаа үдийн завсарлагааны тухай яримаар байна. Ингэхэд одоо арван хоёр хагас болж байна. Үхэр оготнын үүр бүхэлдээ хөдөлгөөнд орох нь тэр. Пүүсний цэвэрлэгч нар ч яваад өгчээ. Дээр тоос сорогч шуугиж эхэллээ. Бодвол Даан хатагтай өнөөх л “урдаа барьдаг ганц эд” гэдэг хивснийхээ тоосыг соруулж байгаа биз.*

*Маргот ч номоо сугавчлан, Холланд хэлний хичээлд нэг л ахиж өгөхгүй байгаа “сурагч” Дуссел руугаа орно. Аав ч яахав жаргалаа эдлэх гэж өнөөх л хайртай зохиолч Ч.Диккенсийнхээ номыг аваад нэг булан бараадна. Ээжийг ажилсаг эзэгтэйд туслахаар дээшээ гарахад би угаалгын өрөө янзлах, өөртөө бага сага засал хийхээр одно. Арван хоёр дөчин тавд Хенк, Коофуйс, Кралер, Элли нар ба Мийн байн байн тэдний хамт дээд давхар луу уван цуван гарна.*

*Нэг цагт Английн BBC радиогийн мэдээг бүгд чих тавин сонсоно. Энэ бол манай хоргодох байрныхны ам мурийлдаггүй, тэр дундаа Даан гуайн хэнтэй ч үг сөрдөггүй ганц үе нь байгаа юм. Нэг арван тавд хөнгөн цай ууцгаана. Бүгд л нэг нэг аяга шөл ууна. Аяганы хийцтэй бол ч тавагладаг цаг даа. Хенк буйдан дээр суун сонин уншиж, муураа дэргэдээ хэвтүүлэн, ширээн дээр аягаа тавьсан нь тайван, тохь тух бүрдсэн харагдана. Ноён Коофуйс гадуур хотоор болж буй явдлын талаар ярьж өгнө. Ноён Кралер шат алгасан гишгисээр үүдэнд ирэв үү, үгүй юу л ойрхон ойрхон тогшиж, алгаа үрсээр орж ирэхдээ тэр өдрийнхөө байдлаас сэтгэл өөдрөг, эсвэл гутранги орж ирнэ.*

*Нэг дөчин тавд салах ёс гүйцэтгэн гарцгааж, дор дорынхоо ажилд орно. Ээж, Маргот хоёр аяга сав угаан, Даан гуай авгайтайгаа хэсэг хажуулахаар явахад, Петер өөрийнхөө хийсэн нүхэнд орж, аав түр дугхийж, Дуссел гуай бид хоёр уншиж, бичиж гарна. Энэ бол хамгийн сайхан цаг даа. Бүгд унтаж байдаг үе болохоор хэн ч садаа*

*болохгүй. Дуссел гуай сайхан хоол мөрөөдөж байгаа нь царайнаасаа илт. Харамсалтай нь миний юм хийх боломжтой цаг даанч богинохон юм. Нэг мэдэхэд л дөрөв өнгөрчихсөн, Дуссел гэдэг ёсорхуу амьтан чинь босчихсон ширээ булаацалдаж гарна.*

**Анне**

## 1943 оны наймдугаар сарын 9. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Хоргодох байрныхаа нэг өдрийн тухай үргэлжлүүлэн ярьж даа. Үдийн хоолны дугараа Даан гуайгаас эхэлнэ. Тэр өөртөө юм юмнаас арай л илүү хийж авна. Даан гуай хүн бүхэнтэй ярьж, хэн бүхний явдалд оролцон, өөрийнхөө бодлыг хамгийн ухаантай нь гэж бодно. Тэр нэгэнт л санал бодлоо хэлчихсэн бол юу ч өөрчлөгдөхгүй гэсэн үг. Хэрэв нэг нь түүний үгийг сөрчихвөл ёстой муугаа үзнэ. Яг л эр муур шиг шуухитнаж гарна даа... Чи нэг удаа санамсаргүй Даан гуайтай үг сөрчихвөл бөөн гай болно. Тэр өөрийгөө бүхнийг мэддэг хүн гэж боддог юм. Гэтэл өнөөдөр Даан гуай хачин хөгжөөнтэй болчихсон байгаа нь хачирхалтай.*

*Эрхэмсэг эзэгтэйн хувьд гэхэд дуугуй байх нь дээр бизээ. Заримдаа ер нь түүнийг муухай ааштай байхад нь холхон байсан нь дээр дээ. Эзэгтэй заримдаа бүх л маргааны буруутан болж байдаг. Бас сайн хутган үймүүлэгч гээч. Хэрүүлийн галд тос нэмж улам дэврээх нь Даан хатагтайн хувьд гар хурууны үзүүрийнх нь ажил гэсэн үг. Франкийн гэргий, охин хоёр буюу ээж бид хоёрын өөдөөс бол хатагтай Даан гав шув хийгээд л орно доо. Харин аав, Маргот хоёртой бол арай болгоомжтой харьцана. Аргагүй л дээ, мань хоёрт бараг өөлөх юм байхгүй юм чинь. Яах ч билээ.*

*Хоолны ширээнд юу болдгийг өгүүлбэл: өөрийгөө соёлтой, ёсорхог, элит хүн гэж үздэг Даан эзэгтэй өлөв долов хийдгийг яана. Төмсний аль жижиг шимтэйг, ер нь хоолны аль нүнжигтэйг нь түүж гарна. Бусад нь түүний үлдээсэн шавхрууг л сая нэг аягалахчаа болно. Тэгээж байхдаа зогсоо чөлөөгүй л бурна. Чалчихы нь хүн сонсоно уу, байна уу гэдэг ер нь падгүй. Өөрийнхөө чалчаа яриаг хүн бүрд сонирхолтой гэж боддог бололтой.*

*Эзэгтэй талимааран инээмсэглэж, бүхнийг мэддэг дүр гарган, хүн бүхэнд сайн дураараа зөвлөгөө өгөх, сайхан сэтгэлт эхийн дүрд тоглож гарна. Тэр багных нь цаана үнэн санаа нь нуугдсан байдаг. Даан хатагтайн нэгд дүр үзүүлэх, хоёрт баясч хөгжих, гуравт аальгүйтэх энэ зорилгууд л түүний дарь эхийн төрхний цаана байгаа юм.*

*Ширээнд суугаа гурав дахь залууг хэн ч тоодоггүй юм. Тэр бол Даан гуайн хүү Петер. Тэр банди дуугарах ч үгүй, хэний ч анхаарлыг таталгүй чимээгүй сууна. За Петерийн ходоод гэж ёроолгүй торх л гэсэн үг. Яагаад гэвэл өөх тостой ямар ч хоолыг их хэмжээгээр цохичихоод огт цадаагүй царай гарган сууна гээч.*

*Дөрөв дэхь хүн нь Маргот. Эгч маань яг л шувуу шиг жоохон иднэ, ярьж хөөрөх нь ч бага. Маргот ногоо, жимсхэн л гоочлоно. Үүнийг нь Даан гуайнхан “муу зуршил” гэж зэмлэдэг юм. Бид бол харин “агаар, хөдөлгөөн дутагдсанаас л энэ” гэнэ. Марготын цаана ээж сууна. Ээж сайн ч иднэ. Их ч ярина. Гэхдээ миний ээж Даан гуайн авгай шиг эзэгтэй биш ээ. Хоолны ширээнд суугаа зургаа, долоо дахь хүмүүс нь аав бид хоёр. Бидний тухай олон юм яриад яах вэ дээ. Энд байгаа хүмүүсээс хамгийн нуруутай, буурьтай, сайхан хүн нь аав байв. Тэр бусдад маань хоол хүртэж байна уу үгүй юу гэдгийг үргэлж харна. Хүүхдүүд л хамгийн амттай, өөдтэйг идэх учиртэй гэдэг болохоор хоол уруу учиргүй ухасхийнэ гэж үгүй. Пим*

*бол ердөө л сайн, сайхны үлгэр дууриал билээ. Харин тэр сайн хүний дэргэд нь хоргодох байрныхны хамаг уур уцаарыг хөдөлгөсөн, болохгүй бүтэхгүй бүхний цуглуулга болсон би суудаг юм.*

*Дуссел доктор хоолыг голж, шилэлгүй тавгандаа хийж аваад хар цагаан дуугүй иднэ. Харин хааяа дуугарах юм бол бурхан минь, хоолны л тухай яриа урсгаж гарна. Тэр нь нэг их маргаан үүсгэдэггүй, хүн бүр оролцох дуртай сэдэв л дээ. Ер нь Дуссел эмч бол ямар ч хоолыг голдоггүй хүн дээ. Өмдөө, шагайгаа хүртэл татаж, час улаан хүрэм, тас хар өнгийн гэрийн шаахайтай хослуулан өмсөж, хар хүрээтэй эвэр шилээ хамар дээрээ тохон явна. Бичгийн ширээнд ч, хоолон дээр ч, үдийн унтлагын үед ч, хамгийн их жаргалангаа эдэлдэг бие засах газар ч хаа л ийм хувцастай явахы нь харна гэсэн үг.*

*Бид өдөр бүр жорлонгийн үүдэнд гурав, дөрөв, заримдаа таван ч удаа хоёр хөлөө сэлгэн хавчигнаж, Дуссел докторыг гарахыг хүлээж ядна. Бусдыгаа ингээж тарчилгаж байгаагаа Дуссел мэддэг гэж чи бодно уу? Даанч үгүй шүү. 6:15аас 7 хагас хүртэл, 12 хагасаас 1 цаг хүртэл, 2 цагаас 2:45 хүртэл, 4 цагаас 4:45 хүртэл, 6 цагаас 6:45 хүртэл, шөнийн 11цаг хагасаас 12 хүртэл жорлонд ороод таг болчихдогий нь бүртгээж болох юм. Өөрөө ингээд ойр ойрхон бие засдаг болохоор тэр биднийг үүдэнд нь хавьчигнан шаналах зовлонг яаж ч ойлгох билээ.*

*За ингээд өдөр бүр бидэнтэй хамт хооллодог ес дэхь хүнийг танилцуулъя. Тэр бол бидэн шиг хоргодож байгаа хүн биш, бидэнд үргэлж тусалдаг Элли юм. Элли хоолонд сайн ч шилж сонгодоггүй юм. Элли баяр баясгалантай зангаараа биднийг дандаа хөгжөөнө. Тэр бол үргэлжид баяр хөөртэй, сайхан загнаж явдаг бүсгүй.*

**Анне**

## 1943 оны наймдугаар сарын 10. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Би одоо шал өөр хүн болохоор шийдлээ. Би хүмүүстэй ширээнд сууж байхдаа тэдэнтэй ярихаасаа өөртэйгөө их ярих нь дээр гэж бодох боллоо. Тэгвэл олон талын ашигтай юм байна.*

*Нэгд, далан хэл дэлгэхгүй байхаар манайхан дуртай байх шиг. Хоёрт, хүмүүсийн санал бодол надад таалагдахгүй бол уурлаад байхгүй юм. Ер нь миний бодол дандаа л зөв санагддаг болохоор түүнийгээ дотроо л хадгалсан нь дээр санагдана. Хоол ундан дээр ч, тэвчмээргүй юман дээр ч дандаа л ингээд дуугүй байсан нь дээр юм аа. Өөрөө өөрийгөө хүмүүжүүлэх нь өлзийтэй учир ийм л байх болно. Тэгээд л урьдынх шигээ элдвийг шүүмжлэн тунгаахаасаа илүү хөхиүн, хөгжсөөнтэй байх гэж чармайх боллоо. Өглөө бүр тухтай хэвтэж чадахааргүй байсан ч, орноосоо огло үсрэн босохын оронд “хэвтээрэй чи” гэж өөртөө өгүүлэн, хөшгөө онгойлгоод гудамжны цэвэр агаарыг түр ч бол амьсгалан, сэрүүн хэвтдэг болов. Ороо хураачихвал дахиад хэвтэх хөг өнгөрдөг юм чинь тэгэх нь дээр шүү дээ. Ингэж өөрчлөгдсөнөөс хойш ээж намайг юу гэдэг болсныг мэдсэн үү? “Ёстой амьдралын жүжигчин” гэх болсон доо. Инээдэмтэй үг байгаа биз?*

*Энэ долоо хоногийн сүүлчийн өдрөөс эхлэн бид цаг хугацааг баримжаалах юмгүй болов. Яагаад гэвэл Вестертурмийн хонх дуугарахаа больсон. Бодвол түүгээр их буу хийгээ биз. Ингээд л чухам хэдэн цаг болж байгааг мэдэхгүй боллоо. Хэдэн цаг болж байгааг чимээгээрээ хэлж, сайхан дуугаараа баясган, уйтгарт орчинд хангинаж байх ямархан нэгэн юм олдоно байх гэж итгэж байна.*

*Дээр доор хаана ч очно, бүгд л шинэ гутлыг минь шагшин, хөлийг минь харна. Мийн эгч л өндөр өсгийтэй, сайхан улаан элгэн тэр гутлыг “хүнээр дамжуулж” хорин долоо тавиар авчээ. Яг л хөлдөө саваа мод баглачихаад дэнжигнэн яваа юм шиг өндөр болсондоо.*

*Өчигдөр азгүй байсан. Тэвнийн учигтай талаар нь баруун гарынхаа эрхийг сүлбэчихэв. Түүнээс болж Маргот миний оронд төмс цэвэрлэх болов. Нэг бүдрэхэд долоо бүдэрнэ гэгчээр бас шүүгээний хаалга мөргөж духаа булдруу болгочих нь тэр. Их чимээ гаргаснаас бас зэмлүүлж, ус гоожуулж болохгүйгээс духандаа хүйтэн жин тавьж чадсангүй. Тэгтэл нөгөө булдруу чинь баруун нүдний дээд талд овойсон юм болдог байна. Бас баруун хөлийнхөө чигчийг тоос сорогчийн гишгүүрт хавчуулаад авав. Тэгээд тэр олон бэртлийнхээ алины нь гэх аргагүй болсонд хамгийн сүүлчийнхээ шархыг аргалах гэж оролдоход хүрэв. Миний бүтэлгүй гэж жигтэйхэн. Гай болж шархандаа халдвар оруулаад хөлөө боолголоо. Өнөөх гоё гутлаа ч өмсөх маань өнгөрөв. Хажуугаар нь Дуссел бидэнд санамсаргүй гай тарих шахав. Тэр анхааруулж хэлэлгүйгээр Мийнээр дамжуулж Муссолинийг муулсан хориотой ном авчруулахаар захижээ. Гэтэл тэр номы нь аваад ирж явсан тэр өглөө нь гай бол Мийнийг SS-н нэг мотоцикльтэй цэрэг дайрчих шахжээ. Мийн ч биеэ барьж чадалгүй “муу гахай” гээд хашгирчихаж. Азаар цаадхи нь сонсолгүй яваад өгч. Цагдаа хэрэв Мийнийг аваад явсан бол юу болох байсныг хэлэх ч юм биш.*



## 1943 оны наймдугаар сарын 18. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Чамдаа өнөөдөр ердийн өдөр тутмын ажил болох төмс хальслах тухай тайлбарлах уу даа. Бидний нэг нь хальсыг нь боох сонин, нөгөө нь иртэйхэн шиг хэдэн хутга, гурав дахь нь төмс, дөрөв дэх нь устай түмпэн авчирна.*

*Энэ өдөр Дуссел гуай хамт төмс арилгалцав. Тэр нэг их ч сайн хальсалдаггүй юм. тэгээд ч тэр үү, хоёр талдаа суусан хүмүүстэй өрсөлдөж байгаа юм уу хаашаа юм баруун, зүүн талдаа суусан хүмүүсийнх рүү өлөлзөж гарна даа. Үгүй таминь, тэгснээ:*

*-Анне, наашаа хар. Хутгаа ингэж барь. Тэгээд дээрээс нь доош нь ингэж хальсалж үз. Үгүй, буруу байна. Ингэж хальсал гэхэд нь би өмнөөс нь ичиж дургүй хүрээд:*

*-Харин ингэж арилгах нь дээр биш үү гэв. Тэгтэл Дуссел:*

*-Үгүй гэм, ингэж хальслах нь хамаагүй дээр байдаг юм. Ер нь чиний яаж хальслах нь надад ямар падтай биш дээ гэснийг би бараг өөрөө тааж байгаа бизээ. Бид юу ч дуугаралгүй цааш хальслацгаав. Тэгээд дэргэд суугаа Дусселийг сэмхэн харвал намайг л буруушааж байгаа бололтой толгойгоо сэгсэрч харагдана. Би дуугарсангүй төмсөө арилгангаа өөдөөс минь харж суусан аавыгаа харав. Аавд бол төмс хальслах нь тийм хайш яйш хийх ажил биш дэг. Харин нарийн ур чадвар шаардах ажил бололтой. Юм уншихдаа ч хүзүү хоолойгоо үрчийлгэн, ямар нэг юм бодох мэт байдаг бол, төмс хальслах, буурцаг ногоог хутгаж холиход туслахдаа ажилдаа улайран, өөр юу ч үл анзаарна. Тиймээс тэр төмс бүрийг өөрийнхөө нүүр нүд мэт хайрлан, хайш яйш огтчиж сэглэлгүй гоц анхааралтай цэвэрлэдэг юм.*

*Би хичээнгүйлэн төмсөө арилгах зуураа нэг юм ажиглаад авлаа. Мань эзэгтэй Дуссел эмчийн харцанд өртөх санаатай оролдоод авдаг юм байна. Эзэгтэйн ширтээд байгааг цаадхи нь огт авч хэлэлцсэнгүй дээ. Даан эзэгтэйг сэмхэн нүдээ ирмэхэд, Дуссел хэнэг ч үгүй төмсөө цэвэрлэсээр суув. Тэгээд хөөрхий хатагтайг инээхээр нь ярвайдаг байгаа. Ээж тэгэхэд нь тэсэлгүй инээмсэглэв. Сээтэгнээд үр дүнд хүрээгүй эзэгтэй нөхөр рүүгээ:*

*-Путти, наад хормогчоо аваач. Өмд, хүрмийг чинь маргааш цэвэрлэх болох нь гэлээ. Даан эзэгтэй нөхрөө Путти гэж өхөөрдөн дууддаг юм. Харин Даан гуай:*

*-Би бохиртуулахгүй дээ гэв. Эзэгтэй бас л нэгийг бодов бололтой,*

*-Путти, чи яагаад суухгүй зогсоод байгаа юм бэ? гэхэд цаадхи нь*

*-Зогсоход аятайхан байна. Би зогсож төмс хальслах дуртай гэв. Авгай хэсэг чимээгүй болсноо:*

*-Путти, наадхиа хараач дээ. Үсэргэж орхилоо гэхэд Даан гуай*

*-Тиймээ хөө би мэдэж л байна гэв. Эзэгтэй тэгтэл яриагаа өөрчлөн:*

*-Путти, англичууд яагаад бөмбөгдөхөө больчихов оо. Ярь л даа гэхэд*

*-Яахав дээ тэнгэр муудаад л тэр биз гэв.*

*-Өчигдөр чинь сайхан өдөр байсан шүү дээ. Гэвч тэд нислэг хийсэнгүй.*

*-За больж үз нэг л юмаа хэчнээн ч нуридаг юм бэ?*

*-Тэр тухай чинь яагаад бодсон санаснаа ярьж болдоггүй юм бэ?*

*-Хэн ярьж болохгүй гэсийн!*

*-Ярьж болохгүй гээгүй гэнэ ий?*

*-За, ээжхэн минь дуугүй байж үзээч!*

*-Франк гуайг хараач, авгайгаа юу л асуусан заавал хариулдаг шүү дээ.*

*Даан гуай тэгэж хэлэхэд нь дургүй нь хүрсэн бололтой харагдав. Эзэгтэй тэгтэл дахиад л:*

*-Өнөөх эзлэх, дайлаад авах өнгөрөв өө гэв. Даан гуайн царай уурандаа цонхийн цайж, тэсэж чадахгүй байртай болцгоов. Эзэгтэйг:*

*-Англичууд ч Германыг яаж дийлэх вэ дээ гэхэд Даан гуай тэсч чадахаа болив бололтой:*

*-Наад амаа тат! Тэнгэрт ниргүүлмэр минь! Хэмээн хаширав. Ээж тэссэнгүй инээчихэв. Би хэний ч царайг харалгүй доошоо л харав. Тэр хоёрын хэрүүл зодоондоо хүрэхгүй л бол аль муудалцахыг тэр гэхэв. Ер нь хэн хэн нь уураа барьж, хэлэх үгээ бодоход яадаг байна аа?*

*Төмс авчрахаар агуулах руу очих хэрэг надад гарав. Петер тэгтэл дээр муурныхаа ширхийг нь түүж байгаа нь энэ гэж бөөн юм болж байв. Тэгээд намайг ормогц түр саатан над руу харахад нь өнөөх мууур нь эзнийхээ гар суларсныг мэдээд ухасхийн алдуулаад, нээлттэй цонхоор арилаад өгөв. Петер хараал тавьж, би инээсээр тэндээс гарав.*

*Анне*



## 1943 оны наймдугаар сарын 20. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр, ажилчдыг оройн яг таван цаг хагаст агуулахаас гарч одоход бид арай гэж чөлөөтэй хөдлөх болов. Чөлөөтэй бай гэсний дохио болж, Эллиг орж ирэхэд бид дор дороо юмаа хийж эхлэв. Би харин Эллид өгөх гэж тавьсан жаахан амттан тавьсан газар руу хөтлөв. Тэгтэл Элли маань “Хөөш Элли, надад...” гэж Даан эзэгтэйн олон юм гунигнаж эхлэхээр ч тэгэв үү, удаан суух гэсэнгүй, над руу нүдээ ирмээд гарав. Энд дээр гарч ирсэн хэн ч тэр эзэгтэйн захиасгүй гарах нь ховор л доо. Даан эзэгтэйн зангаас болоод ирсэн хүмүүс дээшээ гарч ирдэггүй юм даа.*

*Тав дөчин тав болов. Элли ч харьж, би доод давхарт бууж ирэв. Эхлээд гал тогоо, дараа нь аавын хуучин контор орж бүүр доошлон хулганыхаа гөрөөнд гарсан Муши муужгайн байгаа нүүрсний зоорийн хаалгыг татав. Энд өдрийн сонин хэвлэл үзэх гэж Даан гуайн онгичиж хөглөрүүлсэн хавтас бүхий ширээ байх, ноён Кралерын өрөөнд оров. Петер Мофи муужгайн байсан лангууны түлхүүрийг авчрав. Пим, бичгийн машиныг дээш зөөв. Маргот бичиг дансныхаа ажлаа хийх бололтой чимээгүй булан хайж гарав. Даан эзэгтэй устай том түмпэнгийн дэргэд суун, ээж дүүрэн төмстэй түмпэн тэвэрсээр орж ирэв. Хүн бүр гар хөдөлгөх ажилтэй болжээ.*

*Петер төдөлгүй агуулахаас орж ирэн Кралер гуайн өдөр бидэнд зориулан авчирч өрөөндөө орхидог талх байна уу гэвэл, тэр нь мартагдсан байв. Контоорын өмнөх том өрөөнд орхичихсон байж магад гээд орж үзэх хэрэгтэй боллоо. Петер, гадуур яваа хүмүүст цонхоор харагдчих вий гэж мөлхсөөр шүүгээнд үзэж байж талхаа олж буцаад мөлхжээ. Гэтэл Муши муужгай дээгүүр нь харайн, бичгийн ширээнд доогуур нуугдав. Тэгээд муураа олох ажил гарав. Тэгж тэгж арай хэмээн олмогцоо ахин өрөөгөөр мөлхөж очин сүүлдээд авах гэвэл муур нь уухирч Петер аргаа баран, санаа алдахад хүрэв. Муши нь бүр тэгэхээс тэгэх гэсэн юм шиг, цонхон дээр суучихаад биеэ долооно. Петер сүүлчийн мэхээ гаргахаар шийдэн, зүсэм талх харуулж, аз болж Мушиг шүүрэхээр ухасхийхэд нь барьж аван шалавхан хаалгаа хаачихав. Би, тэр хоёрыг эхнээс нь аваад дуустал нь хаалганы завсраар харав. Тэгээд л юмаа хийж гарав. Тог, тог, тог гэж гурвантаа тогших чимээ гарлаа. Энэ нь хоолондоо гэсэн үг дээ.*

**Анне**

## 1943 оны наймдугаар сарын 23. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Нуувчныхаа бас нэгэн өдрийн амьдралыг ярьдаг юм бил үү. Өнөө өглөө цагийн сэрүүлэг найм хагаст хангинахад ээж, Маргот хоёр зэрэг зэрэг уурлан “хүүш ааваа... хүүш Отто... хүүш Пим, найм хагас болчихлоо. Усаа шоржигнуулж дуугаргаж болохгүй” гэхэд аав:*

*-Зүгээр, зүгээр чимээгүй л хөдөлж үзье гэв.*

*Энэ бүгд нь бие засах газар орчихоод гарч өгөхгүй байсан аавд өгсөн анхааруулга байв. Найман цаг хагас гэхэд тэр уг нь өрөөндөө ирсэн байх ёстой байв. Жорлонд ч орж болохгүй, цааш нааш холхилгүй нам гүм болсон байх үе. Доор нүүсэнд хүн байхгүй үед ус шоржигнох чимээ агуулахад хүртэл дуулдана. Есд арван минут дутуу байхад дээр Даан гуайнхан хаалгаа онгойлгож хэн нэг нь шал гурвантаа тогшин:*

*-Аннегийн агшаамал бэлэн шүү гэсэн дохио өгөв.*

*Би тэгэхэд нь нохойн идүүр шиг түмпэнгээ авчрахаар гарав. Доошоо бумагцаа, ус толгойгоо янзлах, шээсний саваа цэвэрлэж авах, ор дэрээ засах мэтийн ажил төрлөө амжуулангуут чимээ гаргаж болдоггүй байх цаг эхлэв.*

*Даан эзэгтэй, нөхрийхөө адил, дээр гэрийн гуталтай гэтэх шиг болсноо, таг чиг болон чимээ тасрав. Чи манай гэрийнхний энэ үеийн байдлыг харвал гайхах биз. Би нэг юм унших юмуу бичнэ. Аав, ээж, Маргот гурав тэр анир чимээгүй хагас цагт ямар нэг юм оролдон, гар хоосон суухгүйг бодно. Аав голдуу өнөөх л шүтдэг Диккенсээ барина даа. Тэр хэзээ ч олигтойхон гудас дэвсдэггүй, хяхтнаа орныхоо ирмэг дээр сууна. Аав уншиж байгаа юмандаа улайрах тусмаа, юуг ч анзаарахаа болиод хааяа сэм сэм инээн ээжид шивнэн уншиж өгнө. Ээж тэгэхэд нь “Одоо хэрэггүй. Сонсох зав алга” гэнэ. Аав ээжийн тэгэх бүрд жаахан гайхсанаа цааш нь уншина. Хэсэг зуур чимээгүй байснаа, ямар нэг аятай юм гараад ирэхлээр нь ахиад л тэвчиж чадалгүй “Хөөе ээж минь уншмаар юм байна шүү” гэнэ.*

*Ээж эвхдэг орон дээр суун унших, эсвэл оёх, хатгах, үгүй бол ямар нэгийг шинээр сурах гэж оролдоно. Хэсэг зуур тэгээд чимээгүй болтол Маргот номоо ханхийтэл хаав. Аав нэгэн шарласан хуудсыг хөмсгөө атируулан шимтэн уншив. Духны нь үрчлээс гүнээ тодорно. Ээж тэгтэл Марготтой нэг юм шивнэн яриа үүсгэв. Би ч сонуучирхан сонсов. Аав ч мөн бидний ярианд оролцов. Хөөе ашгүй ес боллоо. Цайгаа уух болжээ.*

**Анне**

## 1943 оны есдүгээр сарын 10. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Чамд л гэж бичих болгонд заавал нэг сонин юм гарах юм. Гэхдээ сайнаасаа саар муу нь их байх юм аа. Энэ удаад харин нэг сайхан мэдээ байна. Лхагва гаригийн орой есдүгээр сарын найманд бид бүгд радиогоо тойрон суутал “Here follows the best news of the whole war italy has capitulated!” гэж англиар итали үг дуугүй буур өглөө!!! гэж зарлав.*

*Яг найман цагт “Ораня” нэвтрүүлэг эхэлж, “Эрхэм сонсогчид оо! Нэг цагийн өмнө өдрийнхөө мэдээг бэлэн болготол, Италийг бүхэлд нь авсан тухай гайхалтай сайхан мэдээ хүлээн авлаа. Би сэтгэл ихэд хангалуунаар хуучирсан мэдээгээ хогийн сав руу чулуудлаа” гэв. “Ораня” нэвтрүүлэг нь байнга сэтгэл хөгжөөдөг ч урам зориг өгдөггүй юм шиг санагддаг юм.*

*Бид харин ноён Коофуйст л сэтгэл зовно. Бидний хэн нь ч их багагүй цөмөөрөө түүнийг л эсэн мэнд байгаасай гэж зовницгоодгийг чи юу эс андах билээ. Хөөрхий тэр ходоодны өвчиндөө их л шаналан хоолны дэг барин биеэ бодох гэж бас бидний сэтгэлийг ямагт засан, гайхмаар зориг гаргаж явдаг юм.*

*Ээж саявтархан нэг удаа “ноён Коофуйсыг ороод ирэхээр нар гарах шиг л болох юм” гэж билээ. Түүн шиг үнэн үг үгүй дээ. Гэтэл тэр ходоодондоо нэлээд хүнд мэс засал хийлгэж, дөрвөн долоо хоногоос наашгүй хэвтэх хэрэгтэй болжээ. Бид түүнийг хэрхэн үдсэнийг чи харсан ч болоосой. Эмнэлэгт хэвтэх гээд явахад нь биш шүү. Зөвхөн л ойр зуурхан юм дөхүүлэх гээд дөнгөж саяхан ороод гарахад нь үдсэнийг шүү.*

*Анне*

## 1943 оны есдүгээр сарын 16. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Энд хэдий чинээ удах тусмаа тэсэхэд төдий чинээ хэцүү болох нь. Ширээнд суусан хэн ч зөвхөн хоол ундаа идэж ухаас бусад үед зүрхэлж ам нээхээ болив. Хэрэв нэг нь юм хэлбэл, хэлүүлсэн нь гомдчих, хэлсэн нь буруудчих юм. Царай алдаж, гутранги болсныг минь ажиглаж, өдөр бүр балдриан-дисперт гэдэг эм өгөх болсон ч биеийн байдал дээрдэхгүй харин өдрөөс өдөрт улам дордоод байна. Уг нь нэг удаа сэтгэлээ сэргэтэл инээж баясах нь арван тийм цагаан үрлэн эм ууснаас дээрсэн. Энд би инээд баяслыг мартаж нь байна. Би заримдаа энд хүнд хэцүү үе өнгөрөхөд нүүр маань үрчлээтэж, уруул хөдлөхөө больж, адсага шиг ааштай амьтан болчих бий гэж айх юм. Бусад маань ч гэсэн ялгаагүй л энэ өвлийг яаж барна даа гэж зовж байна.*

*Сэтгэл зовох нэг юм гарав. Агуулахад ажилтай М гэгч нэг хүн ар хаалга гэдэг манай нуувч руу орох хаалгыг сэжиглээд байх шиг байна. Бид уг нь түүнд сэжиг авахуулахааргүй л байгаа юм сан. Түүнд хэр удаан найдаж болохыг мэдэхгүй байна. Ямар ч байсан ноён Кралер их л болгоомжтой байх боллоо. Ноён Кралер арваад минутын өмнө таяг малгайгаа аваад, ойролцоох гудамжин дахь эмийн сан руу яваад тэндээ таван минут болов уу, үгүй юу буцаж ирэн манайхан руу ордог налуу шатаар яг л хулгайч шиг нууцаар орж иржээ. Түүнийг нэг цаг арван таван минутад гарахаар хөдөлтөл харин Элли тааралдаж, өнөөх М-ыг доор конторт үлдээчихсэн гээд хоригложээ. Кралер гуай тэгэхэд түр азнахаар шийдэн, нэг хагас хүртэл бидэнтэй байгаад тэсэлгүй гутлаа тайлан оймстойгоо урдах агуулахын хаалган дээр хүрч, гишгүүр бүрээр болгоомжлон бууж тэндээсээ пүүсний конторт оржээ. Элли тэгтэл харин тэр хооронд нь М-ыг ямархан нэгэн шалтгаар пүүсээс гаргаж амжаад өөртэй нь уулзахаар орж иржээ. Ноён Кралер дэмий л конторынхоо шат хүртэл оймстойгоо гэтэхэд хүрчээ. Түүнийг гудамжаар яваа хүмүүс цонхоор харвал юу гэх байсан бол?*

**Анне**

## 1943 оны есдүгээр сарын 29. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр Даан гуайн авгайн төрсөн өдөр. Бид түүнд бяслаг, мах, талхан боовоос гадна нэг шил чанамал жимс бэлэглэв. Эзэгтэй мөн бидэнд тусалдаг хүмүүс болон, нөхөр, доктор Дуссел энэ тэрээс баглаа цэцэгс, бөөн бөөн идэх юм бэлгэнд авлаа. Цаг хугацаа өнгөрсөөр л...*

*Хөөрхий Элли өнгөрсөн долоо хоногт энэ тэрийг нь цуглуулах гэж бараг шургачих шахталаа гүйв. Ихэнхид нь тэр нь ч биш, энэ нь ч буруу байна гэж буцааж гүйлгэснийг яана. Бас ноён Коофуйс өвдөж, Мийнд ханиад тусаж ажил нь ихэссэний хажуугаар өөрийнх нь шагай тулгарч их л зовлонтой явахад хэцүү болоод, бас ар гэрт нь эцэг нь тэр бүхнийг нь ойлгохгүй байгаагаас болоод хөөрхий бүсгүй үсээ зулгаамаар л хямарч яваа юм. Бид л түүнийг тайвшруулах гэж, заримдаа биеэ бодоход яадаг юм бэ гэж хатуухан хэлдэг юм.*

*Бас л хүнсний карт дуусах дөхөв. Дааныхан нэг л юм болох байхаа. Аав уурлаад л байх болж. Аянга буух гээд л хуралдаж байх шиг. Эндээс холхон шиг байж болдог бол арилаад өгөхсөн. Биднийг бараг галзууруулах нь.*

*Анне*

## 1943 оны аравдугаар сарын 17. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Ноён Коофуйс ашгүй ирлээ. Бурхан өршөө! Түүний царай нэг л цонхигор харагдана. Гэвч ажилдаа яагаа ч үгүй орж, Дааныхны хувцас хунарыг борлуулж өгөх гэж хичээж байна. Хөөрхий зайлуул, тэднийхэн хувцасаа заруулахдаа түлжээ. Нэгэнт мөнгөө дууссан бол одоо яая гэхэв дээ. Эзэгтэй өмсөж зүүх юмаа зарах дургүй байх шиг. Даан гуайн нэг костюм лав зарагдахгүй байхаа. Үнэ нь даанч тэнгэрт хадсан юм билээ. Тэр ч бас юу ч бишээ. Эзэгтэйн нэг үстэй дээлийн үнийг дуулбал таминь яана! Түүнээс болж тэд хэчнээн шуугиж, хэчнээн эвлэрсэн гэж санана. Тэгж тэгж авгай нь арай гэж “ээ Путти минь, Путти минь” гэж дуу алдахад Даан гуай, “За яахав нархан Керли минь, Керли минь” гэгцээсээр чимээгүй болсон доо. Эдний гэр бүлийн хэрүүлээс бид үнэхээр залхаж байна аа. Аав хар цагаан үг дуу ч үгүй л байна.*

*Сэтгэл тавгүйтсэнээс, ээжийн царай цонхийн, Маргот толгойн өвчнөөр шаналж, Дусселийн нойр муудан, Даан хатагтай хүртэл өөрөө өдөржингөө хэнгэнэтэл санаа алдаж, би гэдэг хүн би биш болоод байна. Үнэнээ хэлэхэд заримдаа хэн нь хэнтэйгээ муудав, хэн нь хэнийхээ үгийг даасангүй вэ гэдгийг анзаарахгүй юмсан гэх болов. Ганцхан сатаарах юм ажил хийх явдал байв. Тэгээд л би толгой өндийлгүй ямар нэг юм оролдож суух юм даа.*

**Анне**

## 1943 оны аравдугаар сарын 29. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Дахиад л дээдэхчүүдийн тэнд аянга цахилгаан авалцах шиг болоод байна. Тэр нь товчхон шиг бичвэл мөнгө нь дууссанаас үүсжээ. Коофуйс гуайг хэд хоногийн өмнө үслэг эдлэлийн танил худалдаачныхаа тухай ярихад нь авгайнхаа шубыг зарах бодол Даан гуайд төрж, эзэгтэйн долоон жил өмссөн хуучин туулайн шубыг 375 гульденээр заруулжээ. Их мөнгө шүү. Тэгтэл Даан хатагтай оронд нь өөр шуб авах гэж зүтгэн, нөхөр нь хоол унд энэ тэрд юу юунаас өмнө мөнгө хэрэгтэй гэдгээ ойлгуулах гэснээс болж бөөн хэрүүл болжээ. Дээд давхраас сонсогдох хараал, хашгирч орилох дуу, зодоон цохион гээд чи төсөөлөхгүй л дээ. Аймар байсан даа. Тэр бүрд нь бид дөрөв шатан доор амьсгаагаа хураан, азарган тахианууд шиг авгай, нөхөр хоёрыг салгахад бэлтгээж байсан. Би айж ичсэнээсээ тэгээд л орой бүр орондоо уйлахад хүрнэ дээ. Ганцаараа байх шиг сайхан юм алгаа.*

*Ноён Коофуйс дахиад л гэртээ хэвтэрт орох нь байна. Ходоод нь түүнийг шаналгана. Цус нь тогтсон эсэхийг мэдэхгүй байгаа гэнэ. Бие маань нэг л биш, гэр рүүгээ явахаас даа гэхэд нь бид түүнийг их дордсоныг анх удаагаа ажигласан юм.*

*Би ч яахав болж л байна. Харин хоол л харахаас дургүй хүрэх юм. Царай чинь нэг л биш гэж хэн хүнгүй дуугарах болов. Манайхан намайгаа эрүүл байлгах гэж дор дороо л санаа тавьж буйг хэлэхгүй өнгөрч болохгүй бизээ. Тамир тэнхээ оруулдаг сахар, кальци, витаминуудыг ээлжлэн өгч байна. Би л харин биеэ чанд барьж чадахгүй нь харамсалтай. Бүтэн сайн өдөр л арай гайгүй байх юм. Бусад өдрүүдэд хэцүү шүү...*

*Тэр үед аав, ээж, Маргот гурвыг ч тоохоо болино. Энэ нуувчны нэг өрөөнөөс нөгөө өрөөнд орохдоо төөрч мунгинан, шатаар нэг гарч, нэг уруудахад хүрнэ. Заримдаа далавч нь гэмтсэн шувуу ингэж хана мөргөдөг биз гэмээр болох юм. Заримдаа “гадаа гараач! гараач! Цовоо цолгин инээж хөгжин, эрүүл агаарт яваач!” гэж дотроо хашгирах юм. Түүнд минь хэн ч хариулахгүйг мэдэхээр энэ чимээгүй дүнсгэр байдал, айдас түгшүүрийг хэсэгхэн зуур ч гэсэн мартаж гэж хэвтээд өгнө дөө.*

*Анне*

### 1943 оны арваннэгдүгээр сарын 3. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Бидний цаашдын боловсрол, ирээдүйг байнга бодож явдаг аав минь эчнээгээр сурах институтын хөтөлбөр олуулжээ. Маргот тэр зузаан хөтөлбөрийг гурван удаа уншаад хэрэгтэй юм олсонгүй гэнэ. Аав тэгэхээр нь латин хэл эхлэн сурах ном олууллаа. Маргот ч тэрийг гойд сонирхон, удалгүй курсыг нь дуусгав. Латин хэл сурмаар санагдавч тэр нь үнэндээ надад арай л ахадсан зүйл байв. Хэнээс ч дутахгүй юм сурч чадахыг маань мэдэх аав ноён Коофуйсыг надад хүүхдийн судар олж ирэхийг гуйснаар би тэрхүү шинэ гэрээслэлийг сурах болов. Маргот маань тэгэхэд “Анне чи, еврейчүүдийн Шанука сүмд судар бэлэглэх гэж байгаа юм уу?” гэхэд аав:*

*-Тиймээ... Аа... Гэгээн Николаусынх ч байсан яахав гэж бодно. Гэхдээ Иусус Христосын судар еврейн дацанд тохирохгүй шүү дээ гэж миний өмнөөс хариулав.*

*Тоос сорогч эвдэрчээ. Одоо орой бүр цонхоо түгжиж, гэрлээ асаачихаад халуун пийшингийн илчинд нэг муу сойзорхуу юмаар хивс цэвэрлэх ажилтай боллоо.*

*Ойрын үед овоо хэрүүл маргаангүй шиг байна. Зөвхөн Дуссел, Даан гуайн эхнэр хоёр л түнжин муухан байгаа даа. Эзэгтэйн тухай яриа үүсэх бүрд Дуссел “үхэр” эсвэл “хөгшин буг” гэх агаад хатагтай ч хариуд нь дэргэдүүр нь гарах бүрдээ үргэлж түүнийг ёврон “хөгшин чавганц шиг амьтан”, “хөгшин төгцөг” гэнэ. “Хэрээ хэрээнийхээ харыг гайхав” гэж л энэ байх даа.*

*Анне*



## 1943 оны арваннэгдүгээр сарын 8. Даваа гаригийн үдэш

*Хайрт Китти минь!*

*Чи хэрэв захиануудыг минь дараалуулан уншаад үзвэл миний ямархуу ааш зантайдаа бичсэнийг анзаарна даа. Одоо би бас л гутарсан, зориг зүрхгүй болчихсон байгааг чи лав анзаарсан биз ээ. Яагаад гэдгийг нь хэлж чадахгүй байгаа боловч ялан дийлж, давж чадахгүйгээсээ болж, өөрийнхөө тэр хулчгар зангаасаа болж байна уу даа гэж бодно. Элли бидэнтэй хамт байсан энэ орой хонх үргэлжлэн чангаар дуугарав. Царай минь тэгэхэд алчуур шиг цайн, зүрх дэлсэж, бие агзайн, айснаас арай л өнгөрчихсөнгүй. Орой бүр орондоо орсны дараа нүдэнд аймаар юм харагдана. Өөрийгөө аав, ээж ч үгүй гав ганцаар шоронд суугаагаар харна. Заримдаа нэг газар цор ганцаар төөрчихсөн юмуу, эсвэл хоргодох байр маань галд автан шатаж, германчууд биднийг баривчлахаар шөнө дөлөөр орж ирж байгаа юм шиг санагдана. Эдгээрийн аль нэг нь гарцаагүй юм шиг санагдан эл аюул нөмрөх л болно гэдэг бодлоосоо ангижирч чадахгүй юмаа.*

*Мийн заримдаа та нар амар байна гэж бидэнд атаархдаг юм. Нэг бодоход түүний зөв. Гэхдээ тэр биднийг баригдах вий гэж байнга сэтгэл түгшин суугааг яаж мэдэх билээ. Хорвоо дэлхийд бид айх айдасгүй, урьдынх шигээ чөлөөтэй амьдарч болно гэж төсөөлж ч чадахаа больжээ. Би юм л бол “дайн дуусахаар л...” гэдэг юм. Энэ маань харин хэзээ ч биелиггүй мөрөөдөл, эсвэл ид шид шиг санагддаг юм. Урьдын амьдрал, баярлаж гомдож явсан үеийн охид, сургууль гээд өнгөрсөн бүхнийг эргэн санахад би биш шал өөр хүний дурсамж мэт санагдах юм.*

*Энд байгаа бидний найман хүн тал талаасаа хөвөн ирэх нүсэр бараан үүлсэд бүслэгдсэн алгын чинээ хөх тэнгэрт нисч байгаа юм шиг давчуурах юм. Заримдаа биднийг буцах замгүй болтол тал талаас хаисан аймшигт хана улам улам зузааран шахаад байгаа юм шиг санагдахад “Хүүе жаахан амьсгаа авахаар зай гаргаад өгөөч!” хэмээн хашиглан гуйнам.*

*Анне*

## 1943 оны арваннэгдүгээр сарын 11. Пүрэв гариг

*Үзэгний минь тухай магтаал*

*Хамгийн үнэтэй эд зүйл юу вэ гэвэл миний хувьд үзэг минь л байв. Үрлэн хошуутай үзгээ би маш их хайрладаг. Учир нь би ийм үзгээр л арай гайгүй бичдэг юм. Тэр маань бас нэлээд сонин намтартай. Есөн настайдаа хөвөнд нямбайлан ороосон боодолтой үзэг минь надтай учран золгосон юм. Тэр үед Аахин хотод байдаг хайрт эмээ минь харамгүй сэтгэлээр энэ үзгийг надад бэлэглэсэн юм даа. Хоёрдугаар сарын хавсарга гадаа хонгинож байсан үе. Би тэгэхэд ханиад хүрчихээд хэвтэж байсан юм. Содон гоё улаан ширэн гэртэй шинэ үзгийг маань бүх найз, нөхөд танилууд минь дамжуулан үзэж, Анне Франк хэмээх азтай охин би тэр үзэгний эзэн нь болж билээ.*

*Арав хүрэхэд минь аав, ээж хоёр тэр гоё үзгээ сургуульдаа авч явахыг зөвшөөрч, багш маань түүгээр хичээлээ бичиж болно гэв. Дараагийнх нь жилээс би энэ эрдэнээ гэртээ орхиж явах болсон.*

*Дараа нь арван хоёр хүрч, еврейчүүдийн гимназид орохдоо үзгэндээ зориулж харандаатай хамтад нь авч явах цахилгаантай шинэ гэр авсан. Арван гурав хүрэхэд үзэг минь надтайгаа хамт энд бүгж, намайг чамтай хэл залгуулахад шударгаар зүтгэж, зогсоо завгүй ажиллаж эхэлсэн. Тэгээд арван дөрөвтэйд минь надтай сүүлчийн жилээ өнгөрөөх гэж байна...*

*Тав дахь өдөр үдээс хойш би өрөөндөө орж, ширээндээ суун бичих гэсэн чинь аав Маргот хоёр латин хэлээ үзэх болж, хөөрхий би хайр найргүй хөөгдөв. Үзгээ хэрэглэсэн ч юмгүй ширээн дээр орхив. Тэгээд л хөөрхий муу Анне ямар нэг булан эрэх юмуу эсвэл шалаа үрэх боллоо. Шалаа үрнэ гэгч нь түүнд түрхсэн өнгөлөгч хүрэн тосыг шингэтэл арчихыг хэлж байгаа хэрэг.*

*Тав дөчин тавд, би шалаа шүүрдэж, шалны давирхайдсан хүрэн тосны үлдэгдлийг хогтой хамт пийшинд хийв. Энэ хооронд латин хэлний хичээл ч дуусахчаа болж, би арай гэж нэг юм ширээндээ сууж бичихээр болов. Гэтэл үзэг минь олддоггүй. Би нэлээн ултай эрэлд гарав. Маргот тусаллаа. Ээж ч эрэлцлээ. Аав, Дуссел эмч хоёр ч эрэлцэв. Миний үнэнч анд болсон үзэг маань ул мөргүй алга болжээ.*

*Тэгсэн чинь Маргот намайг шалны тос давирхайтай хамт пийшин рүү хийчихсэн юм биш биз гэв. Би ч “ёстой тийм юм байхгүй” гэв. Ингээд шөнө болтол эрээд олоогүй болохоор тэр лав галд оржээ. Целлойд шиг шатамхай юм ховор шүү дээ гэгцээв. Маргааш өглөө нь аав үзэгний минь сэгийг үнсэн дундаас олж тэр эмгэнэлт явдлыг нотоллоо. Алтанхан үзэгнээс минь өрөвдмөөр өчүүхэн юм үлджээ. Аав “ихэнх нь хайлчихсан байна” гэв. Үзэг минь чандарлуулжээ гэж би тайвшрав. Намайг үхэхээр бас чандарлаасай гэж би хүсдэг юм.*

*Анне*

## 1943 оны арваннэгдүгээр сарын 17. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Онцгүй явдлууд зөндөө. Эллигийнхэн сахуутсан гэнэ. Иймээс Элли сар хагас хэртэй бидэнтэй уулзаж болохгүй боллоо. Хүнс хоол улам ховордоод ам хөдөлгөх юм муудсаар байгааг ярих юм биш. Ноён Коофуйс хэвтэрт орж, гурван долоо хоногийн өмнөөс сүү, будаанаас өөр юм шингээхгүй болсон. Ноён Кралерийн ажил толгойтой үснээс нь их болов.*

*Маргот латин хэлнийхээ дасгалуудыг илгээж, нэгэн багшаар засулдаг болсон. Тэр багш тийм авьяаслаг сурагчтай болсондоо бөөн баяр гэнэ. Дуссел эмч бүр мунгинаа болов. Дээд давхрын Дааныхантай дуугарахгүй болсноос хойш тэгчих шиг боллоо. Тиймэрхүү болсон нь хэн бүхэнд ил болоход ээж түүнд өөртөө тийм муу юм даллаад яах юм бэ гэж зөвлөн аргадав. Даан эзэгтэй элдэв шуугиан дэгдээсээр л байна. Түүнээс л болж Даан гуай өөрий нь үл тоомсорлон үг ч солихоо больж, хар цагаан дуугүй болсон гэж Дуссел эмч ярина. Өчигдөр бол*

*Дуссел эмчийн энд ирж бүгсэн арван нэгдүгээр сарын 16ны өдөр дөө. Тэр нэг жилийнхээ ойг тохиолдуулан ээжид баглаа цэцэг бэлэглэв. Түүний нь эзэгтэй мэдчихээд, иймэрхүү юманд мөнгө үрэх нь илүү зан хэмээн муулах юмтай боллоо. Хэ хэ. Өглөө нь намайг түүнд баяр хүргэх үү, эсвэл эмгэнэл илэрхийлэх үү гэхэд аль нь ч байсан яахав гэсэн...*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр орой унтахын өмнө Лизийн царай гэнэт санаанд орж ирлээ. Хөөрхий найз минь ноорч муудсан хувцастай, турж царай алдаад өмнө минь зогсож байх юм. Уйтгарт автсан дүрлэгэр том нүдээрээ намайг ширтэн, зэмлэнгүйгээр “Анне, яагаад би намайг орхисон бэ? Надад туслаач. Тамаас авраач” гэх шиг болов. Би яаж ч чадахгүй, яг л зовж зүдрэн, үхэж буй бусад хүнийг хардаг шиг дэмий л гөлрөн түүнийг эрүүл энх явуулж, дахин уулзуулаарай хэмээн бурханд наминчлав. Түүнээс өөр хэн ч тэгээж нүдэнд харагдаагүй юм. Түүнд л би илүү дотно байж дээ. Түүнийгээ, хөөрхий даанч юм ойлгохгүй, хэт нялхаараа юм гэж буруутган зэмлэж, ойшоохгүй явжээ. Тэгэхэд тэр намайг үеийн бусад охидтойгоо найзлаад өөрийгөө тоохгүй болчих вий гэж айдаг байсан сан. Хөөрхий Лизэд хэчнээн хэцүү байсан бол. Энэ бүхнийг би тэр үед анзаарч мэдсэн гэж үү. Түүнтэй яасан ч хүнлэг биш харьцаж байж вэ би. Хөөрхий минь намайг царайчлан, уйтгартай нүдээр хардаг байж дээ.*

*Ээ... таминь, би одоо л түүнд тусалж чаддаг болоосой. Бурхан минь, энд би бас ч хүссэн бүхнээ хэрэглэн аюулгүй жаргаж байна биш үү. Гэтэл Лиз минь германуудад баригдан ямар аймар хувь тавилан туулж байна вэ. Лиз надаас дутахгүй сүсэгтэйсэн. Яагаад өнөөдөр, Лиз надад ингээж харагдав? Арай үхчихсэн юм биш байгаа даа? Бидний хооронд ямар ялгаа байна? Бид яагаад холдон салах болов? Үнэнээ хэлэхэд, би Лизийг сар, тиймээ, бараг жилээр шахам мартжээ. За, Лиз минь дайн дуусаж, чи минь хэрэв амьд л гардаг юм бол, би чинь буян үйлдэж, хийсэн гэмээ цагаатгахын тулд, чамайг өөр дээрээ авна гэхэд итгээж болно шүү. Харин намайг түүнд туслах чадалтай болох үед миний тусламж хэрэггүй болчих байх даа. Лиз намайг ганц удаа ч гэсэн дурссан болов уу? Бурхан минь, түүнд минь тусалж, ганцааранг нь битгий орхиорой доо. Түүнийг би хайрлаж, өрөвдөж явааг Лизэд мэдүүлж өгөөч. Түүнд энэ бүхнийг давж гарах хүч хайрлан соёрхогтун. Би одоо цааш нь юу ч бодож чадахгүй нь. Нүдэнд минь Лиз харагдаад болохгүй байна. Лиз минь, чамайг эргүүлэн авчирч энд байгаа бүхнийг хуваалцах сан. Тэр үед чадалгүй өнгөрөөсөн бүхнээ засаж, залруулан, туслах минь даанч хожимджээ. Гэхдээ би түүнийг хэзээд марталгүй, түүний төлөө бурханд залбирч явъя.*

*Анне*

## 1943 оны арванхоёрдугаар сарын 22. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Надад хүнд ханиад тусаж, чамдаа тасралтгүй бичихэд минь саад болов. Энд өвдөнө гэдэг бараг өнгөрлөө гэсэн үг. Хоолой өвдвөл хурдхан хөнжилдөө шургах, амжвал зөгийн балтай сүү, зөөлөн боов шүүрэхэд хүрнэ. Бүгдий нь дэс дараалан гүйцээх хэрэгтэй болдог сувилгаануудыг бодоход нүд эрээлжлэх юм. Юу гэвэл хөлөргөх, хоолойд жин тавих, цээжинд хуурай, нойтон жин сэлгэх, час халуун юм уух, хөдөлгөөнгүй хэвтэх, хоолой зайлах, хоолойд тос түрхэх, халуун жин тавих, хоёр цаг тутамд халуун хэмжих гээд барагдах биш. Ингээж л эмчлэх ёстой юм болов уу? Эдгээрээс хамгийн хэцүү нь Дуссел докторынх байв. Тэр сав л хийвэл хэржигнүүртэй эсэхийг мэдэх гэж үнэртэн танартан ханхлуулсан толгойгоо цээжин дээр минь тавина. Нэгд түүний ширүүн үс тэсэхийн аргагүй гижигдэнэ. Хоёрт аль тэртээ гучаад жилийн өмнө анагаах ухаанд суралцаж, эрдмийн зэрэг хүртсэн нь осолдохгүй л үнэн юм байх даа гэх бодол намайг бачимдуулна. Тэр хүн миний зүрхэнд юу эрээд байдгийн? Миний хайртай залуу биш дээ. Дуссел гуай эрүүл үү, өвчтэй юу гэдгийг зүгээр чихээрээ чагнаад хэзээ ч мэдэж чадахгүй ш дээ. Харин хоёр чихээ л сайн угааж, онгойлгомоор юм. Шал дүлий юм байж.*

*Би ашгүй эдгэрч эхэллээ. Нэг сантиметр өсөж, нэг килограм хүндэрсэн ч, царай минь цонхигор хэвээрээ байв. Гэвч юмаа бичих чадалтай болсондоо баяртай байна.*

*Энэ хооронд шинэ сонин юу ч болсонгүй. Хамгийн гол нь бид бүгд харилцан сайн ойлголцож байгаа. Хэн ч хэрэлдсэнгүй. Бараг хагас жил хэртэй энд ийм эв түнжинтэй байхыг үзсэнгүй. Элли маань бидэн дээр ирж чадахгүй, хөл хориотой хэвээрээ л байна.*

*Христосын мэндэлсний өдрөөр самрын тос, чихэр, талханд түрхэх чанамал зэрэг идэх юм арай илүү түлхүү олджээ. Дуссел эмч Мийнийг гуйж хийлгэсэн хоёр бялуугаа ээж, Даан эзэгтэй хоёрт нэг нэгээр нь бэлэглэв. Түүний нь Мийн ажлынхаа чөлөөгөөр хийж амжжээ. Би Мийн, Элли хоёрт бэлэглэх гэж агиаамлынхаа ёотонг хоёр сар шахам хураав.*

*Тэнгэр нэг л дүнсийн, пийшингийн утаа хоргон, хоол шингээж өгөхгүй байна. Дайн дажны талаар ч өөдрөг мэдээ алга. Тэгэхээр баяр хөөр тэгээс доошиллоо гэсэн үг.*

**Анне**

## 1943 оны арванхоёрдугаар сарын 24. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Бид ямар ч баяр баясгалангүй уйтгарлан шаналж байгаагаа чамд зөндөө өгүүлсэн. Миний шаналал улам ихсэв. Бидний байгааг харсан хэн ч “Бурханд өршөөгдөж арьс махтайгаа хатах гэдэг л энэ дээ” гэнэ бизээ. Яахав, бидний энд байгааг бусад еврейчүүдтэй харьцуулахад нээрээ л бурхны өршөөл гэсэн үг л дээ. Гэхдээ наранд эрх чөлөөтэй амьдарч яваа хүмүүсийн дэргэд бол ч ёстой арьс махтайгаа хатаж байна биш үү... Ноён Коофуйсын авгай өнөөдөр ирээд явахдаа, охин Коригоо спортоор хичээллэж, найзуудтайгаа завиар зугаалан, театрт тоглож байгааг ярилаа. Би тийм ч атаархуу охин биш л дээ. Гэхдээ энэ яриаг сонсоод, гадуур дураараа тэгэх явахсан, бусад хүүхдүүд шиг зугаалж цэнгэхсэн, баригдчих вий, хүн биднийг мэдчих вий гэж айж ичилгүй аз жаргалтай байж, ганц ч болов удаа инээхсэн гэж хүсэх юм. Өнөөдөр л гэхэд түм түжигнэж, бум бүжигнасан шинэ жил, христосын мэндэлсний амралтын энэ сайхан өдөр бид яг л дансаа дугуйлуулчихсан юм шиг сууцгаанам.*

*Үнэндээ ачтаныхаа тусыг үгүйсгэж болохгүй ч байдал ийм л байна шүү дээ. Чи минь юу л гэж бодвол бод. Чухамдаа би чинь яаж тэр дарамтыг үүрч чадах юм бэ. Хэн нэг нь хувцаснаасаа эрүүл агаар үнэртүүлэн, даарснаасаа хацраа улаа бутруулсаар орж ирэхэд “хэдийд бид ингэж эрүүл агаар, эрх чөлөөг амтлахаар эндээс гардаг бол?” гэдэг бодлоос түр ч гэсэн салах гэж би хөнжлөө толгой дээгүүрээ татна. Энд нуугдаад жил хагас болсон нь заримдаа зөндөө удсан юм шиг санагдана. Би бүжиглэх, исгэрэх, дугуй унах, ертөнцийг цонхоор биш өөрийнхөө нүдээр харах хүүхэд насны аз жаргал, эрх чөлөөгөө эдлэхийг л хүснэ. Энэ хүслээ чамд л тэмдэглэлээрээ дамжуулан хэлж болохоос биш тэгж чадахгүй ш дээ. Үүнээ ийнхүү зурвасаар өгүүлэн, сэтгэлээ тэжээхээс биш харин ингэж болохгүй шүү дээ. Ер нь энэ тухай би ганц ч хүнтэй ярьж чадах биш. Яагаад гэвэл ийм юм яривал аягүй бол уйлахад хүрнэ. Сэтгэлээ онгойтол нэг удаа ч гэсэн ханатлаа уйлахсан. Аливаа халамж, хайр, сургаал бүхнийг үл ойшоон, намайг хайрлаж, ойлгох төрсөн эхээсээ би өдрөөс өдөрт хөндийрөөд л байх юм. Тэгээд дандаа ирээдүйд хүүхдүүддээ ёстой эх шиг байхыг, тэгэхдээ ямаршуу эх болохоо үргэлжид бодно.*

*Ээж нар “хүүхдүүддээ яаж хандаж байнаа би” гэж бодохоосоо илүү өөрсдийг нь хүүхдүүд нь юу гэж байгааг л сүрхий анзаардаг шүү дээ. Уг нь би өөрийгөө бусдад ойлгуулж чадахгүй байхад “ээж” гэж тэр шидэж үгийн эзэд л үр хүүхдийнхээ дотор сэтгэлийг тайлан уншиж, хайрлаж чаддаг баймаар санагдах юм. “Ээж” гэдэг ойлголтыг өөрийнхөө ээж минь хэн билээ гэдэгтэй тааруулах ямар санаа олсныг мэдэх үү чи? Би ээжийгээ “ээз” гэж дууддаг юм. Ээжийг ээж шиг минь байж чадахгүй болохоор тэгдэг юм л даа. Энд ердөө л төгсгөлийн ж-г нь з-гээр сольсон хэрэг. Миний зориуд дууддаг з-тэй уялдуулан “ээж” гэхийн эхний э-г орхивол, тэр нь “ээз” болно! Ээж минь харин үүнийг анзаардаггүй юм. Тэр нь ч дээр л дээ. Хэрэв мэдчихвэл мэдээж онцгүй болох нь ойлгомжтой.*

*За болих шив дээ. “Арьс махтайгаа хатна” гэдгийг чин зүрхнээсээ бичвэл ийм байна. Үүнийгээ ч бараг туулж байх шиг байна.*



## 1943 оны арванхоёрдугаар сарын 25. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Христос мэндэлсний баярын анхны өдөр үргэлжид л нэгийг боддогоороо Пимын тухай бодмоор санагдана. Тэгэхдээ бүр аавынхаа ноднин өөрөө ярьсан залуугийнх нь хайр дурлалын тухай бодоод байна. Тэр үед би тэр ярианыгх нь учрыг өнөөдрийнх шигээ ойлгосонгүй. Хэрэв аавыг хэрэг болгож дахин яривал би ойлгосноо заавал хэлнээ. Одоо бодоход аав минь хэн ч үл мэдэх сэтгэлийнхээ нууцыг ярьмаар санагдаад л тэрийг ярьсан биз. Урьд нь аав хэзээ л өөрийнхөө амьдралыг ярьж байгаагүй юм. Хөөрхий аав минь залуугийн хайр сэтгэлээ ор тас мартаагүй гэдгээ надаас нуугаагүй юм. Тэр түүнийгээ хэзээ ч мартажгүй байх. Аав улам л гүдэс шулуун зантай болоод байна. Би аав шиг амьдралд ихийг үзээгүй ч ямар нэгэн юманд аавыгаа л дуурайх болов уу гэж найдах юм.*

*Анне*



## 1943 оны арванхоёрдугаар сарын 27. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Христос мэндэлсний баяраар амьдралдаа авч үзээгүй зүйлээ анх удаа авлаа. Элли, Мийн, ноён Коофуйс, Кралер энэ хэд цөм л биднийг гэнэт гайхахад хүргэв. Мийн “1944 онд энх тайвныг тогтоогтун” гэсэн бичигтэй хотол бялуу, Элли ёстой л дайн болоогүй цагт амсаж байсан амтат боов хагас килог авчирчээ. Бас Маргот, Петер бид гуравт нэг, нэг шил тараг, томчуулд нэг нэг шил пиво бэлэглэв. Энэ бүгдийг нандигнан боож, бас шүлэг бичиж хийжээ. Христос мэндэлсний баяр ямар хурдан өнгөрөв өө.*

*Анне*

## 1943 оны арванхоёрдугаар сарын 29. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр орой ахиад л сэтгэл гуниглав. Дахиад л эмээ, Лиз хоёрыгоо харсан. Эмээ минь, хайрт эмээ минь! Таныхаа шаналгааг бид даанч бага мэддэг байжээ. Хөөрхий минь, үргэлж биднийг л гэж санаа тавин бидэнд хэрэгтэй бүхнийг амжуулдаг сан. Эмээ маань дотрын маш хүнд өвчтэй байж билээ. Түүнийгээ өөрөө сайн мэдэж байсан ч ганц ч үг дуугаралгүй, бидний төлөө л гэж явсан байх нь ээ. Үргэлжид л хайр ивээл, ачлал үзүүлэн, хэнийг л гололгүй зөвлөж, тайтгаруулж тусалдагсан. Би болсон хойно бахь байдгаараа дүрсгүйтээд л явдаг байж. Тэр бүхнийг минь дандаа уучлан өнгөрүүлдэгсэн. Эмээ минь та надад үнэнээсээ хайртайдаа тэгдэг байв уу? Эсвэл минийхээ угаасаа хэн болохыг ойлгохгүйдээ тэгдэг байв уу? Би алиныг нь ч мэдсэнгүй. Эмээ минь нэг л ганцаардангүй байж билээ. Биднийг байхад ч мөн л алгаагүй байсан даа. Хүн ер нь хайртай хүнээ алдахаараа л бусад хэчнээн ч олон хүнд хайрлуулсан ч ганцаарддаг жамтай юм байна даа. Лиз маань яагаа бол? Амьд л яваа байгаа даа? Юу хийж байгаа бол?*

*Маргаашаа бодоход уйлмаар болох юм. Тэгээд л бүтэн өдөржингөө усан нүдлэнэ. Хувь тавиланг минь гийгүүлэн амьдралыг минь ивээлдээ авна уу гэж бурхандаа залбиран гуйя даа. Ингээж л би чин зүрхнээсээ наманчлах боллоо.*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 2. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөө өглөө хийх юмаа олж ядахдаа өдрийн тэмдэглэлээ эргүүлбэл цочмог уураа барьж чадахгүйдээ бичсэн ээжийн тухай олон хэсэг тааралдав. Тэдгээрийг уншаад айхдаа өөрөө өөрөөсөө “Энэ их өширхөж, гомдсон хүн чинь Anne чи мөн үү? Хүн ингэж болдог юм уу?” гэж асуулаа. Би яагаад ингэглээ уурлаж, зүрх сэтгэлээсээ үзэн ядах болов оо? гэдгийг эргэн санахын тулд дэвтрээ эргүүлэн үзсээр сууна. Үүнийг бичиж байх тэр үед баяр хөөр гэдгийг мэдэхгүй зовж шаналж байж дээ. Ямар нэгэн явдлыг өөрийнхөөрөө л хүлээн аваад бусдын хэлснийг тайван тухтай тунгаан бодохгүй л явсан байна. Ер нь ямар ч үед маргах, биеэ хамгаалахаа урьтал болгоод байвал түргэн зангаа татаж чадахгүй болдог бололтой.*

*Энэ тэмдэглэлийн дэвтэр минь миний дурсамж, сэтгэлийн өчил минь учраас наддаа хамгийн үнэтэй зүйл минь юм. Би ээжид л их уурладаг байж. Одоо ч бас заримдаа ууралдаг хэвээрээ. Ээж намайг ойлгох гэдэггүй нь үнэн л дээ. Би ч бас ээжийг ойлгох гэдэггүй хүн. Төрсөн үр нь юм болохоор хөөрхий ээж минь надад хайртай сайн л даа. Түүнийг би л харин үе үе эвгүй байдалд оруулдагаас болоод ээж минь аашилдаг нь ойлгомжтой. Түүнийг нь би ойлгохгүй гомдон, муухай загнаснаас, хөөрхий минь гомддог биз. Ийн харилцан үл ойлголцлоос болж бид хоёрын хэн хэнийх нь сэтгэлд таагүй үл мөр үлдээжээ. Үүгээр л бид хоёрын үл ойлголцол дуусаасай гэж хүснэм. Жаргалтай цагийн жирийн өдрүүдэд бол шал өөр шүү дээ.*

*Ямар ч гэсэн ээжийгээ уйлуулдаг байсан тэнэг үе минь төгссөн. Бага ч гэсэн ухаан сууж ээжийнхээ сэтгэлийг амраах гэж чармайх боллоо. Уурласан ч амаа барина. Ээж маань ч бас тэгэх болж. Ашгүй бид хоёр овоо хэрүүл маргаангүй байх болов. Гэхдээ л яагаад ч юм бэ, ээжийгээ би бусад хүүхдүүд шиг ухаангүй хайрлаж чадахгүй юм. Тэгээд ээжид гаргах зүрх сэтгэлийн гомдлуудаа энэ цаасан дээр бичиж л тайтгарах юм даа.*

*Anne*

*Хайрт Китти минь!*

*Би өнөөдөр чамд хоёр ч юмны тухай өгүүлье. Хэн нэгэнд л бүхнээ тоочмоор байх юм. Мэдээж чамтай л үүнийг хуваалцсан нь дээр биз. Яагаад гэвэл нууцыг минь хэзээ ч хэнд ч хэлэхгүй, дуугүй байдгийг чинь би мэдэх юм. Эхнийх нь ээжийн тухай яриа л даа. Би ээжийгээ өрөвдөж, бас эх үр шиг байх гэж хичнээн чармайдгийг минь чи мэднэ шүү дээ. Гэтэл ээжийн нэг тахилыг буруу өрчихсөн бололтой. Ээж нэг удаа Маргот бид хоёрт “Би найз нараасаа илүү та хоёрыг л гэдэг. Яагаад гэвэл та хоёр чинь миний охид шүү дээ.” гэж ярьдаг байгаа. За тийм байж. Энэ чинь ойлгомжтой зүйл. Ямар ч найз нь төрсөн үрийг нь орлоно гэж үү? Би уг нь ээж минь надад эх хүний хувьд үлгэр дууриал болоосой гэж хүсдэг. Гэтэл ийм юм ярьж байдаг. Яахав Маргот тэгээж бодохгүй ч байж болно. Аав мэдээж иймэрхүү ярианаас дөлсхийдэг. Миний ойлголтоор бол ээж гэдэг хүн юунаас түрүүнд бяцхан үрсээ л боддог хүн баймаар юм. Ээж хүн гэдэг манай ээж шиг намайг үнэн сэтгэлээсээ шаналаад уйлж байхад тоглоом тохуу хийдэг байх ёсгүй. Ээжид ойлгогддоггүй нэг зүйл бол миний мөчөөгөө өгдөггүй зан байлаа.*

*Нэг удаа би ээж, Маргот хоёртой шүдний эмчрүү явлаа. Би дугуйтай явсан юм. Тэгээд үзүүлчихээд гараад иртэл нөгөө хоёр чинь хот орно гэлээ. Намайг хамт явъя гэсэн чинь дугуйтай гээд зөвшөөрдөггүй. Би уурандаа уйлчихсан чинь нөгөө хоёр чинь инээлддэг байна ш дээ. Тэгэхээр нь би тэр хоёр луу хэлээ гаргасан юм. Хажуугаар явж байсан авгай намайг харчихаад гайхаж байх шиг байсан. Тэгээд би ганцаараа хариад жаал уйлж билээ. Тэр тухай бодох бүрд хэдийгээр миний буруу байсан ч гэсэн ээж намайг шоолон инээсэн тэр шарх сэдрээд байдаг юм.*

*Хоёр дахь нь миний тухай юм болохоор ярихад эвгүй байна. Гэвч яахав ярихаас биш. Өчигдөр Сис Хеустерийн бичсэнийг уншихад нүүр улайх шиг болов. Зохиогч нь яг надад хандаад байгаа юм шиг бичсэн болохоор нүүр улайгаад явчихсан. Охид шилжилтийн насандаа хэдий чинээ тайван бодлогоширонгүй болох тусмаа биедээ гарч байгаа өөрчлөлт шигээ гайхмаар юмаар оролддог гэж бичсэн байсан.*

*Нээрээ л надад бас яг тийм явдал тохиолдоод байгаа юм. Сүүлийн үед аав, ээж, Маргот гураваас ичээд байх боллоо. Гэтэл харин ч надаас өөр, ичимхий Маргот ичихээ больчихсон байх юм. Надад гурван ч удаа тохиолдсон сонин байдал бүрд өвдөх, эвгүйрхэх, үзэн ядахын алинд ч гэсэн нэг л аятайхан увьдастай болчих шиг санагдсан. Сис Хеустер гэдэг зохиолч миний үеийн охидыг ихэвчлэн төлөвшөөгүй дээрээ байдаг, амьдралыг биеэр үзэж байж өөрийн гэх үзэл бодолтой болно гэжээ. Би чинь дөнгөж арвангурав хүрэх босгон дээрээ энд нуугдсан шүү дээ. Аливааг бодож тунгаах, өөрийнхөө өмнөөс шийдэхийн хувьд би аль эртнээс өөр охин болсон байв. Нэг биш орой хөхөн дээрээ даран, зүрхээ чагнаж тайван цохихыг нь мэдэрч билээ. Нэг удаа найз охиныдоо очиж хонохдоо дотны нөхөрлөлийнхөө тэмдэг болгож тэврэлдэх үү гэхэд тэр татгалзаж билээ. Найз охиноо үнсмээр санагдахад нь үнсдэг ч байв. Насанд хүрсэн хүүхний чармай нүцгэн хөргийг харахдаа гайхдаг байв. Тэр нь миний үлгэр дууриал болсон, уйлж унжихгүйн тулд сэтгэлдээ хадгалан явах үзэсгэлэн төгс дүр шиг санагдана. Ээ, одоо л нэг үеийн охинтой хамт байдаг ч болоосой.*



## 1944 оны нэгдүгээр сарын 6. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Хэн нэгэнтэй яриа өдмөөр болоод тэсэхийн аргагүй болохоор нь Петертэй яримаар болов. Дээр Петертэй хамт байхад ямагт л нэг аятайхан байдаг юм. Учир нь түүний дуугүй, даруухан зан нь хэнд ч саад болдоггүй юм. Би ч тэгээд түүнийг залхах болов уу гэдгээс айгаад удаан сууж зүрхэлдэггүй юм. Уг нь түүнтэй хэдэн үг сольвол дажгүй л санагддаг байлаа. Гэтэл өчигдөр л нэг аятайхан далим гарлаа. Сүүлийн үед Петер үгийн сүлжээ таах шинэ хоббитой болоод байгаа юм. Түүнээс өөр юу ч үл хийнэ. Би түүнд үгийн сүлжээ таахад нь туслан тэр сандал дээрээ, би диван дээр өмнөөс нь харан суулаа.*

*Түүний хөх цэнхэр нүд, уруулаараа инээмсэглэхий нь ажихад сонин санагдав. Бараг нүдээр нь бодол санааг нь уншиж болмоор юм. Нүүрэнд нь итгэл алдарч, гутарч гуньсан байдлаас гадна эр хүний зоримог байдал бас үзэгдэнэ. Болдогсон бол “Өөртөө тохиолдсон бүхнээ надад ярь л даа. Миний нүүрэмгий, задгай амтайгаас битгий болгоомжил л доо” гэж гуймаар байв.*

*Гэхдээ би тэр үдэш ердөө л царай улайснаа хэлэх төдийхнөөр өнгөрөв. Петерийг л гэж бага ч гэсэн зоригжуулах гэсэндээ тэгсэн минь орой орондоо орсон хойно нэг л тэнэг яриа болчих шиг санагдав. Петертэй ямар нэг юм ярих гэж, өрөө рүү нь дандаа л гүйснээс ийм тэнэг юм болчихлоо. Намайг түүнд дурлачихаж гэж чи бодов доо. Тэр тухай ярих юм даанч үгүй шүү. Дааныхан хэрэв хүүгийнхээ оронд охитой байсан бол түүнтэй нь үерхэх гэж би бас л оролдох байсан шүү дээ.*

*Өнөө өглөө долоон цагт сэрээд зүүдээ маш тод саналаа. Би, Петер Весселийн өмнөөс хараад ширээнд сууж байх юм. Бид хоёр нэг зурагтай ном үзэж суух юм. Тэр номны зураг одоо ч бүр тодхон харагдаж байна. Бид хоёр дэмий л бие биесээ гөлрөн сууна. Сайхан бор нүдээрээ намайг талимааран харах Петер Вессел тэгтэл “Мэдсэн бол аль эртний л чамайгаа гэдэг байж.” гэснээ надад ойртохоор нь эргэж харвал зөөлөн хацар нь миний хацарт хүрч бүлээхэн оргиод хэчнээн гайхамшигтай мэдрэмж төрвөө. Сэрсэн хойно түүний хацар миний нүүрэнд хүрсэн хэвээрээ л байгаа мэт санагдан, хүрэн бор нүдний нь эелдэг харц зүрхэнд минь уусаж, түүнийг шохоорхож байсан тэр л хэвээрээ одоо хүртэл хайрлан санаж яваагаа мэдэрлээ. Тэр дэргэд минь үгүй, харин алс хол байгаа болохоор ч тэр үү, өөрийн эрхгүй нулимс асгаран, уйтгарт автав. Тэгснээ Петер Весселд хайртай хэвээрээ, тэгээд бас түүнийг зүүдэлсэндээ баярлан сэтгэл тайтгарав.*

*Надад хэн бүхнээс түрүүнд эмээгийн минь үрчлээт дотно царай зүүдлэгдэнэ. Бас намайг л гэж өгөх байх юмаа олж яддаг нагац эгч, үеийн минь еврей охидод учирсан гай зовлонг амсч яваа найз охин Лизийгээ зүүдэлнэ. Лизийг санах бүрдээ, бүх еврейчүүд, мөрдөгдөн зовж буй хүмүүсийн тухай боддог юм.*

*Харин Петер Вессел, хайрт Петерийгээ би хэзээ ч урьд шөнийх шиг тодоор зүүдлээгүй байсан юм. Надад түүний минь зураг ч хэрэггүй. Би түүнийг сэтгэлдээ тодоос тодхон хадгалж явнам.*



## 1944 оны нэгдүгээр сарын 7. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би үнэхээр тэнэг амьтан шүү. Өөрийнхөө болон дотныхоо хүмүүсийн тухай чамд ярихаа мартаад л яваад байжээ. Намайг жаахан байхад, тухайлбал цэцэрлэгт байхад Карл Самсон гэдэг банди үнэхээр дотно санагддаг байв. Аав нь яачихсан юм бэ бүү мэд, тэр хөвгүүн ээжийнхээ хамт нагац эгчийндээ суудаг байв. Биеэр давжаа, мяраалаг хүү Карлыг нагац эгчийн нь хүү, өөрийн нь бүл, Бобби гэдэг ухаалаг, туранхай, бор банди харж халамжилдаг байлаа. Би Карлтай хэдэн жил тоглож, үерхсэн дээ. Бид үнэхээр хар багын сайн найзууд байж билээ.*

*Дараа нь Петер Весселтэй учран хүүхдийн сэтгэлээр дурласан. Зуны богинохон даашинз өмсөөд, даавуун хүрэм, өмдтэй Петертэй хөтлөлцөөд гудамжаар гүйж явснаа мартахын аргагүй.*

*Түүнийг анги дэвшин, ахлах сургууль руу шилжихэд, би дунд сургуулийнхаа ахлах ангид үлдсэн юм. Тэгэхэд тэр намайг сургуулиар дайрч авах буюу, эсвэл би түүнийг сургуулиар нь дайрч уулзаад хамт явдаг байлаа. Петер тайван төлөв, ухаалаг царайтай, өндөр гоолиг яг л зурсан юм шиг царайлаг гоё хөвгүүн байв. Түүнд хар үс, цэвэрхэн арьс, дүрлэгэр том сайхан нүд, хянган хамар үнэхээр төгс зохисон харагддаг сан. Тэр инээхээрээ хичнээн гоё харагддагийг яана.*

*Зуны амралтаараа манайхан аялалд явж билээ. Биднийг буцаж ирэхэд Петер нүүчихсэн, өөрөөсөө нэлээд ах нэг хөвгүүнтэй найзалчихсан байв. Тэр найз нь намайг хараад “Юун ч жаахан бацаантай үерхдэг юм бэ” гэж голсноос хойш Петер намайг тоохоо больсон юм. Би түүнд сайн хэвээрээ байсан болохоор ид шидтэн байдаг сан бол Петерийг надад дахиад сайн болгоосой л гэж хүсдэг байж билээ. Он жил улирч, Петер өөрийнхөө үеийн охинтой үерхэх болж, надтай дайралдахаараа мэнд ус ч үгүй зөрдөг болсон ч би түүнийг мартаж чадахгүй байлаа.*

*Намайг еврейчүүдийн гимназид ороход манай ангийн олон хөвгүүд надад сайн байлаа. Тэр нь сайхан байсан ч би нэг ч хөвгүүнд дурласангүй. Дараа нь Харри миний хойноос гүйж эхэлсэн юм. Харин миний хувьд Харрид нэг их дурлаагүй л дээ.*

*“Цаг хугацаа сэтгэлийн шархыг эдгээдэг” гэдэг үг байдаг. Үнэхээр Петер мартагдаж, надад түүнээс юу ч үлдсэнгүй. Гэхдээ түүний тухай дурсамж сэтгэлийн мухарт үлдсэн байжээ. Урьд шөнийн зүүднээс Петер мартагдаагүй нь илт боллоо. Харин ч хайр минь надтай хамт өсч торниж байжээ. Тэгэхэд Петер намайг хэтэрхий жаахан гэж голж байсныг би ойлгож байна. Гэхдээ намайг тийм амархан мартсанд нь гомдох юм. Зүүдэнд минь яг л бидний үерхэж байсан үеийнх шигээ байсанд түүнээс өөр хэн ч миний сэтгэлийг тэгээж татаагүйг мэдэв. Өнөө шөнийн зүүд намайг бүр галзууруулах шахлаа. Өглөө аав орж ирээд үнсэхэд “Петер минь намайг ингэж үнсдэг ч болоосой” гэж золтой л хашгирчихсангүй. Би тэр өдөржингөө Петерийг л бодож, дотроо “Петер, хайрт Петер минь” гэж шивнэн байлаа. Хэн ч надад тусалж чадахгүй. Ямар ч гэсэн намайг цаашид*



*амьдруулж, дахин Петертэй минь уулзуулж өгөөч гэж бурхнаас гуйнам. Тэгвэл Петер минь намайг ганцхан өөрт нь л хайртайг нүднээс минь уншиж мэдээд “Анне хэрэв мэдсэн бол би аль эртний л чамайгаа хайрлахгүй юу” гэнэ байх даа.*

*Хайр дурлал, сексийн талаар аавтай ярилцахад “чи энэ тухай юм ойлгох болоогүй” гэсэн. Би бол энэ тухай хэнээс ч дутуугүй ойлгож байгаагаа өөрөө мэдээд байх юм. Надад одоо Петер минь чамаас өөр хэн ч тийм чухал биш болоод байна.*

*Нүүрээ толинд харсан чинь миний царай их өөрчлөгджээ. Миний нүд улам тунгалаг болж, хацарт минь цус хуран ягаарч, уруул хүртэл торго шиг зөөлөрчээ. Аз жаргалтай болчихсон юм шиг санагдавч, нүдэнд хурсан гуниг уруулд минь гүйх инээмсэглэлийг минь арилгах шиг. Петер минь дэргэд байхгүй болохоор би яаж аз жаргалтай байх билээ. Гэвч би над дээр тусч байсан түүний энхрий харц, минийхэд нааж байсан бүлээн зөөлөн хацрыг дахин мэдрэх шиг болов. Ээ Петер минь, би чинийхээ дүр төрхийг яаж мартъя даа. Сэтгэлд минь орших чиний байрыг өөр хэн эзэлж чадах бол?*

*Долоо хоногийн өмнө ч юмуу, эсвэл өчигдөр надаас “чи хэнтэй суух вэ?” гэж асуусан бол би “мэдэхгүй” гэж хариулах байв. Гэхдээ би “хамаг сэтгэл зүрхээрээ дурласан Петер, зөвхөн Петер минь л ядаж нэг хацрыг минь ч гэсэн үнсээсэй” хэмээн хашгирах байсан даа. Би өнөөдөр агуулахын цонхын дэргэд бодолдоо Петертэйгээ уулзан суув. Эгшин зуур бидэн хоёр сэтгэлээ ярилцан уйлалдав. Би түүний уруул, хацрын булбарайг мэдрэв. Чи минь намайгаа бодож, наддаа ирээч, энхрий хайрт Петер минь!*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 12. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Элли ажилдаа орж бидэнтэйгээ хамт байх болсоор хагас сар болж байна. Хенк, Мийн хоёр ажилдаа ирэлгүй хоёр хонов. Гэдэс нь өвдсөн гэнэ.*

*Шинэ мэдээ гэвэл би сонгодог бүжиг сонирхон, уйгагүй орой бүр дасгал хийж байна. Ээж маань цагаан цэнхэр өнгийн хуучин дотуур хувцасаар надад дажгүй гоё бүжгийн хувцас хийж өгөв. Дээр нь цээжээр татаж уях бүч хадаж өгсөн. Биеийн тамирын хуучин муу шаахайгаа бүжгийн улавч болголоо. Бүжгээр хичээллэнгээ энд суусаар хөдөлгөөнгүй хөшиж оршсон үе мөчөө урьдынх шиг уян налархай болгохыг хүснэ. Дасгалын маань хамгийн хэцүү нь шалан дээр суугаад хөлийнхөө баруун зүүн өсгийг тэр талынхаа гараар барин дээш татах юм.*

*Ээжид их таалагддаг “Цэлмэг өглөө” гэдэг номыг томчуул уншицгааж байна. Тэр номд залуучуудын тухай нэлээд сайн хөндөн бичсэн гэнэ. Би л болсон хойно тэр номыг шимтэцгээхэд нь “над шиг л залуучуудтай холбоотой юмыг нь олж уншаасай” гэж егөөтэй нь аргагүй бодов.*

*Ээж маань Маргот бид хоёрыг ээжтэйгаа сайхан харьцаж байгаа нь бусдаас сайн ээжийн хүмүүжлийнх гэж боддог бололтой. Яахав, энэ бодол нь Марготын хувьд үнэн байж болох юм. Харин миний хувьд байдал өөр шүү. Ээж Марготыг надаас илүү өөрт нь хайртай гэж боддог юм. Тэр нь харин их санасан газар есөн шөнө хоосон хонов гэгчийн үлгэр болоод байх шиг. Маргот урьд өмнөхөөсөө шал өөр, надад их хайртай болоод байгаа.*

*Өөрийгөө заримдаа хөндлөнгийн хүний нүдээр харах сонин л юм. Тэгэх бүрдээ би Анне гэдэг хүний хийсэн үйлдлийг харан үнэлж дүгнэхийг оролддог юм. Энд ирэхээсээ өмнө, ингээж элдвийг эргэцүүлэн боддоггүй байхдаа “Анне чи аавын, ээжийн, Марготынх ч биш, ердөө л бусдын үүрэнд орхигдсон хөхөөний өндөг гэдгээ мэд” гэж өөртөө өгүүлэн, өнчин хүүхэд болж тоглодог байлаа. Тийм балай тоглоом сэдэхээргүй хайр элбэрэлд умбасан мөртөө тийм нэгэн уйтгарт амьтан болж тоглож байснаа хэчнээн тэнэг явдал байсныг одоо л ухаарна.*

*Дараа нь нэг хэсэг өөрийгөө их л сайхан зантай, тусч хүүхэд гэж хэлүүлэх гэж оролдов. Тэгээд өглөө бүхэн ээжийг “сайхан нойрсов уу” гэсээр ороод ирээсэй, тэгвэл сэтгэлээсээ баярлан, ялдамхнаар мэндлэх юмсан гэж хүсдэг байлаа. Ээжийг заримдаа энэ тэр явдлаас муухай зан гаргавал урам хугаран сургуульдаа явахын түүс болдог байв. Тэгсэн мөртөө сургуулиасаа харих замдаа, ээжийн аашилсныг зөвтгөж, сэтгэл тайвширан, сэргэлэн цовоо болчихно. Тэгснээ дахиад л нөгөөдөхөө маргааш нь давтан сургууль руугаа уйтгартайяа явна.*

*Гэтэл энэ хэцүү үед бурхан намайг ивээж зүүдэнд Петерийг минь илгээдэг байна шүү. Тийнхүү сэтгэлдээ түүнийгээ хавтага шиг зүүлчихээд түүнийгээ дотроо энхрийлэн таалж “Би чинь Петертэйгээ байна шүү дээ. Энэнийг минь надаас өөр хэн ч мэдэхгүй.” хэмээн бодлогоширно.*

*Ийнхүү би гэдэг хүн бүхнийг давах нь шиг байна. Гэнэн балчир охин миний сэтгэлд ямархан шуурга дэгдэж буйг хэн ч үл мэднэ.*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 15. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Чамд хэрүүл маргаан бүрийг нэгд нэгэнгүй тоочих нь эвгүй юм. Гэхдээ манай хоёр айл өөх тос, мах, шар тос, төмс ногоогоо ч өөрсдөө тус тусдаа хуурдаг болж, бүх юмаа тусгаарласан. Манайх оройн дөрвөн цагийн үед дахиад л өлсөж, ходоод хонгинон, тайван байж болохгүй үедээ идэж байх гэж жаахан арвайн талхтай болов.*

*Ээжийн төрсөн өдөр ойртож байна. Ноён Кралер ээжид баярынх гэж жаахан саахар илүү өгөв. Төрсөн өдрөөрөө юу ч аваагүйдээ тэрүү, Даан хатагтай л их атаархав бололтой. Санаандгүй өгсөн тэр чимх саахар бидэнд баяр хөөр авчирсангүй. Харин уурлаж гонгиноцгоохын шалтаг болчихлоо. Китти минь, чи биднийг хэрэлдэж, муудалцаж ханасан гэж боддог байхаа.*

*Ээж ч ээж, Дааныханд хоёр долоо хоног хэртэй харагдахгүй байх минь гэж ямар ч боломжгүй юм хүсдэг байна. Заримдаа хүмүүс ингэж нэг дор удаан байхаараа эцэс төгсгөлгүй хэрэлдэхэд хүрдэг юм болов уу гэж өөрөөсөө асуухад хүрэх юм. Эсвэл бид тийм муу хүмүүстэй учрав уу? Үгүй бол хүмүүсийн олонхи нь бэртэгчин, тулга тойрсон богинохон бодолтой байдаг юм уу? Хүмүүсийн мөн чанарын тухай бага ч гэсэн мэддэг болсон минь олз шүү. Бид энд бүтэн жил хэрэлдэж муудалцан, цаг нөгцөөж, нар агаар дутагдан туйлдавч дайн дуусаагүй хэвээрээ л байх юм. Юундаа ч номчирхох билээ? Цаашидаа энд удаан хоргодвол ч би гэдэг хүн ёстой сонгинын цооргоно шиг хатах байх даа. Гэтэл би чинь том охид шиг л байхыг хүсэх юм.*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 22. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Ихэнх хүмүүс дотоод сэтгэлээ яагаад бусдаас нууж явдаг юм бол? Би яагаад жинхэнэ бодож санаж байгаагаа нууж худлаа дүр үзүүлж явах ёстой юм бэ? Хүмүүс яагаад нэг нэгэндээ огт итгэдэггүйг би ойлгохгүй юм.*

*Миний хувьд нөгөө зүүднээс хойш нэг л ухаан сууж, ёстой л нэг “бие хүн” болж байгаагаа мэдэрч байна. Жишээ нь Дааныхныг бүр өөрөөр бодох болсныг минь чи сонсоод бүр гайхна даа. Миний үзэл бодол яагаад ингэж өөрчлөгдөв өө? гэвэл ээж л ёстой ээж шиг байх юм бол манайхны хоорондох харьцаа шал өөр болно гэж бодох боллоо. Даан хатагтай ч бас хүнээс өөр этгээд зантай хүн байж болно шүү дээ. Ээж аль болохоор ам хэлээ билүүдэхгүйхэн шиг, бага шиг гай тарих юм бол энэ маргаан зөрөлдөөний хагас нь ч болов хасагдах байсан байх.*

*Даан хатагтайд ямар ч л байсан өөрийгөө шүүмжилдэг сайн тал бий. Аар саар юмаар хөөцөлдөж, хэрүүлд оролцох дуртай, бэртэгчин ч гэсэн хэрэв хүн өдөж хатгаад байхгүй л бол юмыг дорхноо мартчихдаг цайлган сэтгэлтэй хүн. Дандаа аргыг нь олох гэх нь хэцүү ч, түүнтэй тэвчээртэй л байвал зохицоод байж болохоор санагдана. Бид ер нь нуувчны дэг журам, хоол ундны талаар илэн далангүй, нөхөрсөг дотно ярилцвал болохгүй юм гэж үү. Тэгэх л юм бол нэг нь нөгөөгөө өөлөөд байхгүй шүү дээ.*

*Китти чамайгаа одоо юу гэх гэж буйг мэдэж байна. Чи лав “Анне чи үнэхээр ингэж бодлоо гэж үү? Дээд давхрынхны хамаг л хатуу үг бүхнийг сонссон чи ингэж ярилаа гэж үү дээ? Болсон бүхнийг арван хуруу шигээ мэдэх чи юу даа?” гэнэ бизээ. Би бүхнийг “Муу л бол хойд захын хар овоохой...” гэдэг шиг бус, ердөө л Дааныхныг ажиглан, юу нь үнэн, юу нь дэгсдүүлж вэ? гэдгийг өөрийнхөөрөө нотлох гэсэн юм. Яахав үнэхээр тэд болдоггүй юм бол аав ээжийн бодол зөв болно биз. Хэрэв Даан гуайнх тийм ч болдоггүй улс биш бол аав ээжийн бодлыг өөрчлөхийг бодно. Ер нь л би энэ бүхний учрыг олохыг хүссэн юм. Энэ бүхэн аав ээжийгээ эсэргүүцэх гэснийх биш аливаа юмыг өөрийнхөөрөө дүгнэх гэсэн бодлынх юм. Манайхан ч уг нь гайгүй л дээ. Тэгэхдээ тийм л ухаалаг юм бол бид бас янз бүрийн хүмүүстэй зохицож чаддагаа харуулах хэрэгтэй ш дээ.*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 24. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Гайхаж сониучирхмаар юм тохиолдохын алийг тэр гэхэв. Сексийн тухай сэдвийг урьд өмнө гэр орондоо нууцгай, сургууль ангид жигшүүртэй юм шиг ярьдаг байсан. Тэр тухай охид энд тэндгүй л шивнэлдэцгээн, жиг жууг хийн инээлддэгсэн. Тэгэхээр нь би гайхаж “юундаа ингэж нууж хаан, жигшиж зэвүүцдэг юм бол доо?” гэсэн бодол төрсөн. Тэгснээ сүүлдээ би ч энэ сэдвийг сонирхох болж, хааяа дотны найз охидтойгоо энэ тухай шивнэлддэг болсон. Сүүлд нь тэр тухай аав ээжтэй ярьдаг болоход ээж маань нэг удаа “Анне, хөвгүүдтэй тийм юм ярьдаггүй юм шүү. Хөвгүүдийг хэрэв тийм юм ярих гэвэл дуугүй болдог юм гэж зөвлөв” гэв.*

*Энд ирсэн анхны өдрүүдэд ээжээс бага сага юм сонссон бөгөөд бусдыг нь ном зохиол буюу хүмүүсийн ярианаас мэдэж авлаа. Гэтэл хачин ичимхий бүрэг зантай Дааны Петер нэг удаа харин өөрийнх тухай бодлоо өөрчлөхөд хүргэв. Эзэгтэй нэг өдөр өгүүлэхдээ, Петертэй тэр тухай өөрөө ч, нөхөр нь ч ярьж байгаагүй гэв. Тиймээс Петер нь сексийн талаар хэр зэрэг мэдлэгтэйг ээж нь мэдэхгүй байлаа.*

*Өчигдөр Маргот, Петер бид гурав төмс цэвэрлэж суухдаа Моффи муурын тухай яриа дэлгэв. Намайг “Моффийг мий юм уу, эсвэл мигуй юм уу гэдгийг одоо болтол бид мэдэхгүй” гэхэд Петер “Мэдэлгүй яадаг юм бэ. Тэр чинь мий шүү дээ” гэв. Тэгэхэд нь би “Мөн ч эр муур бол доо. Зулзагалах гэж байгаа биш билүү?” гэж хөхрөв. Уг нь Петер өөрөө хоёр гурван сарын өмнө энэний гэдсийг хар даа, удахгүй зулзагалах гэж байсан юм. Тэгтлээ гэдэс нь цүндийсэн нь тэгвэл хүүхдүүдийн орхисон амттаныхыг хулгайлснаас тэгсэн байж таарах нь ээ. Петер хэлснээ нотлох гэж “Биш л гэж байгаа юм бол чи надтай яваад үзээд ир л дээ. Түүнтэй эрхэлж, эргүүлж тойруулж тоглоход мий гэдэг нь харагдах юм чинь” гэв. Үнэхээр тэр муурыг эр юм уу, эм юм уу гэдгийг үзмээр санагдахаар нь түүнийг дагаж агуулах руу очив. Моффи зочин хүлээж авахааргүй арилаад өгсөн байв.*

*Их үд хэвийж, Петерийн бууж ирэх нь сонсогдоход зориг гарган, анир чимээгүй хонгил дундуур гүйн агуулах руу очив. Петер юм боодог ширээн дээр Моффитой тоглон, түүнийг жигнэх гэж жингийн таваг дээр тавьж байв.*

*Тэр намайг харчихаад “Хөөе чи одоо үзэх үү?” хэмээн ичсэн шинжгүй, Моффийг барьж авснаа, сурмагаар сарвуунуудыг нь барин, эргүүлж “Энэ боов нь байна. Үс нь халцархай, тэнд хушга нь байгаа юм” хэмээн лекц уншив. Урьд нь би хөвгүүдийг ингэж амьтны “эр хүйсийг” үзүүлбэл лав ичээд дальдрах байсан. Харин энэ удаад Петерийг давгүй харж, яриаг нь хээв нэг сонсов. Бид Моффитой хэсэг тоглож, элдвийн яриа дэлгэн сууснаа агуулахаас дээш гарав. Намайг “Мэдэх гэсэн юмаа тохиолдлоор номноос олж үздэг юм. Чи бас тэгдэг үү?” гэхэд Петер “Яах юм бэ? Ааваас л асуудаг. Их юм үзсэн хүн шүү дээ” гэв.*

*Бид хоёр аль хэдийнээ шатан дээр ирчихсэн болохоор би дуугарсангүй. Хэн нэгэн охинтой байсан бол арай ч илүү юм яримаар байсан байхаа. Иймэрхүү юмыг хөвгүүдтэй ярихаас зайлсхийх талаар ээжийн зөвлөснийг би мартаагүй байв. Харин би эр эм хүйсийн тухай*

*хөвгүүд маргах юм бол тэнэг наргиагаар биш ухаалгаар ярьж болдог юм байна гэдгийг мэдэв. Петер үнэхээр аав ээжтэйгээ ийм сэдвээр ярьдаг гэж үү? За би ч юу мэдэх билээ дээ?*

*Анне*

## 1944 оны нэгдүгээр сарын 27. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Сүүлийн үед би удам судрын бичиг, язгууртан дээдсийн гэр бүлийн гарал үүслийг ихэд сонирхон судлах боллоо. Ийм юм сонирхвол түүхийн сурвалжуудыг онгичин сүүлдээ бүр нээлт ч хийж болох юм шиг ээ.*

*Би хажуугаар нь английн радиогийн “Home Service” нэвтрүүлгийг алдахгүй сонсох болов. Харин бүтэн сайн өдрүүдэд кино оддын зургийн цуглуулгаа янзлан төрөлжүүлэх болов. Ноён Кралер нэг дэх өдөр бүр кино сэтгүүл авчирч намайг баярлуулдаг юм. Түүнийг маань хөршүүд дэмий л мөнгө үрж байх юм гэдэг ч намайг сүүлийн үеийн шинэ кинонд тоглосон жүжигчдийг цээжээрээ нэгд нэгэнгүй тоочиход үзээгүй байж тэр бүхнийг яаж мэддэг байна гээд л гайхахы нь яана.*

*Элли чөлөөтэй өдрүүдээрээ ихэвчлэн үерхдэг залуутайгаа кино үздэг тул бямба гариг бүр над дээр ирж, юу үзэхээ асуухад нь, би л болсон хойно тэр нь тийм, энэ нь ийм гэж жаал галлан, шүүмжлэхий нь шүүмжилж, сайшаахы нь сайшаана. Тэгэхийг минь ээж харчихаад, чи гол дүрүүд, киноны агуулга, чанар чансааг ингэж мэддэг болсон бол дараа нь кино үзэх гэж явахгүй амар юм болж дээ гэнэ.*

*Намайг заримдаа үсээ шинэ маягаар самначихаар бүгд л эвэртэй туулай үзсэн юм шиг болцгоон, ямар кино жүжигчин үсээ ингэж самнасан байна гэгцээнэ. Өөрөө л бодож янзлахгүй юу гэж үнэнээ хэлэхээр за юу л болдоо, харваас өөрийнх чинь биш дэгээ гэнэ. Тэгээд л үсний тухай хагас цаг хэртэй бурцгаахаар нь санаа зовоходоо бушуухан шиг угаалгын өрөөнд орж үсээ хуучнаараа самнана.*

*Анне*



## 1944 оны нэгдүгээр сарын 28. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би өнөө өглөө өөрөө өөрөөсөө Анне минь, чи идсэнээ эргүүлж хэвдэг хөгшин үнээ шиг улиг домог болсон юмаа давтаад байлгүй, арай л нэг өөр шинэ юм сэдэх юм биш үү хэмээн асуув. Тийм ээ, өнгөрсөн хуучин юм шиг сонирхолгүй залхуутай юм үгүй.*

*Ширээнээ хэрэв улс төрийн тухай бус харин хоол ундны тухай яриа үүсвэл ээж, эзэгтэй хоёр залуу насны дурсамжаа дэлгэн, Дуссел гуай авгайнхаа шүүгээнд байх багтаж ядсан торго дурдан, булга минжин хувцас хунар, хурдан морьд, дөрвөн настайдаа усанд сэлж сурсан гоц авьяастай хүүхдүүд, булчин шөрмөсний өвчин, аймхай өвчтөний тухай гээд түмэн юм хөрвүүлэх нь тэр. Ер нь ширээний ард яриа өрнөх бүрд биднээс хэн нэг нь ярьж эхлэхэд бусад нь тас дайран цааш нь үргэлжлүүлнэ. Ярианых нь наргиа хошигнолыг ч бид бүгдийг мэдэх болсноос ярьж байгаа хүнээс өөр хэн ч инээхээ больсон доо.*

*Коофуйс, Хенк хоёр бидэн шиг бүгж нуугдсан хүмүүсийн тухай сонссон бүхнээ ярьдаг байв. Тэд биднийг мөрдөгдсөн, баривчлагдсан хүмүүсийн төлөө санаа зовон, суллагдсаныг нь сонсвол баярлан, шинэ мэдээ хүлээж суудгийг мэддэг байв. Байгууллагууд хуурамч карт үйлдэн хүмүүсийг найдвартай нуугдах боломж олгон, нуугдаж буй хүмүүсийг мөнгө хүнсээр ханган, залууст найдвартай гар урчууд, хувийн үйлдвэрүүдэд ажил олж өгч байв. Бусдыг аврах, сайн үйлс бүтээхийн төлөө амьдралаа зориулсан тэдэн шиг хүмүүс л бидэнд өнөөдрийг хүртэл сэтгэл харамгүй тусалж байгаа билээ. Гэтэл өөрсдийнхөө амь нас, аюулгүй байдлаа золиослон тусалж байгаа энэ хүмүүсийн амнаас биднийг дараа болж байна гэсэн үг ганц ч удаа сонсогдож байсангүй.*

*Хүнсний барааны шинэ картыг Хильверзумд гаргаж, бидэн шиг нуугдсан еврейчүүдэд хүнс залгуулж байсан хуучин картыг хүчингүй болгосон нь байдлыг улам л хэцүү болголоо.*

*Анне*

### 1944 оны хоёрдугаар сарын 3. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Хэн хүнгүй л ялалтын өдрийг хүлээж байна. Сонинууд энэ тухай зогсоо зайгүй бичиж, хүмүүсийг үймүүлж гүйцэв. Аргагүй шүү дээ. Сонин бүрт л “Германы цэргийн командлал, англичуудыг Холланд руу оруулахгүйн тулд бүх л хүчээ дайчилж байна. Шаардлага гарвал усны даланг тавьж хамгаалах гэнэ” хэмээн бичиж байна. Нэлээд шуугиан дэгдээсэн бэхлэлт, хамгаалалтын газрын зураг хэвлэгдэв. Амстердамын гол дүүргүүд тэнд зурагдсан тул, гудамжуудыг хэрэв метр хэртэй усанд авахуулан хамгаалбал яах вэ гэсэн асуулт үүсэв. Дугуйгаар явж, явган зугатах ч өнгөрч л дээ. Харин ус татартал сугаа хүрсэн усан дотор зогсох уу, яах вэ гэсэн асуулт гарахад манайхан “Сэлээд л үзэж дээ. Усанд шумбагчдын малгай, хувцас өмсчихөөд биднийг чадах ядахаараа усан доогуур шумбавал еврейчүүд гэж хэн мэдэв гэж” гэв.*

*-Бид чинь байшингаасаа гарч чадахгүй таминь. Энэ агуулах чинь тэр чигээрээ өмх болчихсон юм билээ. Усны эхний цохилтод л нураад өгнө.*

*-За тоглоом хийцгээх маань ч яамай таминь. Нэг завьтай л болигтоох юмсан.*

*-Завины хэрэггүй ээ. Хүн бүр л агуулахаас чихэрлэг зүйлийн нэг нэг том хайрцаг авч, шанагаараа сэлүүр хийцгээе.*

*-Би ч модон хөл авнаа. Түүгээр залуу байхдаа түрүүлж байсан юм хэмээн ам амандаа шуугилдав.*

*За, бүх юм тодорхой болоо биз, Китти минь. Мөн ч уйтгартай яриа шүү. Цагаа болоход бүх юм өөрөөр эргэнэ дээ.*

*Чөлөөлөлтийн хоёрдахь хүндрэлтэй асуудал нь германчууд хэрэв Амстердамын оршин суугчдыг нүүлгээд эхэлбэл яах вэ л гэдэг юм. Манайхан тэгэхэд:*

*-Аль болох л сэмхэн нүүнэ дээ.*

*-Хэрхэвч хамт нүүж болохгүй. Хамгийн зөв нь эндээ л үлдэх дээ. Германчууд нутагтаа очоод хүмүүсийг бөөнөөр нь хорихоо болихгүй шүү дээ.*

*-Тиймээ, бид эндээ л үлдэнэ. Үүнээс өөр найдвартай газар бидэнд үгүй. Харин ноён Коофуйсыг наашаа гэр бүлтэйгээ нүүж ирэхийг ятгах хэрэгтэй. Модон хөвөнцөр авчирч, шалаар зулаад унтах хэрэгтэй. 30 кило гурил дээрээ жаахан гурил нэмж захиалбал сайнсан. Хенк хоолны ногоон буурцаг олохыг бодох хэрэгтэй. Одоогоор 30 кило вандуй, 5 кило буурцаг бидний гарт байна. 50 лааз даршилсан ногоогоо тооцолгүй үзэхэд шүү дээ.*

*-Ээжээ, та өөр юу байгаагаа тоолохгүй юм уу? Арван лааз загас, дөчин лааз сүү, 10 кило хуурай сүү, гурван лонх самрын тос, дөрвөн шил шар тос мөн дөрвөн шил даршилсан мах, дөрвөн шил гүзээлзгэнэ, хоёр лонх жимсний шүүс, хорин шил улаан лооль, таван кило*

хүүхдийн будаа, дөрвөн кило цагаан будаа. За байгаа юм маань нийтдээ энэ дээ. Бас ч чамлахааргүй нөөц. Гэхдээ та бидний зочинтой байхыг бодолцвол таарна. Тэр нь долоо хоног бүр нөөцнөөс хэсгийг хорооно шүү дээ. Тэгэхээр байгаа хүнс маань юу ч болохгүй бус уу гэгцээв.

Бид хүрэлцэхүйц нүүрс, түлээ, лаатай. Юмыг яаж мэдэхэв гээд мөнгөө хийх нууц халаас цамцандаа оёх болов. Мөн зугтаахад хүрч юун магад гээд хамгийн хэрэгтэй гэсэн юмсыхаа нэрсийг жагсааж, үүргэвчиндээ хийж бэлдэв. Бас харуул манаа гаргах хэрэгтэйг зөвлөлдөж, нэг хүнийг нүүсний байшинд, нөгөөгий нь арын дээд талын агуулахад суулгахаар боллоо. Тэгтэл бас шатдаг хий, ус, цахилгаан тасарвал хоол ундаа хэрхэн болгох вэ? гэдэг асуулт гарав. Тэгэхэд бид пийшин дээр чанахаас өөр аргагүй боллоо. Усыг яахав, шүүгээд л чанахаас биш. Байнга устай байхын тулд нэлээд хэдэн том шил цэвэрлэх болов.

Араас довтлох нь, өмнөөс довтлох нь, өлсөж л үхэхгүй юмсан гэсэн гонгиноон, үхэл, бөмбөгдөлт, гал түймэр, еврейчүүдийн паспорт, хорт хий гэх мэтийн яриа залхаж үхтэл сонсогдох юм.

Хенктэй ярьсан яриа нь харин биднийг сэтгэл амраав. Бид “Германчууд ухрахдаа оршин суугчдыг нүүлгэж эхэлдэг болов уу гэж зовж байна” гэхэд Хенк:

-Яаж нүүлгэдэг юм бэ. Шороон түмэн хүмүүс нүүлгэх машин тэдэнд хаа байна гэв.

-Галт тэргээр зөөнө байх гэж бодож байна?

-Тэр ч саналтгүй байх шүү. Германчууд ард түмнийг тийм аятай тавтай зорчуулна гэж бодоо юу?

-Хэрхэвч тэгэхгүй. Та нар юумыг юунд дандаа муугаар боддог юм бэ? Хүн ардыг зөөлөө гээд тэд юу хожих билээ?

-Та “Бид хэрэв нутаг усаа бараадахад хүрвэл, ардаа хоцрох эзлэгдсэн бүх газар нутгийнхны хаалгы нь хаах болно доо” гэж Геббельсийн хэлснийг санаж байна уу?

-Тэдний аль чалчихыг тэр гэдэг юм бэ.

-Та тиймэрхүү юман дээр Германчуудыг хүний мөс заах юмуу, эсвэл хүнлэг хандана гэж бодно уу?

-Та нар намайг хэчнээн ч ухаалж болно. Гэвч тэр бүхэнд тань би итгэхгүй.

-Та бас л хэлдгээ хэлэх юм. Хэн ч гэсэн гамшиг зовлонтой нүүр тулахаасаа өмнө амиа хамгаалахыг бодно шүү дээ.

-Та нар сайн юмыг ер олж харахгүй юм. Энэ бол та нарын л үзэл байх даа.

-Бид эхлээд Германд, дараа нь энд хангалттай гай гамшигийг амслаа. Орост юу болж байна даа?

*-Еврейчүүдийн асуудлыг анзаарах завгүй байгаадаг. Дорнодод юу болж байгааг хэн ч мэдэхгүй байна. Орос, английн нэвтрүүлэг яг л германых шиг хэтрүүлэгтэй байж болно ш дээ.*

*-Тэр ч хэтрүүлэггүй байхаа. Английн радио бол дандаа үнэн байдаг. Харин та түүнийг худлаа гэж үзэж байгаа болж бодит байдал түүнээс долоон дор байгаа юм шүү. Та германчууд хэдэн сая гэм зэмгүй хүмүүсийг орос, польшийн нутагт алахы нь алж, хийгээр шатаахы нь шатааж, бас үлдсэнийг нь устгах гэж байгааг үгүйсгэж чадахгүй бизээ гэв.*

*Цааш нь юу гэснийг нуришиж цагийг чинь үрээд яахав. Би гэдэг хүн харин нэлээд тайвширч энгийн байдалдаа орлоо. Ер нь тэгээд үхэх, амьдрах гэдэг ялгаагүй юм шиг санагдана. Бүх юм гагцхүү сайнаар л төгсөөсэй гэж найдан, зөвхөн ажиллаж, сурахаа л хойш тавихгүй юм шүү гэж хатуу шийдэв.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 12. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Гадаа наран ээж, тэнгэр цэнхэртэн цэлмэж, зөөлөн салхи сэр сэрхийн байна. Надад нэг юм үгүйлэгдэнэ. Би эрх чөлөө, нөхдөө үгүйлнэм. Ганц ч удаа бол ёстой нэг дотроо онгойтол уйлахсан. Сэтгэлээ сэргээхсэн. Уйлж чаддагсан бол аятай юу. Арга барагдан хий л бухимдан, нэг өрөөнөөс нөгөөд гүйн орж, хаа л бол хаа түгжсэн цонхын дэргэд очин, адаглаад завсар зайлхайгаар нь сэнгэнэх агаарыг амьсгалахсан хэмээн бодоход зүрх цохилно.*

*Гадаа хавар болчихсон юм шиг санагдана. Амьд байгаль сэргээж байгаа нь мэдрэгдэн, бие сэтгэлд минь хавар ирчихээд байгаа юм шиг санагдана. Тайван байх юм шүү гэж өөрийгөө албадавч юу ч уншиж, бичиж, хийж чадахгүй, сэтгэл тогтоож яднам.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 13. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Миний хувьд гэхэд өчигдөрхнөөс хойш л цөөхөн цагийн дотор их юм өөрчлөгдөв. Сэтгэлд минь нэг л юм үгүйлэгдсээр байгаа билээ. Харин... тэгтэл тэр мөрөөдөл маань намайг шал өөр болгов. Өнөөдөр ажигласнаа чин үнэнээр, ихэд баяртайгаар чамд гэж хэлэхэд Петер намайг нэг л дагуулан хараад байв. Тиймээ, ердийн байдгаасаа нэг л өөр, юу ч гэж бичвэл болох юм бэ дээ, би мэдэхгүй байна. Өмнө нь Петер Марготыг сонирхдог байх гэж санадаг байлаа. Гэтэл тийм биш бололтой. Би бүхэл өдөржингөө түүнд харагдах гэсэнгүй.*

*Учир нь түүн рүү харах, түүнтэй харц тулгарах бүрд гайхмаар сайхан мэдрэмж төрнө. Гань ганцаараа байхаас өөр сайхан юм надад үгүй боллоо. Аав маань миний нэг л өөр болсныг мэджээ. Би аавд яаж бүгдийг ярих билээ. Тайван байлгаад аль, ганцааранг минь байлгаад өгөөч гэж тэдэнд хэлмээр санагдана. Хүссэнээсээ ч илүү ганцаараа байхад хүрэх юм билүү хэн мэдэх билээ.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 14. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Бүтэн сайн өдрийн орой “Германы хөгжимчийн үүрд мөнхийн бүтээл” сонсох гэж бүгдээрээ радио тойрон сууцгаав. Аав бид хоёр л сонсох гэсэнгүй. Дуссел радио оролдоод байжээ. Петер ч тэр, бусад нь ч бүгд л уурлацгаасан юм байх. Тийн хагас цаг хэртэй болоход Петер тэсэлгүй ингэж паржигнуулан эргүүлэхээ больж үзээч хэмээн ширүүхэн гуйжээ. Дуссел ч:*

*-Би юу хийхээ мэдэж байна гэжээ.*

*Петер ч тэгэхэд уурлаж, аав нь дэмжин, Дуссел арга буюу оролдохоо больжээ. Нэг их сүртэй юм болоогүй ч Петерт юм бодогдуулчихжээ. Намайг өнөөдөр агуулах дахь номын хайрцаг ухаж суухад тэр дэргэд ирж бүгдийг яриу. Миний анхааралтай сонсож байгааг Петер ажиглаад:*

*-За сонс л доо. Бодсоноо олигтойхон хэлж чаддаггүйгээ мэддэг болохоор би нэг их хурдан ярихгүй байх шүү. Би юм л бол ээрээд, нүүр чавга шиг улайж, шал өөр юм хэлчихдэг хүн. Оносон үгээ олохгүй бол ярихаа больчихож ч магадгүй. Өчигдөр ч бас тэгсэн л дээ. Нэг юм хэлэх гээд эхэлтэл болж өгдөггүй. Тэрнээсээ ч болсон юм уу будилж эхлэх нь тэр. Би тэр болгон хүнд үзүүлээд баймааргүй будлиу зантай. Тэгээд ч хэн нэгэнтэй муудалцвал ярьж хөөрч учраа олохын оронд шууд л зодолчихдог муу зуришилтай байсан юм. Тэр ч дэмий зан гэдгийг ухаарсан даа. Тэгээд ч тэр юм уу чамайг их гайхдаг юм. Чи бол ярьж ч чаддаг, ер нь хүнд хэлэх гэснээ хэлж ч чаддаг, бас бууж өгдөггүй хүн! гэхэд нь би:*

*-Үгүй чи ерөөсөө юу ч мэдэхгүй байна. Би жинхэнэ бодсоноо хэлдэггүй хүн. Тийм мөртөө баахан юм ярьдгийг яана. Тэр ч бас муу л даа гэв.*

*Өөрийнхөө тухай Петерийг түрүүчийнх шигээ илэн далангүй яриасай гэсэндээ шалан дээрх жинтүүнд хоёр өвдгөө тэврэн сууж түүнийг анхааралтай харав. Энд өөртэйгөө адил зэмлэл хүлээх ханьтай болсондоо баярласан гэдэг тоймгүй. Ашгүй дээ, Петер загнуулна гэж айлгүй Дуссел эмчийг шүүмжилж чадсан нь сайн хэрэг. Тэрээр үерхдэг охидын минь адил нөхөрсөг, дотно хандах болсон нь юутай аз вэ таминь.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 16. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр Марготын төрсөн өдөр. Төрсөн өдрийнх нь бэлгийг үзэхээр Петер арван хоёр хагаст орж ирчихээд үзэхээсээ суух нь гэсэн шиг урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээрээ удав. Марготыг жилдээ ганц болдог энэ өдрөөрөө дураараа байг гэсэндээ би үдийн үед цай авчран, дараа нь төмс оруулав. Намайг өрөөгөөр нь дайран гарахад Петер шатан дээрх бүх бичиг цаасаа авлаа. Агуулахын нээхийг хаах хэрэгтэй юу? гэж асуухад минь:*

*-Буцахдаа тогшоорой! хамт янзалъя гэлээ. Баярлалаа гээд дээш гаран том торхон дахь төмснөөс аль жижгийг нь түүн арван минут хэртэй бөхийтөл нуруу янгинан, хүйт даав. Тэгэхээр нь нээхийг тогшсон ч үгүй шууд л онгойлговол тэр харин тэнд ирчихсэн, том түмпэнтэй төмсийг минь авч туслахаар зогсож байх юм.*

*-Жижгийг нь баахан л эрлээ. Харин олдох нь ховор юм. Бараг бүгдийг нь л тэмтрэв бололтой гэх гэх зуураа би шат руу буучихаад зогсож байтал Петер:*

*-Энэ чинь харин сайхан л төмс байна шүү дээ гээд түмпэнтэйгээ өгөхдөө, гайхалтай сайхан төмс байна шүү хэмээн нэмж хэллээ. Тэгснээ сэтгэл бүлээцэм энхрий, эелдэг харцаар над руу харав. Тэр харц нь миний төлөө ямар ч сайхан зүйл хийхэд бэлэн гэдгийг нь илтгэх ажээ. Бодсоноо сайхан үгээр илэрхийлж чадахгүй ч түүний харц сэтгэлийг нь илтгэнэ үү гэлтэй харагдана. Би ч түүнийг нь олж харсандаа ихэд баярлав. Тэгэхээр ч үл барам Петерийн хэлсэн үгс, тэр гайхам харцыг нь бодохоос одоо ч баярламаар байна.*

*Намайг бууж ирмэгц минь ээж “Их төмс хэрэгтэй. Оройн хоолонд бас хэрэглэнэ шүү дээ” гэв. Би дуртай нь аргагүй дээш гарч, төмс аваад ирье гэв. Би дахиад л Петерийн өрөөгөөр өнгөрөхдөө тайван байдлыг нь алдагдуулсандаа уучлалт гуйв. Петер тэгтэл хана шат хоёрын хооронд хөндөлсөн зогсоод “Би аваад ирье” гэв. Намайг “Хэрэггүй ээ, жижгийг түүхгүй” гэхэд тэр гарыг минь тавив. Буцаж ирэхэд минь Петер нээхийг нээн түмпэнтэй төмсийг минь авав. Гарахдаа “Ингэхэд чи юу хийж байна дээ?” гэвэл Петер:*

*-Франц хэлээ оролдож сууна гэсэн. Тэгэхэд нь даалгаврыг чинь үзэж болох уу? гээд гараа угаачихаад буйдан дээр суулаа.*

*Түүнд ганц хоёр юм хэлж өгсний дараа бидний хооронд яриа эхлэв. Петер дайн дуусахаар Энэтхэг дэх Холландын тариалангийн аж ахуйд явах бодолтой гэнэ. Дараа нь еврейчүүдийн тухай яриу. Христос шашинтан болж төрсөн болоосой, дайны дараа христ болохсон, тэгвэл дээр юм гэв. Дараа нь бид аавын тухай, хүний оюун билэг болон дэвэн дэлхийн юм хамж шимэн баахан ярилцсан. Дөрөв хагаст би тэндээс гарав.*

*Орой нь Петер сонин юм ярилаа. Петерийн надаас гуйж аваад бараг хагас жил хэртэй зургийг нь өрөөндөө өлгөсөн алдартай жүжигчин эмэгтэйн тухай хөөрөлдөв. Тэр зураг өөрт нь сайхан санагддаг гэнэ. Тэгэхэд нь би сонирхвол тийм зурагнууд авч болно шүү гэв.*

*Түүнийг яагаад дандаа л Муши муурыг эрхлүүлж байдгийг нь ойлгов. Тэр хайрлуулж,*



*энхрийлүүлхийн хүслэнгээсээ болоод л тэгдэг бололтой. Түүний ярьсан нэг зүйлийг би мартаж орхижээ.*

*-Би үнэндээ айна гэдэг юу болохыг мэддэггүй. Харин ямар нэг юм үгүйлэгдэхэд л айдас хүрдэг юм. Үүнээс л ангижрах хэрэгтэй гэв.*

*Петерийн өөрийгөө голох нь даанч их юм аа. Тэр жишээлбэл өөрийгөө усан тэнэг, манайхныг ухаантай гэж боддог аж. Тэгээд ч намайг франц хэлний хичээлд нь тусалбал тун их баярлах бололтой. Хэрэв түүнийг дараа тэгвэл нь “Солиорохоо больж үз. Чи чинь англи хэл, газар зүйг надаас илүү мэддэг шүү дээ” гэж хэлмээр санагдчихлаа.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 18. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би түүнийг л харах гэсэндээ дээшээ гардаг болов. Энд амьдрал минь нэг л утга учиртай болж би дандаа л баяр хөөртэй байх болсон тул урьдынхаасаа илүү сайхан санагдаад байнаа. Петерт сэтгэлтэй болчихож гэж намайг битгий бодоорой. Арай тиймдээ хүрээгүй юм шүү. Харин Петер бид хоёрын хооронд үерхэл, итгэл өвөрлөсөн тийм холбоо бий болж байгаа нь үнэн юм. Хэрэв болж бүтвэл би татгалзахгүй. Петер ч мөн их өөрчлөгдсөн дөө. Одоо тэр намайг гаран гартал минь ярьж хөөрдөг болсон.*

*Дээшээ ойр ойрхон гархад минь ээж дурамжхан болж, Петерийг тайван байлга, битгий үймүүл гэнэ. Миний тийнхүү дээш гүйх болсон нь дотоод сэтгэлийнх гэдгийг ээж үнэхээр мэдэхгүй байна гэж үү? Намайг Петерийн аягын чинээ умгар өрөө рүү явах тоолонд ээж маань намайгаа харамлана уу гэлтэй анхааралтай харах юм. Намайг бууж ирэх болгонд хаана байсныг шалгаана. Энэ нь надад зовлонтой биш ч нэг л эвгүй байх юм.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 19. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр хагас сайн өдөр. Хагас сайн өдөр гэдэг нь өөрөө бидэнд ямар өдөр байдгийг хэлээд өгч байгаа бизээ. Нам гүм сайхан өглөө байв. Дээш гарч энэ тэрхэнд туслав. Тэгэнгээ “түүнтэй” таван үг явуут солилоо. Хоёр хагаст жаахан юм тайван унших юмуу эсвэл бичих гэж бүтээлэг авч, аавын хуучин ажлын өрөө рүү орохоор доош буув. Тэнд суугаад нэг ч их удсангүй, сэтгэл хөдлөөд байхаар нь ширээн дээр хоёр гараа зөрүүлж дэрлэн жаал уйлав. Өөрийгөө хэчнээн азгүйгээ мэдэрмэгц нулимс өөрийн эрхгүй асгарсаар байв. Ээ чааваас даа намайг тайтгаруулах гэж “тэр” хүрээд ирдэг ч болоосой. Тэндээс намайг гархад оройн дөрвөн цаг болж байв. Би түүнтэй уулзаж юун магад хэмээн төмс авчрахаар дээш гарав. Замдаа угаалгын өрөөнд үсээ янзлах санаатай ортол тэрээр агуулахад байгаа Моффи муур руугаа бууж яваа нь сонсогдов. Нулимс дахиад л бөөн бөөнөөр асгараад ирэхээр нь би жорлон руу зугтаж, жижиг толио нуув. Час улаан өнгийн элгэвч маань нулимсанд халтартсан байв.*

*“Би Петерийг мартаж чадахгүй нь. Магадгүй тэр намайг гэсэн юмгүй, ингэх ч шаардлагагүй байж болно ш дээ. Миний тухайд хөнгөн юм бодож явдаг ч юм билүү? Би бахь байдгаараа, цааидаа Петергүй байх хэрэгтэй. Өнөөх л итгэх, тайтгарах, хүсэн мөрөөдөх юмгүйгээрээ л байх болох нь ээ” хэмээн элдвийг бодов. Түүний мөрөнд толгойгоо наагаад, ганцаардан итгэл алдарсан байдлаа мартмаар санагдана. Ер нь тэгээд намайг огт анзаардаггүй, бусдыг ч бас л тийм найрсагаар хардаг юм болов уу. Би л намайг учиртай хараад байна гэж санасан юм биш биз? Ээ Петер минь чи минийхээ юу хэлэхийг сонсож, байдал төрхийг минь хардаг ч болоосой. Гэлээ ч зүгээр л тэгэж санагдсан байж болох үнэнийг би тэсэхгүй нь. Сэтгэл дотроо уйлавч итгэл, хүсэл мөрөөдөл дахиад л намайг эзэмдэн авах юм.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 20. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Бүх амьтны долоо хоногт хийдэг юмыг манай нуувчныхан зөвхөн бүтэн сайнд хийдэг юм. Хүмүүсийг гоёлынхоо хувцсыг өмсөөд салхинд гарахад бид их цэвэрлэгээнд орно.*

*Найман цаг гэхэд нойрны тулам Дуссел эмч ч босож угаалгын өрөөнд орсноо их угаалгаа эхлэн бараг цаг хэртэй алга болно. Ес хагаст хөшигнүүдийг нээж, пийшин галлан, Дааныхны угаалга эхлэнэ. Арав арван тавд Дааныхны исгэрч дохио өгөх сонсогдон, угаалгын өрөө суларна. Манайхны нойрны туламнуудын эхнийх нь толгойгоо дэрнээсээ салгана. Маргот, ээж, би гээд л дараа дараагаар их угаалганд орно. Хүйтэн гэж жигтэйхэн. Би урт өмдтэй болсондоо баяртай байв. Аав л хамгийн сүүлд угаах ээлжтэй дээ.*

*Арван нэг хагаст өглөөний цайгаа ууна. Энэ тухай их нуришихгүй. Юу идэж уудгаа хангалттай бичсэн шүү дээ. Арван хоёр арван тавд хүн бүр хийх дуртай юмаа хийцгээж эхэлнэ. Аав комбинзоноо өмсөж, өвдөг дээрээ сөхрөн, хивсээ их л төвөгтэй сойздон, бүх л өрөө тасалгаагаар нэг тоос манан татуулна. Дуссел гуай ороо дээш нь эргүүлж, Бетховений морин хийлийн концертоос тогтоосон аяа исгэчин, цэвэрлэнэ. Ээжийн нааш цааш холхих хөлийн чимээ сонсогдон угаасан юмаа өлгөнө. Даан гуай малгайгаа духдуулж аваад Петер, Муши муужгай хоёрыг дагуулан доош арилна. Даан хатагтай хар ногоон хүрмэн дээрээ уртаа гэгчийн хормогч зүүн, хөлдөө галош углан, толгойдоо зузаан улаан ноосон алчуур зангидаад, угаах юмаа сугавчлан явж өгнө. Маргот бид хоёр сав суулга угаан, өрөөгөө цэвэрлэнэ дээ.*

**Анне**

## 1944 оны хоёрдугаар сарын 23. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдрөөс хойш гадаа хачин сайхан болж намайг бүүр сэргээчихэв. Цэвэр агаар амьсгалах санаатай, Петерийн байгаа агуулах руу өглөө бүр очдогоороо очив. Суух дуртай шалан дээрх газраасаа би цэлмэг хөх тэнгэрийн өөдөсхөн чөлөө, навч нахиагүй мөчирт нь усан дуслууд ишилэн үрэл шиг гялалзах туулайн бөөр мод, мөнгөн ялтасхан агаарт эрвэгнэн хийсэх шиг харагдах цахлайг ажиглав. Намайг тэгэж суухад Петер дээврийн тулгуур баганыг толгойгоороо налан, над шиг цэвэр агаар амьсгалан алсыг ширтэж, тэр таатай байдлаа дэмий яриагаар үргээхээс болгоомжлох мэт дуугүй зогсоно. Тийнхүү бид алсыг нэлээн удаан ширтлээ. Петерийг тэгээд мод хагалахаар дээшээ гарахад би түүнийг тун сайн хөвгүүн гэдгийг мэдэв. Нарийвтар шатаар түүнийг дээш өгсөхөд нь би дагаад дээшээ гарав. Мөч хэртэй түлээ хагалах хооронд бид нэг ч үг сольсонгүй. Тэндээс Амстердамын нэг хэсэг үзэгдэн, байшин барилгын дээврүүдийн зах хязгаар нь ялгарахгүй хөх цэнхэр униарт уусан харагдана. Тэгэхэд надад “Илч гэрлээрээ ивээгч наран, үүлгүй хөх цэнхэр тэнгэр, мөнхөд ийм байхыг би мэдрэн байвал уйтгарлах гунихын хэрэг юу билээ” гэсэн бодол төрөх аж. Аз жаргалгүй, ганцаардан шаналах, эсвэл сэтгэл зовохын аль нэг нь учирвал цэлмэг тэнгэр, байгал орчин л тайтгарал өгөх юм даа.*

*Бид чинь энд зовлон гаслан дунд удлаа шүү дээ. Би өнгөн талаас нь яриагүй шүү. Би эрүүл агаар, эрх чөлөөг хүснэм. Гадагшаа харан байгал бурхны бүтээлийг танин мэдэхдээ, өөрийнхөө аз жаргалтайг ухамсарлан, аз жаргалаас өөр юу ч үзээгүй байгаагаа мэдэрлээ. Алдар нэр, эд баялаг бүгдийг чи алдаж болно. Харин зүрх сэтгэлийн аз жаргалыг алдсан ч ахин бадарна. Чи тэнгэрийг хэдий чинээ харж чадна, төдий чинээ л зүрх сэтгэлийнхээ ариуныг мэдрэн, аз жаргаланд үргэлжид умбана.*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 27. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Өглөөнөөс үдэш болтол би Петерээс өөр юу ч бодсонгүй. Түүнийг унтахдаа нүдэндээ харж, зүүдэндээ үзэж, сэрэхдээ тэр намайг харах болов уу гэж бодох боллоо. Ер нь нийтлэг адил юм Петер бид хоёрт нэлээд байдгийг мэдлээ. Яагаад тэр вэ гэдгийг чамд тайлбарламаар байна. Бидэнд хоёуланд маань эхийн хайр халамж дутагддаг. Түүний ээж хэтэрхий хөнгөмсөг, сээтэгнүүр зантай, хүүгийнхээ сэтгэлийг боддоггүй байхад миний ээж намайг гэж зууралддаг ч эх хүний гол шинж болсон элбэрэл халамж гэж үгүй. Тэгээд л бид хоёр дотоод сэтгэлтэйгээ тэмцэлдэнэ. Гэвч сэтгэлээ хатуу байлгах гэхээр арай л балчирдан ганцаардана. Хэрвээ хал үзэж, хар толгойгоо мэдэхтэйгээ болсон бол "арилаад л өгөх минь..." гэсэн хүсэлдээ автсан байх бизээ. Харин ингэх боломжгүй болохоор сэтгэлээ нуун, намайг зайлаад өгөөсэй гэж хүстэл нь загнамаар санагдана. Намайг бодвол Петер өөр. Тэр зожгирон дуугаа хурааж, нам гүм байх бөгөөд амиа аргалан өөрийгөө болгоод байдаг юм. Ингэхэд бид хоёр хэзээ, хаана нэг өөрсдийнхөөрөө байх бол?*

*Анне*

## 1944 оны хоёрдугаар сарын 28. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Бүх юм ид шидээр болдог болоосой. Тэр надад өдөр өнгөрөх тутам дотно санагдавч түүнийгээ илчилж болохгүй, шаналсан ч энгийн хөгжсөөнтэй байх хэрэгтэй болох юм. Петер Вессел, Даан гуайн Петер хоёр миний хайрлаж байсан, хайрлаж байгаа, хүсэн мөрөөдөж буй нэг л Петерийг би болгов. Ээж тэсвэрлэшгүй загнан, аав яришиг болмоор их энхрийлэн, Маргот надад долгинох мэт харьцах боллоо. Би гэдэг хүн тайван байхыг хүсэх юм.*

*Намайг агуулахад очиход Петер хүрч ирсэнгүй. Мужааны ажил хийх гэж дээвэрт гарсан бололтой. Алхны сулхан тогшилт бүрт зориг минь мохон уйтгарт автав. Алсад сүмийн хонх “Толгойгоо өргө, сэтгэлээ чангал” гэх шиг нэгэн хэмээр хангинана. Би өөрийнхөө уяхан сэтгэлтэй, юманд туйлбаргүй зантайгаа мэднэ. Чи минь наддаа туслаач дээ, туслаач!*

*Анне*

# 1944 оны гуравдугаар сарын 1. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Миний сэтгэлийн зовлон манай нүүсэнд хулгай орсноос болж түр мартагдав. Энэ удаагийн орсон хулгай нь ноднингийн долдугаар сарынхаас илүү нарийн юм. Ердийнхөөрөө Даан гуай өчигдөр долоо хагаст ноён Кралерийн өрөөнд ороход дундах шилэн хаалга, конторын хаалга хоёулаа онгорхой харагджээ. Тэгэхэд нь гайхаад лавлан харвал төв контор ундуй сундуй болсныг үзээд бүр ч гайхжээ. “Энэ чинь хулгай орж” гэсэн бодол толгойд нь эгшинээ ороход Даан гуай үүд хаалгаа үзэхээр шатаар хурдан гэгч нь буувал хаалганы далд цоож бахь байдгаараа байжээ. Даан гуай тэгэхэд “Петер, Элли хоёр л өнөө орой бужигнуулж орхиж дээ” гэж бодоод ноён Кралерийн тасалгаанд хэсэг зуур зогссоноо гэрлээ унтрааж, өрөө тасалгааны ундуй сундуй болсныг тоолгүй дээш гарчээ.*

*Петер өнөө өглөө нэлээд эрт хаалга тогшиж, гадна талын хаалга дэлгэгдсэнийг, ханын шүүгээнд байсан ноён Кралерийн шинэ бичгийн сав, буулгадаг аппарат гээд баахан юм алга болсныг мэдээлэв. Петерийг гадна хаалга хаахаар явахад Даан гуай өчигдөр оройныхоо үзсэнийг ярив. Бид бүр айж сандарцаалаа.*

*Хаалга эвдээгүйг бодоход хулгайч түлхүүр хэвлэсэн байх гэж шуугицгаав. Хулгайч өчигдөр орой нэлээд эрт орж ирээд хаалга цоожилчихоод Даан гуай саад болохоор нь нуугдаад, мань эрийг явангуут нь хулгайлсан юмаа аваад хаалга онгорхой орхин санд мэнд зугтсан байх гэгцгээв. Гэтэл хэн манай түлхүүрийг хэвлэсэн байх таарах вэ? Хулгайч яагаад агуулахад орсонгүй вэ? Тэр нь агуулахын ажилчдын нэг биш биз? Даан гуайн хөлийн чимээгээр тэр хүн одоо биднийг илчлэх болов уу?*

*Бидний хаалгыг онгойлгохоор хулгайч ахин хэзээ ирэх бол гэдгийг мэдэхгүй нь бүр ч аймшигтай байлаа.*

*Анне*



## 1944 оны гуравдугаар сарын 2. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр Маргот бид хоёр агуулахад байв. Маргот олон юманд надтай яг адилхан ханддаг ч өнөөдөр бид хоёр хамт байснаас болж би дураараа байж чадсангүй.*

*Элли өнөөдөр ээж, Даан хатагтай хоёртой аяга шанага угааж байхдаа сэтгэл гутрах болсноо ярив. Тэр хоёр юу гэж зөвлөсөн гэж санана? Ээжийн юу гэж зөвлөснийг чи мэдэж байна уу? Түүнийхээр бол Элли хорвоо ертөнц мөхөж сүйрч байгааг л бодох хэрэгтэй гэнэ. Сэтгэл хямарсан хүн зовлон гунигийн тухай бодох ямар хэрэгтэй юм бэ? гэж намайг хэлсэн чинь “энэ тухай чи ярих болоогүй” гэдэг байгаа.*

*Томчууд гэдэг ийм л “юмтай” хүмүүс дээ. Яаж ч бодсон сэтгэл гутралд автсан хүнд хорвоогийн зовлон зүдгүүрийн тухай бод гэсэн зөвлөгөө өгөх гэж дээ. Хөөрхий муу Эллид сэтгэл засах ганц үг хэлэх гэж байтал аав яриан дундуур ороод “шавар” болчихлоо. Залуу л бол, дүү л бол шүүмжлэн бодох учиргүй гэж эрүүл ухаантай хэн ч хориглохгүй биз ээ. Миний бодлоор Элли, Маргот, Петер бид дөрөвт энэ цэцэрхэх дуртай тэнэгүүдийн өгч чадахгүй зөвлөгөө, тайтгарал хэрэгтэй л байх шиг. Хажуугаар нь ээж ойрын үед шалтаг л гарвал үглэх боллоо. Өөрөөс нь илүү Даан хатагтайтай ярилцах болсонд атаархсан юм байх даа.*

*Өнөөдөр үдийн үед Петерийг арай гэж олсон. Бид хоёр бараг дөчин таван минут хэртэй ярилцав. Петер надтай гэр бүлийнхнийхээ тухай ярив. Тэдний аав ээж хоёр нь архи тамхинаас эхлээд улстөрийн тухай ч маргалддаг гэнэ. Бас манай аавыг “чанга эр” гэсэн. Хэ хэ. Харин манайхан дээд давхрынхныг нэг их таашаадаггүйг сонсоод Петер гайхав. Би тэгэхэд нь:*

*-Миний үнэн үгтэйг чи мэднэ шүү дээ. Яагаад би чамд үүнийг хэлж болохгүй байх билээ? Бид чинь танайхны сайн мууг андахгүй болсон шүү дээ. Петер би чамайг ойлгохыг хүсдэг. Би чамд тусалж чадахгүй гэж үү? Энэ хоёр гэр бүлийн дунд чи чинь “төвийг сахиж” байгаа шүү дээ. тэр чинь чамд дарамттай байгааг би мэдэж л байна гэхэд Петер:*

*-Тиймээ би чамайг надад тусалбал баярлана гэв.*

*-Чи аав дээр орж байвал зүгээр дээ. Манай аав ч чамлахааргүй сонирхолтой юм ярина шүү. Түүнтэй ямар ч сэдвээр ярьж болно.*

*-Тиймээ аав чинь сайн хүн шүү.*

*-Чамд аав таалагддаг юм байна тийм үү? гэхэд Петер толгой дохив. Тэгэхэд нь би:*

*-Тэр ч бас чамд сайн шүү Петер гэв.*

*Түүний царай улайн тэр цөөн үгэнд хэрхэн баярлаж хөөрсөн нь илт байв. Түүнийг:*

*-Чи тэгэж бодож байна уу? гэхэд нь би:*

*-Тиймээ үнэн шүү. Тэр тэгээж байхыг олон сонссон шүү гэв. Петер бас л аав шиг “чанга эр” болох дог оо.*

*Анне*

### 1944 оны гуравдугаар сарын 3. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Лаа барьсны дараа сэтгэл минь өнөө орой нэг л хөгжсүүн, тайван байв. Би нагац эмээгээ олон лааны тэр бадрангуй гэрэлд харах шиг боллоо. Хөөрхий эмээ минь намайг халамжлан өмөөрч, дандаа л баярлуулдаг байсан сан.*

*Харин өөр нэгэн хүн миний бодлыг эзэмдсэн нь Петер байв. Намайг өнөөдөр түмпэн дүүрэн төмстэй шатан дээр зогсоход тэр:*

*-Чи үдээс хойш юу хийх вэ? гэж асуув.*

*Тэгэхэд нь шатан дээр суугаад түүнтэй жаал ярилцав. Тав арвантавд түмпэнтэйгээ дээрээс авч доош буулаа. Петер аав, ээжийнхээ тухай юу ч ярьсангүй. Бид хоёр уншсан ном, хоргодож эхлэхээс өмнөх амьдралаа ярилцлаа. Петер ямар сайн хүү вэ? Ер нь түүнийг нэг их голоод баймааргүй дурлаж болмоор санагдлаа. Мань хүн орой нь харин тэр тухай ам нээсэн юм. Би төмсөө хальсалж дуусаад түүн дээр очив. Дэндүү бүгчим халуун байхаар нь би:*

*-Маргот бид хоёроор чи халуун, хүйтний хэмжээг тогтоож болно шүү. Хүйтэн болбол бидний царай цонхийж, халуун болбол улайдаг юм гэвэл Петер:*

*-Чи дурлаж үзсэн үү? гэв.*

*-Дурлаад ч яах билээ дээ? гэсэн миний хариулт ямар ч гэм зэмгүй бөгөөд тэр “Яагаад болохгүй гэж?” хэмээн асуув. Яг энэ үеэр хоолонд орцгоо гэсэн тул бид бууцгаав. Энэ асуултаар надад нэг юм хэлэх гэсэн юм болов уу? гэж бодоод, “Миний ингэж чалчдаг нь чамд тээртэй санагдаж байна уу?” гэж асуухад Петер:*

*-Яалаа гэж дээ, харин ч хэчнээн аятайхан санагддаг гээч хэмээн товчхон хэлэхэд нь би их ичсэнээ санаж байна. Хонгор Китти минь, би гэдэг чинь дурласан залуугаасаа өөр юм ярихаа больсон дурлалт бүсгүй шиг л болжээ. Харин дурласан залуу нь Петер болж таарах нь. Хэдийд харин тэр үгээ түүнд хэлэх юм бэ бүү мэд. Бодвол түүнийг надаас таатай үг сонсох үед л хэлэх байхдаа. Ямар ч гэсэн Петер тайван л байхсан гэж байгаа бололтой. Юу бодож байгааг нь одоогоор төсөөлөх юм алга. Ямар ч атугай бид хоёр харилцан биесээ ажиглаад л байх шиг байна. Уг нь бид хоёр бие биенээсээ нэг их дөлөөд байлгүй, арай л дотно болмоор санагдах юм. Хоорондоо бодсоноос ч хурдан дасахыг хэн байг гэх вэ? Түүнийг надруу аятайхан ширтэн харах бүрд би хариу нүд ирмэж догдлон баярлацгаах боллоо.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 4. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Энэ хагас сайн өдөр ойрын хэдэн сар тохиолдоогүй уйтгар, гуниг, дарамтгүй амралтын өдөр байв. Мэдээж энэ бол Петерийн л ач.*

*Өнөө өглөө угаасан хормогчоо өлгөх санаатай агуулахад орвол Петер аавтай өдөржингөө юм хийх гээд тэнд байж байв. Франц хэлний хичээлээ хийхэд минь хамт байлцахгүй юу гэж тэр надаас гуйв. Дахин гуйлгаж гувшуулаад яахав гэж бодоод би шууд францаар ярьж эхлэв. Эхлээд би франц хэлний тухай жаахан юм тайлбарлаад дараа нь англи хэлний хичээл оров. Аав Диккенсээс бид хоёрт уншиж өгөв. Диваажингийн оронд байгаа юм шиг жаргалтай байсан би тэгэхэд аавын дэргэдэх сандал дээр Петерийг шахан суув. Арваннэгд доош бууснаа ахиад л арваннэг хагаст дээш гарвал Петер шатан дээр намайг хүлээж байв. Тэгээд арванхоёр дөчин тав хүртэл жаал ярилцаж зогслоо.*

*Таминь, би чинь хэчнээн баяр хөөртэй байна вэ? Петер үнэхээр намайг шохоорхоод байна гэж үү? Ямар ч гэсэн тэр сайн хөвгүүн юм байна. Харилцан бие биесээ сайтал ойлголцож байх шиг санагдана. Эзэгтэй ч гэсэн бид хоёрыг хамт байхад дуртай байх шиг. Өнөөдөр харин юу болсон юм “Дээр та нарыг дүрсгүйтэхгүй гэж итгэж болно биз?” гэж асууж байна. Би тэгэхэд нь “Та намайг гомдоох гээ юу?” гэж асуув. Ямар ч гэсэн өглөөнөөс үдэш болтол ингэж Петертэй хамт дээр байх болсондоо баярланам.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 6. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Петерийг харваас надтай уулзах гэж мөрөөдөж байгаа нь илт. Гэтэл өчигдөр орой ээж нь Петерийг “Гиюүрэгч” гэхэд миний уур хүрсэн гэдэг жигтэйхэн. Петерийн нүүр ичингүйрсэндээ час улайв. Эхийнх нь нүүрийг түүний өмнөөс самардчихмаар л санагдсан. Хүмүүс яагаад амаа барьж чаддаггүй юм бэ? Петерийг хэчнээн ганцаардаж байгааг дэмий л харж суухын зовлонг чи ч төсөөлөхгүй бизээ. Өөрийгөө тойрсон хэрүүл маргаан, хүйтэн хөндий байдалд тэр заримдаа хэчнээн их дарамттай байгааг нь хараад би өөрөө ийм юм амсвал яах бол гэж дотроо бодох болов. Хөөрхий Петер минь! Өөрийг чинь гэх хайр халамж хэчнээн хэрэгтэй вэ!*

*Надад ямар ч найз нөхөд хэрэггүй гэх түүний үг чихэнд минь хэчнээн хүйтэн сонсогддог гээч. Түүнийг арай л ингэж хэлэх гээгүй байх гэж би бодно. Тэр албаар хайш яйш хайнга дүр байдал үзүүлж цаана нь жинхэнэ санаагаа нуугаад байх шиг. Петер хэдий хүртэл ийм байх юм бол?*

*Петер минь, чаддагсан бол чамдаа туслахсан! Чинийхээ энэ ганцаардлыг хоёулаа хамтдаа туулахсан! Энэ бодлоо түүндээ хэлье гэж хэчнээн хүсэвч мэдээж би хэлж чадахгүй л явна.*

*Өчигдөр би толгойгоо угаахдаа нэг л хайхрамжгүй байв. Петерийг хажуу өрөөнд байгаагийг нь мэдэж байв. Гэхдээ яаж ч чадсангүй. Аз болоход Даан гуайнх охингүй, хүүтэй байдаг! Хэрэв энд Петер шиг эсрэг хүйсний татах хүчгүй бол би хэчнээн уйтгар гунигтай байхсан бол.*

*Анне*

*Жич: Хамаг л үнэнээ чамд илэн далангүй бичиж байгааг минь чи мэднэ дээ. Тиймээс би чамдаа нэг уулзалтаас нөгөө уулзалт хүртэл болсон явдлыг бичиж байна. Петерийг над руу жаахан ичингүйрэн ойртохыг анзаарах бүрд сэтгэл минь догдлох боллоо. Тэр яг л над шиг сэтгэлээ бариад байгаа юм байна. Чухамхүү өөрийнх нь энэ арчаагүй ч юм шиг байдалд намайг татагдаад байгааг Петер мэдэхгүй л байна даа.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 7. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Би хэрэв 1942 оныхоо амьдралыг эргэн санавал бүгд л зүүд мэт санагдана. Амьдрал энэ нуувчинд хал үзэж, хашир таньсан Аннегаас шал өөр Аннег бүүвэйлж байжээ. Сайхан амьдрал гэж тэр л үеийг хэлэх байх даа. Хуруу даран тоолох олон найз охидтой, багш нарынхаа хайртай шавь нь, эх эцгийнхээ эрх танхи охин нь амттанаас өөр юм иддэггүй, хэзээд мөнгөтэй, дутагдах гачигдах юмгүй явж дээ.*

*Чи яаж эргэн тойрныхоо хүмүүсийг өөртөө тэгээж татдаг юм бэ? гэж чи лав асууна байх. Хэрэв Петер үүнийг “гайхамшиг” гэх юм бол энэ худлаа. Багш нар бол миний яг таг хариулт, наргианч яриа, баясгалантай царай, өөнтөгч харц зэрэгт минь дуртай байсан байх. Би гэдэг хүн хэзээний л хачин аальгүй, гоёж гоодох дуртай охин байсан. Гэхдээ хичээнгүй, нямбай, шударга, цагаан цайлган гээд бас нэлээд хэдэн сайн тал надад байсан учраас хүмүүсийг өөртөө татдаг байсан болов уу. Би надаас хичээл хуулдагчуудын хэнийг ч доромжилж байсангүй, бас өөртөө байгаа чихэр боовоо атга атгаар нь хуваадаг байсан. Тэгээд л тэр баясгалантай амьдрал дундаас гэнэт энэ нуувчинд орж ирсэн дээ. Тэгээд энэ байдалдаа дасах гэж ядаж байтал нэг жил өнгөрчихөж.*

*Намайг сургууль дээр яадаг байсан гэж чи санана? Элдэв шоу цэнгүүний хөтлөгчөөр юм л бол “Аннегийн нэр дэвшиж” үнэхээр хөгжилтэй охин байлаа. Сургууль дээр ч хаана ч намайг тойрон хүрээлэх найз нөхдөөр дутаж байсангүй. Тэр үеийн Анне, одоогийн энэ Аннетэй даанч зүйрлэшгүй цагаан цайлган, эрх танхи охин байж дээ.*

*-Чамтай тааралдах бүрд чи хоёроос доошгүй хөвгүүн, бөөн охидоор тойруулчихсан, үргэлж л инээж баяссан гол хүн нь байдагсан гэж нэг удаа Петер маш онож хэлсэн шүү. Тэр найз охидынхоо ярьж хэлж байсныг би хараахан мартаагүй байнам. Би уг нь хүнийг чамлахааргүй шүүмжилж ч чаддаг, дураа хүрвэл аальгүйтэж ч чадна. Болдогсон бол одоо ганц удаа ч хамаагүй тэг үеийнх шигээ хөгжилтэй, санаа зовох юмгүй байж үзэх юм сан. Надад одоо жинхэнэ дотны найз л юу юунаас илүү үгүйлэгдэж байна.*

*Гэвч би энд ирэхээс өмнө ч заримдаа ганцаардах үе байсан л даа. Гэнэт үнсэнд хаягдсан шалз шиг санагдан, өдөржин ямар нэг юм оролдон, чадлынхаар хэрээр өөрийгөө зугаацуулдаг байв. Дутагдаж гачигдах, зовж зүдрэхийг мэдэхгүй сургуулийн баясгалант үе минь эргэж ирэхгүйгээр өнгөрчээ.*

*1943 оны эхний хагас хүртэл надад уйлах, ганцаардах үе зөндөө тохиолдож, өчүүхэн явдлыг би бөөн сүр болгон боддог байжээ. Тэгээд өөртөө тохиолдсон явдлыг аавдаа л ярьж, түүнийг өөрийнхөө талд элсүүлэх гэж зүтгэдэг байж. Мэдээж аав юу гэж дандаа миний талд ороод байхав.*

*1943 оны сүүлийн хагаст би арай дээрдсэн юм байна. Гэнэн томоогүй хүүхэд гэгдэхээ больж, том хүн шиг үзэгдэх болж эхэлсэн. Би юмыг тал талаас нь эргэцүүлэн бодох болж, өөртөө тохиолдсон явдлаа өдрийн тэмдэглэлдээ бичиж эхлэхдээ хэн ч намайг цаашид тоглоомон бөмбөг адил нааш цааш шидэх ёсгүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм. Би хэний ч*

заавраар биш, өөрийнхөөрөө төлөвшихийг хүсч байна. Тэгээд бас аавыг зөвхөн миний талд байж, миний итгэлт хүн байх ёсгүйг аяндаа ойлгож, цаашид өөрөөсөө өөр хэнд ч итгэх хэрэггүй гэж хатуу шийдсэн.

Шинэ онтой золгосноос хойш бүүр огт өөр болж, элдвийг таамаглан бодлогоширох болов. Би үеийн охиныг биш, харин үеийн хөвгүүнийг мөрөөдөн бодох болж, түүний ачаар өөртөө байгаа аз жаргалыг нээж олсон юм. Үдэш бүр орондоо ороод “Сайн сайхан бүхэнд баярлан байна би” гэж өөртөө шивнэнэм. Тэгээд амьдралдаа байгаа сайн сайхныг олж харах баясч, хөгжиж чаддаг боллоо. Бид бусад еврейчүүд чи баригдалгүй бүгж нуугдаж чадсан, эрүүл энх, эсэн мэнд яваа, би бас Петертэй хэзээ нэгэн цагт сэтгэлээ илчлэн нандин дурлалаа хуваалцах хайр сэтгэл, ирээдүй, байгалийн сайхан, урлагийн агуу бүтээл гээд миний амьдралд учрах, бас ертөнцөд угийн байдаг бүхий л сайн сайхныг үзэж амтална гэхээс хязгааргүй их аз жаргалыг төсөөлөн байна.

Тэр болгондоо би зовлон зүдгүүрийг умартан, харин сайн сайхан зүйлийн л тухай бодох болов. Ээж бид хоёрын гол ялгаа энд л байна. Бэрхиээлтэй учрах бүртээ ээж “Ертөнцийн зовлон зүдгүүрийг бод. Тэгээд чи тэр болгоныг эдлээгүйдээ баярла” гэж зөвлөдөг бол би харин “Тал хөндий, уул ус, наранд гарч баяс. Ямар ч байсан байгалийн сайхнаар аял. Өөрөө өөртөө байгаа аз жаргалыг нээж гарга. Танд байгаа болон, таны эргэн тойронд байгаа сайн сайхныг олж харвал жаргалтай болно” гэдэг юм. Минийхээр бол “Золгүй явдал тохиолдоход зүгээр л зовлонгийн тухай бодоод байх нь ээ дээ?” гэж асуумаар болдог ээжийн зөвлөгөө шал буруу. Ээжийнхээр байх юм бол чи улам гутралд орно. Минийхээр бол харин чамд зовлон учравч, байгаль ертөнц, наран саран, эрх чөлөө гээд мөнхийн сайн сайхнаас эрч хүч, урам зориг авч болно. Тэгэж байж л өөрийгөө зоригжуулан, тэнцвэрээр олно. Хэн аз жаргалтай байхыг хүснэ тэр л бусдыг аз жаргалтай болгоно. Хэн зориг чанга, итгэл төгс байна тэр л зовлонг даван туулж чадна шүү дээ.

**Анне**

## 1944 оны гуравдугаар сарын 12. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Сүүлийн үед бүүр хөлд хий орчихлоо. Петертэй үргэлж ярьж суудаг боллоо. Заримдаа ч яриагаараа түүнийг залхаачих вий гэж айх юм. Тэр надад гэр бүлийнхээ тухай, өмнөх амьдралынхаа тухай бүхнийг ярьлаа. Гэвч би түүнтэй улам их ярьмаар болох юм. Тэгэх бүрдээ яагаад сонссоноо чамлах болов оо? гэж өөрөөсөө асууна. Петер намайг урьд нь “адайр ааштай амьтан” гэдэг байжээ. Гэтэл одоо тийм биш байна гэнэ. Би гэдэг тийм их өөрчлөгдсөн л юм байх даа. Эсвэл Петер тийм өөр болчихсон юм болов уу? Харин би сайн найзууд болох талаар хэлээд яахав гэж бодоод өнгөрлөө. Бид хоёрын үерхэл энэ нуувчны уйтгартай амьдралыг даван туулахад их тус болох байх даа гэж бодно. Петер бид хоёр нэлээд ямыг хамтарч хийдэг боллоо.*

*Бүтэн сайн өдрийн үдэд гадуур болж буй үйл явдлын тухай мэдээ сонсоод унтахаар шууд хэвтлээ. Сэтгэл нэлээд хямарчихсан юм. Уг нь ээж, аав хоёрын өрөөнд орох ёстой байсан юм. Нэгэнт хэвтээд өгсөн болохоор ээжийн асуултанд хариулж, аавд элдвийг тайлбайрлах нь ядаргаа санагдав. Тэгээд толгой өвдсөн хэмээн шалтаглав.*

*Ер нь хэн ч гэсэн миний энэ гонгинооныг уучилж болно шүү дээ. Би ердөө л зүрх сэтгэлдээ байгаа бүхнээ чамд тоочиж, дотроо нэг сайн онгойлгож аваад ирэх долоо хоногт цовоо цолгин, сэтгэл хөнгөн байх гэж л ингэж далан булчирхайгаа тоочлоо шүү Китти минь!*

*Сүүлийн үед Маргот ч уяхан сэтгэлтэй болж, миний итгэлийг хүлээх гэж хичээх болжээ. Харин би эгчдээ илэн далангүй, бүхнээ хуваалцаж чадахгүй юм. Маргот хэдийгээр сайхан сэтгэлтэй, хүнлэг, элэгсэг зантай ч гэсэн сэтгэлийн нарийн нандин нууцаа ярихад арай л хэтэрхий номчирхуу санагддаг юм. Маргот намайг ярихад миний адайр зангийн тухай бодлогошрон, хэлэх үг бүрийг минь дүгнэсэн шинэстэй сонсож, “Ёстой л холиож байна даа, ингэж бодох ч буруу даа” гэхчлан шүүмжлээд байх шиг санагддаг юм. Ингэхэд би хэзээ нэг сэтгэл амгалан байж, энэ бүх бодлоос салдаг бол?*

*Анне*



## 1944 оны гуравдугаар сарын 14. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Өөрт маань шалихгүй мөртлөө, чамдаа сонсгомоор нэг яриа байна. Хоолны хулдаасан бүтээлэгтэй ширээнд энд нуугдахаас өмнөх үеийн үнэр нь арилаагүй нусны алчуураар амаа дарсан Даан хатагтайн хажууд би хэсэг суулаа. Энэ үеэр бидэнд дамын үнээр хүнсний тасалбар нийлүүлж байсан хүмүүс баригдаж бид тасалбар ч үгүй, өөх тосгүй боллоо. Мийн, ноён Коофуйс хоёр өвдөж, Элли ажилдаа дарагдаад гарч чаддаггүй. Бидний хамаг горьдлого алдран, хоол хомсдов. Өглөө хэлэн дээрээ тавьдаг хумсын чинээ цөцгийн тос ч тасрав. Маргарин хэмээх хиймэл шар тосны тухайд бол дурсах ч юм биш. Талханд хямгатай гэж өглөөний цайнд шарсан төмс иддэг маань ч өнгөрөв. Тэгээд өглөөний цайндаа будааны заваан агшаамал идэцгээх боллоо.*

*Харангадаж үхэхээс айсан Даан хатагтайн дамаас авахуулсан сүүгээр сүлсэн бидний үдийн хоол өнөөдөр даршилсан вандуй! !! Энэ олиг муутай хоолыг идэж чадахгүй огиулж магадгүй гэж болгоомжлоод би алчуураа авсан. Ганцхан жил хадгалахад тийм эвгүй үнэр танартай болно гэдэгт итгэмээргүй юм шүү. Тэр вандуйг хөгц үнэртсэн чавга, эхүүн цуу, ялзарсан өндөгтэй хольсны дараа эндхийн бүх өрөөгөөр нэг муухай үнэр ханхлахыг нь яана. Тэрнийг иднэ гэж бодохоос огиудас хүрнэ. Хувин бүрээс тэн хагасыг нь хаяхад хүрдэг муудсан төмс бас дээр нь нэмэгдэнэ гээч. Бид тэр төмсийг арилгаж суухдаа гэмтэж муудсанаар нь энэ өмөн үүтэй, тэр улаан бурхантай хэмээн янз янзаар оношлон ярилцана. Дайны дөрөв дэх жилийг хүртэл бүгж нуугдана гэдэг тийм ч амаргүй шүү. Бүх зовлон үүгээр төгсөх болтугай. Бид цөм дэндүү нэгэн хэвийн амьдралдаа залхаж гүйцлээ.*

*Даан эзэгтэй “шидэт тогооч” шиг байхаа болиод удав. Хийх юмгүй болохоор залхуу хүрэх юм. Хоол хийх л юм. Харин шарж хуурах тосгүйгээр хоол хийнэ гэдэг ярих ч юм биш. Муухай үнэрт нь бөөлжис цутгах болов. Тэгээр тэр хоолоо бүгд хэл амаа билүүдэн голж шилцгээнэ. Түүнээс гадна энэ дайнд ямар ч ахиц гарахгүй, харин Германчууд завшаад өнгөрөх ч юм билүү гэж бодох боллоо.*

*Даан гуай ”Тамхи л татахсан. Байдагсан бол ханатлаа татахсан. Тэгэх л юм бол улс төр, хоол унд, Керлийн сэтгэл мэтгэл ч яамай. Тамхиа байг гэхэд яадаж мах идэхсэн. Энэ амьдрал дэндүү муу байна гэсэн үг. Ингээж юм бүхнээр дутагдаж гачигдах гэж” хэмээн үглэнэ.*

*Хатагтай Франк буюу ээж маань харин “Бусад юм ч яахав. Ганцхан зүсэм хөх тарианы талх л идэхсэн. Өлсөж байна гэдэг ч тоймгүй. Англичууд ч их дутагдалтай улс л даа. Харин байлдахдаа гайгүй байх шиг байна уу даа. Жаал ярьж шуугихсан. Польшид л очоогүйдээ баярлах юм” гэнэ.*

*Ноён Франк буюу аав маань тэгэхэд “Бүх юм болж л байна. Надад юу ч хэрэггүй. Зөвхөн л тайван байцгаагтун. Бидэнд бас ч хугацаа их байна. Төмс л байвал болох нь тэр. Харин миний хувиас жаахныг ч болов тэр муу Эллид өгч үзээрэй” гэнэ.*

*Дуссел эмч бол “Хийж байгаа юмаа л эртхэн дуусгах минь. Улс төр шал балай юм. Энд бид баригдвал яах вэ? Тэгэхгүй л бол!” гэнэ. Би, би, би харин...*



*Хайрт Китти минь!*

*Хи..ши..тэгчих юмуу ингэчихвэл ямар гай босоод ирэх бол...хэрэв тэр маань өвдчихвөл биднийг гэх хүн хорвоод үгүй болж өнгөрцгөөх нь...харин тэгэхэд...хэрэв...гэсэн яриа чих дэлсэнэ. “Хэрэв, хэрэв” гэцгээх болсны учир нь биднийг ертөнцтэй холбодог ноён Кралер дайчилгаанд дуудагдсаныгх билээ. Элли салхинд цохиулснаас хэвтэрт орж, Мийн ханиаданд боорлуулж, ходоодондоо цус алдсанаас ноён Коофуйс эмнэлэгт ухаангүй хүргэгдээд байдаг. Ийм эмгэнэлт юм гэж байх уу?*

*Агуулахынхан маргааши ажилгүй, гэр гэртээ чөлөөтэй өнжинө. Элли гэртээ хэвтээ тул хаалга үүд ян тан цоожтой, бид ч хавь ойрныхонд санамсаргүй чимээ өгч, сэжиг авахуулчихгүй юмсан гэсэндээ хулгана шиг л чимээгүй суув. Үдийн нэг цагийн орчим Хенк биднийг яг л амьтны хүрээлэнгийн манаач шиг эргэж ирэв. Хенк бидэнд өнөөдөр дэлхий ертөнц, гадуур болж байгаа үйл явдлын шинэ сонинг ярилаа. Бид түүнийг тойрон хэчнээн сонирхож ам ангайн суухыг чи харсан ч болоосой. “Эмээ үлгэр ярьж байна” гэдэг зураг дээрх шиг л харагдсан байх.*

*Хоол унднаас авахуулаад л бид асууж, шалгааж гарахад тэр бүр Мийнийн эмчийн тухай бас ярьж сонирхуулав. Эмч ч гэж дээ. Надад л эмч юм даа. Өнөө өглөө утасдсан чинь туслах нь утас авч байна. Ханиад дарах эм хэлж өгөөч гэтэл найм, есөн цагийн хооронд очиж ав гэх юм. Ханиад хэрэв хүндэрвэл эмч харин өөрөө утсаа аваад “Хэлээ гарга! Аа гээрэй. За, болно. Сонслоо. Таны хоолой өрөвсөж, улайсан бололтой. Та эмийнхээ жорыг ирээд авчихаарай, баяртай!” гэнэ. Тэгээд л дуусах нь тэр. Мөн их дадлагажсан байгаа биз тийм үү? Эмч гэдэг чинь ингээд утсаар оношлочихдог байгаа! гэж тэр ярив. Би харин эмч нарыг зэмлэхгүй. Тэд бусдын л адил хоёр гартай болохоос дөрвөн гартай биш. Харамсалтай нь өвчтөн нь тоогүй олон болж, эмч нар нь хуруу дарам цөөрсөнд байгаа юм. Гэхдээ бид Хенкийн энэ яриаг сонсоод баахан хөхрөлдсөн. Эмчид үзүүлэхээр хүлээх өрөө хэрхэн өөрчлөгдсөнийг хэн бүхэн төсөөлөх болжээ. Үнэ төлбөргүй үзүүлдэг өвчтөн бүүр нүдний гэм болж, хөнгөн өвчтэй хүнийг “Юугаа хийж энүүгээр эргэлдээд байгаа юм бэ? Ард очихгүй юу. Юуны өмнө муу байгаа нь үзүүлэг!” гэнэ.*

**Анне**

*Хайрт Китти минь!*

*Өнөөдөр гадаа тийм гэж өөлөхийн аргагүй сайхан байна. Одоо би дээврийн агуулах руу очно. Яагаад би Петерээс бүүр долоон доор сэтгэл тавгүй байгаагаа одоо л ойлгов. Тэр өрөөндөө бодож, мөрөөдөж, дуртай үедээ унтаж байхад би нэг өрөөнөөс нөгөөд холхиж байдаг. Дусселтэй хамт байдаг болохоор өрөөндөө ганцаараа байх нь тун ховор юм. Гэхдээ заримдаа ганцаараа биш байгаадаа бас баярладаг л юм. Учир нь үүний ачаар дээшээ гүйх сайхан шалтаг гарч ирдэг юм. Тэнд, эсвэл энэ тэмдэглэлээ бичихдээ Китти минь чамтайгаа байхад л нэг чөлөөтэй байж чадах юм. Аз болоход хэн ч миний хайр сэтгэлийг анзаарч мэдсэн юм алга. Ээжтэй хуучин шигээ л жаахан хүйтэвтэр, аавтай нэг их дотно биш, Марготтой бодол санаагаа бараг ярихгүй шахам боллоо. Ер нь бодолтойхон шиг байя. Сэтгэл дотроо дайн болж байгааг хэнд ч мэдэгдээд яахав. Өнөөдрийг хүртэл ухаан бодол минь сэтгэл зүрхээ ялаад л байгаа юм. Заримдаа ч сэтгэл зүрх минь ухаан бодлоо ялан дийлчих вий гэж айх юм. Үгүй, тэгээд сэтгэл минь ялсан ч яахав дээ. Тийм ээ?*

*Тэр тухайгаа Петертэй ярилцаж чадахгүй нь хамгийн хүнд байна. Ямар ч байсан тэр эхэлж ярих ёстой. Ярих гэж мөрөөдөж байгаа зүйлээ, мөрөөдөлд автсан сэтгэлээ хэнд ч ярихгүй байх шиг хэцүү юм үгүй биз!*

*Тиймээ Китти, Анне чинь бага ч гэсэн солиорч байх шиг байна! Би гэдэг хүн ийм хараал идсэн цаг, хараал идсэн нөхцөлд амьдрах гэж дээ. Гэвч, бодсон санаснаа бичиж чадахтайгаа байгаадаа баярлах юм. Тиймгүй бол яг л бүтэж үхэх байсан байх. Энэ бүхний талаар Петер юу гэж боддог бол? Тэр тухай надад удахгүй ярина гэдэгт итгэж байна. Уг нь Петер нэлээд зүйлийг тааж мэдсэн байх ёстой. Амар тайван, нам гүм байх дуртай Петерт миний сэргэлэн цовоо, нүүрэмгий, яриа зан таарах юм гэж үү? Миний зүүдэг багийн цаадхыг олж нээх анхны бөгөөд цорын ганц хүн нь Петер байх ёстой юм гэж үү? Тэр миний юуг олж хараа бол? Хайр сэтгэл хос хоёрын хамтын зовлон дунд үүсэж, хоёр сэтгэлийг нийлүүлэн гагнадаг нь эртний ёс бус уу? Надад ч бас тийм хайр ирж байгаа юм биш үү? Петер надад сайн гэдгийг би мэднэ. Тэр тэгээд анх яаж сэтгэлээ илэрхийлэхийг би үнэхээр төсөөлөхгүй байна. Жирийн юм ярихдаа ч ичээд байдаг хүн яаж хайраа илчлэх бол? Би түүнд хайрынхаа тухай бичиж ч болох юм. Тэгвэл ярилцахыг хүсдэг мөртөө үгээр илэрхийлэхэд хэцүү зүйлийг минь тэр мэдэж авна шүү дээ.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Бид хэдийн зовлон овоо нимгэрч эхэллээ. Ноён Кралер дайчилгаанаас чөлөөлөгдсөн. Харин Эллийг ханиадаа бидэнд халдаачихна гээд ирүүлэхгүй байгаа. Аав, ээж хоёр Маргот бид хоёрт заримдаа “шавар” болдгийг эс тооцвол бүх юм хэвэндээ оров. Намайг чи битгий зэмлээрэй Китти! Тиймээ, намайг ээжтэйгээ сайн учраа ололцдоггүйг чи мэднэ шүү дээ. Аав бол шал ондоо. Маргот бид хоёр хоёулаа аавдаа хайртай. Бидний үеийнхэн бүгд л нэг ч удаа гэсэн ээж нарын аан уун гэхээс холдож, өөрсдөө дураараа байхыг хүсдэг шүү дээ. Гарч орох, юу хийх, хоолонд чимх давс нэмэх эсэхээ хүртэл ээжээсээ асууж, орой бүр найм хагас болоход хувцас хунараа тайлж, орондоо орон зөвшөөрөл авч байх хэрэг үү. Унших гэсэн бүхнээ бас ээжээс асууж, хянуулж байх уу. Үнэнийг хэлэхэд надад унших номны хувьд нэг их хатуу биш, хүссэнээ уншдаг ч гэсэн бүх л өдөржингөө ээжээр заалгаж, зааварлуулж байх нь Маргот бид хоёрт хоёуланд минь яришигтай санагддаг. Тэр тусмаа би бүх юман дээр аав ээжийн зааж залснаар байхыг хүсэхгүй. Энд ч, тэнд ч эвий хөөрхий болж байдаг нялх балчир хэвээрээ биш том болоод байхад.*

*Багад минь өхөөрдөн дууддаг байсан нэр ч шал нялуун, тэнэг сонсогдох болж. Товчхон хэлэхэд би чинь эцэг эхийн хайр халамжнаас гарч, биеэ даасан хүн болохыг хүснэ. Маргот өчигдөр “Толгой өвдөх юмуу сэтгэл шаналахад ч асуугаад байлгүй шанаагаа тулах, дураа хүрсэн үед чөлөөтэй санаа алдчихаж ч болохгүй нь инээдтэй юм” гэв. Би арван дөрөв хүрмэгцээ л яах юу хийхээ мэддэг болж, аливаа юманд хэний буруу, хэний зөвийг өөрөө ялгаж салгаж чаддаг болсон. Ер нь амьдралд хандах өөрийн гэсэн бодол, өөрийн гэсэн хандлагатай болчихсон шүү дээ. Ер нь эцэг эх ч бай, хэн ч гэсэн хүнд хайрлуулъя гэвэл өөрөө хэний ч хайр хүндлэлийг хүлээж чадахуйц байх хэрэгтэй шүү дээ. Миний хувьд Петерт л хүндлүүлж байвал боллоо. Би түүнийг хүндлэн хайрлаж чадна даа. Петер бол үнэхээр сайн хөвгүүн шүү.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 19. Ням гариг

*Хайрт Китти минь!*

*Миний хувьд өчигдөр маш шийдвэрлэх өдөр болж өнгөрөв. Петертэй ярихаар хатуу шийдэв. Ширээнд суухаасаа өмнө би:*

*-Петер би өнөөдөр татлан бичгийн дасгалаа хийх үү? гэж шивнэв. Тэр тэгэхэд:*

*-Үгүй гэв. Намайг:*

*-Чамтай жаахан ярилцмаар байна гэхэд Петер:*

*-Тэгээрэй гэв. Аяга шанагаа угаасны дараа аав ээж дээр үл ялиг саатаад Петер дээр очив. Түүнийг нээлттэй цонхны зүүнтэй нь зогсож байхад би баруун талд нь очиж зогсов. Гэрэлтэйд ярилцсанаас бүрэг бараг харанхуйд ярилцах нь хамаагүй дээр ажээ. Петерт ч бас тийм байх шиг санагдав. Бид хоёр энд тэр болгоны нь бичиж барахааргүй удаан ярьж суулаа. Энд ирснээс хойш ийм сайхан хөгжилтэй өнгөрөөсөн ганц ч орой байсангүй. Эхлээд бид эцэг эхчүүдийнхээ балай явган хэрүүлийн тухай ярилцсан юм. Тэгээд би аав, ээж, Марготын тухай, бас өөрийнхөө тухай ч ярилаа. Петер тэгтэл гэнэт:*

*-Танайхан сайхан нойрсоорой гэхдээ үнсэлцдэг үү? гэв. Би:*

*-Тэгэлгүй яахав. Бүр түвэгшээмээр олон гээч! Танайхан үнсэлцдэггүй юмуу? гэв.*

*-Үгүй, би хэнийг ч үнсэж үзээгүй.*

*-Төрсөн өдрөөр ч үгүй гэж үү?*

*-Төрсөн өдөр ч мэдээж өөр л дөө!*

*Бид хоёр хоёулаа л аав ээж нартаа бүрэн итгэдэггүйгээ, ялангуяа Петер аав ээж нь өөрийнх нь итгэлийг хүлээх гэж хэчнээн оролддог ч тэдэндээ итгэдэггүйгээ ярив. Намайг гомдол гутралаа дандаа орондоо тайлдаг гэхэд Петер харин агуулах руу зугатан тайвширдаг гэлээ. Мөн эгчтэйгээ одоо л дөнгөж ойлголцож байгаа боловч жинхэнэ чин сэтгэлээсээ бас тэр болгон ярьдаггүйгээ ч хэллээ. Ийнхүү бид хоёр хамаг сэтгэлээ уудлан ярилцсан. Би Петерийг зөв ойлгож байжээ.*

*Дараа нь 1942 оныг эргэн дурсацгааж, одоогийнхоос огт өөр байснаа, энд ирээд эхэн үедээ бие биеэ тоодоггүй байснаа хүүрнэлдэв. Намайг юм болгонд оролцсон, тогтворгүй зантай гэж Петер бодож байсан бол, би түүнийг жирийн нэг хөвгүүн шиг санаж явжээ. Түүний нүүрэмгий биш үл ойлгогдох байдал нь харин өнөөдөр намайг баярлуулав. Петер өөрийгөө хэт зожиг байснаа өгүүлэв. Тэгэхэд нь би миний хөнгөмсөг юм шиг илэн далангүй зан, түүний дөлгөөн тайван байдал хоорондоо ялгаагүйг, мөн нам гүмийг мөрөөдөхдөө өдрийн тэмдэглэл хийх болсноо ярив. Тэгээд л манай ээж аавыг охидуудтайгаа энд нуугдан суух болсонд тэр баярлаж явдгаа, би түүнтэй энд учирч, эцэг эхтэйгээ харьцахдаа хэт бүрэг*

*ичимтгийг нь ойлгон өөрт нь туслахыг хүсдэгээ нэгд нэгэндгүй цөмийг ярилаа. Түүнийг:*

*-Чи надад ямагт тусалдаг шүү дээ! гэхэд нь би гайхан:*

*-Юугаар тэр билээ? гэв. Петер тэгэхэд:*

*-Хөгжилтэй хөхүүн байдлаараа гэв.*

*Энэ нь түүний надад хэлж чадах хамгийн сайхан үг байв. Би ийм сайхан үг урьд нь хэзээ ч сонсоогүй мэт. Тэр намайг хамгаас дотно найз хэмээн тооцдог юм байна. Болоо юм биш үү? Хариуд нь хэлэх талархлын сайхан үг ч олдохгүй юм. Китти минь, би өнөөдөр жирийн байдгаасаа өөр байгаадаа уучлалт гуйя. Би сэтгэл санаагаа тэр чигээр нь бичлээ шүү. Петер бид хоёр нуух хаах юмтай боллоо гэдгээ одоо л би ойлгов. Намайг хармагцаа түүний инээх, эсвэл нүдээ ирмэхэд нь миний дотор гэрэл гэгээ асах шиг болох юм. Үргэлж л ийм аз жаргалтай байхыг би хүснэм!*

***Баяр хөөр аз жаргалтай байх болсон Anne***

## 1944 оны гуравдугаар сарын 20. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөө өглөө Петер намайг орой ирэх үү гэснээ, өөрөө хийх юмгүй гэв. Түүний өрөө ч уг нь нэг хүн шиг хоёр хүнд хүрэлцэхүйц зайтай л даа. Намайг тэгээд доор байгаа манайхан ч юу гэгцгээх юм бэ, орой болгон очиж чадахгүй байх аа гэхэд Петер, өөрийнхнөө юу гэх бол гэж битгий биеэ барь л даа гэв. Би хагас сайн өдрийн орой л очъё гэж ам өгөөд дахин сартай шөнө болбол хэлээрэй гэв. Петер:*

*-Тэгнэ тэгнэ. Сар гарвал доошоо бууж хамтдаа харцгаана гэсэн.*

*Энэхэн зуурын аз жаргалд минь сүүдэр туслаа ч гэх үү, юу ч гэх юм бэ, нэг юм тохиолдох нь тэр. Аль хэдийнээс Марготыг Петерт сайн юмуу гэж боддог маань санагдаад явчихлаа. Чухам Маргот түүнд сайн эсэхийг тодорхой мэдэхгүй байгаа нь ч онцгүй юм. Би ингээж Петертэй байх бүрдээ муу эгчийгээ шаналгаж байгаа юм биш байгаа гэж бодогдоно. Маргот шаналж байгаа юм уу, үгүй юм уу гэдгээ огт мэдэгдэхгүй байгаа нь гайхалтай. Би бол ухаан алдаад, уйлаад бөөн юм болсон доо. Нэг удаа Маргот “намайг өрөвдөхийн хэрэггүй” гэхэд нь би:*

*-Гурав дахь хүн л болчихоогүй бол яамай гэвэл Маргот:*

*-Би тийм юманд дасжээ гэж энгүүнээр хэлэв. Тэр бүхнийг Петерт би хэлж зүрхэлсэнгүй. Дараа л хэлж болох юм даа. Одоо бол бид хоёр хоорондоо ойлголцох нь илүү чухал байна.*

*Ээж намайг өчигдөр нэг юманд холбогдуулчихав. Заримдаа ээжийн аяыг дагаж, үгийг нь сонсож байхгүй бол болохгүй нь ээ. Аль болохоор биеэ барьж, ээжтэй эвтэй байж, аар саархан зэмлэлийг нь тоохгүй байх минь. Аав ч надтай урьдынх шигээ дотно биш болчихжээ. Аав намайг балчир охин шиг үздэгээ болихыг хичээснээс ч юм уу, нэг л хөндий хүйтэн харилцах юм. Юу болохыг л хүлээхээс дээ. За яах вэ, Петерийг л харж суувал болох юм шиг санагдах юм. Ийм юм болчих гэж байх уу.*

*Марготын хэчнээн сайхан сэтгэлтэй, хүнлэгийн нотолгоо болсон зурвасыг өнөөдөр гуравдугаар сарын хоринд хүлээн авав. Түүнд “Анне, би өчигдөр чамайг хардаж, жөтөөрхдөггүйгээ хэлсэн бөгөөд энэ маань зуун хувь үнэн бишээ. Учир нь Петер та хоёрт атаархахдаа биш, харин бодол санаагаа хуваалцан, сэтгэлээ ярих хэнийг ч урьдын сайхан цагт хэрэгсэлгүй явж байгаад одоо хэнтэй ч учрах аргагүй тийм цаг үетэй золгосондоо л харамсдаг юм. Та хоёрыг харилцан бие биедээ итгэж, бодол санаагаа хуваалцаж байгаасай гэж би чин сэтгэлээсээ хүснэм. Амьдралд өөрийнхөөрөө хандахыг хүсч байгаа чинь ч зөв. Миний хувьд гэвэл сэтгэлээ дотносон ярья гэвэл Петертэй лав хэзээ ч бүтэхгүй юм шиг санагддаг байсан юм шүү. Надад бол олон юм хэлүүлэхгүй ойлгодог хүн хэрэгтэй. Тийм байж чадах хүн надаас илүү ухаантай хүн байх ёстой. Гэтэл Петер тийм биш шүү дээ. Харин Петер та хоёрын хувьд бол шал өөр хэрэг. Та хоёр хоорондоо таарна гэж би бодож байна. Чи намайг гомдооно гэж бодох хэрэггүй. Чи ердөө ч намайг гомдоогоогүй...” гэжээ.*

*Миний хариу:*



*“Хайрт Маргот минь!*

*Чиний захиа ер бусын дотно юм. Гэхдээ би үүнд бүрэн тайтгарахгүй. Хэзээ ч тайтгарахгүй. Чиний хэлсэн итгэлцэх гэгч нь Петер бидний хооронд тийм ч их яриад байхаар юм болоогүй байна. Ер нь наран гийсан өдрийн гэрэлтэйгээс саран шингэсэн шөнийн харанхуйд, нээттэй цонхны дэргэд ярилцах нь дээр байдаг бололтой. Сэтгэлийн үгс чинь хашигчсанаас шивнэлдэхэд илүү хөнгөн урсдаг байх... Петерт эгч шиг нь ханддаг, түүнд над шиг туслахад бэлэн байдгий чинь ойлгож байна. Ямар ч итгэлийн тухай яриа бидний хооронд байхгүй ч хайрлаж байгаа л бол болно шүү дээ...*

*За, энэ тухай ярихаа больё. Энэ тухай дахин хэзээ ч ам нээхгүй шүү. Ямар нэг юм хэлмээр бол зурвас бичихийг бодоорой. Би чамаар хэчнээн их бахархдагийг чи мэдэхгүй биз ээ. Би аав та хоёроос их юм сурахыг хүсдэг. Та хоёр хоорондоо ялгахаргүй олон сайн талтай юм шиг санагддаг шүү.”*

***Анне***

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр орой би ийм захидал Марготоос авлаа. Тэр “Хайрт Анне!*

*Өчигдрийн чинь захиаг уншихад чи дээш гарч юм хийх юмуу эсвэл Петертэй ярихдаа санаа зовоод байгаа юмуу гэсэн бодол төрлөө. Ингэх хэрэг байхгүй юм биш үү. Миний хувьд гэвэл итгэлцэх л гол юм шиг санагдана. Надад бол Петер таарахгүй санагддаг юм. Би чиний бичсэн шиг, түүнийг эрэгтэй дүү шигээ санаж явдаг шүү. Биднийг эгч дүүс шиг харилцаатай болох уу, үгүй юу гэдгийг одоо яаж мэдэх вэ дээ. Элдвийг надтай холбон бодож, сэтгэл зовохын хэрэггүй. Өөрт олдсон сайхан үерхлээ хүндэтгэн сэтгэлээ баясгаж яв” гэжээ.*

*Энэ бүхэн сайнаар өрнөх нь ээ. Китти минь, бодоод байхад бид хоёр энэ нуувчинд аугаа их хайртай учрах нь байна. Би түүнтэй дараа нь суух уу үгүй юү гэдгийг үнэндээ мэдэхгүй юм. Учир нь тэр том болохоороо ямар хүн болохыг хэн ч мэдэхгүй шүү дээ. Тэгээд ч бид хоёр гэрлэх хүртлээ тийм их хайр сэтгэлтэй болох ч юмуу, үгүй юмуу гэдгийг бүү мэд. Юу ч болсон Петерийн надад сайн гэдэг нь илт боллоо. Тэгэхдээ надад хэр сэтгэлтэйг бас мэдэхгүй. Тэр надтай зүгээр сайн найз байх гэв үү, эсвэл дурлачихсан уу, ердөө л дүү шигээ хайрлаад байна уу гэдэг нь мэдэгдэхгүй юм. Өчигдөр би түүнээс “Хэрэв хэдэн арван Анне бий болчихоод чам руу зогсоо зайгүй гүйгээд амар заяа үзүүлэхгүй бол яах вэ?” гэж асуухад:*

*-Тэд нар бүгд яг чам шиг байвал харин ч зүгээр юм биш үү гэсэн. Энэ үгнээс нь тэр намайг орж ирээсэй гэж хүсдэг юм байна гэж ойлгосон. Петер франц хэлэндээ үнэхээр хичээж орой 10 хүртэл суух юм. Тэр инээж баясч байхдаа ч, жирийн байхдаа ч эелдэг сайхан зантайг яана. Миний бодлоо бол юм бүхнийг өнгөцхөн хардаг ердийн охидын нэг биш, харин өөр шиг нь хэцүү бэрхийг амссан атал аливаа сайхныг мөрөөддөг охин гэдгийг минь мэдээд Петер надад улам татагдаж байгаа бололтой.*

*Миний хариу*

*“Хайрт Маргот минь!*

*Хамгийн чухал нь цаашид яахыг хүлээзнэх нь дээр юм шиг санагдана. Ер нь Петер бид хоёр шийдвэрээ гаргах хүртэл нэг их удахгүй биз. Үйл явдал цаашидаа яаж өрнөхийг үнэхээр мэдэхгүй байна. Хэрэв бид хоёр улам дотно болох юм бол чамайг түүнийг сайнаар үнэлдэг гэдгийг ямар ч гэсэн хэлнээ. Петер чиний тухайд юу бодож явдгийг бас мэдэхгүй байна. Гэхдээ юу гэж боддогийг нь асуух болно. Лав л муугаар санадаггүй байх. Чи бас бид хоёрын байгаа газар хамт байж болно шүү дээ. Чи яасан ч бидэнд саад болохгүй. Яагаад гэвэл бид хоёр заримдаа юу ч ярилгүй зүгээр л хамт байх дуртай. Харин үдэш болохоор л ярилцаж эхэлдэг. Чи зоригтой байгаарай. Би ч тийм байхыг хичээнэ. Өөрт чинь тийм байх үе бодож байгаагаас чинь ч хурдан ирнэ бий.”*

## 1944 оны гуравдугаар сарын 23. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Ашгүй бидний хувьд хэрэг сайнаар эргэж байх шиг байна. Манайханд хоол хүнс залгуулдаг “дамчин” азаар шоронгоос гарчээ. Мийн өчигдөр ажилдаа орж, Эллигийн ханиад зүгээр болсон. Харин хөөрхий Коофуйс гуай гэртээ нэлээд удах бололтой. Энд өчигдөр нэг онгоц сөнөжээ. Багийнхан нь шүхрээр буухад эзэнгүй тэр онгоц сургууль дээр унасан гэнэ. Азаар сургууль тарсан үе таарчээ. Аймар түймэр гарч, хэдэн хүн амь алджээ. Германчууд шүхэрчид рүү учиргүй их галлав. Бид мэтийн аймхай эмэгтэйчүүд үнхэлцгээ хагартал айсан. Буудалцана гэдэг ч... Үдшийн цэвэр агаар амьсгалах гэж би одоо Петер рүү байнга очих боллоо. Түүнтэй зэрэгцэн гадагшаа харж суух шиг сайхан юм үгүй. Намайг тийшээ очих бүрд Даан гуай, Дуссел хоёр үргэлж л ярих ярихгүй юм хэлнэ. Тэр хоёр “Анне гэртээ орохоор явлаа” гэх юмуу эсвэл “Залуу эр хэзээ л ийм орой охидыг өрөөндөө хүлээн авч байлаа даа, ёсонд хазгай юм” гэх мэт тэнэг юм хэлнэ. Петер хэрүүлийн үг дайвартай тийм зэмлэлийг тоох ч үгүй. Ээж нь ч гэсэн бид хоёрыг огт тоохгүй шинжтэй биш дэгээ. Хүүгээсээ бид хоёрын тухай нэлээд шалгаадаг бололтой. Тэгэхэд нь Петер “Энэ хөгшичүүл залуус бидэнд атаархаад байх шиг. Бас өөрсдийнх нь жигшмээр хэрүүлд дургүй хүрдэг болохоор бидэнд зэвүүцдэгээс зайлахгүй ээ” гэнэ. Заримдаа тэр хэрэг болгон доош бууж ирээд л намайг аваачина. Тийн тэднийг элдвийн юм хэлээд байхаар ичсэндээ үг ч хэлж чадахгүй болно. Би харин хэчнээн ч эвгүйрхсэн нүүр улайдаггүйд баярладаг юм.*

*Аав намайг ямагт л гоёж гоодсон хүүхэлдэй шиг байх юм гэдэг. Харин би чухамдаа тийм хүүхэлдэй шиг охин биш шүү дээ. Би чинь их л бардам хүн. Сургууль дээр нэг хөвгүүн намайг “инээх чинь хөөрхөн юм” гэснээс өөр хэн ч өдий хүртэл миний хөөрхнийг хэлээгүй. Өчигдөр л харин Петер намайг хөөрхөн, сайхан гэсэн. Чамдаа л энэ бүхнийг нэгд нэгэнгүй тоочмоор санагдах юм Китти минь. Петер байсхийгээд л “Инээ л дээ” гэнэ. Тэгэх нь надад тааламжтай болохоор би:*

*-Чи намайг инээлгээж яах гэсэн юм бэ гэнэ. Петер тэгэхэд:*

*-Яах юу байхав. Чи инээхээрээ хөөрхөн болоод л тэр. Инээхэд чинь хацар дээр чинь хөөрхөн хонхорхой гарах юм. Яагаад тэгдэг байна аа? гэхэд нь би:*

*-Төрөлхийн юм аа. Миний цорын ганц хөөрхөн юм л энэ хонхорхой байгаа юм гэв.*

*-Үгүй энэ чинь худлаа.*

*-Үгүй би өөрийгөө тийм нүд булаасан хөөрхөн охин биш гэдгээ мэднэ. Тийм байгаа ч үгүй, байх ч үгүй.*

*-Надад бол чи хөөрхөн санагддаг. Би чамаас өөр хөөрхөн охин үзээгүй.*

*-Тэр худлаа.*

*-Чамд үнэнээ хэлэхэд чи итгэнэ байлгүй гэв. Би ч тэгэхэд нь түүнийг өөрий нь бас л хөөрхөн*

*хөвгүүн гээд хэлчихсэн. Манайхан тал талаас бидний гэнэтийн үерхлийн тухай элдэв юм ярих юм. Бид үерхлээ яасан ч эцэг эхчүүдийн хэл амны бай болгомооргүй байна. Тэдний дандаа үглэж зэмлэх уйтгартай юм. Тэд нар залуу насаа мартчихдаг юм байх даа? Мартсанаас л зайлахгүй. Тэд биднийг хөгжин баясахад хөмсөг зангидаад л, үнэн сэтгэлээ нээхээр шоолон инээлдэх юм.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 27. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Манайхны ярианы ихэнхийг улс төрийн маргаан эзэлдэг юм. Улс төрийн яриаг ер тоодоггүй би л тэрэнд нь оролцдоггүй. Тэд улс төрийн сэдвээр бооцоо тавих, дооглох, хараах, зүхэх мэтээр чадах бүхнээрээ л ярилцаг. Харин битгий л хэрэлдээсэй. Яагаад вэ гэвэл тэр нь дандаа балаг тарьдаг юм.*

*Гадуур чөлөөтэй явдаг хүн бүхэн дандаа л үнэмшмээргүй шинэ сонин юм ярих болж, радио маань л өнөө хүртэл нэг ч худал хэлсэнгүй. Хенк, Мийн, Коофуйс, Кралер гуай нар цөм бүх л үйл явдлыг өөр өөрсдийнхөөрөө ярин, үйл явдлыг нэг дэвэргээж, нэг доордуулна. Арай гайгүй нь Хенк л юмуу даа. Манайхны улс төрийн сонирхол нь ихэнхдээ нэгэн хэвийн дайралт, бөмбөгдөлт, сайд нарын хэлсэн үгийн талаар тоо томиггүй маргахын зэрэгцээ “Тэгж яавч болохгүй”, “Бурхан таалаг, тэд хэрэв эхэлсэн бол хэдийд дуусгах бол?”, “Тэр чинь ашиггүй зүгээр юм болов уу даа. Гайхалтайяа түүнээс өөр яах ч билээ” гэсэн тоолж барамгүй санал хэлцгээнэ. Өөдрөг, гутранги үзэлтнүүд хийгээд бас юмыг бодитой хардаг хүмүүс бүгд л өөр өөрсдийнхөө бодлыг зөвтгөн дайн дуусаж, тайван цаг ирээсэй хэмээн мөрөөдөцгөөнө. Тэгээж маргаж байхдаа тэд уйдна гэж үгүй. Германы Веермахт, ВВС-ийн мэдээнүүд дутуу санагддаг юмуу бүү мэд, саяхнаас нэвтрүүлж эхэлсэн “Агаарын хамгаалалтын мэдээ” гэгчийг бас сонсоцгооно. Томчууд хар нүд хуу татангуут л радио сонсоцгоож гарна. Минийхээр бол өдөрт нэг юмуу хоёр удаа л мэдээ сонсоход болмоор юм. Манай томчууд хоол идэх, унтахаас бусад үед радио тойрч аваад л хоол унд, унтлагын яриа дэлгэж гарна. Ээ дээ, үүн шиг уйтрартай юм үгүй дэгээ. Ийнхүү яриа дэлгэх нь сэтгэл хөшүүн эмээ болохгүй байх арга юм байх!*

*Бүтэн сайн өдрийн есөн цаг болж байна. Цай ч бэлэн болж, манайхан нэг доороо бөөгнөрөв. Хүлээн авагчийн зүүнтээ Дуссел, түүний урд Даан гуай, дэргэд нь Петер, хажууд нь ээж, түүний ард Даан хатагтай, ширээний дэргэд аав, Маргот бид гурав тус тус сууцгаав. Харчууд тамхиа татан, сонсогчдын хараа радио долгион тааруулж буй Петер дээр тусна. Рурийн сав газрыг чиглэсэн нислэг бидний дээгүүр өнгөрч байна хэмээн радио хангинахад өглөөнийхөө урт бараан даашинзтай чигээрээ суугаа ээж, Даан хатагтай хоёр айн чичрэв. Аав цайгаа оочин, Муши мий бидний өвдгийг дамнан хэвтсэнээс Маргот бид эгч дүүсийн шинжтэй бие биеэ налан суув. Маргот үсэндээ цагирагтай, би багадаж дэдийсэн гэрийн халатаа хэдэрчихсэн байлаа. Юу болдог бол гэж би тэсч ядан, бусад хүмүүс харин шүүн ярилцахыг хүлээж ядан бие биесээ өдөцгөөж эхэлнэ дээ.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Улс төрийн талаар нэлээд юм бичиж чадах ч гэсэн өнөөдөр тэс өөр юмны тухай өгүүлмээр санагдав. Нэгд, Даан эзэгтэйг атаархаж байна гэж бодох болсноосоо болж ээж намайг дээшээ Петер лүү очихыг хориглов. Хоёрт, Петер хүндлэмтгийгээсээ юмуу эсвэл үнэн сэтгэлээсээ ч тэрүү бүү мэд, намайг Марготтой хамт өрөөндөө ирэхийг урив. Гуравт, Даан эзэгтэйн атаач занг дууриавал ямар вэ гэж ааваас асуувал “хэрэггүй биз ээ” гэв. Одоо яадаг юм билээ? Ээж муухай аашилан, би ч бас мөчөөгөө өгөхгүй хачин зан гаргана. Аав Петер бид хоёрын хамт байгаад дургүйцэх нь байтугай, харин ч бидний эв найртай байгаад баярлаж байна. Маргот ч Петерийг таашааж, хоёр хүний хоорондын ярианд гурав дахь нь илүү гэж бодож байгаа шинжтэй.*

*Петерийг надад сэтгэлтэй болоосой гэж хүснэм. Тийм болчихвол бид хоёр бүүр санаа амар, бие биенээ ойлголцоход улам чөлөөтэй болохсон. Петерийг дандаа л намайг хараад гөлөрч байдаг болж гэж ээж хэлдэг байна шүү. Тэр ч үнэн л дээ. Бид хоёр үе үе бие бие рүүгээ нүдээ ирмэлцэх болж, ялангуяа Петер миний хацрын хонхорхойг илүүтэй сонирхдог болсон юм!*

*Би чамлахааргүй зовлонтой л байна. Ээж бид хоёр дахиад л муудалцчихсан. Нүдний өмнө болж буй бидний муудалцааныг аав мэдээгүй царай гаргаад л явах юм. Ээж минь намайгаа гэсэндээ л надад гомдов бололтой. Би мөн л намайг ойлгохгүй юм гэж ээжид гомдов. Петер...Петерийг гэхээ би болихгүй. Тэр бол сайн хөвгүүн. Бид улам сайхан үерхэцгээнэ. “Хөгшчүүл” яагаад ийм юманд оролцоно вэ? Азаар би бодол санаагаа нууж сурчээ. Петерийг л гэж байдгаа мэдэгдээгүй маань юутай зол вэ. Өөр нэг Петерийн хацарт хацраа нааж байна гэж зүүдэлсэн шигээ энэ Петертэй хэзээ тийм дотно болох бол? Петер Вессел, Петер Даан хоёр минь! Та хоёр одоо нэг л хүн болжээ. Биднийг юу ч ярихгүй зүгээр зэрэгцэн сууж байхдаа л хэчнээн аз жаргалтай, сэтгэл тэнэгэр байдгийг томчуул мэдэх ч үгүй, ойлгох ч үгүй. Хэдийд энэ хэцүү үл ойлголцол арилж, томчууд биднийг гоочлохоо больж амар заяа үзүүлдэг бол? Ямар ч байсан энэ бүхнийг давах л хэрэгтэй. Тэгвэл сайнаар төгсөнө дөө! Петерийн зөрүүлсэн гараа дэрлэн, нүдээ аниад хэвтэх нь яг л хүүхэд шиг агаад, Муши мууртайгаа эрхлэх нь энхрий хайр хүрмээр харагдана. Бас шуудай төмс юмуу, элдэв хүнд юмыг өргөхдөө чадалтай, буудалцааныг ажиглах, бас хулгайч орсон эсэхийг мэдэх гэж харанхуй руу явахдаа айдаггүй, зоригтой мөртөө зарим юманд ямар ч эвсэлгүй байдаг нь хүртэл надад таалагддаг юм. Уг нь тэр минь надаар юм заалгахаас илүү өөрт минь юм тайлбарлаж өгөх нь гоё байдаг юм. Ээж минь намайг үргэлж л хажуудаа байлгах гээд байх юм.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр Болкештайн гэдэг нэг сайд “Ораня” нэвтрүүлгээр дайн дуусмагц энэ аймшигт хүнд үед бичсэн захидал, өдрийн тэмдэглэлүүдээр түүвэр ном гаргавал зүгээр юм гэв. Үүнээс болж бүгд л миний өдрийн тэмдэглэлийг шохоорхож гарлаа. Би “Нуувчныхан” гэсэн роман бичээд хэвлүүлбэл ямар сонин байхыг чи бод л доо. Нэрийг нь харсан хүн бүр лав энэ чинь тагнуулын роман гэж бодох биз.*

*Харин энэ үнэхээр бодмоор юмны нэг шүү. Дайн дууссаны дараа жил биш ч гэсэн арван жилийн хойно еврейчүүд биднийг хэрхэн байшингийн хонгилд нуугдан амьдарч, юу идэж, юу ярьж байсныг бичвэл сонирхолтой биш гэж үү? Би хэдийгээр чамд мундахгүй их юм ярьсан ч миний эндэх амьдралын өчүүхэн хэсэг гэдгийг чи юу эс андах вэ. Ганцхан жишээ гэхэд л өнгөрсөн ням гаригт английн 350 нисгэгч бараг хагас сая шахам килограмм бөмбөгийг Юмидэд хаян, хавь орчны байшин барилгыг чичиргэсэн, бас газар сайгүй ханиад томуу дэгдсэнийг сонсоод бүсгүйчүүл бид хэчнээн айв даа. Чи тэр бүхнийг яаж мэдэх билээ. Хэрэв хамгийн жаахан юмыг ч орхилгүй, бүхнийг чамд ярих гэвэл би өдөржингөө цаас эрээчих болно шүү дээ. Хоолны ногоо эсвэл юу ч хамаагүй хоолой л давах юм авах гэсэн хүмүүс газар сайгүй оочирлон зогсох болж гэнэ. Машинтай нь машинаа, дугуйтай нь дугуйгаа дээрэмдүүлсэн болохоор эмч нар өвчтөндөө ч очиж тус болж чадахгүй болжээ. Газар сайгүй том том дээрэм хулгай гарсан тухай мэдээ тарж, Холландын зүйр үгэнд ч байдаг ёс дэглэм, шулуун шударга гагц нь яачихав таминь хэмээн өөрөө өөрөөсөө асуухад хүрч байна. Наймаас арван нэгэн насны бяцхан жаалууд хүртэл айлын цонхыг хагалаад дайралдсан бүхнээ хулгайлах болжээ. Бөгс өндийх л юм бол айлын гэрийг ухчихаад байгаа болохоор хэн хүнгүй л орон гэрээ таван минут ч эзэнгүй орхиж зүрхлэхээ байжээ. Хулгайлсан бичгийн машин, перс хивс, цахилгаан цаг, хувцас хунар, эд бараа юу л байна түүнийг буцааж өгвөл ийм юм, тийм мөнгөөр шагнана гэсэн зарлалууд өдөр бүрийн сониныг дүүргэх боллоо. Гудамж талбай дахь цагийг хуу хамж, ярьдаг утасны аппарат ч бүтэн үлдээгүй юм байх аа.*

*Хүмүүс бүгд сэтгэлээр унажээ. Долоо хоногоор авдаг хоол хүнсний зүйл ч муудсаар байна. Ялалтыг хот хөдөөгүй хүлээцгээн, эрчүүд германы цэрэгт татагдах нь улам ихсэв. Багачуул хүүхдүүд ам хөдөлгөх төдий юмаар амь зогоож, өвдөх нь хэрээс хэтэрчээ. Нийт хүмүүсийн хувцас хунар муудаж, тартагтаа тулан хөл нүцгэрчээ. Гутлын нэг зан дамаар долоон гульден тавин центээс наашгүй болон үнэ нь хаджээ. Ихэнх гуталчид хүр харахаасаа айдаг болсны дээр зарим нэг нь гутлыг нь гурав дөрвөн сараар хүлээлгэж байгаад алга болно. Энэ бүхний эцэст ганц сайн тал байгаа нь байдал муудах тусам Германы эсрэг тэмцэл хөдөлгөөн улам их болж байна.*

*Анне*

## 1944 оны гуравдугаар сарын 31. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Гадаа хүйтний эрч хэвээрээ ч ихэнх айлууд түлэх нүүрс, ганц залтас ч үгүй сууна. Ганихан л гайгүй эерэг юм дуулдана. Юу гэвэл, оросууд фронт дээр гайхамшигт ялалт байгуулж буй нь хүмүүсийг урамшуулж байна даа. Үнэндээ би улс төрийн тухай бичих гэсэнгүй. Тэгэхдээ оросууд Румыны Прутэд, цаашлаад ерөнхий Тубернид нэлээд ойртжээ гэдгийг чамд дуулгах гэсэн юм. Тэд Одессын босгонд тулжээ. Энд орой бүр Сталины онцгой мэдэгдлийг хүлээж байна. Москва хотноо ёслолын буудлага өдөр бүр нүргэлэх ажээ. Дайн тулалдаан дахин ойртоод ирчихсэн юм шиг тийнхүү нижигнүүлэн байх нь тэдэнд сайхан санагддаг юмуу эсвэл баярлаж хөөрснөө өөрөөр илэрхийлж болдоггүй юм болов уу, бүү мэд. Унгар улс Германы цэрэгт эзлэгджээ.*

*Манай бүгэвчнийхэн онц сонин юмгүй сууна. Өнөөдөр Даан гуайн төрсөн өдөр. Тэр гэрийнхнээсээ төрсөн өдрийн бэлэг гэж авгайнхаа хадгалж байгаад өгсөн хоёр хайрцаг тамхи, ганц аяга хүрэх жаахан кофе л авав. Мөн түүнд ноён Кралер нимбэгний ундаа, Мийн сарнай загас, манайхан үнэртэй ус, алтанзул цэцэг, гурил тос нь муугаас үйрэмтгий ч харин амт сайтай үхрийн нүдтэй бялуу зэргийг бэлэглэлээ. Ашигүй тэд Петер бид хоёрыг муу хэлцгээх нь түр намдав. Бид хоёр ч жинхэнэ сайн найзууд болж, үргэлжид хамт юм ярин сууцгаана. Бусад хөвгүүдтэй ярихаас зайлсхиймээр зүйлийн талаар ярихад ч Петер намайг биеэ барихад хүргэдэггүй нь таатай юм. Жишээлэхэд л бид хүний цусны тухай хүүрнэхдээ эмэгтэйчүүлийн сарын тэмдгийн тухай санаа зоволгүй ярив. Бүсгүйчүүл бид түүнд яггүй бие сайтай юм шиг санагддаг гэнээ. Яагаад тэр юм бол?*

*Би энд маш сэтгэл хангалуун байх боллоо. Бурхан намайг үнсэнд хаягдсан шалз шиг орхисонгүй. Орхих ч үгүй биз ээ.*

*Анне*



# 1944 оны дөрөвдүгээр сарын 1. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Гэхдээ амьдрал хүнд хэвээрээ байна. Юу гэх гээд байгааг минь чи мэдэж байгаа шүү дээ, тийм үү? Сэтгэлд үүрд үлдэх ганцхан үнсэлтийг л би мөрөөднөм. Тэр намайг дандаа ингээд л жирийн найз шиг бодож явах гэж үү? Хүнд хэцүүг үүрч чаддаг, бас зовлонгоо хэнтэй ч хуваалцаж чаддаггүйг минь чи бид хоёр хоёулаа мэднэ шүү дээ. Би ийм юман дээр ээждээ хандах биш. Болдогсон бол одоо, Петерийн мөрийг налаад, хөдлөхгүй жаал суухсан. Тэр надад хайраа илчлэхгүй байгаа нь ганц ичимхий зангийнх нь гэж үү? Тэгээд яагаад зөвхөн надтай л байхыг хүсдэг юм бол? Тэгсэн мөртөө яагаад хайрын тухай нэгч үг хэлэхгүй байна вэ? Больё, нам тайван байя. Сэтгэлээ барин тэвчиж л байвал боллоо. Харин...нэг онцгүй юм нь гэвэл би л дандаа Петер рүү дээшээ гүйхээс биш тэр хэзээ ч над руу бууж ирэхгүй болохоор би л түүний хойноос гүйгээд байгаа юм шиг. Энэ уг нь өрөөний байршлаас л болж байгаа юм л даа. Петер ч үүнийг ойлгож байгаа. Гэхдээ улам ихийг ойлгох хэрэгтэй!*

*Анне*

### 1944 оны дөрөвдүгээр сарын 3. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Зөвхөн манай нуувчинд биш, бүх л Холланд, цаашилбал Европ тивд хүнс улам ховордсоор байгаа тухай чамд нарийвчлан бичмээр санагдав. Энд ирсээр өнгөрөөсөн хорин нэгэн сарын хугацаанд хоол хүнсний янз бүрийн үеийг үзэж өнгөрөөлөө. Тэр нь юу гэсэн үг болохыг чи одоохон сонсноо. “Хоол хүнсний үе” гэгч нь нэг хэсэг ганц л төрлийн юмыг идэх юмуу, эсвэл дан ганц ногоогоор гол зогоох үеийг л хэлж байгаа юм. Бид нэг хэсэг дандаа л эндивий гэх ногоог, хааяа төмстэй, ихэнхдээ төмсгүй шарж, хайрч идсэн. Бас нэг үе дан бууцайгаар өл залгаснаа больж хэдэн долоо хоног колдан идэв. Тэгснээ дахиад л хэдэн сараар мэхээр, өргөст хэмх, улаан лооль, байцаа гэх мэтийг улирлын байдлаар дан дангаар нь идэж байлаа. Өдөр ч, орой ч дандаа л давсалсан байцаа идээд байвал ямар байхав дээ. Бүр хоолой давмааргүй бол өлсөж байгаад ч болсон идээд байна. Одоохондоо бид шинэ ногоогүй хэцүү цаг болоод байна. Энэ үед бидний голлож өл залгуулах үдийн хоолны долоо хоногийн цэс нь: ногоон буурцаг буюу хүрэн вандуйны шөл, гуриланд өнхрүүлсэн төмс, нухсан төмсний бантан мэтхэн байснаа бурхны өршөөлөөр заримдаа шар манжин юмуу даршилсан лууван болж нэг өөрчлөгдсөнөө дахиад л хүрэн вандуйн шөл болон эргэнэ. Төмсгүй үдийн хоол бараг байсангүй. Талх ховордсоноос өглөөний цайнд ч төмс иднэ. Хүрэн, цагаан вандуйгаар шөл хийж, төмсөөр Юлианы, хатан хааны, хүрэн вандуйн гэх мэт нэрд гарсан бин хийж иднэ. Бас тэгээд вандуйгүй юм нэг ч үгүй. Талх ч вандуйтай, боов ч вандуйтай. Оройн хоолонд хиймэл шүүстэй төмс, азаар хараахан дуусчихаагүй байгаа улаан манжингийн шанцай иднэ. Өнхрүүшний тухай бас ярих хэрэгтэй. Бид түүнийг нэг гурилархуу юмыг хөрөнгө, устай зуурч хийнэ. Түүний нь наалданги, хатууг хэлэх юм биш. Ходоодонд яг л чулуу гэсэн үг. Тэгэхдээ яахав дээ, бусдыгаа бодохоор ховор юм болохоор сонин доо. Долоо хоногт хааяа амсах ёслолын хамгийн амтат зоогны нэг бол нимгэн зүсэм элэгний хиам буюу жимсний чанамал түрхсэн хатсан талх юм. Гэвч бид ямар ч гэсэн хоног сарыг өнгөрүүлэн, энэ хоолнуудаа амтархан идсээр байна.*

*Анне*

## 1944 оны дөрөвдүгээр сарын 4. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Юуны тулд би хичээл номоо орхилгүй, шамдан хичээллэж байгаагаа анзаарахгүй явжээ. Нэг бодоход дайн дажин төгсөх нь яагаа ч үгүй, төгсөх ч юмуу, үгүй ч юмуу гэдэг нь үлгэр шиг юм. Дайн хэрвээ энэ есөн сард дуусахгүй бол миний сургуульдаа явах бас л өнгөрч, мөн л хоёр жилээр улирчихгүй юмсан гэж чармайх л болох байх даа. Бүхий л өдрийн минь ухаан бодол, хүсэл мөрөөдлийг Петер, зөвхөн Петер л эзэлчихээд бямба гаригт бүүрч шаналах болов. Би түүний өрөөнд очоод суухаараа нулимсаа хүчлэн барина. Нимбэгний ундаагаа ууж буй Даан эзэгтэйтэй хааяа инээж хөхөрч суухад сэтгэл хөдлөн догдолно. Харин ганцаараа болмогц л дотроо онгойтол уйлах хэрэгтэй юм гэдгээ мэднэ. Заримдаа би зөвхөн унтлагын хувцастайгаа шалан дээр элэглэн хэвтэж, хэсэг мөргөснөө удалгүй тэр дэвсгэр гудас ч үгүй шалан дээр сөхрөн, тохойлдсон гараа дэрлэн уйлдаг байв. Эхэр татан уйлж байгаагаа өөрөө мэдмэгцээ, бусдад мэдэгдэхгүй юмсан гэж нулимсаа барьж, сэтгэлээ чангалан “Ямар ч гэсэн ухаарч сэхээрэхсэн. Тиймээ сэхээрэх...” хэмээн амандаа дахин дахин үглэдэг дээ. Биеэ хөшөөсөн тэр байдлаас салаад арай гэж орныхоо ирмэгийг түшин өндийж, оройн арав гучаас өмнөхөн орондоо нэг юм хэвтэнэ. Тэгээж л сэтгэлээ арай гэж онгойлгоно доо. Тиймээ, бүүр нэг тайвширна. Тэгээд л боловсрол мэдлэггүй харанхуй үлдчихгүйн тулд, үргэлж урагшлан хөгжихийн тулд, сэтгүүлч болохын тулд цаг мөчтэй уралдан сурах болно. Би юу бичиж чадахаа бичсэн, хэдэн өгүүллэгүүд маань зүгээр болсныг, өдрийн тэмдэглэлээ хойч үеийнхэнд нуугдсан еврей бидний инээдэмт амьдралыг бага ч атугай өгүүлж чадна гэдгийг бүгдийг мэдэж байна. Ямар ч гэсэн өөрийгаа авьяас билэгтэй эсэхийг харуулах хэрэгтэй. “Эвагийн мөрөөдөл” гэдэг өгүүллэг минь хамгийн сайхан түүх болжээ. Гайхмаар юмны нэг нь би түүнийгээ чухам юунаас сэдэвлэсэнээ санахгүйд оршино. “Кадийгийн амьдрал” маань ч бас гайгүй л шиг, ихэнхдээ гайгүй шүү л болж байна. Харин тэгэхдээ бүхэлдээ яагаа ч үгүй байна.*

*Энд би өөрөө өөрийгөө хайр найргүй шүүмжилдэг юм. Юу нь сайн, юу нь муу болсныг мэдэх болжээ. Юм бичдэггүй хүн бол бичнэ гэдэг нь хэчнээн нарийн ажил болохыг мэдэхгүй. Урьд нь би юм зурж чаддаггүйдээ ямагт харамсан гуньдаг байсан бол харин одоо бага ч гэсэн бичиж чаддагтаа баярлах боллоо. Ном буюу сонинд юм бичих авьяас дутлаа гэхэд өөрөө өөртөө л бичиж чадаж байвал боллоо шүү дээ.*

*Ямар ч гэсэн би урагшаа, өөдрөг явах хэрэгтэй. Аахар шаахар ажил хийсээр хожим нь мартагдчихдаг авгайчуул болон ээж, Даан хатагтай нар шиг амьдрана гэвэл ухаанд багтахгүй юм. Би нөхөр хүүхэдтэй байхаас гадна өөрийгөө бүхэлд нь зориулсан зүйлтэй байх хэрэгтэй! Ертөнцийн мөнх бусыг үзэвч, хорвоо дээр үлдээсэн ул мөртэй байхыг хүснэм. Тэгээд ч би оюун ухаанаа хөгжүүлж, сэтгэлдээ байгааг үгээр илэрхийлэн бичиж чадах авьяасыг надад байгал ээж бэлэглэсэнд хязгааргүй баярладаг юм. Бичихээр л зовлонгоо мартан, зориг зүрх орно. Харин би хэзээ нэгэн цагт хүмүүст хэрэгтэй утга учир төгс бүтээл туурвиж чадах болов уу? Өнөөх мөрөөдөл болсон сэтгүүлч, зохиолчийн аль нэг нь болж чадах болов уу? Чадна гэдэгтээ би итгэдэг, зүрх сэтгэлээсээ итгэдэг. Би бичгийн хэлээр өөрийнхөө бодол, өөрийнхөө үзэл, өөрийнхөө мөрөөдлийг цөмийг илэрхийлж чадна. “Кадийгийн амьдрал” маань нэг л урагштай болж өгдөггүй. Цааш нь юу бичих вэ гэдгээ*

*мэдэж байгаа атал яг бичээд эхлэхээр нэг л болж өгөхгүй юмаа. Тэр маань олигтой юм болохгүй бол хогийн хувин юмуу зуух руу орж ч мэдэх юм. Энэ бодол таатай би ч дөнгөж арван дөрөв хүрч буй, амьдралын туршилагагүй хүн яаж ч гүн ухааны юм бичиж чадах вэ дээ гэсэн нэгэн бодол харван орж ирэх юм. Ямар ч байсан сэтгэлээр унахгүй шүү. Аз ч дайрч болно. Бичиж л байх минь!*

*Анне*

## 1944 оны дөрөвдүгээр сарын 6. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Миний онцлон сонирхож дурладаг зүйл юу болохыг асуусан бол би түүнд чинь хариулмаар санагдав. Тун олон зүйл тоочих тул бүү айгаарай гэж сануулъя. Юуны өмнө бичих. Гэхдээ энэ бол дураа хүрэхээр оролддог зүйл биш.*

*Хоёр дахь нь язгууртан сурвалжтануудын удам судрын түүх. Бүх сонин сэтгүүл, ном судар, сурвалж бичгээс би франц, герман, испани, англи, австри, орос, норвеги, холландын сурвалжит гэр бүлүүдийн тухай материалыг эрэн шүүрдэж, түүнийгээ түүвэрлэн, бас түүх намтрын номноос уншиж, тэмдэглэсэн зүйлсээ хавсарган янзалсан. Ийнхүү түүнийн тодорхой нэг үеийг хуулан бичиж, эмхэтгээд байна. Тэгэхлээр гурав дахь сонирхдог зүйл маань түүх юм. Аав ч олон сайхан холбогдох ном худалдан авч өгсөн. Би эндээс гарч, нийтийн номын санд орж, сонирхсон зүйлсээ ном судраас онгичих өдрөө хүлээж чадалгүй, оролдсоор сууна.*

*Дөрөв дэх хобби гэвэл эртний грек, ромын үлгэр туульс байна. Тэр талаарх олон ном надад бий. Бас кино оддын болон тэдний гэр бүлийнхний зураг цуглуулдаг. Ном цуглуулах болон уншихад донтож, зохиолч яруу найрагч, зураач хийгээд ер нь урлагтай холбоотой юмыг бүхэлд нь сонирхоно. Магадгүй, сүүлд хөгжим ч сонирхож мэдэх юм.*

*Тоо, алгебр, геометрийг бодохоос толгойтой үс арзайна. Бусад хичээл бүхэн надад зугаатай, гэвч түүх л бүхнээс сонин!*

*Анне*

## 1944 оны дөрөвдүгээр сарын 11. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Толгой тархи минь дүүрэн байна! Юунаас эхлэхээ мэдэхгүй сууна. Тав дахь өдрийн үдээс хойш болон хагас сайн өдөр бүгдээрээ баахан тоглоцгоов. Өдөр хоног нэг л янзаар урссаар дорхиноо өнгөрөн одож байна. Бүтэн сайн өдөр би Петерийг над дээр орооч гээд орж ирэхээр нь хэсэг өрөөндөө хамт сууснаа дээш гарч тэндээ зургаан цаг хүртэл байсан. Оройн зургаа арван таваас долоо хүртэл Моцартын маш сайхан концертийг радиогоор нэвтрүүлэв. Надад “Шөнийн бяцхан уянга” нь үнэнхүү онцгой санагдлаа. Сайхан хөгжим сэтгэл хөдөлгөөн баясгадаг боловч би олон хүний дэргэд биеэ барин, сэтгэл зүрхнээсээ амтархан сонсож чаддаггүй юмаа.*

*Бүтэн сайн өдрийн орой Петер бид хоёр хамтдаа дээврийн агуулах руу очив. Тухтай сууцгаах гэж манай өрөөнөөс ганц хоёр жинтүү аваачин, түүнийгээ хайрцаг дээр дэвсээд шахцалдан суув. Муши муужгай бид хоёрт хань болов. Тийн хаая хүүе гэх хүнгүй тайван суутал гэнэт найм дөчин тав орчимд Даан гуан дуу гарч, Дусселийн дэрийг авсан эсэхийг асуув. Бид ч огло үсэрцгээн жинтүү, муураа аваад Даан гуайтай хамт доош буулаа. Тэр жинтүүнээс болж бөөн шуугиан дэгдэв. Дэрлэж унтдаг жинтүүний нь нэгийг бидний авч явсанд Дуссел эмчийн уурласан гэж жигтэйхэн. Жинтүүндээ нохой бөөс орсон байх гэж айсан тэр хэчнээн шуугиан тарьсан гэж санана. Хэлдэг юм биш. Петер бид хоёр түүнээс өшөө авах гэж дэвсгэр доор нь овоо ширүүн үстэй хоёр сойз шургуулж бөөн хөхрөлдөөн болов.*

*Бидний зугаатай явдал удахгүй төгсөх нь тэр. Ес хагаст Петер харин хаалга тогшиж, англи хэлнийхээ хүндхэн өгүүлбэрт туслаач гэж аавыг гуйв. Би тэгэхэд нь Марготод “Ээ дээ, юу л бол. Туслуулна барина гэдэг ч худал байх аа” гэв. Миний таавар зөв байжээ. Дэлгүүрт хулгай оржээ. Аав, Петер, Даан гуай, Дуссел нар яах ийхийн завгүй тийшээ очицгоов. Ээж, Маргот, Даан эзэгтэй бид дөрвөн эмэгтэй тэднийг хүлээж хоцров. Бид дөрөв айж сандарснаа мартагнах гэж дэмий л ярьж гарлаа. Тэгтэл доор нэг юм тус тас гээд чимээгүй болчихов. Цаг ч ес дөчин тав болов. Бид бүгд царайгаа цонхийлгон, нам гүм дагжин сууцгаав. Эрчүүд маань хаачив? Юу тас няс гэдэг билээ? Тэд нар маань хулгайчтай үзэлцэж байгаа юм болов уу? гэсэн янз янзын асуулт тавин сууцгаалаа. Арван цагт харин хүний хөлийн чимээ гаран, аав цонхигор царайлан ууртай нь аргагүй Даан гуайг дагуулсаар орж ирэв. Тэгээд гэрлээ унтраа, чимээгүй дээшээ гарцгаа, цагдаа ирнэ гэв. Юун айж сандарлаа гэхтэй манатай, ум хумгүй гэрлээ унтраацгаан, гарт дайралдсаныг авч нөмрөн дээш гарцгаав. Дээр очмогцоо “Тэгээд юу болсон бэ? Хурдан яриа ч ээ” гэж гуйлаа. Гэвч ярьж хөөрөх завдал ч гарсангүй. Эрчүүд дахиад л доош буув. Арван цаг арав болоход нөгөө дөрөв дээш гарч ирэв. Гудамж руу ордог хаалга, эргэдэг тавиур бүхий үүдийг хан ян түгжиж, хоёр нь Петерийн онгорхой цонхон дээр харуулд гарав. Тэгээд ингэж ярьцгаав. Петерийг дээр сууж байтал хүчтэй түн тан хийх сонсогджээ. Тэгэхээр нь тэр доош бууж харвал агуулахын хаалганы зүүн хавтасны нэг самбар уначихсан байжээ. Санд мэнд дээш гүйж гаран, эрэгтэйчүүдэд хэлээд доош буужээ. Тэгтэл тэд агуулахыг түйвээж байгаа хулгайч дээр яг орчихжээ. Гэтэл Даан гуай яах ийхийн тухгүй “Цагдаа!” гээд хашигирчихаж. Хулгайчид ч яаран зугтсан байна. Цагдаагийн эргүүл тэр онгорхойг харчихаад бөөн юм болох*

вий гэж бодоод тэд хаалганы унасан самбарыг эргүүлж бөглөнгүүт нэг хүн гаднаас нь хүчтэй гэгч өшиглөн унагажээ. Мань дөрөв ч сандарч орхисон нь мэдээж. Даан гуай хүүтэйгээ болдогсон бол тэр эрийн бодийг нь хөтөлчих байсан гэнэ. Даан сүхээрээ газар балбаж байтал удалгүй нам гүм болжээ. Хаалганыхаа самбарыг бэхэлье үү гэтэл бас нэг гай учирчээ! Юу гэвэл гадаа нь зогсож байсан сэтгэлтэй хос гар чийдэнгээр өрөөг гэрэлтүүлжээ. Тэгэхээр нь манай эрчүүдийн нэг нь “хараал идмэр” хэмээн шивнэжээ. Тэгээд цагдаагийн дүр үзүүлж байснаа болиод мань хэд хулгайчийн дүрд хувирчээ. Манай дөрөв дээш гаран Петер гал зуух, эзний конторын үүдийг онгойлгож утсыг нь авч шалан дээр чулуудаад нуувчиндаа оржээ. Эхний явдал ингэж дуусчээ.

Сэтгэлт хосууд цагдаа дуудах нь лавтай байлаа. Энэ нь ядаж улаан өндөгний баярын орой, бүтэн сайн өдрийн үдэш орой байв. Баярын дараа өдөр нүүсэнд хэн ч ирэхгүй тул нүрээв гариг хүртэл бид сэтгэл амар байх аргагүй болов. Хоёр шөнө, нэг бүтэн өдөр ийнхүү айж дагжин сууна гэдгийг чи бодоод үз! Арав хагас, төдөлгүй арван нэгэн цаг болов. Чимээ байдаггүй. Тэгтэл арван нэгэн цаг арван таван минутад доор чимээ гарав. Хүн бүхэн бусдынхаа амьсгааг сонсохуйц чимээгүй таг чиг болов. Гаднаас орж ирж буй хүмүүсийн хөлийн чимээ, эхлээд байшинд, дараа нь гал тогоонд...бүүр сүүлдээ манайхны шатан дээр гарав. Хүн бүхэн амьсгаагаа даран, зөвхөн л найман зүрх түг түг цохилон байлаа. Тэгтэл мөнөөх алхаа бидэн рүү ордог шүүгээн хаалганы тушаа тачигнав. Энэ эгшнийг үгээр дүрсэлж чадашгүй нь ээ. “За, ингээд л өнгөрдөг байж дээ” гэж бодов. Энэ шөнө бид бүгд гестапогийнханд чирэгдэж яваа маань нүдэнд минь харагдах шиг боллоо. Шүүгээн хаалгыг хоёр ч удаа түлхэх сонстож, бас юм унах дуулдав. Тэгснээ нөгөө хөлийн чимээ холдоод явчихав. Аюул түр ч болов холдов. Манайхан их багагүй айсандаа чичирцгээн эрүү шүд нь хавьжигнах нь сонсогдов. Үг дуугарах сөгөөтэй хүн нэг ч байсангүй. Байшин чимээгүй болсон ч шүүгээ хаалга бүхий хонгилын гэрэл асаастай чигээрээ хоцров. Сайхь шүүгээ сэжигтэй харагдав уу? Эсвэл цагдаа гэрлээ унтраахаа мартав уу? Унтраах гэж хэн нэг нь дахиж ирэх болов уу? гэсэн бодолд өөрийн эрхгүй автдаг юм байна. Байшинд хэн ч байхгүй юм шиг болоход сая хэл амны ээдрээ арилав. Гэвч гадаа үүдэн дээр цагдаа зогсож байхыг үгүй гэх газаргүй ажээ. Бүгд айснаас чичирсээр байв. Даарахад нус, яарахад шээс гэгчээр хэн хүнгүй л морь хармаар болов. Хувин дээвэр дээр байсан бөгөөд Петерийн барьж ирсэн цаасны төмөр хувингийн хэрэг гарав. Даан гуай эхэлж, аав дараа нь бие засав. Ээж ичээд байгаа бололтой. Ээж, Маргот, Даан эзэгтэй биднийг учраа олог гэж аав хувинг өрөөнд оруулав. Маргот, Даан авгай, бид гурав дуртайяа бие засав. Дараа нь бас ээж ч бие засав. Тэгтэл цаасны хэрэг гардаг байна. Азаар би жаахан цаас хармаалсан байлаа. Саван дахь өтгөн шингэний үнэр ханхлан, бид дэмий л шивнэлдэцгээнэ. Бидний ядарсан гэдэг тоймгүй. Шөнийн арван хоёр цаг болов. Шалан дээр хэвтээд унтацгаа гэх нь дуулдав. Маргот бид хоёрт дэр, орны бүтээлэг өгөв. Марготыг шүүгээний урдуур хэвтэхэд би дэргэдэх ширээнийхээ хөлний хоорондуур хажуулав. Шалан дээр хэвтэхэд өнөөх хувинтай юмнаас ханхлах үнэр гайгүй байв. Даан эзэгтэйг жаахан хажуулаад босож сандал дээр суухад Даан гуай хөлийг минь дэрлэн шалан дээр хэвтэв. Бүх юм дахин бодогдоод Даан гуайг дугхийхээр бие чичирнэ. Цагдаа буцаж ирвэл яах вэ гэж айсандаа бодов. Хэрэв сайхан сэтгэлт Холланд хүмүүс байвал аварна. Харин нацистууд байвал хахууль өгнө дөө! гэж бодов.

Тэгтэл Даан эзэгтэй “Радиоогоо нуугаарай” гэв. Даан гуай тэгэхэд “Тэгье, гал тогоонд нууцгаая. Нээрээ тэд биднийг олох юм бол түүнийг бас олно л доо” гэв. Аав:

-Аннегийн өдрийн тэмдэглэлийг ч бас олох байх даа гэвэл манайхны хамгийн аймхай нэг нь:

-Шалавхан шатаагаач гэв. Энэ нь цагдаа нар шүүгээ түчигнүүлэн байгаатай адил аймар сонсогдов. Намайг тэсэж чадалгүй:

-Үгүй! Миний өдрийн тэмдэглэл надтай хамт өнгөрөх болно! гэхэд аав юу ч дуугарсангүй. Бурхан өршөө. Миний санаанд тодоос тод ул мөрөө үлдээсэн тэр бүх яриа хөөрөөг энд бичихийн хэрэггүй бизээ. Мөн ч их маргалдацгаасан даа. Айж сандарсан би Даан авгайг аргадаж тайвшруулав. Бид Геспотагийнхны байцаалт, мөрдөлт, тэднээс оргож зугатаах болон аливаад зориг самбаатай байх тухай хүүрнэлдэв. Даан гуайн авгайд хандан:

-Эзэгтэй, бид яг л тулааны талбарт байгаа цэрэг шиг л байх хэрэгтэй! Тэгвэл “Ораня” нэвтрүүлэгт хэлдгээр хатан хаан, эх орон, эрх чөлөө, үнэн шударга ёсны төлөө байх болно шүү. Цорын ганцхан гайхмаар юм гэвэл, бид тэр бүхнээ золгүй явдал руу аваад одож болох юм гэв.

Даан гуайг авгайтайгаа байраа солиход аав маань над дээр ирэв. Эрчүүд тасралтгүй тамхи татаж, үе үе гүнээ санаа алдах нь сонсогдон, хэн нэг нь хувин дээр мордох нь дуулдана. Энэ байдал эргэн давтагдсаар дөрвөн цаг, таван цаг, тав хагас болов. Би Петерийн өрөөнд очив. Бид хоёр цонхон дээр шахцалдан, чимээ анир чагнан, бие биесийхээ чичрэхийг мэдрэн суув. Бид хааяа ганц нэг үг сольцгоон сонор соргог суулаа. Зэргэлдээх айл хөшигөө татав.

Өглөөний долоод эрчүүд хэн нэгнийг ирүүлээч гэж гуйхаар ноён Коофуйсыг утсаар дуудах юм болцгоов. Тэд утсаар түүнд хэлэх гэсэн үгээ бичив. Агуулах руу ордог гадна хаалган дээр суугаа манаач утасны дууг сонсох юм бол цагдаагийнхан буцаж ирж болох нь бүүр ч осолтой билээ. Коофуйст хэлэх үг нь “Хулгай орлоо. Цагдаа нууц хаалга бүхий шүүгээ хүрээд буцлаа. Хулгайч сандрахдаа агуулахын хаалгыг цөм цохиж, цэцэрлэг рүү зугтсан байж таарна. Гол хаалга түгжээстэй байснаас ноён Кралер хоёр дахь хаалгаар гарч явсан болог. Бичгийн машинуудаа эзний конторын төмөр авдранд хийсэн нь дээр. Хенкэд хэл хүргэж, Эллигээс түлхүүр авахуулан, муурын хоол дөхүүлэх нэрээр нүүр рүү ирүүл.”

Ашгүй бүгд л хүссэнээр болжээ. Коофуйс гуайд дээр бидэн дээр байсан бичгийн машинуудыг доорхи эзний өрөөний төмөр шүүгээнд хийсэн тухай хэл өгөв. Бид ширээ тойрон, Хенк ирдэг болов уу эсвэл цагдаа ирдэг болов уу гэж түгшин хүлээж суулаа. Петер зүүрмэглэн, Даан гуай бид хоёр шалан дээр хэвтэж байв. Тэгтэл доор хүний хөлийн хүнд чимээ сонсогдов. Намайг “Ашгүй Хенк ах!” гээд сэмээрхэн босоход манайхны нэг нь:

-Үгүй биш. Цагдаа байна! гэв. Нэг хүн хаалга тогшин, Мийпийн исгэрэх сонсогдов. Даан хатагтайн царай цонхийн, сандал дээр хөдлөх тэнхээгүй сууж байлаа. Хэрвээ тэр түгшүүрт байдал дахиад минут хэртэй үргэлжилсэн бол эзэгтэй ухаан алдах байв. Мийн, Хенк хоёрыг орж ирэхэд бидний сууж байгаа өрөө тасалгааг ямар байсан гэж санана. Зөвхөн ширээн дээр байгааг харахад ойлгомжтой. Чанамал жимс барьсан ганган бүжигчний хөрөг бүхий дэлгээстэй “Кино ба театр” гэдэг сэтгүүл, чанамал жимсний хоёр шил, бүтэн хагас талх, толь, сам, шүдэнз, үнс, янжуур, үнсний сав, тамхи, эмэгтэй хүний гэрийн халат, гар чийдэн, жорлонгийн цаас ундуй сундуй хөглөрнө. Хенк, Мийн хоёрыг хараад л бөөн баяр хөөр, уйлаан майлаан болцгоов. Хенк өнөөх онгорхойг модоор таглаад



тэр явдлыг цагдаагийн газар ойлгуулахаар одов. Мийн харин тэр онгорхойг үзэж, цагдаад хэл хүргэсэн тухай мэдээг агуулахын хаалган доороос олжээ. Хенк бас л түүн рүү очих болов. Хагас цаг хэртэй хугацаа өнгөрөхөд би байраа эмхэлж цэгцлэн, хэвийн байдалдаа орцгоов. Хагас цагт бид хэзээ ч тэгээж бүх юмаа амжуулж үзээгүй юм. Маргот бид хоёр доош бууж, ор дэрээ янзлан, жорлонд орж угаалга цэвэрлэгээгээ хийн, үсээ самнав. Дараа нь өрөө тасалгаагаа жаахан янзлаад дээш гарахад ширээн дээрх юмсыг аль хэдийнэ хурааж янзалсан байв.

Бид ус авчран, кофе чанаж, өглөөнийхөө цайны ширээг засав. Аав, Петер хоёр өнөөх хувингуудад байсан өтгөн шингэнийг асган, хлортой халуун усаар цэвэрлэжээ. Арван нэгэн цаг гэхэд бид тайвширцаан, Хенктэй хамт ширээ тойрон суухад тэр:

-Нэг үл таних авгай манай шөнийн эргүүл Слатер Уай дээр ирж, нөхрөө муу завьтайгаа хотын сувгаар явахдаа манай үүд цөм цохигдсоныг хараад, цагдаа авчран пүүсний бүх л өрөө тасалгаагаар орж үзсэн гэж ярьжээ. Хоёр дахь өдөр л Кралер гуайнд очиж мэдэгдье. Тэр цааш нь ярина байх. Булангийн ногоочныхоор орж, хулгай орсныг яривал өнөөх номой эр “Би мэдсэн. Өчигдөр эхнэртэйгээ танай пүүсийн дэргэдүүр өнгөртөл хаалга тань цөм цохиулсан байна билээ. Авгай маань харчихаад бушуухан шиг холдье гэсэн. Харин би тэссэнгүй гар чийдэнгээр гэрэлтүүлж үзсэн. Тэгтэл хулгайчид нь түр тар гээд л зугтчихсан. Танайхныг нэг л өөр байна уу гэж санадгаас юу ч болж мэднэ гээд цагдаа дуудсангүй. Гэхдээ би тодорхой юм мэдэхгүй шүү. Харин тэгэхдээ та нарыг нэг л зүгээргүй гэж боддог шүү!” гэсэн гэв. Хенк тэгэхэд нь талархаад гарчээ. Тэрээр биднийг энд байгааг гадарлаад, үдийн хоолны төмс залгуулдаг байх нь ээ! Сайн эр.

Хенкийг гарч одоход бид сав суулгаа угаан, үдийн нэг цагийн хэрд цөм унтахаар хажуулав. Гурав дөчин тавд сэрээд харвал Дуссел арилаад өгсөн байв. Нүүрээ угаах санаатай нойрмог царайлан явтал Петер мөн л нүүрээ угаах санаатай явж байгаад гэнэт тааралдав. Бид доор уулзахаар болзлоо. Үс толгойгоо хурдхан самнаад доош буувал Петер:

-Агуулахад очвол чи айхгүй биз гэв. Би зөвшөөрөөд тухтай суух гэж дэрээ аваад буув. Гадаа хэчнээн сайхан байсан гэж санана. Удалгүй түгшүүрийн дохио хангиналаа. Бид хоёр тэндээ сууж л байлаа. Петер нэг гараараа мөрөөр минь тэвэрсэнд би ч бас түүнийг тэврэв. Тэгээд биднийг кофегоо уу гэж хэлэхээр Марготын ирэн иртэл тэврэлдэн суулаа.

Бид талх идэж, жүржсийн ундаа уун, жаахан төрхгүйтэв. Өөр гойд юм ч болсонгүй. Бүхнээс илүү зоригтой байсанд нь би Петерт талархав. Бидний хэн нь ч өнгөрсөн шөнийх шиг аюулд учирч явсангүй. Ёстой л тэнгэр биднийг тэтгэжээ. Бүр шүүгээн хаалга хонгилд цагдаа ирж гэрэл асаасан мөртөө юу ч анзааралгүй яваад өгсөн гэж бодоод үз л дээ.

Чөлөөлөлт хэрэв бөмбөгдөлтөөр эхэлбэл хэн хүнгүй л хар амиа бодох хэрэгтэй болно доо. Тэгэхэд ч муу хоргодох байр маань бас л хөөрхийлөлтэй бидэндээ нөмөр болно бий! Тэрхэн мөчид бид яацаах бол? Өчигдөр хулгай орсноос болж мөн л их юм өөрчлөгдлөө. Дуссел эмч орой бүр ноён Кралерийн өрөөнд суудгаа больж, угаалгын өрөөнд суух болов. Оройн найм хагас, ес хагас болоход Петер эргүүл хийж байгаа нь энэ гэж өрөө тасалгаагаар явдаг болов. Петерийн цонх онгорхой байдгийг болиулав. Оройн есөн цагаас хойш жорлонгийн ус татахыг зөвшөөрөхгүй боллоо. Өнөө орой агуулахыг хаалгыг бөхөлж бэхлүүлэхээр нэг

мужсаан ирүүлэв. Кралер ер нь бидний болгоомжгүй байгааг зэмлэж, Хенк ийм байдалд бидний хэн нь ч доошоо бууж болохгүйг анхааруулав. Бид дүрвэж амь хоргодсон хувь тавилангүй еврейчүүд учраас тайлбар хийх эрхгүй, үг дуугүй байх үүрэгтэйгээ хатуу санав. Еврейчүүд бид дураараа байж болохгүйг, гонгинолдолгүй сэтгэл чангахан байж, хувь тавилангаар оногдсон лай ланчигаа эдлэн, хэрээрээ байж, бурханд залбирах хэрэгтэйгээ л мэдлээ. Энэ аймшигт дайн нэг л өдөр дуусаж, бид зөвхөн еврейчүүд биш хүн гэдгээ мэдрэх цаг ирнэ дээ. Хэн биднийг ингэж ялгаварлаж эхлэв ээ? Хэн нь еврейчүүд биднийг улс түмний дундаас онцгой ялган золиослох болов оо? Хэн биднийг өдий хүртэл ийнхүү зовоон шаналганам бэ? гэвэл тэр нь бурхан ажээ. Бас бурхан л биднийг энэ зовлонгоос ангижруулна. Газар дэлхий, хүн ардаас сайныг нь суралцах, түүнийхээ төлөө өөрсдөө зовох ёстой гэдэг нь магадгүй зөвхөн еврейчүүд бидний бодол, сүжиг болохыг хэн мэдэх билээ. Бид дангаараа Холланд, Англи эсвэл ямар нэгэн өөр орныг хэзээ ч төлөөлж чадахгүй. Бид хэзээний л еврейчүүд хэвээрээ байна, ийм байхыг ч хүсдэг. Зоригоо чангалагтун... Бурхан еврей хүн ардыг хэзээ ч зовлонд орхиж байгаагүй юм. Улиран одох тэр он жилүүдэд еврейчүүд хүчирхэгжин батажсан. Сул дорой нь устан талийхад, амьдрах чадвартай нь үлдэн үндэс угсаагаа тасалсангүй!!! Би өнгөрсөн шөнө ингээд л үхэх ёстой болж дээ гэж бодлоо. Цагдааг ирэхийг хүлээж байхдаа яг л тулалдааны талбар дахь цэрэг шиг шийдчихээд байлаа. Хэрэв амьд үлдэж, дайн дуусгавал Холландын харьяат болох минь гэж хүсч байна. Би Холланд хүмүүс, эдний болон миний эх орон Холланд нутаг, Холланд хэлэнд хайртай. Энд л ажиллахсан гэж хүснэм. Сансандаа хүрэлгүй замынхаа дундаас буцахгүй юмсан. Шаардлагатай бол энэ тухайгаа Холландын хатан хаанд ч бичнэ!

Би улам бүр эх, эцгээсээ хараат биш болсоор байна. Хэдийгээр би балчир ч гэсэн надад ээжээс илүү амьдрах зориг, өөртөө итгэлтэй зан төрх, сэтгэлгээ байна. Би өөрийн гэсэн зорилго, үзэл бодол, итгэл биширэл, хайрлах юмтай. Намайг байгаагаар минь л байлгаач. Тэгвэл л болох нь тэр. Би өөрийгөө дотоод сэтгэлийн хүч чадал зориг бүхий эмэгтэй хүн гэдгийг бас мэднэ. Бурхны ивээлээр хэрэв амьд үлддэг юм бол ээжийн хүрснээс илүүд хүрнэ. Энэ амьдралаа зүгээр нэг утга учиргүй өнгөрөөхийг хүсэхгүй байна. Хүмүүсийн сайн сайхны төлөө ажиллах болно! Зориг, өөдрөг сэтгэл бүхнээс чухал гэдгийг би мэдэж байна!

Анне

## 1944 оны дөрөвдүгээр сарын 14. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Нуувчныхан өнөөдөр нэг л тавгүй байна. Аав яагаад ч юм бэ дэвэрч буцалдаг дээрээ хүрч, эзэгтэй салхи цохиулж хэвтэрт орон, Даан гуай тамхигүйдсэндээ царай алдаж, Дуссел эмч тухгүйтсэндээ бухимдах юм. Бүх юм нэг л авцалдаж өгөхгүй байна. Жорлонгийн хаалга гажиж, усны крантыг хэт мушгичихжээ. Танил талын ачаар аль алинийг нь дор нь засуулав.*

*Би уян зөөлөн байхаа больжээ. Петер бид хоёр шороо тоостой дээврийн шувуу модны хооронд хаа нэгтэй модон хайрцаг сандайлаад, бие биесээ налан хүзүүдэн суудаг боллоо. Тэгэх үед Петер үсний минь долгиотсон хэсгээр оролдон, хоёулаа шувуудын уянгалан жиргэхийг сонсон, моддын ногоорох, наран ээх, үүлгүй тэнгэрийн хөхрөх зэргийг харахад хэчнээн гэгээн сайхан хүсэл мөрөөдөл оргилдог гээч!*

*Тэнд л бухимдах царай, уцаарлах дууг сонсох нь үгүй. Харин тэгэхэд доор байранд бол хэнгэнэтэл санаа алдах, яришгтай үглэж дуулах сонстон, бид чинь ямар тахилыг нь буруу өрчихөв гэмээр л юм болно. Тиймээ аливаа муу бүхнийг хүн өөрсдөө хийдэг шүү дээ. Энэнийг л дууриахсан гэж үлгэр авах хүн манай нуувчинд алга. Бүгд өөрийнхөөрөө л байх гэж загнана. Өдөр бүр л их багагүй эндээс хэзээ нэг гарч амардаг бол гэгцгээх боллоо.*

*Намайг хийх ажил, итгэл, хайр дурлал, зориг зүрх маань л хөл дээр минь зогсоож, сайн сайхан, аз жаргалтай болгоном. Китти минь, өөрийнхөө бичсэнийг үзэхэд би чинь яльгүй мунгинаад байх шиг байна. Яагаад тийм болсноо ч мэдэхгүй юм. Бичсэн юм маань нэг л эрэмбэ дараалалгүй санагдан, хоорондоо ямар ч холбоогүй юм шиг харагдаад, үүнийг хожим нь хэн нэг нь сонирхох болов уу даа хэмээн үнэн сэтгэлээсээ эргэлзэх үе байдаг юм. Үүнийгээ би “Нугасны муухай дэгдээхэйн сэтгэлийн үг” гэж нэрлэхээр шийдлээ. Болкештайн, Гербранди мэтийн ноёд миний өдрийн тэмдэглэлээс нэг ч их юм олохгүй бизээ.*

**Анне**

## 1944 оны дөрөвдүгээр сарын 15. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Нэг аюулын дараа бас нэг аюул гараад ирэх юм. Энэ бүхэн хэдийд дуусч амраадаг бол? Ямар нэг золгүй явдал учирч болно гэдгийг хэрхэвч мартаж болохгүй. Орох хаалганы түгжээг шөнөд нь дотроос нь түгжээд, өглөө онгойлгож орхихоо Петер мартжээ. Өөр нэг хаалганы нь цоож эвдэрчихсэн билээ. Үүнээс болж ноён Кралер ажилчидтайгаа байшинд орж чадахгүй болжээ. Тэр хөршийнхөөрөө дамжин гал тогооны цонхыг хагалж ороод хаалга тайлжээ. Ноён Кралер бидний унхиагүй мартамхайд уурсав. Петер гэмисэндээ огт өөр болов. Ээжийгээ үг хэлэхэд гоморхон нүдэнд нь нулимс гүйлэгнэв. Чухамдаа бол бид бүгдээрээ л буруутай бус уу. Уг нь эрчүүд өдөр бүр түгжээгээ онгойлгосон уу гэдэг байв. Гэтэл урьд шөнө хэн ч асуусангүй мартжээ. Түүнийг би л бага ч гэсэн тайтгаруулж магадгүй юм. Петерт туслах хүсэл надад хэчнээн их байна вэ.*

*Сүүлийн долоо хоногуудад манай энд болсон явдлуудаас мэдээлэхэд: Моффи мий өвдөж, хөдлөх ч үгүй шүлсээ цувуулан хэвтэв. Мийн түүнийг авчуурт боон, хоолны цүнхэнд хийж, малын эмчид аваачив. Эмч дотор нь өвдсөн байна гээд эм өгчээ. Эмээ ууснаас хойш Моффи гэрийн бараа харахаа болин, үргэлж л энд тэнд хань ижлээ эрэн давхих боллоо.*

*Агуулахын цонхыг шөнө бүр онгорхой үлдээдэг тул Петер бид хоёр оройжингоо тэнд суух болов. Коофуйс гуай жаахан тосон будаг олж тус болсноор жорлон хуучин хэвэндээ орлоо. Эвдэрсэн крантыг авч шинийг хийв. Энэ сард бидэнд наймхан ширхэг хүнсний карт олджээ. Маатан чихэр бидэнд шинэ амттан болов. Аз хаяхад шилэнд хэдхэн ширхэг өргөст хэмх үлджээ. Ногоо бүүр тасрав. Үдийн хоол маань хуурамч цуу төдийхөнтэй дан ганц төмснөөс хэтрэхгүй болов.*

*Хэчнээн ч их бөмбөгдөнө вэ дээ. Ден Хааг гэдэг газар хотын зөвлөлийн байшин дээр бөмбөг унаж, маш их баримт бичиг утсан гэнэ. Бүх Холландчууд шинэ паспорттой болох юм байх. За, өнөөдөр ингээд дуусах шив дээ!*

**Анне**

*Хайрт Китти минь!*

*Өчигдрийг чи хэзээ ч мартаж ёсгүй. Яагаад гэвэл тэр бол миний бүх насанд ганц л тохиолдох өдөр минь байсан. Охидын хувьд амьдралдаа анх удаа таалагдсан хөвгүүндээ үнсүүлэх нь утга учиргүй гэж үү? Баруун хацрыг минь нэг удаа ноён Брам, гарыг минь ноён Валкер үнссэнийг үнсэлт гэхгүй бизээ.*

*Анх удаагаа санамсаргүй түүнд хэрхэн үнсүүлснийг минь чи сонс л доо. Би өчигдөр орой найман цагт Петертэй буйдан дээр нь зэрэгцэн сууж байлаа. Тэр минь урьдынх шигээ хүзүүгээр тэврэн суув. Намайг “Чи жаахан цаашлахгүй юу. Миний толгой хайрцагт тулаад байна.” гэхэд Петер буйдангийн хашилага хүртэл цаашлав. Намайг гараа суган доогуур оруулан ойртвол тэр мөрөөр минь чанга тэврэв. Бид уг нь бүшгүйдээ л шахцалдан суудаг л даа. Гэхдээ өчигдрийнх шиг тэгээж шахцалдан сууж байсангүй. Түүнийг цээжийг минь өөр рүүгээ татахад зүрх минь урьд өмнө байгаагүйгээр цохилсон атлаа нэг л таатай байв. Мөрөө дэрлүүлэн, миний толгойг толгойгоороо түшин суугаа нь ч Петерт холдоод байх шиг байв. Би түүнийг налахаа больж биеэ тэгшилээд таван минут хэртэй сууж байтал Петер гэнэт толгойг минь хоёр гараараа барин, өөр рүүгээ татав. Хэчнээн сайхан байсан гээч. Тэрхэн мөчийн жаргалыг үгээр дүрсэлж чадахгүй нь. Петер миний хацар, гарыг эв дүйгүйхэн илж, мушгиран унжсан үсээр минь хэсэг зуур оролдоход бидний толгой өөрийн эрхгүй ойртоцгоов. Китти минь, тэрхэн үед бүхэл биеэр минь түгсэн сэрлийг би чамдаа бичиж чадахгүй нь. Би мөн ч их аз жаргалтай байсан. Петерийг ч бас тийм байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Найм хагасын хэрд бид суудлаасаа босов. Петер пүүсний байшин дотуур явж эргэхэд нь чимээ гаргахгүй байх гэж биений тамирынхаа шаахайг өмсөв. Би зогссоор л байв. Харин намайг гарч буух гэж огцомхон баруун тийшээ эргэхэд...би бас сайн санахгүй байна...Петер хацраас минь зүүнтэйгүүр, чихэн дээр унасан үсийг минь үнсэв. Би эргэж харалгүй доошоо гүйв. Би одоо өнөө оройг хүлээж ядан сууна.*

**Анне**

## 1944 оны дөрөвдүгээр сарын 17. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Аав, ээж маань арван тав хүрэхтэй үгүйтэй охиноо хүний арван долоо хүрсэн хөвгүүнтэй нэг буйдан дээр тэврэлдэн сууж үнсүүлэхийг зөвшөөрнө гэж чи бодож байна уу? Би л лав тэднийг зөвшөөрнө гэж бодохгүй байна. Гэхдээ би өөрөө өөрийгөө мэдэх болсон шүү дээ. Түүний гарыг дэрлэн, элдвийг бодлогоширон хэвтэх шиг сайхан юм, хацрыг нь өөрийнхөө хацарт хүрэхийг мэдрэх шиг сэтгэл догдлуулсан юм, хэн нэгэн хүн намайг хүлээж байх шиг сайхан юм үгүй бус уу!*

*Гэхдээ, гэхдээ гэдэг үг заавал байх ёстой. Петер энэ явдлыг ингээд л больчих юм биш байгаа? Би түүний өгсөн амлалтыг мартажгүй. Гэхдээ тэр ямар ч гэсэн...эр хүн шүү дээ. Ийм харьцаа надад арай эртдэж буйг, арван тав хүрэв үү үгүй юү бусад хүний санаанд оромгүй ийм бие даасан байдалтай байгаагаа би сайн мэдэж байна. Би Маргот эгчийгээ дурлал хайр юм уу гэрлэх суух тухайгаа ярилцалгүйгээр хэн нэгэн хөвгүүнд хэзээ ч ингэж үнсүүлэхгүй гэдгийг баттай мэднэ. Петер бид хоёрт тэр тухай бодсон юм алга. Ээж ч гэсэн ааваас өмнө өөр хүнтэй ойртоогүй нь лав. Петерийн гарыг дэрлэн, зүрхээ цээжинд нь наан, толгойгоо нийлүүлээд суудгийг минь миний найз охид мэдвэл юу гэх бол?*

*Пөөх Анне, ямар ичдэггүй юм бэ гэнэ байх даа. Үгүй, энэ үнэндээ надад тийм ч ичмээр санагдахгүй байна. Бид чинь энэ дэлхий ертөнцөөс таслагдчихаад сүүлийн үед бүүр ч айх зовохын туйлыг үзэн суунам. Ийм үед яахаараа бид чинь бие биедээ тэмүүлж байгаа хэр нь хөндий дөлж суух юм бэ? Яачихлаа гэж нас биеэнд хүртлээ хүлээх хэрэгтэй юм бэ? Яагаад ийм олон юм бодох хэрэгтэй болов оо? Өөрөө өөрийгөө залж жолоодох нь миний үүрэг. Петер надад хэзээ ч зовлон шаналал авчрахгүй. Зүрх сэтгэлийнхээ хэлж байгаа, бид хоёрыг аз жаргалтай болгох бүхнийг би яагаад хийж болдоггүй билээ? Китти минь, чи минийхээ үл ялиг эргэлзэж буйг анзаарсан шиг байна. Энэ нь сэтгэлтэйгээ марган буй, хүндтэй юмны маань нэг нь шүү дээ. Аавд намайг долоон булчирхайгаа тоочих ёстой гэж бодож байна уу? Бидний энэ нууцыг гурав дахь этгээд сонссон байх ёстой гэж бодож байна уу? Хэт нялуун зангаа хаясан нь дээр шүү. Чингэснээр сэтгэл минь тайван явах бус уу?*

*Тийм ээ, би түүнтэй маш их зүйлийг ярихыг хүснэм. Зөвхөн л амраглан сууна гэдэг утгагүй хэрэг. Түүнтэйгээ бүхний тухай илэн далангүй ярилцахад маш их итгэл хэрэгтэй. Гэхдээ ийм итгэлтэй болох гэсэн ухамсар л биднийг хагацашгүй болгох биз!*

**Анне**

## 1944 оны дөрөвдүгээр сарын 18. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Манайхан бүгд тайван, энх тунх байна. Аав саявтархан Орос, Итали бас өрнөдийн орнуудад тавдугаар сарын хорьдын өмнө томоохон давшилт болох гэнэ гэв. Ингээж удах тусам чөлөөлөгдөх горьдлого маань тасрах юм. Наанадаж арав хоног хойшлуулсны хойно Петер бид хоёр жинхэнэ ёсоор ярицлаа. Би түүнд ичиж зоволгүй бодож санаснаа хүүрнэн, охид бидний хамаг л нууцыг тоочив. Тэгээд тэр оройг уруулд маань маш их ойрхон үнсэлтээр төгсгөв. Түүн шиг сайхан мэдрэмж үгүй биз ээ.*

*Би таалагдсан бүхнээ доогуур нь зурчихсан номоо дээш авч гаран аятай сайхан гэсэн бүхний нь амтархан уншицгааж болох шүү дээ. Юм л бол гараа дэрлэн хэвтэцгээх нь онцгүй санагдах юм. Петерийг миний хийх дуртай зүйлд бас дуртай байгаасай гэж бодох болов.*

*Бид мөнхөд ээлжлэн солигддог дөрвөн улирлын нэг өвлийн дараа сайхан хавартай золгов. Дөрөвдүгээр сар хэт хүйтэн, халууны аль нь ч үгүй сэрүүвтэр, үе үе шиврээ бороотой сайхан байлаа. Бидний өнөөх туулайн бөөр мод ногоорч, гөлөглөсөн харагдана. Элли маань хагас сайн өдөр биднийг маш их баярлуулав. Тэр гурван баглаа хэлгий цэцэг авчрахдаа надад бяцхан цэнхэр цэцэг өгөв. Китти, алгебраа давтах минь, баяртай.*

*Анне*

**1944 оны дөрөвдүгээр сарын 19. Лхагва гариг**

*Хайрт Китти минь!*

*Lieve Schat!*

*(Энэ нь Дорит Крейсер, Ида Вюст, Харольд Паульсон нарын тоглосон нэг киноны нэр юм шүү!)*

*Нээлттэй цонхон дээр, байгалийн сайхнаар нүдээ хужирлан, шувуудын жиргээнийг сонсож, хацраа наранд ээн, сэтгэлтэй хөвгүүнээ тэвэрч, анир чимээгүй шахцалдан суухаас илүү сайхан юм байдаг болов уу. Нам гүм, таг чиг, амар тайван байх нь юутай сайхан бэ. За тэгээд энэ таатай байдлыг маань Муши муужгай саатуулаагүй бол хэчнээн гоё вэ!*

***Анне***



## 1944 оны дөрөвдүгээр сарын 21. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр их үдийн үед хоолой өвдөхөөр нь орондоо хэвтэв. Хэвтсээр уйдаад байтал, ашгүй өнөөдөр халуураагүй байлаа. Тэгэхээр нь боссон минь энэ. Өнөөдөр эрхэмсэг хатан хааны угсаа залгамжлах гүнж Йоркийн Элизабет 18 нас хүрч гэнэ. Хааны удмынхны заншлаар бол гүнж насанд хүрээгүй гэж ВВС мэдээлэв. Тийм үзэсгэлэн төгс гүнж хэн гэгч ханхүүтэй гэрлэх бол? Лав тохирох хунтайж олдохгүй биз гэсэн бодол төрлөө. Түүний эгч Маргарет Розе гүнж Бельгийн хунтайж Будевияатай гэрлэх байх, тийм үү?*

*Энэ хоргодох байранд нэг золгүй явдал арай гэж гайгүй болоход дараагийнх нь зөрөөд ирэх юм. Гаднах хаалгыг дөнгөж бөхөлж дуусмагц, дахиад л агуулахын ачилчны гэгч хэрэг гараад ирэв. Тэр ажилчин төмсний гурил хулгайлчихаад буруугаа Эллид чихэх гэжээ. Бидний дургүй хүрснийг хэлэх юм биш. Элли ч уурласан гэдэг жигтэйхэн.*

*Бичсэн зохиолыг минь хэвлэх эсэхийг ямар нэгэн сэтгүүлээс асуулгамаар байна. Мэдээж нууц нэрээр шүү дээ. Хонгор минь дараа болтол баяртай!*

*Анне*

## 1944 оны дөрөвдүгээр сарын 25. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Хулгайч орсноос хойш бид Даан гуайн саналаар олон янзын болгоомжилсон дэг журмыг мөрдөх болсон нь таалагдаагүйгээс Дуссел арав хоног хэртэй түүнтэй ер дуугарсангүй. Тэр дүрэм журмаар Даан гуай өөрийг нь л гадуурхаж хавчиж байна гэж эмч гуай ойлгожээ.*

*Дуссел эмч нэг өдөр надад “Эндэх бүх юм эмх замбараагаа алдлаа. Аавтай чинь нэг ярихаас” гэв. Дуссел хагас сайн өдрийн үдээс хойш бүтэн сайн өдрийг дуустал доор байдаг эзний конторт суугаад байх шаардлагагүй атлаа зөрөөд байв. Түүнийг үгэнд орохгүй юм гэж Даан гуайг уурлахаар нь аав ярилцахаар доош буулаа. Мэдээж тэр өнөөх л үглэдгээрээ үглэжээ. Харин энэ удаад Дуссел аавтай зөрсөнгүй. Дусселийн үг даадаггүйг мэддэг аав түүнтэй аль болохоор хааяа л ярилцахыг бодно.*

*Би “Газар дэлхийг нээгч Блурри” гэдэг аятайхан өгүүллэг бичив. Тэр маань миний гурван сонсогчдод овоо таалагдсан гэж байгаа. Би нэлээд хүндхэн хатгалгаатай ханиад хүрчихлээ. Тэр нь Маргот, аав, ээж гуравт ч халдав. Петер л битгий авчихаасай. Тэр надтай үнсэлцэхийг хүсч байгаа даа. Намайг тэр “Элдорадо” гэж дуудах болсон. Ямар ч л гэсэн Петер надад хайртай юм шиг!*

*Анне*

## 1944 оны дөрөвдүгээр сарын 27. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өнөө өглөө Даан эзэгтэйн тэнгэр бүрхжээ. Дусал эм, ширхэг ч үрэлгүй боллоо гээд ханиадыг баахан харааснаа нар ч гардаггүй, давшилт ч эхэлдэггүй, адаглаад цонхоор ч юм харагдахгүй юм гэж бухимдав. Аль юманд уурладаг юм бэ гэж бидний хөхрөхөд эзэгтэй нээрээ ч тийм дээ гээд даган инээлээ.*

*Би одоо Гөттингений их сургуулийн нэг профессорын бичсэн “Тавдугаар Карл” хааны тухай уншиж байна. Тэр эл номыг дөчин жил бичжээ. Би тавьхан хуудсыг таван өдөр уншив. Түүнээс хэтрэхгүй байна. Гэтэл энэ ном 598 хуудастай юм. Энэ зузаан номыг хэчнээн өдөр унших нь вэ чи бод л доо. Дараа нь бүр дэд дэвтрийг нь унших санаатай! Гэхдээ маш сонирхолтой ном юм!*

*Жирийн нэг сурагч охин миний оролдож байгаа зүйлүүд ирээдүйд хийх ажилдаа бэлтгэж байгаа хэрэг юм. Нельсоны “Сүүлчийн тулалдаан” гэдэг жүжгийг холландаас англи руу орчуулж дуусаад дараа нь 1700-1721 онд болсон хойд зүгийн дайн, их Петр, арван хоёр дугаар Карл, аугаа их Аугуст, Лестинскийн Станислав, Мацерна, Бранденбург, Поммерийнхны хөвгүүд, тэдний удмынхан, Дани түүний холбогдолтой он дарааллын бичгийг бүхэлд нь барьж авсан. Бас Бразил дээр тогтоож, тамхи, кофены илүүдэл, Рио-Де-Жанейрогийн бүтэн хагас сая оршин суугч, Сан-Паула болон Пернамбук, Амазонк мөрний сав газрын ард түмний тухай уншихаа ч мартсангүй! Тэндэх нутгийн негр, мулатуудын тэн хагасаас илүү нь бичиг үсэггүйн дээр үе үе халуун томуу хижигт нэрвэгддэг тухай уншив. Мөн жаахан зав гарахаар нь өвгөн Ян, Людвигийн Вильхелм, Казмирын Эрнст, Казмир нэгдүгээрийн Хайнрих гээд л бяцхан Маргарет Францискаг хүртэлх үе залгамжилсан удмыг судлав. Би арван хоёр цагт агуулахад хичээлээ үргэлжлүүлэн хийлээ. Тэгэхдээ бүр сүм хийдийн түүх үзсээр нэг цаг болгов. Тэгээд л хоёр цагт хөөрхий жаал ажилдаа орох нь тэр дээ. Энэ удаад навтагар хамартай сармагчингийн тухай унших гэж байна. Дараа нь Ноа, Сем, Хаам, Жапет зэрэг архадуудын гэрээслэл, тавдугаар Карлын намтар зэргээс уншина. Мөн Петертэй хамт Такерийн “Хурандаа” зохиолыг англиар уншина. Франц үсгийн дуудлагыг чагнаад Миссиппи, Миссурийг харьцуулан үзнэ. За өнөөдрийн хувьд болох шив дээ, баяртай.*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Петер Весселийг зүүдэлснээ би ер мартаж чадахгүй байна. Түүнийг бодох бүрд, өнөөдөр ч гэсэн тэр, хацрыг нь хацарт минь хүрэхэд мэдэрсэн тэр гайхамшигт сэрэл санагдсаар байна. Гэтэл Дааны Петертэй хамт суухад яг тэрэн шиг тийм хүчтэй таашаал төрөхгүй юм. Харин өчигдөр Петертэй бас л буйдан дээр шахцалдан суухад нэг тиймэрхүү сэрэл мэдрэгдсэн шүү. Тэрхэн мөчид л хуучин Аннегийн оронд сэтгэл чанга, цэнгэл жаргалд дуртай, хайр дурлалыг мөрөөдсөн хоёр дахь Анне бий болчихсон мэт болов. Түүнд шахан суусан бөгөөд өөрийн минь сэтгэл үлэмж хөдлөхөд нулимс өөрийн эрхгүй хацрыг минь даган бөмбөрч, түүний хувцас дээр дусав. Үүнийг Петер ажиглаа болов уу? Петерийн сэтгэл минийх шиг хөдлөө болов уу? Тэг нэг ч үг дуугарсангүй. Петер өмнөө хоёр Анне байгааг мэдээд байгаа юм болов уу? Таамаглах аргагүй хэчнээ олон асуулт гарна вэ?*

*Найм хагас болоход би босоод бид хоёрын ямагт салан оддог цонхон дээр очив. Биеэ чичирч байгааг үзвэл би хоёр дахь Анне хэвээрээ байв. Петерийг над дээр ирэхэд би хүзүүдэн авч зүүн хацрыг нь үнсэв. Тэгээд баруун хацрыг нь үнсэх гэтэл миний уруул түүнийхэд хүрэв. Бид хоёр гэнэт тэврэлдээд хэзээ ч болихгүй гэсэн шиг дахин дахин үнсэлцлээ. Петер хайр энхрийллийг үнэхээр их үгүйлж явжээ. Урьд өмнө нь охид, хөвгүүдийн алинтай нь ч үерхдэггүй байсан тэр анх удаагаа үерхэл нөхөрлөлийн ид шидийг үзэж, түүнд өөрийгөө бүр мөсөн тушаажээ. Ийн бид хоёр бие биесээ оллоо. Хэдийгээр үерхэл нөхөрлөл минь улам батажсан ч “Петер шиг хүсэж мөрөөдөн, шаналж, хайлан уярч, хөл алдах чинь зөв үү? Охид ийм байж болох уу?” гэсэн асуулт намайг шаналгахад “Би чинь ингэхийг л мөрөөдөж байсан шүү дээ. Удтал ганцаардсан би сэтгэл тайтгаран, баяр баясгалантай байгаа юм биш үү” гэж хариулах болов. Бид хоёр өглөө, өдөр, орой болгон юм л бол уулзаж, тэр бүрдээ хязгааргүй их аз жаргалд автана. Тэр үед л бид зөвхөн бие биесийнхээ эрхшээлд ормуй. Орой бүр сүүлчийн удаа үнсэлцсэний эцэст түүнийг дахин харалгүй гав ганцаар харанхуйд баймаар санагдан зугтахын хүслэнд автана! Арван дөрвөн гишгүүр доош буухаас би өөр хаачих билээ дээ? Гэрэл гэгээн дунд ярьж хөөрөн, инээж хөхрөн, томчуудын асууж шалгаахад бас хариулж, сэжиг авахуулахгүй байх хэрэгтэй байдаг. Гэхдээ өчигдөр үдшийнх шиг явдлыг ор тас мартъя ч гэсэн зүрх минь хүсэхгүй биз. Петер миний бодож байснаас огт өөрөөр сэтгэлийг минь өөртөө татчихлаа. Хонгор Петер минь, чи намайгаа яачих нь энэ вэ? Надаас юу хүсээд байгаа юм бэ? Би одоо хаачдаг билээ? Одоо л би хайр дурлал гэгчийг биеэр амсан байж Эллийн юунд эргэлзэн байсныг ойлгогчоо болж байна. Би одоо том болчихсон байсан бол Петерийг надтай сууя гэвэл юугаа хэлдэг байна? Анне минь, шударга л байж үзээрэй! Түүнтэй сууж ч чадахгүй, бас мартаж ч чадахгүй! Учир нь Петер миний мөрөөдлийн зан төрхтэй залуу биш! Тэр дэндүү хүүхдээрээ, бас оюун бодлоороо бол надаас ч балчир юм шиг санагддаг юм. Тэр зөвхөн өөртөө амар тайван байхыг л боддог номхон дөлгөөн зантай хөвгүүн.*

*Ингэхэд би чинь үнэхээр арван дөрөвтэй гэж үү? Өнөө л гэнэн хонгор сурагч охин хэвээрээ байна гэж үү? Аливаа юманд үнэхээр дадлага туршлагагүйтэж байна гэж үү? Үгүй, би гэдэг хүн үеийнхнийгээ бодвол нэлээд юм уншиж хэрсүүжжээ. Үе тэнгийнхнийхээ хэний нь ч мэдэхгүй юмны зах зухыг гадарлах болжээ. Тэгээд ч юу юуны тухандгүй цаг зуурын хүсэлдээ*

*хөтлөгдчихөөд, хожим нь өөр хөвгүүнтэй хэрхэн харьцах бол гэхээс айх боллоо. Ухаан бодол, зүрх сэтгэлийн зөрчил шиг хэцүү юм үгүй дэг. Аль аль нь өөр өөрийнхөө цаг үеэр ярих болно. Харин би цагийг зөв сонгосон гэдгээ л баттай ойлгож байна.*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 2. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Хагас сайн өдрийн орой би өөрсдийнхөө тухай аавд хэлбэл ямар вэ гэж Петерээс асуувал тэр хэсэг эргэлзсэнээ хэлсэн нь дээр гэсэн. Тэгэхэд нь би Петерийн сэтгэл юутай ариухан, цайлган юм бэ? гэж баярлав. Доош бууж ирмэгцээ аавд “Ааваа та Петер бид хоёр хамт байхдаа хоорондоо метрийн зайтай суудаггүй гэдгийг ойлгосон байлгүй. Бид хоёр дотно болсныг буруу гэж боддоггүй биз дээ?” гэвэл тэр бага зэрэг бодлогоширсноо:*

*-Үгүй Анне! Муу нь ч юу байхав. Харин хөл хориотой энэ оромжинд болгоомжтой л байх хэрэгтэй шүү гэв.*

*Бүтэн сайн өдрийн өглөө аав намайг дуудаад:*

*-Анне, аав нь хэлснийг чинь нэлээд бодлоо. /Энэ хооронд би аав цааш юу гэх бол гэхээс маш их айж байлаа./ Энэ бүгэвчинд ер нь ингэж байж болохгүй! Би та хоёрыг энгийн үерхэж байгаа гэж боддог байлаа. Петер тэгээд чамд сэтгэлтэй болчихоо юу? гэхэд нь*

*-Тэр талаар бодоогүй гэв.*

*-За тийм байж, Анне минь. Та хоёрыг би сайн ойлгож байгааг минь чи мэднэ. Тэгэхдээ түүнд нэг их нүүр өгч, өдөж сөдөлгүй хөндийхөн л байхыг бодоорой. Дээшээ битгий үргэлж гүйгээд бай. Эрчүүд тиймэрхүү юманд үргэлж л түрэмгий байдаг улс шүү. Тийм нөхцөлд эмэгтэй хүн биеэ барьж чаддаг байх хэрэгтэй. Харин эрх чөлөөтэй байхад бол өөр хэрэг. Тэнд бол чи арай ондоо олон хөвгүүд охидтой үерхэж, спортоор хичээллэнэ. Энд бол ингэж байнга хамтдаа байвал нэг л өдөр бие биесээсээ уйдаж хэцүүдэхэд хүрнэ. Та нар үргэлж л хамт байх болжээ. Миний охин сайн бодоорой. Болгоомжтой байгаарай.*

*-Ааваа, би яах ч үгүй. Тэгээд ч Петер чинь төлөв даруу сайн хөвгүүн шүү дээ!*

*-Тиймээ гэхдээ л түүний зан ааш сайн төлөвшөөгүй байгаа. Сайн болоход ч муу болоход ч амархан даа. Яахав дүн нуруугий нь харвал гайгүй юм шиг санагддаг юм.*

*Ийнхүү аав бид хоёр нэлээд ярилцсаны эцэст аав түүнтэй ярилцахаар боллоо. Бүтэн сайн өдрийн үдэд Петер надтай хамт сууж байснаа:*

*-Анне, чи аавтайгаа ярьсан уу? гэдэг байна. Би тэгэхэд нь:*

*-Ярьсаан. Түүнийгээ л чамд хэлэх гэж байна. Аав бидний тухай нэг их муу юм бодоогүй. Харин биднийг салахдаа нэг их сүйд майд болдоггүй байх гэж боддог гэсэн гэвэл Петер “Бид хоёр муудалцахгүй гэж тохиролцсон шүү дээ. Би хэлсэн үгэндээ эзэн болно” гэв.*

*-Би ч бас адилхан. Харин аав биднийг жирийн үерхэж байгаа гэж боддог гэсэн. Тийм байж болно гэж чи бодож байна уу?*

*-Тэгэлгүй яах вэ, харин чи?*

*-Тиймээ би чамд итгэдэгээ аавд хэлсэн. Петер минь, би аавдаа итгэдэг шигээ л чамд итгэдэг шүү. Чамайг итгэлийг минь хөсөрдүүлэхгүй гэж би боддог. Тийм үү?*

*-Хөсөрдүүлэхгүй ээ гэж хэлэхдээ Петерийн царай нь ичсэндээ улайчихлаа. Тэгэхэд нь би:*

*-Би чамайг сайхан сэтгэлтэй, тийм ч учраас их юманд хүрэх хүн гэж боддог гэв. Бид хоёр ийн элдвийг ярилцав. Би жаахан байж байгаад “Чамайг эндээс гармагцаа л намайг тоохоо болих байх гэж бодох юм” гэхэд Петер их л уурлаж:*

*-Анне, яасан ч тэгэхгүй. Намайг тэгнэ гэж битгий бодоорой! гэлээ. Тэгтэл ч намайг манайхан дуудав. Дараа нь нэг дэх өдөр Петер аавтай уулзсан гээд:*

*-Аав чинь энгийн үерхэл заримдаа хайр сэтгэл болон хувирдаг гэж боддог юм байна. Тэгэхэд нь би аавд чинь санаа зоволтгүй, бидэнд итгээд л орхи гэсэн гэв.*

*Аав намайг дээшээ цөөхөн гарч бай гээд байна. Би харин үүнийг яагаад ч зөвшөөрөхгүй. Петерийг л гэж гүйгээд байгаа юм биш, түүнд итгэж болно гэв. Үнэндээ би Петерт итгэдэг. Итгэдэгээ ч батлахыг хүсдэг. Би аав ээжийн үгэнд ороод итгэл алдаж чадахгүй. Үгүй, би дээшээ очдогоороо очих л болно.*

*Энэ хооронд Дуссел гуайн элдвийн жүжиг ашигүй төгсөв. Тэр хагас сайн өдрийн орой холландаар цэврээс цэвэрхэн гэгч нь уучлалт гуйв. Даан гуай ч юм бодсон шинжгүй сайхан аашилсан. Харин Дуссел эмч бүхэл өдөржингөө тэр байдлаараа сайхан загнав. Төрсөн өдөр нь өнгөрсөн бүтэнд нам гүм өнгөрлөө. Түүнд манайхан 1919 онд дарсан ганц шил дарс, Даан гуайнхан бас нэг шил Пикасили дарс, боодол сахлын хутга, ноёр Кралер чанамал нимбэг, Мийн ном, Элли цэцгийн сав бэлэглэлээ. Тэр өөрөө бидэнд нэг нэг өндөг өгсөн.*

**Анне**

### 1944 оны тавдугаар сарын 3. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Долоо хоногийн сониноос гэвэл улс төрийн яриа түр намжив. Яриад байхаар ч гойд юм болсонгүй. Өнөөх л давшилт, чөлөөлөлт нь хэзээ вэ гэж хүлээж байна.*

*Ингэхэд Моффигоо алдсанаа чамд хэлсэн билүү? Өнгөрсөн дөрөв дэх өдрөөс хойш сураг чимээгүй алга болсон доо. Бодвол тэр золиг муурын диваажингийн оронд очиж, нэг махассан айлын тогоог тосолсон биз. Арьс нь одоо лав нэг айлын хүүхдийн малгай болчихсон байхыг байг гэх газаргүй шүү дээ. Петер тун ч гунигтай байна.*

*Өнгөрсөн хагас сайн өдрөөс эхлэн бид хөнгөн цайгаа арван нэг хагасаас уух болсон. Өглөө идсэн бяцхан дийз агшаамлаар үдийн хоолыг аргацааж байна. Ногоо гэж нүдний гэм болсон. Манайхан жаахан ялзарч муудсан байцаанаас өөр ногоо гэхээр юмгүй боллоо. Бууцай, буурцагны нухаш ч үгүй болоод байдаг. Тэмс ч бас ялзарчээ. Хачин юм болж байгаа биз!*

*Хоёр сар хэртэй тавгүйдэцгээв. Харин өнгөрсөн хагас сайн өдрөөс жаал гайгүй болж эхэллээ шүү. Мундахгүй гай үүссэн ч заяа минь хаячихаагүйд баярланам.*

*Ингэж хорионд суухдаа хааяа сэтгэл хямрахдаа өөрөө өөрөөсөө элдвийг асуухад хүрдгийг ч ийлгоно биз. Яах гэж энэ муухай дайныг хийдэг юм бэ? Хүмүүс яагаад эв найртай амьдарч чадахгүй болчихдог билээ? Яах гэж хүний хийж бүтээснийг эвдлэн сүйтгэдэг юм бэ? Өдөржин ажил хийгээд голоо зогоох гэсэн ядууст сохор зоос ч олдохгүй байхад яахаараа дайнд өдөртөө хэдэн арван саяар нь үрнэ вэ? Дэлхийн зарим газар нь хоол хүнс нь илүүдээд ялзарч муудаж байхад яагаад энд хүмүүс өлсөж, харангадаж байдаг байна? Хүн яахаараа ингэж тэнэглэдэг юм бэ? Дайн гэгч энэхүү тэнэглэлийн хөлд би нэг биш удаа золиослогдон хохирч байна. Гэхдээ хэзээ ч цөхрөнгөө барахгүй. Энд нуугдан бүгж байгаагаа ч миний зоригийг чангалж хатуужуулах нэгэн адал явдалд тооцно. Би бусад эгэл жирийн охидоос өөрөөр амьдарч, хожим нь гал тогоо, аяга шанагаар оролдсон гэрийн эзэгтэй болохгүй гэж хатуу шийдсэн. Өсч өндийж яваа хүүхдэд байдаг нуугдмал авьяас чадвар надад байгаа гэж итгэдэг. Оюун ухаан минь бас бүрэлдэж байгаа болохоор амьдралд тохиолдох хүнд сорилт надад ухаан суухад нэмэр болж байгаа бизээ. Ямар ч гэсэн энд хүнд хэцүү байна гээд өдөржин гомдоллон сууна гэж үгүй. Удахгүй дайн дуусаж, би чөлөөлөгдөж, эрх чөлөөт амьдралдаа эргэн орно гэдгийн мэдэж байгаа болохоор юундаа гутрах билээ!*

**Анне**



## 1944 оны тавдугаар сарын 5. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Аав маань надад сэтгэл дундуур байх болов. Тэр бүтэн сайн өдрийнхөө ярианаас хойш намайг орой бүр дээшээ гүйхээ болино гэж боджээ. Аав нялуурахад дургүй гэнэ. Би бол энэ үгийг сонсмооргүй байна. Тэгээд энэ тухай аавтай нэг ярихаар шийдэв. Бас Маргот маань ч надад сайн зөвлөгөө өглөө. Юу гэхийг минь сонс л доо!*

*“Аваа! Намайг ямар бодолтой байгааг мэдэх гэж байгаа байх гэж бодоод би танд хэдэн юм хэлэхээр шийдлээ. Та миний үерхлийг ингэсхийгээд больчих байх гэж найдаж байх шиг байна. Та охиноо жаахан үеийнхтэй нь яг адилхан байлгах гээд байх юм. Энэ тань л буруу юм шиг санагдах юм! 1942 оны зургадугаар сард би энд ирснээс хойш нэлээн юм үзэж өнгөрөөлөө шүү дээ. Та намайг үеийн найзуудаа үгүйлэн уйдагдаа бараг орой бүр дэрээ нэвтэртэл уйлдаг байсныг минь мэдвэл миний дээшээ гүйгээд байгаагийн учрыг ойлгоно. Ээж юмуу эсвэл өөр хэн нэгний түшиг тулгуургүйгээр хөл дээрээ зогсож чадахгүй болтлоо энд уйтгарлаж байлаа шүү дээ. Ингэж одоогийнх шигээ өөртөө итгэлтэй болж, би гэдгээ мэдрэх хүртэл хэчнээн их нулимс, хэчнээн их тэвчээр гаргасан гэж санана. Та намайг ингэж байсан гэж үү хэмээн шоолж, эсвэл гайхаж магадгүй. Тэглээ гээд би өөрчлөгдөхгүй. Би өөрийгөө мэдэхтэйгээ болсноо, та нарт ямар ч дараа болохооргүй бие даасан хүн гэдгээ улам улам мэдрэх боллоо. Бас ямар нэг зүйл нуугаад байна уу гэсэн бодлыг танд төрүүлэхгүй гэсэндээ танд л гэж энэ бүхнийг тоочиж байна. Өөрийнхөө явдлыг би өөрөө л хариуцна шүү дээ.*

*Анх энд ирээд намайг зовж, шаналж байхад та нарын хэн нь ч ойлгоогүй. Та ч гэсэн нүдэн балай чихэн дүлий царайлж байсан. Та надад туслаагүй! Нэг их шуугиан тарих хэрэггүй л гэж сануулсан. Миний бие өсөж төлжиж, ой ухаан хөгжиж, ээжийг таныг царайчлахааргүй бие дааж байна.*

*Ингээд л хөлөө олж, өөрийгөө авч явахаар ухаан сууснаа мэдэнгүүт өөрийнхөөрөө баймаар байна. Та намайг дөнгөж арван дөрөвтэй гэж битгий гол. Та намайг хэчнээн цагдаад ч хорьж дийлэхгүй. Та надад итгээд, тайван дураар минь орхихыг гуйя”*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 6. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр үдийн хоолны өмнөхөн чамд тоочсон бүхнээ бичсэн захиаг аавын халаасанд хийчихсэн. Намайг аяга шанагаа дээр угааж байхад Маргот ирээд “Аав захиагий чинь уншихаад оройжингоо тавгүй байсан” гэв. Хөөрхий муу аав минь, намайг ингээж эх захгүй зан гаргасандаа хэчнээн айж эмээж байгааг мэдэж байгаа болов уу? Аав минь тун ч эмзэг сэтгэлтэй хүн шүү дээ! Юу ч битгий асуугаарай гэж би Петерт хэлэв. Ашгүй аав тэр тухай яриагүй байгаа юм болов уу?*

*Энд бүх юм овоо хэвэндээ орж л байна. Юмны үнэ улам өсч байгаа тухай гадуур хүмүүсийн ярих нь санаанд багтах юм биш. 250 грамм цай 350 гульден, хагас кило коферхуу юм 80 гульден, хагас кило шар тос 35 гульден, ганц өндөг нэг гульден 45 цент болж гэнэ. Болгарийн 100 грамм тамхийг 14 гульденээр авч өгөлцөх болжээ. Хүн бүхэн дамын наймаа дүнгэнүүлж, хүүхэд бүхэн зарах юмтай байдаг болсон гэнэ. Манайханд талх дөхүүлдэг хөвгүүн бидэнд нэхмэлийн утас нэг боодлыг 90 центээр худалдав. Сүү нийлүүлэгч маань хүнсний талон, оршуулгын газрын эзэн бяслал зардаг болсон гэнэ. Өдөр бүр хулгай дээрэм, алаан хядаан дуулдан, түүнд мэргэжлийн хүмүүс заримдаа цагдаа, манаач нар ч өөрсдөө оролцох болжээ. Хэн хүнгүй л жсаахан ахиухан юм бусдаасаа өрсөөд долоочихсон гэдэг болж. Авдаг нь нэмэгдэхгүй болохоор эцэстээ бүх хүн хуурч мэхлэх болсон байна. Залуучуудын хэрэг эрхэлсэн цагдаагийн газар ажлаа дийлэхгүй байгаа гэнэ. Өдөр өнжихгүй шахам арван таваар арван долоон насны охид заримдаа насанд хүрсэн бүсгүйчүүд ор сураггүй алга болох болжээ.*

*За Китти дараа баяртай уулзъя! (Уг нь ингээж төгсгөх нь буруу ч юм шиг. Англиас герман хэлээр явуулдаг нэвтрүүлэг дандаа баяртай, дараа сонсоорой гэдэг юм. Миний хувьд бол баяртай, дараа бичимз гэвэл зөв юм байна.)*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 7. Ням гаригийн өглөө

*Хайрт Китти минь!*

*Аав бид хоёр өчигдөр үдэд нэлээд удаан ярилцав. Би ч хүн аймаар енгэнүүлэхэд хүрсэн. Аав ч гэсэн. Китти минь, аавын надад юу гэснийг сонсох уу? Тэр “Би өдий наслахдаа маш олон захиа авсан санагдана. Харин чиний бичсэн шиг тийм жигшүүртэй захиа нэгийг ч авч үзсэнгүй! Анне чи, өөртөө өмөг түшиг болон чамайг л гэж хайрлан халамжилж, чиний л төлөө юу ч хийхэд бэлэн байдаг эцэг эхийгээ өөртөө хамаагүй гэжээ. Чамайг бид харж хайхрахгүй зөнд нь орхисон гэж чи боддог юм уу? Үгүй Анне минь, хэрэв чи тэгээж бодож байгаа бол нүгэл шүү. Магадгүй чи тэгээж бодоогүй байж ч болох юм. Харин ингээж бичсэн байсан. Анне, эцэг эх бид чинь арай ч ийм үг сонсохдоо хүрээгүй байх шүү” гэв. Тиймээ би бодоод байхад үнэхээр гэмшиж барамгүй буруу юм хийжээ. Амьдралдаа хийсэн хамгийн том алдаа минь энэ болог. Тэгээд түүнийгээ цагаатгах гэхдээ дэмий л уйлж унжин, нус нулимастайгаа хутгалдахаас өөр яаж ч чадсангүй. Мэдээж тэгэхдээ сайн эцгийг буруушаах, намайг ингэх ч гэж дээ гэж гомдож гонсоймоор юм бас л бишгүй байх шүү дээ. Гэхдээ юм болгоныг хэт өөртөө хамааруулж, өөнтөглөх болсон үед минь намайг биеэ тоох тэр өндөрлөгөөс гуд татан буулгаж, дарж өгсөн нь сайн хэрэг. Анне охины хийсэн бүхэн гайхамшигтай гэж хэлэх ёстой юм шиг бодол маань байхгүй болох нь тэр. Аав ч гэсэн надад ингээж нэр хүндээ алдсан нь ичгүүртэй байлаа. Тэр захиаг минь пийшин рүү чулуудах гэж гэнэ. Тэгсэн бол сэтгэлд бүр сэвгүй амар болох байж дээ. За Анне минь, чамд сурч мэдэх зүйл их байна шүү. Юуны түрүүнд л өөрийгөө шүүмжлэн бодож сур!*

*Бэрхшээлийг туулна гэгч болж байна. Үеийнхэн маань энэ бүхнийг давж чадах байсан болов уу? Гэхдээ би ганцаардлаа мэдэрсэн ч хэзээ ч цөхөрч, гутарч байгаагүй шүү. Надад ичих, бүүр ч их ичмээр юм байжээ! Нэгэнт өнгөрсөн юмыг яаж ч болдоггүй. Харин түүнийг дахин давтахгүйг л бодох хэрэг. Ахиад бүхнийг өмнөөс нь эхлэхээс. Петертэй байгаа хойно гайгүй биз. Тэр л намайг дэмжиж байвал чадахдаа л чадна! Би одоо гав ганцаараа биш шүү дээ. Тэр надад хайртай. Би түүнд хайртай. Бас би өөрийн гэсэн ном, өгүүллэгүүд, өдрийн тэмдэглэлтэй. Бас ч тийм муухай аашгүй, тэнэг бус, сайхан загнаж явахыг хүсдэг, хөхиүн хөгжсөөнтэй бодгаль шүү дээ!*

*За Анне, захиа чинь үнэмшилгүй хатуухан үгтэй болж. Чи өөрөө нэлээд ихийг яггүй сайн ухаарчээ. Гэвч аав минь надад үлгэр дууриал болсон хэвээр, намайг өөрийгөө өөрчлөх урам өгсөн хэвээрээ байна!*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 8. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Ер нь би чамдаа өөрийнхөө тухай ярьсан билүү? Үгүй шиг санагдана. Одоо л харин жаахан юм өгүүлье. Өвөг эцэг, эмэг эх маань багагүй хөрөнгө хогшилтой хүмүүс байсан. Өвөө маань өөрийнхөө хөдөлмөрөөр баяжсан хүн. Харин эмээ угаасаа хөрөнгө хогшил, нэр төртэй айлын охин байжээ. Ингээд л миний аав баян айлийн хүүгийн хувьд залуу насаа бүжиг цэнгээн, сайхан охид, хүлээн авалт цэнгүүнд умбаж, тансаглан өнгөрөөсөн гэж байгаа. Тэгтэл дэлхийн нэгдүгээр дайн болж, мөнгөний ханиш унахад аав бүх хөрөнгөө алджээ. Товчоор хэлбэл аав маань бага насаа эрх танхи өнгөрөөсөн хүн. Гэтэл аав тавин тав наслахдаа өчигдөр анх удаагаа гурилын түмпэн цэвэрлэж бөөн инээдэм болов.*

*Ээж ч гэсэн нэлээд хөрөнгөтэй айлын охин л доо. Бид аав ээжийн сүй тавих ёслолд 259 зочин ирсэн хүлээн авалтын тухай зөндөө л сонссон. Одоо бол биднийг хэн ч баян гэхгүй. Харин дайны дараа л аз мэдэж дээ гэж бодно. Үнэндээ чамдаа гэхэд би л лав ээж, Маргот хоёрын хүсдэг шиг тулга тойрсон сонирхолгүй амьдралаар энэ насаа элээхгүй гэж боддог. Би хэлээ сайжруулж, урлагийн түүхийг судлах гэж Парис, Лондонд нэг жилээр явна. Энэ төлөвлөгөөг минь Палестинд очиж эх баригч болох гэсэн Марготынхтай харьцуулаад үз л дээ! Би ганган хувцас, сонирхолтой хүмүүсийн тухай бодох дуртай. Их юм үзэж, нүд тайлахыг л хүсэх юм. Бас бага зэрэг хөрөнгө хогшилтой ч болмоор байна. Эд хөрөнгө илүүдэх юу байхав дээ.*

*Мийн өөрийнхөө очсон нэг сүй тавих ёслолын тухай өнөө өглөө ярилаа. Сүй тавьсан хоёр нэлээд чинээлэг гэр бүлээс гаралтай юм байх. Мийн маань найрын ширээнд тавьсан бөөрөнхий махтай ногоотой шөл, бяслаг хачиртай зүссэн талх, өндөгтэй хүйтэн зууш, нарийн махан таташ, төрөл бүрийн гурилан жигнэмэгүүд, усан үзмийн амтат дарс, сайхан тамхи зэрэг амтат идээ зоогийг хорхой хүртэл тоочив. Тэгээд Мийн өөрөө арван хундага дарс тогтоож гэнэ. Үгүй тэр уг нь архичдад үнэн дургүй хүн байсан юмсан. Мийн л арван хундагыг уусан юм бол нөхөр нь хэчнээн шилийг хөнтрөө бол? Тэр ёслолд оролцсон зочид үнэхээр их хөгжилтэй байжээ. Мийн тэр найран дээр хөөрхий бүгэгчид биднийгээ бодож л байсан юм байх. Тэгээд л ямар нэг муу юм болбол хэрэг болно гэж сайхан сэтгэлт холланд хүмүүстэй танилцаж, нэр усыг нь тэмдэглэж авчээ. Хэдийд өлсөж үхэхээ мэдэхгүй, өглөөдөө лагалдсан халбага будаагаар ходоодоо аргацааж, өдөр бүр түүхий бууцай, муудсан төмсөөр гол зогоон, ихэнхдээ хоосон суудаг бидэнд арааны шүлс гоожуулам найрын тухай Мийнийн яриа гайхмаар байлаа. Мийн биднийг тэр сүй тавих ёслолд аваачсан бол бусад зочдод хоолой давуулах юм лав үлдэхгүй байсан биз. Чамдаа гэж хэлэхэд, бид чинь сайхан хоол, гоё хувцастай хүмүүсийн тухай анх удаа л сонсож байгаа юм шиг Мийнийг бүчиж аваад, ам хэлийг нь сугалчих шахсан гээч. Гэтэл бид чинь саятны ач нар байлаа шүү дээ...*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 10. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр үдээс хойш Петер бид хоёр агуулахад франц хэлээ үзэж суутал гэнэт юм дуслах ишиг болов. Харвал ард ус гоожиж байв. Юу болох нь энэ вэ? гэж Петерээс асуухад тэг үг дуу ч үгүй юун гай болох нь энэ вэ гээд дээвэр рүү гүйж гарвал Муши муужгай нь идүүрийнхээ цоорхой дээр оцойчихсон сууж байна гэнэ. Тэгээд чимээ гарахад бие нь хөнгөрсөн Муши мий доош зугтжээ. Даанч өчигдөр орой аавын авчирсан төмс, зомгол нь хачин үнэртэй байсан юм. Муши муужгайн шээс байж дээ...*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 13. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр аавын төрсөн өдөр боллоо. Аав ээж хоёр маань хуримлаад арван есөн жил болжээ. Ашгүй цэвэрлэгч авгай эрт яваад өгчээ. Өнөөдөр энэ жил байгаагүй нарлаг сайхан өдөр болж байна. Манай туулайн бөөр мод өвч цэцэглээд ноднингийнхоосоо ч үзэсгэлэнтэй гоё ногоорчээ...*

*Аавд ноён Коофуйс Шведийн нэрт байгал судлаач Линаусын намтар, ноён Кралер болохоор байгалийн ухааны түүх, Дуссел “Амстердам усанд” гэсэн роман, Даан гуай мэргэшсэн мастер ч хийж чадахааргүй өөрөө нээгддэг тагтай сийрсэн хайрцаг бэлэглэв. Тэр саван дотор нь гурван өндөг, нэг шил пиво, нэг шил тараг, бас ногоон зангиа байлаа. Харин бидний нэг шил чанамал жимс сийрсан саванд нь багтсангүй. Мийн, Элли хоёрын өгсөн лиш цэцгийн дэргэд миний өгсөн сарнайн үнэр гоц сайхан үнэртэнэ. Өнөөдөр аав ёстой л эрх хүүхэд шиг байлаа. Бас 50 ширхэг жигнэмэг боовтой болов. Гоё байгаа биз. Тэр өөрөө харин хүн бүхэнд зүсэм бялуу, эрчүүд нэг нэг шил пиво, эмэгтэйчүүдэд нэг нэг шил тараг өгсөн. Аавын минь төрсөн өдөр үнэхээр сайхан баяр болж өнгөрлөө.*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 16. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Бид хоёр ойрдоо хэрүүл маргааны тухай нэг их ярьсангүй. Хэхэ. Харин одоо эхнэр, нөхөр Дааныхны өчигдрийн бяцхан хэрүүлийг ярья. Даан хатагтай:*

*-Германчууд Атлантын далайд байр сууриа улам хүчтэй болгожээ. Тэд англичуудыг хөл хорихын тулд чадах бүхнээ хийж, асар их хүчтэй байгаа нь мэдэгдэж байна шүү гэхэд Даан:*

*-Аа мэдэхгүй. Тийм ч гайхмаар юм байгаа юмуу? гэв. Эзэгтэйг:*

*-Яалаа гэж тийм биш! гэвэл Даан гуай:*

*-Тийм л их хүчтэй байгаа бол германчууд ялж дээ гэв.*

*-Ялах байх аа. Надад германчууд ялна гэхээс өөр юм бодогдохоо болилоо.*

*-Чамд ч юу ч гэх билээ. Муу амтай гэдэг нь.*

*-Чи дандаа л юу ч гэх билээ, хэлэх ч юм олдохгүй л гэх юм. Ганц удаа өөр юм хэлэхэд яадаг юм!*

*-Тиймээ болохгүй байна. Миний үгийг ямар тоох биш!*

*-Чи харин дуугарах ч болно, хэлэх ч болно доо. Чи хэзээ хэрэгтэй юм хэлж байлаа!*

*-Миний үг өнөөг хүртэл дандаа үнэн байсан шүү!*

*-Тэр ч гайгүй хэвтэнэ. Чинийхээр бол бид аль эрт чөлөөлөгдөөд, Финланд улсад энхийг тогтоож, Итали өнгөрсөн өвөл дайнгүй болж, Оросууд энд ирчихсэн байхгүй юу. Би л лав чиний үгэнд итгэхгүй! гэхэд Даан гуай үсрэн босч:*

*-Чи наад даравгараа татна байгаа. Миний хэлсэн үнэн байсныг чи нүдээрээ үзэж, орой руу чинь орно доо. Нэг өдөр л чи үнэний буянг эдэлж, би ч чиний солиорохыг сонсохоо болих бий вий. Наад тэнэг үгийг чинь хамар доорх хагархайтай чинь барих өдөр ирэх байлгүй! гэв. За ингээд жүжиг дуусаж, хөшиг хаагдлаа.*

*Жич өгүүлэхэд: Ингэж л Дааныхны хэрүүлийг үзэж, элгээ хөштөл хөхрөлдөх юм даа. Энэ томчууд гэж тэнэг юмнууд хүүхэд бидэнд цэцэрхэхийн оронд өөрсдөө ухаан суумаар юм даа!*

**Анне**

## 1944 оны тавдугаар сарын 19. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр миний гол харлан, гэдэс хонхолзон базалж, үнэхээр шаналгаатай байлаа. Их өлсөөд л тэгсэн биз гэж чи хэлэх байх л даа. Ашгүй өнөөдөр овоо гайгүй боллоо. Өлсөх гэдэг тэвчихийн арга алга. Манайхны идэж байгаа хүрэн шошийг л идэхгүй юмсан гэж хүснэ. Петер бид хоёр ч яахав хоорондоо сайн л байна. Хөөрхий тэр хөвгүүнд надаас ч илүү хайр энхрийлэл хэрэгтэй санагдах юм. Унтахынхаа өмнө “Сайхан нойрсоорой” гээд үнсэхэд түүний царай чавга шиг улайгаад, дахин үнсээч гэж гуйдаг. Би үнэнээ хэлэхэд Моффи муужгайн хамгийн сайн орлогч болсон байгаа биз Китти минь? Тэглээ гээд над муудах нь юу байхав. Өөрийг нь хэн нэгэн хайрлан байгааг мэдсэнээс хойш түүний сэтгэл сэргэсэн биз...*

*...Петер надад үнэхээр хайр сэтгэлтэй хэвээрээ байгаа. Харин би л түүнд сэтгэлийн хамаг нууцааа яаран дэлгэхгүй гэсэндээ биеэ бариад байгаа. Хэрэв Петер миний сэтгэл зүрхийг нээе гэвэл багагүй тэвчээр гаргах хэрэгтэй дээ!*

**Анне**



## 1944 оны тавдугаар сарын 20. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Өчигдөр орой дээрээс бууж ирсэн чинь лиш цэцгийн гоё ваар уначихсан, Маргот шалаар нэг тарсан миний гар бичмэлийг түүн, ээж сөхөрч суугаад ус арчиж байлаа.*

*-Юу болоов? гэж би сандран асуугаад, хариу хүлээлгүй хохирлоо тооцохыг оролдлоо. Язгууртны удмын тэмдэглэлийн хавтас, дэвтэр, номнууд усан дунд байж байв. Уур хүрсэндээ юу хэлж, яаж байснаа ч санадаггүй. “Юун гайтай юм бэ. Яаж энэ бүх хохирлоо нөхнө дөө. Аймар юм бэ.” гэж амандаа гөвтнөөд байсан гэж Маргот дараа нь хэлэв. Лав л аав чанга чанга хөхрөөд, ээж, Маргот хоёр усан дундаас миний юмыг цуглуулж байсан санагдана. Миний хувьд энэ бүхнийг хийх гэж зарцуулсан цаг, хичээнгүйлэн бичсэн тэмдэглэл минь дэндүү харамсалтай, бодохоос нулимс цийлэгнэмээр байсан. Сүүлд сэхээ ороод үзэхэд бас ч гэж гарз тийм аймаар биш байсан нь аз. Тэгээд норсон юмуудаа хэцэнд өлгөн хатаалаа. Хэцэн дээр хатсан юмыг хараад инээд хүрмээр байсныг яана. Жишээ нь Бургундын герцог Карлын охин Мариагийн хөрөг, Бургундыг эзэлж авах гэж Францтай байлдсан тавдугаар Карлын хөрөгтэй, Холландын тусгаар тогтнолын төлөө хоёрдугаар Филипптэй тулалдсан Ораниегийн Виллемийн хөрөг, арван зургаадугаар Людовикийн хатан Мариа Антуанеттегийн хөрөгтэй хэцэнд хамт зүүлттэй байгаа нь өшөө хорслоо мартан эвлэрцгээсэн мэт харагдана. Үнэхээр зугаатай. Даан гуай хөргүүдийг хараад “үндэс угсааг нь гутаасан явдал” хэмээн ёжиллоо. Тэр хөргүүдээ харж байхыг Петерт захичихаад доош бууж:*

*-Миний ямар ном норсон байна? гэж усанд автсан номыг янзалж суусан Марготоос асуусан чинь тэр:*

*-Алгебрийн ном чинь л норчихож гэлээ. Үнэндээ алгебрынхаа номонд харамсах юм алга. Харин ч болдогсон бол тэр хуучин номыг өөрийн гараар ваартай усанд хийчихмээр байдаг юм. Шинэ номтой болчихвол тэр новишийг хэдэн хэсэг тастаад хаяхсан!*

*Анне*

*Хайрт Китти минь!*

*Уржигдар аав Даан эзэгтэйд мөрийгөө алдаж таван шил тараг өгөв. Энэ хугацаанд чөлөөлөлт болсонгүй. Бүх л Амстердам, Холландчууд, Европын баруун хэсэн тэр аяараа өдөр шөнөгүй л чөлөөлөлтийг мөрөөдөн, мөрийцөж марган, цэц булуулдаж байгаа гэдэгт би итгэлтэй байна. Дайн дуусахгүй бүхний тэвчээрийг барж байна. Хамраасаа цаашихыг хардаггүй англичууд өөрийнхөө орны төлөө байлдаж байгаа болохоос Холландыг л чөлөөлөх гэж байгаа юм шиг бодох нь утгагүй юм. Ямар ч улс бусад орны төлөө цэрэг эрсээ үхэл рүү илгээхгүй. Англи ч адилхан. Гэхдээ Германы эсрэг довтолгоо, чөлөөлөлт, эрх чөлөө нэг л өдөр ирэх болно. Хүчирхэг Англи, Америк хоёр л тэр цагийг тогтоохоос биш Холланд мэтийн эзлэгдсэн орныхон юугаа мэдэх юм бэ! Сүүлийн үед улам олон хүн бидний эсрэг болж, еврейчүүдийн эсрэг үзэл ноёлох болсон нь хэчнээн харамсалтай вэ. Би энэ байдалд маш их гутарч байна. Еврейчүүд Германчуудын өмнө дэндүү доошоо орж, өөрсдийнхөө хамгаалагчдаас нүүр буруулж байна, үүнээс болж сая сая христосчууд аймшигт харгислал, дарамт үүрч байна гэж биднийг зэмлэх боллоо. Хэрэв байдал ийм байгаа нь ортой гэвэл зоосны нөгөө талыг харъя л даа. Христосчууд бидний оронд байвал яах вэ? Еврей ч бай, христос шашинтан ч бай, ямар ч хүн Германчуудын дарлалд тогтоож суух уу? Мэдээж үгүй гэдэг нь ойлгомжтой. Гэтэл яагаад еврейчүүдийг зэмлэнэ вэ? Холландад цагаачилсан германы еврейчүүдийг Польш руу явуулах гэнэ. Тэд дахин Холландад ирэх эрхгүй гэнэ гэсэн сураг нууц хүрээнд сонсогдож байна. Гэтэл бид Холландад цагаачлан амьдрах эрхтэй шүү дээ. Харин Гитлерийг байхгүй болохоор л германдаа очиж болох юм. Ер нь энэ гай гамшиг авчирсан, дуусахгүй урт үргэлжилсэн дайн яагаад гарах болов? гэсэн асуулт гарч байна...*

*Тиймээ “Христос шашинт хүн хийсэн гэм нүглээ ганц өөрийнхөө хар толгойгоор хүлээх ёстой. Харин еврей хүний гэм бурууг бүх еврей үндэстэн үүрэх ёстой!” гэсэн аймшигт журмыг өнөө хүртэл баримталсаар байгаа нь дэндүү эмгэнэлтэй.*

*Үнэнийг хэлэхэд шударга, хүмүүнлэг улсын иргэд Холландчууд хүртэл энэ дэлхийд хамгийн их ялгаварлан гадуурхагдсан еврейчүүд биднийг ад үзэх боллоо гэж үү. Би нэг л зүйлийг тухайлбал Холландчууд еврейчүүдийг үзэн ядах үзлийг устган, өөрсдийнхөө хэн болохыг харуулна гэдэгт огт эргэлзэхгүй байна. Учир нь хүний эрхийг дээдэлдэг эрхэм үзэл санаагаа энэ ард түмэн хэзээд орхихгүй. Еврейчүүдийг үзэн ядах үзэл бол дэндүү шударга бус зүйл шүү дээ. Би Холланд оронд эх орон шигээ хайртай. Эх нутаггүй бидэнд эх орон минь болно гэж итгэсээр явна.*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 25. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Өдөр бүр л нэг муу юм дуулдах юм. Өнөө өглөө бидэнд хоолны ногоо залгуулдаг сайхан сэтгэлт худалдаачин эр гэртээ хоёр еврей нууж байснаасаа болж баривчлагджээ. Ингээд ядарсан еврейчүүд нөгөө ертөнцөд одоод зогсохгүй, хөөрхий тэр энэрэнгүй сэтгэлт худалдаачинд гай зовлон тохиолдлоо.*

*Ер нь хорвоо ертөнцийн хамаг юм урвуугаар эргээд байна. Сайхан сэтгэлт, ёс журамт хүн бүр харих лагерь, шорон гянданд хоригдон тарчилж, хөгшин залуу, баян хоосон гэлтгүй бүх хүн тамын зовлонд унаад байна. Тэдний нэг хэсэг нь хоол хүнсний нөөцгүй болж дамын наймаанаас, үлдсэн хэсэг нь еврейчүүд болон герман цэрэгт татагдсан эрчүүдийг нууж хамгаалснаас гай зовлонд унасаар байна. Маргааш юу болохыг хэн ч тааж мэдэхгүй боллоо. Бидний хувьд тэр ногооны худалдаачин баригдсан нь нөхөж бариггүй гарз болов. Элли, Мийн хоёр бидэнд тэднийхээс төмс авдаг өнгөрсөн тул улам л өлмөн зэлмүүн байж, бүсээ чангалах болж байна. Үүнээс болж бид яаж аргалахаар болсныг мэдвэл аймаар санагдана даа чамд. Ээж юу гэсэн гээч! Бид өглөөний цай уухаа больж, үдэд зүсэм талх, муудаж ялзарсан буурцгийн агшаамал нэг аягыг идэн, оройдоо хуурсан төмс төдийхнөөр нөөцөө барагдтал гол зогоох гэнэ. Долоо хоногт нэг юмуу хоёр удаа л жаахан бууцай юмуу ногоон зууш идэх юм байх аа. Энэ нь өлсгөлөн л гэсэн үг. Гэвч дутагдаж гачигдана гэдэг германчуудад баригдан тарчилсанаас дээр л дээ.*

*Анне*

## 1944 оны тавдугаар сарын 26. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Би гэдэг хүн арай гэж цонхны өмнөх ширээн дээрээ тайван сууж, чамдаа ярих юмаа бичих боломжтой боллоо.*

*Хулгай орсон сараас хойш би үргэлж шаналан дотроо ч гаднаа ч бүр нурмайж гүйцэв. Нэгд, бүх л байшингийнхныг сандаргасан ногоочны баривчлагдсан, бас еврейн асуудал, хэзээ болих нь үл мэдэгдэх дайралт, чөлөөлөлт, муу хоол унд, сэтгэлийн зовлон, хүмүүсийн гутрал, Петерийг гэх сэтгэл, хоёрт, Эллигийн сүй тавьсан явдал, хүн амьтны хөл үймээн, улаан өндөгний баяр, цэцэг навч, ноён Кралерийн төрсөн өдөр, бялуу, кино, архины газар, концертын тухай яриа байв...*

*Мийн, ноён Кралер хоёр бидний өмнөөс хамаг хүнд хүчрийг үүрч байна. Мийн ажилдаа дарагдан, ноён Кралер асар их хариуцлага үүрч буйдаа бухимдан заримдаа ам нээх ч тэнхэлгүй болно. Ноён Коофуйс, Элли хоёр бидэнд санаа тавьж халамжлах бөгөөд хааяа ганц хоёр өдрөөр хөөрхий нуугдагсдыг мартагнана. Мэдээж тэдэнд санаа тавих өөр юм багагүй гардаг л байж таарна. Ноён Коофуйс өвчтэй учраас биеэ бодох, Элли сүйт залуугаа гэх нь мэдээж. Гэвч тэд өөрсдийнхөө ажлын хажуугаар бидний төлөө гүйж, ирж очдог нь хэвээрээ. Хөөрхий тэд биднийг орхих бүрдээ л бөөн сэтгэлийн зовлон болно.*

*Усны хоолой бөглөрснөөс ус гоожихоо больж, жорлонд орж болохгүй бас угаадсаа том саванд хадгалах боллоо. Өнөөдөртөө ч яахав болж л байна. Харин слесарууд засаж чадахгүй бол яахыг бүү мэд. Хотын цэвэр бохир усны албанаас ирэх долоо хоногт л хүн ирнэ гэсэн. Мийн шашны баяраар “Баярын мэнд!” гэсэн бичигтэй үзэмтэй талх илгээсэн байна. Тэр нь өөр эрсэн хүнд тохуурхсан ч юм шиг санагдана. Учир нь үргэлж урам зориг алдран, айдас хүйдэст автаж суугаа бидэнд баяр тэмдэглэхтэй манатай байлаа. Бид ногооны худалдаачныг баривчлагдсанаас хойш улам аймхай болж, бүгд бие биенээ “Чи, чиш!” гэцгээн, гэтэн явцгааж байлаа. Цагдаа нар тэдний хаалгыг цөм цохин орсон юм гэнэ. Манай хоргодох байрыг ч тэгэхгүй гэх баталгаа байхгүй шүү дээ. Хэрэв тийм юм бидэнд нэг өдөр...үгүй тэгвэл юу болохыг би бичиж зүрхлэхгүй. Гэвч тийм явдал тохиолдож болно гэдгийг огтхон ч мартаж болохгүй. Ингээд л аль хэдийнээс битүүхэн айх эмээх сэтгэлд бүр мөсөн автах боллоо. Оройн найман цагт би жорлонд орохоор доош буув. Дор хэн ч байсангүй. Манайхан цөм хүлээн авагчаа тойрон мэдээ сонсдог цаг байв. Би байдгаараа л зориг гаргав. Тэгсэн ч нэг л болдоггүй ээ. Дээрээс учир нь олдохгүй анир чимээ, гаднаас машины дүнгэнэх сонстож, доорх танхимд ганцаар байснаас нуугдахын оронд аль хэдийнэ үхсэн бол энэ бүх зовлонг амсалгүй, тэр тусмаа сайхан сэтгэлт Холланд хүмүүст гай бололгүй амар амгалан байх байсан юм биш үү гэж би байнга өөрөөсөө асууж, боддог боллоо. Гэвч манайхан бүгд л энэ үнэнийг хүлээхээс айж, амьд байгалийг санагалзан, хорвоогийн сайн сайханд итгэн, амьдралаас зууралдана. Болох ёстой юм нь бушуухан болоосой. Тэгвэл энэ ойлгомжгүй түгшүүрт байдалд айж хүлээж сууснаас дээр биз. Хэчнээн хатуу аймшигтай ч төгсгөл ирээсэй. Тэгэх юм бол нэг бодлын сэтгэл амар болох юм шиг санагдах юм.*



## 1944 оны тавдугаар сарын 31. Лхагва гариг

*Хайрт Китти минь!*

*Бямба, ням, даваа, мягмар гаригуудад байр маань үзэг бариад юм бичихийн эцэсгүй бүгчим халуун боллоо. Өнөөх усны хоолой тав дахь өдөр бас л эвдрээд хагас сайнд ашгүй засуулсан. Ноён Коофуйсын эхнэр их үдэд айлчилж, Корри охин нь Жодитайгаа хоккейн клубт очсоныг яриw. Элли бүтэн сайнд энд хулгай дээрэм орчихоогүй байгаа гэж эртээ ирж эргээд, өглөөний цай хүртэл хамт байw. Даваа гаригт Хенк Хант биднийг манаж хонов. Хоёр дахь өдрөөс овоо нэг салхивчаа жаахан ойнгойлгохтой болоw. Яасан ч халуун бүгчим өдрүүд вэ гэмээр ийм баярын өдрүүд үзсэнгүй. Энд хэчнээн халуун байсныг хэлэх ч юм биш. Чамайг ойлгох байх гээд зүгээр л бүгчимхэн байлаа гэж бичив.*

*Бямба гаригийг өглөө нь үнэхээр сайхан өдөр байснаа үдэд салхивчаа хаах үед л "ийм халуун битгий болоосой" гэмээр бүгчим болчихсон. Бүтэн сайны халууныг бүр ч ярих юм биш. Цөцгийн тос гал дээр тавьсан юм шиг хайлж урсаад, байранд хэсэгхэн ч сэрүүн газар олдохгүй зовсон. Талх хатан, сүү гашилж, ядахдаа салхивч нээж болохгүйг яана. Гадаа халуун ч гэсэн хүмүүсийг дур зоргоороо баярлаж байхад бид гэж хөөрхийлөлтэй хүмүүс хамраа ч цухуйлгаж болохгүй нуугдаж суух гэж дээ. "Хөл өвдөж байна гэж айхтар. Нимгэн юмгүй болохоор жин ч тавьж чадсангүй" гэж Даан эзэгтэй гаслана. Бүгчим халууныг тэсэж яадан шаналж байтал ашгүй хэдийгээр нартай ч өнөөдрөөс овоо салхи сэвэлзэж эхэллээ.*

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 5. Даваа гариг

*Хайрт Китти минь!*

*Энд нэг таагүй юм болсныг дуулгая. Юу гэвэл цөцгийн тос хуваарилахаас болж Дуссел, манайхны хооронд шалихгүй маргаан гарлаа. Дуссел тэгээд бууж өгөв.*

*Сониноос Дуссел, Даан эзэгтэй хоёрын үерхэл улам зузаарч, сээтэгнэх, үнсэлцэх, инээж ханиах нь ихсэв. Дуссел гуай бүр яргуй амссан ямаа шиг сэргэчихжээ.*

*Тавдугаар арми Ром хотыг эзлэн авчээ. Хот эвдэрч сүйрээгүй, бөмбөгөнд ч өртөөгүй юм байх.*

*Төмс ногоо улам ховордлоо. Тэнгэрийн муухай аашилж байгаа гэдэг хачин. Умард Францын эрэг болон Калайны хүзүүвчийг ширүүн бөмбөгдөж эхлэв.*

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 6. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Английн радио үдийн 12 цагт “Хүсэн хүлээсэн өдөр ирлээ!” гэж албан ёсоор мэдээлэв. Англичуудын довтолгоон эхэлжээ. Англичууд өглөөний найман цагт мэдээлэхдээ “Булоне, Хавре, Шербург, Калайн хүзүүвчийг хүчтэй бөмбөгдлөө” гэв. Цааш нь германы эзэмшилд байгаа бүх оршин суугчдын аюулгүй байдлыг хангах журмыг мэдээлэв. Эргээс 35 километр зайд суугаа оршин суугчид бөмбөгдөлтөд бэлтгэх хэрэгтэй болжээ. Англичууд хэрэв боломж гарвал бөмбөгдөлтөөс нэг цагийн өмнө урьдчилан сэргийлэх хуудас онгоцоор хаях гэнэ. Германы нэвтрүүлгээс үзвэл үнэхээр английн шүхэрчид францын эрэгт буужээ. ВВС агентлаг “Германы усан онгоцууд английн десантын усан онгоцтой тулалдаж байна” гэж мэдээллээ.*

*Есөн цагийн өглөөний цайн дээр ийм маргаан гарлаа. “Энэ хоёр жилийн өмнө Диенпед буусан десант шиг юм болдог болов уу?” гэж нэг нь хэлэхэд, Английн арван цагийн олон хэлийн нэвтрүүлгээр “Довтолгоон эхэллээ!” гэсэн шүү дээ. 11 цагийн герман хэлээр явдаг нэвтрүүлгээр ерөнхий командлагч генерал Д.Эйзенхаур ярьсан шүү дээ гэгцээв.*

*Нэг цагийнхаа нэвтрүүлгээр: Цэргийн анги нэгтгэлийг буулгах, ар талыг бөмбөгдөхөд 11000 нисэх онгоц бэлэн байж тасралтгүй нислэг хийнэ. 4000 десантын болон жижиг онгоцууд Шербург, Ле Хаврегийн хооронд сум хэрэглэл, цэрэг зогсоо зайгүй зөөж байна. Англи, Америкийн цэргүүд ширүүн тулалдаанд оров гэснээ Белгийн ерөнхий сайн Гербранди, Норвегийн хаан Хаакон, Францын Де Голль, Английн Черчилль нарын мэдэгдлийг нэвтрүүлэв.*

*Манайхан бөөн хөл хөгжсөөн болж байна. Хэзээ нэгэн цагт хэрэгжинэ гэхэд хэтэрхий сайхан үлгэр шиг санагддаг, нөгөө их хүсч мөрөөдсөн чөлөөлөлт үнэхээр хажуу хаяанд ирчихлээ гэж үү? 1944 он бидэнд ялалт авчрах юм гэж үү? Үүнийг бид яг мэдэхгүй ч итгэл найдвар, урам зориг орж, хүч тэнхээ авав. Урам зоригтой л байвал айх, гачигдаж дутагдах, өлсөхийн зовлонг тэсэж, итгэл дүүрэн байж чадах билээ. Уйлж унжин, урвайж гутрахгүй юмсан гэж уруулаа тас зуух хэрэгтэй. Зовлон гамшигийг туйлд нь хүртэл амссан Орос, Франц, Итали, Германы ард түмэн л харин енгэнэтэл уйлах, баярлах эрхтэй. Бид бол ингэх ёсгүй!*

*Китти минь, чөлөөлөгчид наашлан эрх чөлөө ойртож байгаа нь мэдрэгдэн буй нь бүхнээс сайхан байна. Маргот лав “За ашгүй ес юм уу арвадугаар сард сургуульдаа явах нь байна” гэх байх даа!*

**Анне**

*Жич: Өө чамд шинэ мэдээ дуулгая. Шөнө, өглөө үүрээр германы ар талд баахан сүрлэн мануухай буулгахад тэр нь газар хүрмэгцээ дэлбэрээд байсан гэнэ. Бас шөнө дөлөөр тас хар шүхэртэй олон шүхэрчдийг буулгасан гэнэ. Өглөөний долоон цагт эрэг орчмын германы бэхлэлтэн дээр таван сая килограмм бөмбөг хаясан онгоцуудын түрүүч нь буудалдаа буцаж иржээ. Өнөөдөр 20000 нисэх онгоц агаарт тулалдаж байгаа гэнэ. Эрэг орчмоор германы бэхлэлтийн ангиуд жагсаалаас гарчээ. Толгойн сэргийлэх бяцхан ангиа л германчууд дөнгөж аварсан юм байх. Тэнгэр бүүдгэр бүрхэг байгаа нь бүр ч сайн байгаа юм байх. Арми, ард*



*түмэн яг л “One will and one hope” байгаа юм байх.*

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 9. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Чөлөөлөлт ойртсоор ойртсоор л байна. Холбоотнууд францын эрэг дэх Баукс гэдэг тосгоныг эзлэн аваад, Ка хотын төлөө тулалдаж байна. Шербург хэмээх томоохон боомт хот байдаг хойгийг чөлөөлөхдөө тулжээ. Орой бүр фронтын мэдээнд хамгаалалт, хориглолтын байлдааны гайхамшигт ялалтууд, цэрэг дайчдын эрэлхэг гавьяаны тухай л ярьж байна. Түүнчлэн англидаа буцаж буй шархдагсдын тухай ч нэвтрүүлнэ. Цаг агаар муу ч нислэг сайн болж байгаа гэнэ. ВВС агентлагийн нэвтрүүлгээр чөлөөлөлтийг шууд цэргийнхээ хамт явж хийх гэсэн Черчиллийн төлөвлөгөө Эйзенхуар болон бусад генералуудын зөвшилцлөөр хойшлогджээ. Тийм өндөр настай хүн хэчнээн зоригтой байгааг бод л доо. Черчилл одоо лав дал хүрсэн байлгүй.*

*Баяр хөөр энд яльгүй намжив. Гэвч бид дайныг энэ жилийн сүүлчээр дуусна гэж итгэсээр байна. Ялалтын цаг нь болсон байлгүй. Харин Даан хатагтайн таамаглал буруудах нээ. Эзэгтэй чөлөөлөлтийн тухайд марган биднийг зовоох нь өнгөрөхтэйгөө зэрэг харин тэнгэрийн муухай болсон тухай бүхэл өдөржингөө янишин шаналгах болов. Болдогсон бол хүйтэн устай хувинд суулгахсан.*

*Даан гуай Петер хоёроос бусад маань цөм “Унгарын яруу аялгуу” гэдэг гурамсан роман уншлаа. Энэ нь алдарт хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч Франц Листийн намтар зохиол юм. Надад энэ ном таалагдсан ч хүүхнүүдийн тухай хэтэрхий их бичсэн юм шиг санагдсан. Ноён Лист агуу хөгжимчин байснаас гадна, бүр дал хүртлээ цуутай дурламтгай эр байжээ. Түүний амрагуудын жагсаалт Мария Агульд, Саун Виттгенштейны язгууртан хатагтай Каролина, бүжигчин Лола Монте, төгөлдөр хуурч Агнес Кингво, София Монте, Черкессийн сурвалжит хатагтай Ольга Янина, бароны ахайтан Ольга Майдорф, жүжигчин Лилла гээд л хөвөрнө. Надад бол хөгжим, урлагийн тухай бичсэн нь илүү сонин санагдсан. Тэр номд мөн Шуманн, Клара Вийк, Хектор Берлоц, Иоханнес Брамс, Бетховен, Иохим, Ричард Вагнер, Ханс Булоу, Антон Рубенштейн, Фридрих Шопен, Виктор Хюго, Онере де Бальзак, Миллер, Хуммел, Сцерни, Россини, Черубини, Паганини, Мендельсон гээд асар олон алдартны тухай гарах юм. Лист хүн бүхэнд тус болж явдаг сайхан сэтгэлтэй, нэрэлхүү, урлагийг хамгаас илүү дээдэлдэг, бүсгүйчүүд, шарз архинд ухаангүй дуртай, олз ашиг боддоггүй, шашин шүтдэггүй хүн байсан юм байна.*

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 13. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Миний төрсөн өдөр боллоо. Би арван тав хүрлээ. Аав, ээж маань надад Шпрингерийн урлагийн түүхийн таван боть ном, дотуур хувцасны хослол, хоёр бүс, нэг нусны алчуур, хоёр шил тараг, нэг шил чанамал жимс, амтат бялуу, ургамал судлалын лавлах, Маргот болохоор хос бугуйвч, Даан гуай ном, Дуссел хиймэл арвай, Мийн, Элли хоёр дэвтэр, амттан, ноён Кралер хамгийн том бялуу буюу гурван зүсэм тослог бяслаг, “Мария Терезия” гэдэг ном гэх мэт чамлахааргүй их бэлэг сэлт өгцгөөсөн. Харин Петер гайхалтай гоё сарнайн баглаа өгсөн шүү. Хөөрхий минь надад гоё сарнай олж өгөх гэж их хичээжээ. Гэтэл санаснаар нь бүтсэнгүй гэж надад хэлэв.*

*Далайд шуурга болж, цаг агаар муу байгаа ч фронт дээрх давшилт урагшилсаар байгаа мэдээ дуулдана. Англичуудын эзэлсэн францын тосгодоор Черчилль, Смит, Эйзенхуар, Арнольд нар өчигдөр очсон гэнэ. Бас Черчилль германы эзэмшлийн эрэг рүү гал нээсэн шумбагч онгоцныхонтой уулзжээ. Атаархмаар юм!*

*Холландчуудын бодол санааг биднийхтэй мэдээж зүйрлэшгүй. Дайныг хараад гар хумхин суусан англичууд гэнэт ухаан орсон юм шиг дайрч эхэлсэнд хүмүүс баярлаад, Английг “Хөгшчүүдийн засаг” хэмээн харааж, аймхай хулчгар, элдэв муугаар нь дуудаж байсан хүмүүс одоо амаа барьж байгаа биз. Цаашид ч хүн ардын тархинд шингэсэн эндүүрэл арилна бизээ!*

**Анне**

*Хайрт Китти минь!*

*Толгойд минь мянган бодол эргэлдэн, хүсэл мөрөөдөл оргилно. Уг нь би тийм ч яахаа алдатлаа биеэ тоож, хамраа сөхсөн амьтан биш. Өөрийнхөө өчнөөн дутагдлыг сайн мэддэг, түүнийгээ засч арилгаж чаддаг юм сан. Хүмүүс тэгээд яагаад намайг биеэ тоосон, сагсуу охин гэж бодоод байдгийг би гайхаад олохгүй юм. Намайг цаг үргэлж өөлж, муулж явдаг Даан хатагтайг би ухаан мэдрэл нь тааруухан гэж боддог. Миний бодлоор ухаан муу, тэнэг хүн л өөрөөсөө илүү ухаантай хүнийг үргэлж өөлж муулан, элэглэн шоолж доог хийж явдаг юм биш үү?*

*Даан эзэгтэй өөрөө дандаа тулга тойрсон юм бодож, насандаа зохиогүй бариу хувцас өмсөн, гуяа хасаа гялалзуулж явдагаа мэдэхгүй намайг түргэн ууртай, хэтэрхий богино юм өмсдөг энэ тэр гэж өөлнө. Бас өөрөө үнэн худал нь мэдэгдэхгүй юм ярьж явдаг мөртлөө намайг сониуч саваагүйгээр нь дуудна. “Олны үг ортой” гэгчээр заримдаа би үнэхээр тийм яадгаа алдсан саваагүй амьтан юм болов уу гэж гайхдаг юм. Энэ бүхэн нь өөртөө итгэж, хэн бүхэнд муугаа дуудуулаад байх дургүй миний төрөлх зан төрхөнд дарамттай юм. “Зэмлэл бүр заавал үнэний хувьтай” гэдэг хэлэх дуртай цэцэн үгээ санан, заримдаа би үнэхээр саваагүй юм болов уу гэж бодох юм. За тэгээд дээрээс нь ээж хошуу нэмэрлээд эхэлбэл зааж зааварлагсдын дарамтыг тэсэхээ больж “Намайг хэзээ л хэн л ойлгож байсан юм?” гэсэн үг амнаас унана. Хэлмэгдүүлсэн зэмлэл, зааварчилгаа сонсох болгонд аман дээр гараад ирдэг энэ үгэнд үнэний хувь байдаг юм шүү. Хүн өөрийнхөө алдаа дутагдлыг хүлээх ёстой ч энэ нь ор үндэстэй, бас эрүүл ухаанаар бодож тунгаасан байх ёстой гэж боддог юм.*

*Кит минь, ингэхэд чи Петер бид хоёрын тухай ямар нэг шинэ мэдээ сонсмоор байна уу? Ямар ч байсан Петер хайр сэтгэлтэйдээ биш, сайн найзын хувиар улам л надад сайн болоод байгаа. Миний бодлоор бид хоёрын хэн хэн нь нэг юмнаас болгоомжлоод байх шиг. Тэр нь юунаас болоод байна гэдгийг харин мэдэхгүй юм даа. Петерийг санан мөрөөдөх маань заримдаа арай хэтрээд ч байх шиг. Тэгэхдээ ганц хоёр өдөр түүнтэй уулзахгүй бол үгүйлж санахаа больчих юм. Петер бол эелдэг, дөлгөөн сайн хөвгүүн. Гэхдээ бас сэтгэлд хүрэхгүй юм түүнд дэндүү олон байдгийг хэлэхгүй өнгөрмөөргүй байна. Ялангуяа түүний яриа хоол унднаас хэтрэхгүй явцуухан сэдвийг тойрон эргэлддэг нь таалагддаггүй юмаа. Гэхдээ бид хоёр ямар ч байсан хэрэлдэж муудалцахгүй гэж тохирсон болохоор маргалдахгүй л байна. Ер нь тэр маань тайван дөлгөөн зантай, хүний аясаар хүн. Бас миний үгийг ээжийнхээсээ илүү сонсдог. Аливаад нямбай, эмх цэгцтэй. Заримдаа би энэ хөвгүүн яагаад надад бодсон санаснаа нэг мөсөн илчлэн ярихгүй байна вэ? Би л зүрх сэтгэлийг нь татаж чадахгүй байгаа юм болов уу? гэж өөрөөсөө асуухад хүрч, түүнийг ажиглахад энэ бүхэн нь түүний төрөлхийн бүрэг даруу зангаас болж байгаа нь илт байдаг юм. Түүн шиг хэт бүрэг хүмүүс гүнзгий мөрөөдөлдөө автаад, итгэл найдварыг хайж явдаг бололтой. Тэгээд ч Петер бид хоёр хамаг л ухаан суух, төлөвших насаа энд бүгээж суухдаа өнгөрөөчихөж байна.*

*Бид хоёр дандаа өнгөрсөн, одоо, ирээдүйн амьдралынхаа талаар ярилцах дуртай. Тийн яриа дэлгэхдээ энэ дайн, гудамжинд хамраа ч цухуйлгахгүй энд нуугдаж суугаа нь болох ёсгүй юм*

гэдэг. Гэтэл тэр болох ёсгүй гээд байгаа юм нь болчихоод байдаг.

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 15. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Амьд байгалийн сайхны харж, амьсгалж, зугаалж мэдрэх эрхгүй болчихоод мөрөөдөн суух шиг хяслантай юм алга. Урьд нь эрх чөлөөн дунд гүйж явахдаа, номин хөх цэнхэр тэнгэр, шувуудын жиргээ, өвс ногоо, анхилам цэцэгсийн сайхан үнэр, саран авхайн мөнгөн цагаа туяа гэдэг хэчнээн гайхамшиг гэдгийг анзаарах сөхөөгүй байсандаа харамсах юм. Би энд хоргодох болсноосоо хойш ертөнцийг өөрөөр хардаг болжээ. Саяхан нэг өдөр би сарыг ганцаараа тухтайхан харах гэж шашны баярын нэг амь тэмцмээр бүгчим орой арван нэг хагас хүртэл нүдээ анилдахыг ч тоолгүй хүлээсэн. Харамсалтай нь сар хэтэрхий өдөр шиг гэрэлтэй байснаас хөшигөө нээх боломж гараагүй юм.*

*Бас нэг удаа цонхоо нээгээд хаврын цэнгэг агаар амьсгалж, шөнийн үзэсгэлэнг гайхан удтал зогсч билээ. Тэр үдшээс хойж жинхэнэ шөнийн гоо сайханг харахсан гэсэн хүсэл минь хархнууд, хулгайч дээрэмчнээс ч айхыг мартуулсан юм.*

*Би энэ удаа ганцаараа доош бууж пүүсний контор, гал тогоо хоёрын цонхоор гудамж руу харлаа. Хүн гэдэг амьд байгалийн сайхан, одот тэнгэрийн дор унтахын гайхамшигийг эрүүл саруул, эрх чөлөөтэй явахдаа мэдрэхгүй, адын хүсэл шуналдаа хөтлөгдөж явсаар өнгөрөөдөг бололтой. Нар, сар, тэнгэр, үүлс, оддыг ажиглан ертөнцийн сайхныг мэдрэх гэдэг гайхамшиг. Хүн сэтгэлээ тайтгаруулах гэж элдэж эм ууж байснаас энэ бүхий сайхыг харж мэдэрсэн нь дээр шүү дээ. Байгаль л намайг амьдралын амар тайвныг эвдсэн ширүүн цохилтыг сөрөх хүч өгөх юм. Байгалийн тэр гайхам сайхныг тоос шороотой хөшиг, халтартсан цонхоор харахаас цаашигүй байхын хэцүүг үгээр илэрхийлшгүй. Ер нь байгалийн хамгийн сайхан нь худал хуурмаг юмгүйдээ л сэтгэлийг баясгадаг бизээ.*

*Анне*

## 1944 оны зургадугаар сарын 16. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Бас л нэг юм боллоо! Даан эзэгтэй цөхөрсөндөө сүүлийн үед хулхиараа буудуулах, шорон гянданд хоригдох, дүүжлэгдэх, амиа хорлох юмсан гэх боллоо. Тэрээр хүү нь өөрөөс нь илүү надад итгэх болсонд байж ядаж байх шиг. Хөөрхий түүний сээтэгнэхий нь Дуссел эмч тоохгүй болохоор гомдон, бас булган дээлнийх нь мөнгийг тамхинаас өгч дуусгалаа гэж нөхөртөө уурлах, уйлах, өөрийгөө хараах, зүхэх, инээх гэхчилэн хаврын тэнгэр шиг аашилна. Юм л бол хэрүүл өднө. Ийм хачин ааштай, мунхаг хүнтэй яаж шүүхэн харьцвал дээр вэ? гэвэл зүгээр л тоохгүй орхичихсон нь дээрээ. Үүнээс болоод хүү нь түүнтэй шазруун загнан, нөхөр нь уурлах юм...*

*Ноён Кралер газар ухах ажилд дуудагдан сар хэртэй явах болов. Мань хүн дайчилгаанаас эмчийн магадлагаа, нүүсний албан бичгээр чөлөөлүүлэх санаатай гүйж байна. Ноён Коофуйс ходоодондоо мэс засал хийлгэх боллоо. Өчигдөр арван нэгэн цагийн хэрд бүх айлын утсыг тасалжээ.*

*Анне*

**1944 оны зургадугаар сарын 23. Баасан гариг**

*Хайрт Китти минь!*

*Энүүгээр гойд сонингүй. Англичууд Шербургийг дайрчээ. Аав, Даан гуай хоёр энэ оны аравдугаар сарын арван гэхэд чөлөөлөгдөх болов уу гэлцэх юм. Оросууд өчигдөр Витебскийн дэргэд давшилтад оржээ. Энэ нь орос руу герман дайрсны яаг гурван жилийн ойн өдөр юм.*

*Төмсний нөөц дуусах гэж байна. Тэгвэл төмсөө найман ам бүлдээ ширхэг ширхэгээр хувааж хүртээх байх даа...*

*Анне*



## 1944 оны зургадугаар сарын 27. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

*Фронтос чих мялаасан баярт мэдээ дуулдаж байна. Шербург, Витебск, Слобиныд давшилт амжилттай болж, асар их зэвсэг, амьд хүч олзолжээ. Шербургэд байсан германы таван генерал алагдаж, хоёр нь олзлогджээ. Англичууд усан боомтыг эзлэн, гол түшиц газрыг нь авсан болохоор хүссэн бүхнээ хуурай газар гаргаж болно. Англичууд гуравхан долоо хоногт Котентины хойгийг эзэлж чадсан нь гайхамшигтай ялалт юм! Давшилтыг эхлүүлснээс хойшихи гурван долоо хоногт бороо, салхи шуургагүй ганц ч өдөр байсангүй. Гэвч францын нутаг дахь цаг уурын таагүй байдал англи, америкийн ялалт, хүчирхэгээ харуулахад нь саад хийж чадсангүй! Германы шидэт зэвсэг гэгдсэн пуужингууд өдөр шөнөгүй тачигнавч ангид олигтой хохирол учруулж чадахгүй, германы сонингууд худлаа дэвэргэн шуугихаас хэтэрсэнгүй. Дээрээс нь германчууд “Большевикийн аюул” гэгчээс айж дагжсандаа болоод юун англитай манатай байх шиг байна. Веермахт германы цэргийн албанд ажилладаггүй бүх герман эмэгтэйчүүд хүүхдээ эрэг орчмын нутгаас Холланд, Умар герман руу нүүлгэн шилжүүлжээ. Холландын үндэсний социалист хөдөлгөөний удирдагч Муссерт гэдэг этгээд давшилт тулаад ирэхээр армид элсэн германчуудтай мөр зэрэгцэн холланд орноо аврах гэнэ. Тэр бүдүүн гайхал үнэхээр байлдах юм байх даа. Тэр одоо тийм л сүрхий баатар юм бол Орост очиж германчуудтайгаа хамт байлдахгүй яасан юм бол доо...*

*Китти минь чи биднийг долдугаар сарын 27 гэхэд ямархуу байдалтай байх бол гэдгийг бодож байна уу?*

**Анне**

## 1944 оны зургадугаар сарын 30. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Агаар муу англичуудын хэлдэгээр “bad weather at a stretch to the 30th of june” гэгч л болж байна. Энэ зөв биз? Ингэхэд би чинь англи хэлийг овоо л гадарладаг болж байгаа юм байна. Жишээ нь “An ideal Husband”-г тольтойгоор уншиж байна. Давшилт овоо л нааштай сонсогдож байна. Бобрийск, Могилев, Орша чөлөөлөгдөж, германчууд бөөн бөөнөөрөө олзлогджээ. Ашгүй бүх юм баярламаар байгаа сурагтай. Манайхны доторх сайн сайхныг зөгнөгч, өөдрөг хэд нь хөөрсөөр л байна. Сониноос Элли үснийхээ засалтыг өөрчилжээ. Мийн нэг долоо хоног чөлөө авсан. Сүүлийн үеийн сонин ийм л байна даа.*

*Анне*

## 1944 оны долдугаар сарын 6. Пүрэв гариг

*Хайрт Китти минь!*

*Энэ Петерийг дээрэмчин юмуу дамын наймаачин болдог юм билүү гэхэд нь тоглоомгүй айдас төрөв. Хэдийгээр энэ нь тоглоомын үг ч гэсэн өөрийнхөө зан төрхийн сул талаас айдгийнх нь илрэл бололтой. Маргот, Петер хоёр хоёулаа юм л бол “Хэрэв чам шиг чанга, хүссэндээ хүрч чаддаг, зориг хатуу байсан бол...” гэж дуу алдацгаадаг юм. Би үнэхээр тийм чанга байж чаддаг юм болов уу? Хэнд ч толгойгоо мэдүүлэхгүй юмсан гэдэг маань үнэхээр тийм сайн чанар юм гэж үү? Ер нь зарим хүмүүс яаж “Би ч дорой буурай ядарсан амьтан даа” гэж хээв нэг ярьж, тэр дорой буурай чигээрээ насыг бардаг юм болоо? Ёстой ойлгомжгүй юм. Түүнийгээ мэдсээр байж яагаад тэр дорой буурай зангаа ялж, зорьсондоо хүрч чадахгүй өөрийгөө “алдаг” юм бол? Би Петерийг яаж нэг өөрийгөө боддог, өөртөө итгэлтэй, өөрийгөө өөд нь татдаг болгох вэ гэж удтал тархиа гашилгалаа. Үр дүнд хүрэх эсэхийг бүү мэд.*

*Надад нэг ч гэсэн хүн итгэдэг юм бол хэчнээн сайхан бэ гэж заримдаа боддог байж билээ. Петер жаахан ч гэсэн намайг гэх болжээ. Тэр итгэлийг нь хөсөрдүүлж болохгүй. Петер шиг сул зөөлөн хүмүүсийг хөл дээр нь бат зогсоон, амьдралын их далайд хөлөө олж чаддаг болгох нь үнэхээр амаргүй ажил юмаа... Би яасхийж Петерийг гүнзгий гэгч нь шигдсэн, өөрт нь таатай юм шиг болж дассан тэр намгаас нь татаж гаргах вэ гэж гайхиурсаар байна.*

*Бид ч яахав хоргодох байрандаа амь зууж л байна. Гэхдээ чухам яах гэж, юуны тулд амь зууж яваагаа мэдэхгүй юм. Бүгд л аз жаргалтай амьдрах гэсэн адилхан зорилготой ч бүгд өөр өөрийнхөө замаар жаргалтай, зовлонтой амьдарч өдөр хоногийг өнгөрөөнө. Энд бүгсэн хүмүүсийн хамгийн залуу нь болсон Маргот, Петер бид гурав уг нь элбэг дэлбэгхэн амьдралд өсөж торницгоосон хүмүүс. Бид гуравт сурах, зорьсондоо хүрэх бололцоо, ирээдүйн сайн сайханд итгэх итгэл энд ирэхээс өмнө байсан. Гэхдээ...бид чинь энд ч гэсэн өөрсдөө өөрсдийнхөө аз жаргалыг дархлах хэрэгтэй. Түүний тулд дандаа заавал элбэг дэлбэг, тос торгонд умбаж байх шаардлага байхгүй. Аз жаргалаа олж авахыг тулд залхуурч, хүнээс илүү хөдөлчих вий гэж биеэ оторлолгүйгээр шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй. Хийх ажилгүй, өмнөө тавьсан зорилгогүй хүмүүсийг хараад үнэхээр ойлгож чаддаггүй юм. Харин Петер бол тийм биш. Түүнийг дутагдал бол өөрийгөө ямар нэгэн авьяасгүй гэж голон, хэзээ ч биеэ дайчилдаггүйд байгаа юм. Хөөрхий энэ хөвгүүн хүнийг баярлуулах, бусдад аз жаргал өгөхийн утга учрыг огт ойлгодоггүй нь өрөвдмөөр. Ядаж тэр шүтэж биширэх юмгүй, Исус Христос гээд олигтойхон цэвэрхэн дуудаж ч чадахгүй, бурхдын нэрээр хараал зүхэл хэлдэг хүн дээ. Хэдийгээр би ариун санваартан биш ч гэсэн Петерийн энэ зан дэндүү бүдүүлэг, ёс горимгүйг нь харуулдаг нь харамсалтай.*

*Сэтгэлдээ шүтэх, биширэх юмтай хүн хэзээд сэтгэл өөдрөг, сэтгэлдээ түшиг тулгууртай байдаг. Шүтэж, биширнэ гэдэг ганцхан хойд насны нүгэл гэсгээлээс айх айдас биш юм. Халуун хүйтэн там, диваажин нь ихэнх хүнд эргэлзээтэй санагддаг. Гэхдээ аливаа шашин хүнийг сайн сайхан зүйлд хөтөлдөг. Шашин гэдэг хүмүүсийг хүчирхэг догшин бурхдаар далайлгасан сүрдүүлэг төдий биш, хүмүүнлэг үзэл, шударга ариун байдлыг дээдлэн гэгээрүүлэх гэсэн арга юм. Өдөр бүр нэг сайн үйлийг санаачлан цаг хүчээ хайрлалгүйгээр*

*түүнийгээ бүтээгээд байвал сэтгэл гэгээрэх шүү дээ...*

*Анне*

## 1944 оны долдугаар сарын 8. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Пүүсний ерөнхий төлөөлөгч ноён Б Бевервиякт байхдаа тэндээс гүзээлзгэнэ худалдан авчээ. Ингээд замдаа тоосонд дарагдсан 24 хайрцаг гүзээлзгэнэ хүргэгдэн ирлээ. Бид ч тэр дор нь талыг нь жигнэн найман шилэнд, нөгөө талыг нь чанаад найман вааранд юүлээд авав. Мийн маргааши нүүсэнд жимс чанахаар болов. Тэгээд өдөр нь нэг цаг болж, хөл татрах үеэр хаалгаа дангинатал түгжиж аваад хайрцагтай гүзээлзгэнийг зөөж гарлаа. Даан гуай хүүгээ дагуулан аавтай дээш авиран, бид халуун тогооноос ус зөөн, Маргот хувин сав хайн бүгд л гар хумхилгүй хөдөлцгөөлөө. Конторын гал тогоо руу орвол тэнд Мийн, Элли, Коофуйс, Хенк, аав, Петер гээд л гэгээн цагаан өдрөөр нуугдагсад болон халамжлагчид холилдож гүйцээд байж байв. Гадны хүмүүст юу ч харагдахааргүй, хөшиг битүү хаалттай ч гэсэн чанга чанга ярин, хаалга үүдээ дуугаргах нь баярламаар атлаа аймаар ажээ. Бид чинь бүгж байгаа хүмүүс биш билүү? гэж би өөрөө өөрөөсөө асуун, эрх чөлөөтэй болохоороо яг ийм мэдрэмж төрж, болгоомжлох байх даа гэж бодов. За тэгээд чанамалаар ваарыг дүүрмэгц нь л дээш зөөж байсан. Манайхны гал тогоонд хуучин тавилгаас ганц ширээ үлдсэн агаад түүн рүү гүзээлзгэний ишийг чулуудаж байгаа харагдана. Мэдээж бас цэвэрлэсэн гүзээлзгэнэ хувинд орохоос аманд орох нь их байсан шүү. Тэгэж байтал дахиад нэг хувин хэрэгтэй болов. Петерийг гал тогоо руу бууж ирэхэд гаднах үүдний хонхыг нэг хүн хоёр удаа даржээ. Тэгэхэд Петер тавиуртай нууц хаалгаа онгорхой орхисноо санаад хувингаа тавив уу үгүй юү дээш яаран гүйв. Бид ч усны цоргуудаа нээлттэй нь орхин, гүйцэт угаагдаагүй гүзээлзгэнээ тэвшинд нь хаяад, дээшээ яаран гарч “Энэ чинь юу вэ таминь, усны цорго шоржигсноод хүн байгаа юм биш үү” гэх вий гэхдээ дээр байдаг усны гангийн тохируулагчийг барьцгаав. Ашгүй тэгтэл Хенк “Тэр хонх дарсан хүн нь шуудан зөөдөг завьчин байсан” гэдгийг хэлэхээр ирэв. Тэгэж байтал дахиад л хонх жингэнэхэд бид түргэн жагсаал авцгаав. Би нөгөө тавиуртай нууц хаалган дээрээ ирж, шатаар гараад хэн байгааг харах гэж Петертэй хамт хулгайч шиг гэтсээр хашилага руу тонгойж чагнавал нэг хүн доороос ирж яваа сонсогдов. Нэг л таньдаг хөлийн чимээ байлаа. Петер тэгэхэд нь шат руу аяархан бууж, хэсэгхэн зогссоноо “Элли!” гэж дуудвал хариу байдаггүй. Дахиад л “Элли юү?” гэтэл бас чимээгүй. Гал тогоонд гарах чимээ Петерийн дуунаас тод сонстох аж. Тэгээд Петерийг гал тогоо руу орохоор доош буухад би юу болдог бол гэж харан зогссоор байсан. Гэтэл:*

*-Петер, цаашаа яв яв. Ном шалгагч ирсэн байна гэх нь ноён Коофуйсын дуу байлаа. Петерийг амьсгаадсаар гарч ирэхэд нууц хаалга хаагдав. Нэг хагаст ноён Кралер ч ирэв.*

*Ээ бурхан минь надад гүзээлзгэнээс өөр харагдах юм алга боллоо. Өглөөний цай гүзээлзгэнэтэй байсан бол одоо бас Хенк гүзээлзгэнэ идэж, ноён Коофуйс гүзээлзгэнэ амтлан, Мийн гүзээлзгэнэ чанаж, надад ч бас гүзээлзгэнэ үнэртэнэ. Гүзээлзгэнээс бүүр залхаж, түүнийг харахгүй, үнэртэхгүй гэж дээш гарахад тэнд ч бас гүзээлзгэний угаадасны үнэр ханхийв. Үлдсэн гүзээлзгэнийг бүгдийг чанав. Орой нь хоёр шилийг задлав. Аав ёстой хурдан гэгч нь чанана. Түрүүчийнхээ хийсэн чанамалаас өглөө нь задалж хэрэглэсэн бол өдөр нь дөрвийг задаллаа. Даан гуайнхны хийсэн чанамал муудахаар чанаргүй болсноос аав орой бүр гүзээлзгэнэ чанах болов. Чанасан будаа, зүссэн талх, аягалсан шар сүү бүгд л*

гүзээлзгэнэтэй болж, бүх л амттанг гүзээлзгэнэ орлох болсон. Гүзээлзгэнэ ийнхүү хоёр өдөр хэртэй хаа сайгүй элбэгшсэнээ шил ваарнуудаар дүүрч, цоож цуургаатай шүүгээнд хадгалагдан ховордлоо.

Марготыг “Анне, нөгөө булангийн ногоочингоос 19 фунт уутан хальст буурцаг авсан” гэхэд нь би “Яасан сайн хүн бэ. Үнэхээр сайн хүн юм. Гэвч ажил нь дийлдэхгүй дээ!” гэв. Ээж:

-Хагас сайнд өглөөгүүр буурцаг хальслахад та нар туслаарай гэв. Нээрээ л өнөө өглөө цайны дараа амсар дүүрэн уутан хальст буурцагтай паалантай хувин ширээн дээр биднийг хүлээж байлаа. Буурцаг арилгах нь залхуутай ч хальсыг нь аваад идэхэд сайхан юм. Хүмүүс ийм хальст буурцгийн хэчнээн амттайг анзаардаггүйг өнөөдөр л мэдэж бид баахан гайхацгаасан шүү. Сониноос энэ буурцаг хоолонд шошноос гурав дахин их орох юм. За тэгээд буурцаг хальслана гэдэг нь нямбай нь дэндүү дүрэмдүү шүдний эмч эсвэл тааруухан жижиг түшмэлээр хийлгэвэл таарсан төвөгтэй, цаг тэвчээр барсан ажил юмаа. Над шиг тэвчээр муутай хүнд бол ёстой таардаг ажил биш юм. Өглөө ес хагаст хальсалж эхлээд арав хагаст завсарлаж, дахиад цагийн дараа бас үргэлжлүүлэн үйлээ эдлэхээр боллоо. Буурцагны оройг тас чимхэн, хальсыг нь сугалж, сахлыг нь аваад, цэвэрлэсэн буурцагаа түмпэн рүү шидэх чимээ бүүр чихэнд хоногшихлоо. Ёооё, нүдний өмнүүр дандаа хальс, буурцагнууд гээд ногоон юм, дахиад л ногоон, ногоон, ногоон юмнууд хөврөн эрээлжлүүлнэ.

Уйтгарлахгүйн тулд ямар нэг хийх юмтэй байхсан гэхдээ би үдээс өмнө баахан чалчин хүмүүсийг инээлгэж, тэрэндээ өөрөө ч хөгжин цагийг аятайхан өнгөрөөлөө. Буурцгийн сахлыг цэвэрлэх гэж мунгинаж суухдаа би хэзээ ч өөдтэйхэн гэрийн эзэгтэй болж чадахгүйгээ ойлгосон шүү.

Бид арван цагт нэг жаахан юм хэлэн дээрээ тавьсан болоод, гучин минутын дараа эргээд л нөгөө үйлтэй ажлаа эхэлж нэг арван тав болтол хийв. Арай гэж тэр буурцаг цэвэрлэх ажил дуусахад би яг л далайн өвчин туссан хүн шиг болж бусдаас түрүүлэн орон дээрээ унаад өгөв. Тэгээд дөрөв хүртэл дугхийгээд дахиад л нөгөө лайтай буурцагтайгаа ноцолдож гарлаа даа.

Анне

## 1944 оны долдугаар сарын 15. Бямба гариг

*Хайрт Китти минь!*

*Манайхан номын сангаас “Та орчин үеийн охидыг юу гэж боддог вэ?” гэсэн сонирхолтой нэг ном авчруулжээ. Энэ номын тухай чамд яримаар байна. Өнөөгийн залуусыг дотор нь орсон юм шиг мэддэг зохиолч залуу насыг ёстой нэг будаа болтол нь шүүмжлэн бичжээ. Мань зохиолч урд нь залуус л өөрсдөө хүсвэл ертөнцийг агуу сайхан болгон өөрчилж чадна гэдэгт итгэдэг байсан юм гэнэ. Гэтэл ингэж итгэж найдаж явсан залуус нь зорилгоо ухамсарлахгүй, цагаа үр ашиггүй өнгөрөөж, амьдралд дэндүү өнгөцхөн хөнгөмсгөөр хандаж байгаа юм байх аа. Энэ хэсэг нь яагаад ч юм намайг хэлчих шиг санагдлаа. Эцэст нь би дотны анд чамдаа өөрийгөө болон үеийнхнээ өмгөөлөн өмөөрөхөөр шийдээд байгаа нь энэ.*

*Би урьд нь чамд ярьж байсан даа, өөрийгөө шүүмжилж, дутагдлаа засахыг хүсдэг хүн. Өөртөө тохиолдсон бүх үйл явдлыг, өөрийнхөө гаргасан шийдвэрүүдийг дандаа хөндлөнгийн нүдээр харахыг хичээдгийг чи мэднэ. За тэгээд бараг хэлсэн үг бүрээ эргэн санаж “ингэж ч хэлдэг байж үү” гэх юмуу “Ашгүй оноод хэлчихжээ. Хэлэх гэсэн юмаа л хэлж” гэхчлэн тунгаан боддог юм. Ер нь эргээд санахын аргагүй олон алдаагаа би өөрөө зэмлэж байсан. Тэгэх үедээ “хүүхэд бүр өөр өөрийгөө хүмүүжүүлэх хэрэгтэй юм шүү” гэж аавын хэлдэг үгийн үнэнийг гайхдаг. Нээрээ л өөрөө л бүхнийг ухаарахгүй юм бол эргэн тойрны хүмүүс яахав дээ. Тэгэхээр сайн хүн болох эсэх, төлөвшиж чадах уу үгүй юу гэдэг цэвэр өөрөөс л хамаардаг юм биш үү? Тэр тухайгаа би чамд нэг бус удаа өгүүлж байсан даа. Аав, ээж хоёр ерөөсөө намайг ойлгохгүй байгааг бас хөндмөөр байна. Мэдээж тэд минь намайг эрхлүүлж, хайрлаж, хамгаалж, хийх ёстой бүхнээ хийсэн. Гэвч би тэдэндээ өөрийгөө ойлгуулж чадахгүй нэг хэсэг их ганцаардсан. Тэгэхэд аав миний зөрүүд занг өөрчлөх гэж үнэхээр их хичээж билээ. Эцэст нь би өөрөө л алдаа дутагдлаа ухаарч, засч чадсан юм даа. Хамгийн гол нь аав ч юмуу хэн нэг нь надад хандахдаа арчаагүй бяцхан хүүхдийг өрөвдөж байгаа юм шиг, эсвэл өөрийн ухаангүй тэнэг амьтантай ярьж байгаа юм шиг харьцдаг байсан нь таалагддаггүй байв. Даанч аав минь үүнийг ойлгосон янз алга. Ингэхэд би өөрийнхөө тухай ярих дургүй хүнд итгэмээргүй санагддаг юм. Би чинь аавын тухай бараг мэдэхгүй болохоор бидний хооронд яаж ч элгэсэг дотно яриа үүсэх билээ дээ. Манай аав бүхнийг хөгшин хүний байр сууринаас хардаг гээч...*

*Одоо надад амар тайван байдал л чухал байна. Учир нь гайхамшигтайгаар бий болсон өөртөө итгэх итгэлээ би алдахыг хүсэхгүй байна. Эцэст нь аавд энэ бүхнээ учирлан бичсэн өнөөх балай захидлаас болж над руу чиглэсэн буруушаал, зэмлэл өдий хүртэл намайг шаналгасаар байна. Китти минь, ямар нэгэн юманд бууж өгөхгүй, хатуу чанга, зориг тэвчээртэй байх чинь ямар ч хэцүү юм бэ!*

*Намайг хамгийн их зовоож байгаа зүйл энэ бишээ! Петерийн тухайд бол ааваас бүүр долоон дор гээч. Петерийг санаж мөрөөдөх сэтгэл улам нэмэгдэх бүр тэр надад хайр энхрийлэл ойлголцол дутагдсан өрөвдмөөр хөвгүүн гэж бодогдох болсон юм. Надад ч гэсэн хүсэл мөрөөдөл, баяр гунигаа хуваалцах анд найз хэрэгтэй байсан юм. Тэгээд алхам алхмаар түүнд дасан сэтгэл татагдах боллоо. Бид хоёр сэтгэлдээ хадгалж явсан нандин нууцаа бие биедээ ярьж улам ойр дотно болж л байна. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл хайр сэтгэлийн*

*тухай ганц ч үг цухуйлгаагүй л явна. Петер хэтэрхий бүрэг доройгоосоо ч юмуу эсвэл надаас зовоод биеэ барьсандаа энэ сэдвээр ам нээхгүй байгаа юмуу бүү мэд.*

*Би ч бас жирийн үерхлээс илүү дотночлон ойртох оролдлогыг хориглосноороо буруудсан ч байж магад. Тэгсэн ч гэсэн Петер харваас хайр дурлалдаа шатан над руу улам тэмүүлсээр байгаа нь илт байх юм. Заримдаа ч би Петерийг өөрөөсөө хөндийрүүлж, эр хүн шиг хатуужуулахыг хүсэх юм.*

*Би нэгэн номноос “Залуучууд ихэнхдээ хөгшичүүдээс илүү их ганцаардан шаналдаг” гэсэн үг уншиж байсан нь үнэний хувьтай л юм. Ямар ч байсан энд бүгж нуугдах нь настайчууд, томчуудаас илүү залуучууд бидэнд хэцүү бэрх байгаа гэж би дүгнэж байна. Насанд хүрсэн хүмүүс амьдралд хандах үзэл бодолтой болчихсон байдаг болохоор алив цохилтонд нэг их хөл алдахааргүй болсон байдаг. Гэтэл залуучууд хорвоо ертөнц орвонгоороо эргэн, хүний гэгээн сайхан хүсэл тэмүүлэл унтарч болохоор ийм цаг үед үзэл бодлоо олж авч, хөл дээрээ зогсоно гэдэг үнэхээр амаргүй!*

*Гайхалтай нь бид утга учиргүй, хэзээ ч биелишгүй мэт итгэл найдвараа алдахгүй байсаар байна. Хэчнээн хүнд бэрх, муу муухай юм нүүрлэсэн ч хүний сайхан чанар хэзээ ч арилан алга болохгүй гэдэгт би итгэдэг. Дэлхий ертөнцөд хүний гараар бүтээсэн гайхамшигт бүхийг устган хуйхалсан дайны гал дүрэлзэн байгааг харж, амьдралыг минь таслах аймшигт сүйрлийн чимээг чих минь анирдан, сая сая хүний гаслан зовлонг би мэдэрч байвч, нэг л сайхан өдөр гаслан зовлон төгсч, энх тайван тогтоно гэдэг итгэлээ би хэзээ ч алдахгүй! Би энэхүү ариун хүслэнгээ цаг мөч тутамд эрхэмлэн өндөрт өргөнө. Хүсэл минь биелнэ гэдэгт итгэнэм.*

*Анне*



## 1944 оны долдугаар сарын 21. Баасан гариг

*Хайрт Китти минь!*

*Цагийн байдал нааштай болж итгэл төрөх болж байна! Тиймээ байдал сайн тул руугаа эргээж байна! Хэчнээн сайхан мэдээ сонсогдож байна гээч. Гитлерийн амийг хорлох оролдлого болжээ. Тэр хүн еврей ч бус, коммунист ч биш, англи ч биш цэвэр герман генерал, угсаа сурвалжит гүн байсан гэнэ. Харамсалтай нь Фюрерийн амь “бурхан тэнгэрийн ивээлээр” энд тэндээ жаахан шалбарч түлэгдээд л өнгөрчээ. Бас Гитлерийн хажууд байсан генерал дарга нараас нэлээд хэдэн хүн алагдаж, шархадсан гэнэ. Гэмт хэрэгтнийг буудан хороожээ. Энэ бол германы дээд тушаалын генерал дарга нар нь хүртэл дайнаас залхсаны нотолгоо юм. Хэрэв Гитлерийг бурхан ивээгээгүйсэн бол холбоотонд бүр ч таатай байдал бий болж, цэвэр цустан гэгдэх германчууд гэдсэндээ хөлөө хийлцэн, орос, англичуудын ялалт түргэсэж, ялалт ойртож, хот тосгоны сэргээн босголт хамаагүй эрт эхлэх байв. Яагаад ч юм чөлөөлөлт, ялалтын тухай ярих нь бас ч өдий санагдана. Үйл явдлаар дүүрэн тэр цаг сэтгэлд нэг л бууж өгөхгүй байна.*

*Китти минь чи ойлгож байна уу? За, тэгээд өөр юу гэхэв, аравдугаар сараас сургуульдаа явж эхлэх нь гэхээс баярласандаа хөл газар хүрэхгүй нээ. Аа тийм би юунд ч нэг их яарахаа больсноо хэлэх гэснээ мартаж нь! Шалихгүй юман дээр хэл ам, хэрүүл зөрчлийн бай болохгүйн тулд хэн нэгнийг нэрлэхээ болиод удаж байна. Уучлаарай.*

*Анне*

# 1944 оны наймдугаар сарын 1. Мягмар гариг

*Хайрт Китти минь!*

“Зөрчлийн бай” гэж өмнөх өдөр бичсэний минь төгсгөлийн үг, өнөөдрийн захидлын маань эхний үг болог. Ингэхэд чи “Зөрчлийн бай” гэж яг юу юм бэ гэдгийг надад тайлбарлаач? Чухам юуг зөрчил гээд байгааг чи тайлбарлаад өгөөч? Энэ салаа утгатай олон үгсийн нэг юм. Гадаад зөрчил ч гэж бий. Дотоод зөрчил ч гэж бий. Гадаад зөрчил гэдэг бол өөрийн чинь сайн мэдэх таагүй муу чанарууд буюу бусадтай санал нийлэхгүй, чиний илүү сайн мэдэх тэвчиж явбал таарах зүйл юм. Дотоод зөрчил бол өөрөө ч үл мэдэх хувийн нууц ажээ. Би чамд нэг удаа өөрийнхөө дотор хоёр хүн байдгийг ярьсан шүү дээ. Нэг дэх нь ямарваа юмыг амар хөнгөн хийх гэсэн зан, юмыг шоолон шүүмжлэх араншин, дүрсгүй, хөхүүн төрх юм. Тэгэхээр нэг дэх Anne аалиггүйтэн сээтэгнэх, үнсэлцэх, тэврэлдэх, хөгжин цэнгэх, элдвийг чалчих дуртай хүн. Энэ Anneгийн тэр зан нь намайг хөнгөн хийсвэр, өөнтөгч, шооч болгон, нөгөөх төлөв төвшин, нигүүлсэнгүй, сайхан сэтгэлт, буурь суурьтай хоёр дахь сайн Anneгаа дийлчихдэг юм. Тэгээд л хоёр дахь Anne хэн ч мэдэхгүй болдог. Тийм биз? Хэрэв нэг дэх Anne дийлдэггүйсэн бол хамаагүй цөөхөн хүнийг гомдоож, хүмүүс намайг хамаагүй илүү үнэлэхсэн.

Би нэг өдрийн үдийг хөгжиж наргиж өнгөрвөл хүн амьтан нэг сар надаас дөлж буруутгана. Үгүй тэгээд Anneгийн хагас нь болсон нэгдүгээр Anneг би хөөж зайлуулаад сайн Anneг үлдээх гээд чадаагүйг чи даанч төсөөлөхгүй дээ. Тэгэж болохгүй, яагаад ч бүтэхгүйг би одоо л ойлгож байна. Харин ч намайг мэдэх ойр дотныхон маань миний дотоод сэтгэлийг нээж сайн талыг минь мэдчихвий гэж айх юм. Тэгсэн мөртлөө тэд намайг шоолон хөнгөмсөг, томоогүй, төрхгүй гэхээс гадна “эрвээхий” Anne гэж дуудахад нь хүртэл дасчихжээ. Хэрэв ид шидээр ч юмуу, хүчээр миний доторх нөгөө сайн Anneг гаргаад ирвэл эд нар “Шал өөр Anne чи юун хүн билээ” гэх шиг сонуучирхаад салахгүй “Та минь ээ! Битгий над руу шавааралдаач ээ, дарж алах нь ээ!” гэмээр наалдаад ядаргаа болж нэг л мэдэхэд би буцаад муу Anne болчих байх даа. Хөөрхий Anne ингээд л хэзээ ч бүр ганц ч удаа үнэн дүрээрээ олны дунд байж чадахгүй, ямарваа тохиолдолд ганцаараа л учраа олохоос өөр аргагүй болдог юм даа.

Дээр ярьсан шигээ үнэн дүрээ өөрчлөн зөрүүд аашилдгаасаа болж хайр сэтгэлийн роман уншдаг, аальгүй, хөвгүүдийн араас гүйж сээтэгнэдэг, бардам, их зантай охин гэж ойлгогдоход хүрээд байдаг юм. Тэгэхэд нь өнгөн дээрээ харагддаг муу Anne инээж хөхрөн, юм л бол мөрөө хавчин, элдвийг ярин дүрсгүйтхэд нөгөө ухаалаг, тайван Anne бүхнийг дотроо тунгаан, шал өөрөөр нухацтай боддог юм. Үнэнээ хэлэхэд Китти минь, би өөртэйгөө тэмцэлдэх гэж хэчнээн их хүч гарган, хэчнээн их шаналдаг гээч. Тэгээд л заримдаа өөртөө “Чи нөгөө сайн Anneгийнхаа үгэнд ороогүйгээс муухай аашлан, хүмүүсийн гайхширч шоолсон царайг харж, дургүйцэж адалсан үгийг сонсож байна шүү дээ” гэж хэлэн ганцаараа эхэр татан уйлдаг юм. Уг нь би дотоод зөвлөгчийнхөө үгийг сонсохыг мэдээж хүсдэг. Тэгээд л яг сонсох гэхээр нэг л болж өгдөггүй юм. Хэрэв намайг нэг л өдөр гэнэт буурь суурьтай, хэрсүү, хянуур хүн болчих юм бол гэр бүлийнхээс минь бусад хүмүүс Anneгийн бас нэг шинэ маяг гэж л бодно шүү дээ. За тэгэхээр миний нөгөө хорон үг урсаж гарна даа. За ер нь тэгээд гэнэт нэг өдөр чалчихаа болиод дуугаа хураачихвал “Юу болов Anne? Өвчин зовлон тусчихав уу?”

*гээд л сүйд майд болоод эм тан уулгаж, халуурчихав уу гэж духан дээр дарж, судас барьж гэдэс дотор чинь зүгээр биз гэлцэн бөөн шуугиан дэгдэх нь ойлгомжтой болно. Түүнийг нь би бас тэвчихгүй. Тэгээд л ер нь хүссэнээрээ байж болдоггүй юм бол ингэдэг хэрэг гэж элдвийг сэдэн, хачин хачин юм хийж, гайхируулснаа гэнэт уйдаад, эцэст нь сэтгэл зүрхнийхээ аль сайхныг нууж, мууг нь гаргахад хүрч, намайг энэ дэлхийд бүрэн ойлгох хүн олдохгүй юм бол яахаа мэдэхгүй болж, дахиад л элдвийг сэдэж гарна даа.*

*Анне*

**Анне охины өдрийн тэмдэглэл ингээд л төгссөн юм.**